

Аръяабал бурханы үүднээс
хатуужил сахих зан үйл
тус амгалангийн гэгээ

НОГООН ДЭВТЭР

Хоёрдугаар цуврал

Орчуулан эмхэтгэсэн
Монголын Бурханы Шашинтаны Төв Гандан хийдийн гавж
Доктор, Ph.D Ц.Отгонбаяр

Улаанбаатар, 2013 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

ГАРЧИГ

Уялга үг	5
Маанийн тус эрдэм	6
Хатуужил сахирын ёс	9
Их Аръяабал бурхандаа тахил өргөхүй	10
Даган хэмээх бэлтгэл өдөр	12
Монгол орны сан	13
Хатууд оршихуйн зан үйл бумба бүтээхуйн ёсон	19
Түй буюу угаал өргөхүй	22
Мандал өргөх ёсон оршвой	25
Цагаан дар эх оршвой	27
Адистын дээдийг хайрлагч эх	28
Манз буюу цай уух	29
Бурханы шашин дэлгэрэхийн ерөөл	30
Богд зонховын шашин дэлгэрэх ерөөл	32
Зая бандида Лувсан Данзан Пүлжинжигмэдийн төрөл тутмын залбирал	34
Дүнчүүр маани	36
Үндсэн өдрийн уншлага анхны	43
Тасалгаат чого	
1. Сожин авахуй	43
2. Ламан Чодво буюу багшийг тахихуй	47
3. Дүншаг буюу уналыг наминчлахуй	51
4. Жившаг буюу ер уналыг наминчлахуй	54
5. Ламан чодво буюу багшийг тахихуй судраас хилэнцээ наманчлахын гишүүн	55
6. Аръяабал бурханы балмуй ёсны багшийн дамжлага сэлт	56
7. Аръяабал бурханы магтаал	57
8. Их нигүүлсэгчийн бүтээлийн арга	60
9. Бодь мөрийн гурван эрхэм зүйл оршвой	61
10. Шүтэн барилдлагын магтаал	63
11. Ногоон Дар-эхийн магтаал	69
12. Дээрхийн гэгээнтэн Далай багшийн айлдсан Монголын Их Богдын хойд дүр эх нутагтаа түргэн залрахуйн залбирал	72
13. Маанийн сургаал	73
14. Ламан чодво буюу багшийг тахихуй судраас багшийг шүтэх ёс	75
15. Дагжид буюу өөртөө аръяабал бурхныг үүсгэхүй	82

16. Дагжидийн чодво жанлав буюу аръяабал бурханыг өөртөө үүсгэхийн тахил адислалт.	85
17. Дүнжид буюу аръяабал бурханыг өмнөө бясалгах бүтээл ануу.	86
18. Дүнжидийн тахил адисламой	88
19. Мандал хураангуй	92
20. Жигдэнгомбо хэмээх аръяабал бурханы мөргөл	93
21. Ламан чодво буюу багшийн тахилын хэсгээс (шинчогдамба).	94
22. Төгсгөлийн уншлага чого зан үйл залбирал	98
23. Хутагт сайн явдлын ерөөлийн хаан (санжид монлам) . . .	103
24. Хутагт майдарын ерөөл /санжаагүнла/	110
25. Бодь сэтгэлийн ерөөл буюу дагийжанчивма	113
26. Эхэн эцэс завсар гурвын ерөөл буюу чогуужалвама . . .	121
27. Энхжингийн орны ерөөл буюу пүлжинма	124
28. Дүйнхорын ерөөл буюу дидарлхагсама	128
29. Гомбо сахиус буюу махагалын магтаал	132
30. Даши буюу өлзий хутаг оршоохуй	134
31. Аръяабал бурханд ерөөл өргөхүй	137
Маани хөгжөөх	138
Эцэг эхийн ачийг хариулах маани	140
Нүгнай буюу хатууд оршихуйн зан үйлийг ёсчлон дагаж бүтээл бясалгалын туйлд хүрсэн бясалгаач ёгузер нарын намтраас дурьдвал	142
Даваашонугийн намтар	142
Бал-ишсамбуугийн намтар.	143
Пеняпагийн намтар	145
Даваажанцангийн намтар	147
Нипугвагийн намтар	153
Срүва – доржжалвугийн намтар	159
Шандандажигийн намтар	161
Задвазидүлватүгжижанжүвийн намтар.	164
Чожил доглходва шагжа жанчүвийн намтар.	165
Чүлсамба жанчүв барын намтар	167
Шэйрэв бумын намтар	167
Тогмид самбуу балын намтар	170
Нэрт эрдэмтэн заваадамдин гавжийн энэрэнгүй сэтгэлийн тухай түвд хэл дээр магтаж бичсэн яруу найраг.	188
Их нигүүлсэнгүй сэтгэл дор магтму хэмээх 108 бадагт болор эрдэнийн эрх судар оршивой	188

УЯЛГА ҮГ

Эрхэм хүндэт өглөгийн эзэн уншагч авхай та бүгдийн энэ өдрийн түмэн амгаланг айлтгахын ялдамд энэ Арьяабал бурханы үүднээс хатуужил сахихуй судар орчуулахын уг шалтгааны талаар зухас дурьдбал: Өнгөрдөг луу жилийн цагаан сараар би өөрийн багш түвд Агваанжамц ламтантай Энэтхэг очиж 14-р Дээрхийн гэгээнд бараалхаж мэнд айлтгах дашрамд нутаг орны байдлын талаар тайлбарлах завшаан тохиож тэр дашрамд нутаг орны талаар засал гүрэм сурахад та нар Улаанбаатарын утааг их ярих болжээ. Уг нь гадна талын хөгжил буурал гэхээс илүү дотор тал уруугаа өнгөөж харж гэмээнэ зүгээрсэн дээ хүмүүс олдох тусмаа хүнээ байж хүмүүнлэг талаасаа өдөр болгон ухарч адгууслаг талаа хэвийн болгож харж байгаа нь хамгийн эмгэнэлтэй жишээ нь гадаа согтуурхах машин дотроо хоорондоо хэрэлдэх хараах, нулимах морь харах зэргийг энгийн байдаг зүйл мэтээр үздэг болж буй нь дотоод сэтгэлийн хөгжил туйлаас дордож адгууснаас дор авир гаргаж байгаа нь нийтлэг болжээ. Иймээс хөгжил дэвшилийг өөрөөсөө эхлэж хий. Та хоёр хөдөөгүүр явж нүгнай буюу хатуужил сахих хэрэгтэй заавал хийдэд сууж хамба болох гээд яахав гэж инээн айлдсанчилэн уг сударыг монгол хэлээр дээр чадан ядан орчуулсан билээ. Алдаа эндүүрэлийг минь түмэнтэй өршөөнө үү. МБШ төв Гандан хийдийн гавж доктор нэрийг зүүгч 1983 оноос өнөөг хүртэл Гандан хийдийн хуралд хурж буй эрдэм чадал үгүй ар мөрний нэгэн хуврага Цэрэнбатын Отгонбаяр бээр Тийн ялсан хэмээх усан могой жилийн шарагчин хонь сарын шинийн найманы харагчин хонь өдөр цагт хавчигдан сандруухан шиг бичиж өндөрлөв.

Тус амгалангийн гэгээ хэмээх энэхүү хатуужилд оршихуйн сударыг Зая бандида гэгээн „Дагбу бүрэлгү лувсан дамби жанцан, чойнхор хансүр гүжи равжамба галсан равжаа, лхадандэво хамбын төлөөлөгчид , Брайбун гомон ордосын намжилдорж, гавж Лүдэвжамц, Равжүнлуvsанноров, халхаас ирсэн амбан сэцэ тэргүүн аврал айлдгасанд түшиглэн Лүдэвийн гэгээн, Дүвни балму нарын зохиосон хятад номлолоос үндэслэн Гэндэнжамц ламын “Амгаланд оршихийн бүтээлийн арга” судраас голчлон авч, чимэглэн шагжаан тойн гэлэн Далай лам Галсанжамц бээр Арьяабалын ордон Поталын өргөөндөө зохиов.

МААНИЙН ТУС ЭРДЭМ

Маань өгүүлсэний тус эрдмээр гурван цагийн Амгалан залрагсадын тааллын хувилгаан, бурхан бүгдийн энэрэл нигүүлсэхүй дүрсэнд ургасан хутагт мэлмийгээр дурайтал болгооч Жанрайсаг бурхан мөн агаад огторгуй сацуу амьтны тус хэргийг бүтээн үйлдэгч мөн болой хэмээн Нан-ва таяа бурхан зарлигдаад орой түүн дээр Гэрэл машид түгээхүй нэрт самадид тэгш агуулан сууж бодьсадва нугуудын манлай их нигүүлсэлт хутагт Жанрайсиг бурхнаа амьтны тусыг зохиохын авшгийг соёрхжээ. Жанрайсиг бурхны энэрэл нигүүлсэхүйн эрдэм агуу, зүрхэн тарни **УМ МА НИ БАД МЭ ХУМ** болой. Түүний алдрыг өгүүлэх бөгөөд тогтоол тарнийг урьснаар тоолшгүй хилэнц арилж буян хэмжээлшгүйг хураан үхвээс Сугавадын оронд төрнө, гал, ус, салхины аюулаас аврагдана. Жанрайсаг бурхны нэрийг мэдэх хэнийг ч бол бусад бээр уурын сэтгэлээр харж хөнөөлийг үйлдэж чадахгүй. Хутга мэс, хулгай дээрмийн аюул хүрэхгүй. Түүний алдрыг дуудан мөргөснөөр хүсэл тачаал, уур мунхагаас хагацана. Охин, хүү алийг хүсвээс тэр нь заяана. Гольт тоот амьтан хэмжээлшгүй зовлон эдэлж буйг болгоогоод гэтэлгэж чадах болой хэмээн сударт зарлигласан.

Маанийн тус эрдмийн талаар XIV Далай багш:

Маанийн утга ба бурхныг эрэх хэрэггүй. Маанийг тоолж унших маш сайн. Унших үедээ утгыг нь маш сайн сана.

-**УМ** үсэгт **А,У,М** гурван үсэг багтах бөгөөд энэ нь эхлэн суралцагчийн арилаагүй бие, хэл, сэтгэл, хийгээд бурханы лагшин, зарлиг, таалал гурвыг билэгдэнэ. Бие хэл сэтгэлийн арилаагүй чанаруудыг дэс дараалан тэвчиж орхиод ариун чанарт болохыг маанийн дараагийн дөрвөн үсгээр билэгдэнэ.

-**МА НИ** нь чандмань эрдэнийг илэрхийлэх утгатай. Эрдэнээр аргын тал болох асрал, нигүүлсэл, бодийн сэтгэлийг билэгддэг. Чандмань эрдэнэд үгүйрэл хоосролыг арилгах эрдэм хүч байдаг шиг бодийн сэтгэлд сансар нирвааны доройтол бүхнийг арилгах хүч байдаг. Чандмань эрдэнэ ахуй үесийн горил хүслийг хангадаг шиг бодийн сэтгэлээр ашдын хүслийг биелүүлж болох юм.

БАД МЭ хэмээх хоёр үсэг лянхуа цэцгийг илэрхийлэх утгатай. Лянхуа цэцэг шавраас ургадаг ч шаврын гэмээр халдаагдаагүй байдаг шиг оюун билэгт ч харш буруу бүгдээс ангижрах хүч бий. Билэг үгүй бол гэм бүхэн үүснэ. Үхэл мөнх бусыг онох, хоосон чанарыг онох зэрэг, олон билэг ухаан байж болно. Маанийн сүүлчийн **ХУМ** үсэг өөрийн гэмийг арилгахад арга, билэг хоёр

ялгалгүйд, магадлалтай шүтэх хэрэгтэйг илэрхийлдэг.Маань бол арга билэг хоёр ялгал үгүйн хослог барилдсан бодь мөрийн дадлагад тулгуурлан өөрийн ариун бус бие хэл сэтгэл гурвыг бурханы мөн чанарт урвуулах боломж байгааг харуулж байна. Бурхны хутгийг гаднаас эрэх хэрэггүй, түүний мөн чанарыг бүтээх уг шалтгаан буюу үр хөрөнгө бүгдийн үндсэнд байдаг юм хэмээн айлджээ.

УМ үсэг ёзоорын нисваанис буюу мунхаг хийгээд тэнгэрийн ертөнцийн зовлонг арилгаж дээд шид бүтээлийг олж өглөгийн барамидыг төгсгөхийн,

МА үсэг ёзоорын нисваанис буюу уур хийгээд асурын зовлонг арилгаж нийтийн шид бүтээлийг олж шагшаабадын барамидын төгсгөхийн,

НИ үсэг харамын сэтгэл хийгээд хүний зовлонг арилгаж өвчин ад амирлуулах шид бүтээлийг олж өглөгийн барамидыг төгсгөхийн,

БАД үсэг шунал тачаал хийгээд адгуусны зовлонг арилгаж нас буян арвижуулах шид бүтээлийг олж хичээнгүйн барамидыг төгсгөхийн,

МЭ үсэг атаа хийгээд бирдийн зовлонг арилгаж бусдыг эрхэндээ хураах шид бүтээлийг олж самад дияаны барамидыг төгсөхийн,

ХУМ үсэг тамын зовлон хийгээд омгийг арилгаж тотгор бүгдийг гэсгээх шид бүтээлийг олж билэг барамидыг төгсгөхийн эрдмүүдтэй.

УМ МА НИ БАД МЭ ХУМ нь Чандмань эрдэнэ хийгээд лянхуаг баригч та нь би хийгээд хамаг амьтанд асрахуй, нигүүлсэхүй, бодийн сэтгэлийг үүсгэн соёрх хэмээн урин дуудаж байгаа болой. **УМ МА НИ БАД МЭ ХУМ**-д бурханы хамаг ном хийгээд амьтаныг зовлонгоос гэтэлгэх арга агуулагддаг. Маанийн зургаан үсэг бурхан бүгдийн мөн чанараас илүү. Илүү нь юу вэ гэхээр гурван ялгавартай. Энэ нь хүнээр заалгалгүй сурдаг, мартагддаггүй, би их юм мэдсэн хэмээн омог төрдөггүй юм. Иймээс нийт даяараа өдөр бүр дор хаяж гурав уншиж байхад хичээвээс зохистой гэдэг .Бүтээвээс ач тус нь санаанд багтамгүй их. Маанийн ариун шимийн дээд утга нь тонилохуй мөн. Маань бол арга билгийн дээд нэгтгэл гэдэг.

Маанийг тоо хурааж унших: Эрхиний нэг ширхэгийг эргүүлэхдээ маанийг бүтнээр нь уншина. Дүнчүүр маань унших, бумши хийж уншихын тус эрдэм хязгааргүй. Дүнчүүр гэдэг нь монгол тооны нэрээр арав, зуу, мянга, түм, бум, сая, живаа,

дүнчүүр гэх буюу зуун саяыг хэлнэ. Тоо барьж унших нь тоогоо гүйцээж таслахгүй унших зэргээр маанийг бүтээл болгоход тустай.

Маанийг олууллаа, ая дантай унших: Маань хөгжөөн олуулаа ая дантай уншихад далайд нэгэн дусал ус хийхэд тэр далай барагдах хүртэл тэр дусал байсаар байдгийн адил олууллаа буян хийхэд олны буян хэзээ хүртэл оршино тэр хүртэл байх юм. Ганцаар үйлдсэн буян галавт оршивч нэгэн уурын төдийн шатаж алга болдог гэдэг. Тиймээс зориулга ерөөлийг сайтар тавьдаг ёстой.

Маань бүтээсний буян: Маанийн дарцаг, хүрд бүтээх, хад чулуун дээр бичсэнээр маш их буян хураадаг.

Маань унших үеийн бодол бясалгал: Маанийн тус эрдэмийг санан зовлонтой амьтан бүгдийн эгээрэл хүсэл бол амгалантай учрах мөн тул эдгээр амьтан бүгдийн эгээрэл хүсэл бол амгалантай учрах мөн тул эдгээр амьтанд туслах нь миний үүрэг байх ёстой хэмээх сэтгэлийг үүсгэн Бүх амгалан, эрдэм увидас, гэгээрлийн эх булаг болсон хамаг амьтан бол миний хамгийн дотно төрөлхтөнүүд юм. Эдгээр амьтаныг зовлон хийгээд зовлонгийн шалтгаанаас хагацуулж энэрэл нийгүүлсэлийн бурханы хутагт хөтлөх ёстой. Үүнийг ёсчилон бүтээхийн тул би өөрөө энэрэл нигүүлсэлийн бурханы тарнийг бүтээхийн төлөө, хэрэв би бодийн сэтгэл эртхэн төрүүлсэн бол надтай үйлийн барилдлагатай олон амьтан бодийн хутагийг олох байсан. Би өөрийгөө энхрийлэх болон миний хэмээх барих үзлээр хүлэгдсэний улмаас эдгээр амьтан зовж байна. Иймд бодийн бэлтгэлийн үндэс болон энэрэл нигүүлсэлийн бурханы бясалгалыг бүтээе...гэхчилэн олныг бясалгаарай. Монголчууд эртнээс нааш гэр хотол, ахан дүүс, багш шавь бултаараа сууж буянаа арвижуулан, маанийг аялгуулан хөгжөөдөг байсан сайхан уламжлалтай билээ. Монгол орны газар газарт олон янзаар маань хөгжөөдөг агаад энэ удаад монголд нийтлэг түгэн тархсан мааниудаас цөөн хэдийг багтаав. Уншигч та буянаа арвижуулан маань хөгжөөгөөрэй.

ХАТУУЖИЛ САХИХЫН ЁС

Монголчууд нүгнай сахихаас их буян байхгүй, түймэр тавихаас их нүгэл байдаггүй гэж ярьдаг. Нүгнай гэдэг нь Чилэн зовох гэсэн утгатай үг байна. Нүгнайг лам хуврагууд хүрээ сүм хийдэд болон гэр орондоо ч сахидаг байсан хурал ном юм. Хурлын гол утга нь нэг өдөр хоол унд идэлгүй өлсөж ундаасан бирдийн зовлонг өөрийн биед авч зовлонгоос гэтэлгэх их нигүүлсэнгүй сэтгэлийг үүсгэдэг. Мөн нэг өдөр үг дуу гаргалгүй адгуусны зовлонг мэдэрч, адгуусны зовлонгоос гэтэлгэх их бодь сэтгэлийг үүсгэдэг. Харин гурав дахь өдөр нь халуун хүйтэн тамын зовлонг өөрийн биед мэдэрч тамын амьтдыг тамаас гэтэлгэж их нигүүлсэхүй сэтгэлийг үүсгэдэг. Ингэж хурал хурснаар гурван муу заяаны амьтдыг зовлонгоос гэтэлгэх төдийгүй тэнгэр, асури, хүнийг зовлонгоос гэтэлгэх Жанрайсэг бурхны үүднээс үйлддэг хурлын зан үйл, уншлага юм. Нүгнайг нэг удаа үйлдэх буюу түүнд даган баяссаны буянаар дөрвөн түмэн хилэнц ариусаж тэнгэр хүмүүний дээдийг олно. Мөн дараа төрөлдөө там, бэрд, адгуусанд үл төрж зүс царай сайтай, яруу дуу хоолойтой, ухаан саруул нэгэн болно гэж айлджээ.

Хураангуй маанийн иш өгөхүй

Гэмээр эс хиртсэн лагшингийн өнгө цагаан
Туулсан бурханаар тэргүүндээ чимэгт
Нигүүлсэхүй мэлмийгээр амьтнаа болгоогч
Нүдээр-Үзэгч дор өчирлөгийг талбимуй.

“УМ МАНИ БАДМЭ ХУМ”

Буян үүгээр түргэнээ би
Эрхэт Нүдээр-Үзэгчийг бүтээх болж
Нэг ч амьтныг хоцроолгүй
Түүний газарт байгуулах болтугай.
Таныг магтаад өчин залбирсны хүчээр
Би тэргүүтэн хаана оршсон газрын зүг тэнд
Өвчин, үгээгүй, хэрүүл, тэмцэл амирлаад
Ном хийгээд өлзий хутаг дэлгэрэх болгон адистидла.

ИХ АРЪЯАБАЛ БУРХАНДАА ТАХИЛ ӨРГӨХҮЙ

Ялж төгс нөгчигсөн, тэгүүнчлэн ирэгсэн, дайсан бүгдээ амирлуулагсан үнэхээр тугуулсан их нигүүлсэхүйн Аръяабал бурхандаа нийт монгол туургатны өмнөөс бие хэл, сэтгэл бээрээ мөргөн тахин номончилмой. /Здахин/

Түнжинт ардын минь бүтээл түвшин төрийн минь шүтээн та болгоон соёрхоо.

Сүү өргөхүй

Асрал энэрэлийн дээд
Аръяабал бурхандаа
Алив муу үйл хийсэн бол
Ард түмнийхээ өмнө наминчилж
Ариун цагаан сүү өргөсний
Агуу буян хүчин еэр монгол түмэн
Ашиддаа аюулгүй амгалан байх болтугай

Тараг өргөхүй

Энэрэл нийгүүлсэхүйн дээд Аръяабал бурхандаа
Элгэн цагаан тараг өргөсний
Энгүй буянаар эх болсон монгол түмэн
Эмгэг хууч өвчингүй эрүүл мэнд байх болтугай

Хоормог өргөхүй

Хүч бүхэн төгөлдөр Аръяабал бурхандаа
Хоормог хэмээх ундаа малын буяныг
Харам үгүй сэтгэлээр өргөсөн монгол түмэн
Хил, хэл, мал гурваасаа үл хагацах болтугай

Ундаа өргөхүй

Ач бүхэн төгөлдөр Аръяабал бурхандаа
Айраг хэмээх ундаа өргөсний
Алив буян еэр монгол түмэн
Ам цангах, өлсөх зовлон амирлах болтугай

Цэцэг өргөхүй

Үнэхээр тугуулсан Аръяабал бурхандаа
Үр тарианы охь цэцэг өргөсний хүчин еэр монгол түмэн
Үржилт түмэн бодис ургаж
Үйлс сайн бүгд дэлгэртүгэй.

Үнэртэн хүж өргөхүй:

Шагшаа бодийн явдалт Аръяабал бурхандаа
Сайхан үнэрт хүжэс өргөсний хүчин ээр монгол түмэн
Саар муухай бузар дэвээс өнөд хагацаж
Сайн мөрийн зам лугаа учрах болтугай

Зул өргөхүй:

Мөнхийн гэрэлт Аръяабал бурхандаа
Мунхаг харанхуйг гийгүүлэх зул өргөсний ачаар
Монгол түмний оюун ухаан
Машид бадрахын өлзий орших болтугай

Нанчид өргөхүй:

Нигүүлсэхүйн туйл Аръяабал бурхандаа
Нанчод хэмээх унааны дээдийг өргөсний хүчин ээр
Нийт монгол түмэн олон
Нийгэм даяараа шидэс бүтээл олох болтугай

Тахилын идээ өргөхүй:

Энэрэлт Аръяабал бурхандаа
Идэж уухынхаа дээдийг өргөсний хүчин ээр
Эх болсон хамаг амьтан
Идээ ундаагаар тасрахгүй байх болтугай

Дуу өргөхүй:

Жаран эгшиг төгөлдөр Аръяабал бурхандаа
Яруу зохист хөгжим өргөсний агуу хүчин ээр
Цээл хоолой нь тэнгэрийн эгшиг шиг
Цэнгэл жаргалаар өнөд мандтугай

ДАГАН ХЭМЭЭХ БЭЛТГЭЛ ӨДӨР

ИТГЭЛ- Бурхан ном хийгээд чугуулганы дэгээд дор бодийн хутагийг олохуй хүртэл би бээр итгэмой (3 удаа уншина).

Миний өглөг тэргүүтэн эдгээр еэр хамаг амьтаны тусын тулд бурхан бүтэх болтугай. (3 удаа уншина).

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай. Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийнг шалтгаан лугаа хагацах болтугай. Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай. Хамаг амьтан ойр хол уурлах дурлахаас хагацаж тэгш дор орших болтугай.

ГАНДАНЛХАВЖАА-Буюу төгсбаясгалант зуун тэнгэр

Намо Гүрү Манзугохаяа

Төгсбаясгалантын зуун тэнгэрийн итгэлийн зүрхнээс

Маш цагаан шинэ тараг овоолсон мэт үүлийн үзүүрт

Номын хаан Бүхнийг айлдагч Сумадигирди

Хөвгүүд лугаа сэлт энэ орноо залран соёрх

Өмнийн огторгуйд арслант ширээ, лянхуа, сарны дээр

Гэтэлгэгч лам баясгалангийн цагаан мишээлтэй

Миний оюун сүсгийн буяны дээд орноо

Шашныг дэлгэрүүлэхийн тулд зуун галавт оршин соёрх

Мэдэгдэхүүний эн бүхнийг мэдэгч оюун таалалтай

Сайн хувьтын чихний чимэг болсон сайн

номлол зарлигтай

Алдаршлын цогоор үлэмж үзэсгэлэнт лагшинтай

Үзэн, сонсох, дурдахуйн хэргийг төгсгөсөнд мөргөмүй

Сэтгэлд зохистой элдэв тахилын усан, цэцэг хийгээд

Анхилуун үнэрт хүж, зул, үнэрт усан тэргүүтэн

Бодьтой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан тахилын

үүлэн далай үүнийг

Буяны орны дээд тан дор тахил болгон өргөө.

Алин бээр тэргүүлэш үгүй цагаас хураасан

Бие,хэл,сэтгэл нүгэл юун үйлдсэн хийгээд

Ялангуяа гурван санваарын үл зохилдохуйн зүгүүдийг

Зүрхнээс хатуу гэмшлээр тус тус наманчилъя

Цөвүүн цаг үүнээ олонтаа сонсоод бүтээл дор хичээн

Найман номыг тэвчихээр чөлөө учралын хэргийг хийсэн

Итгэл таны ахуй их зохионгуй дор

Ба бүрэн саналын угаас даган баясмуй.

Гэтэлгэгч лам дээдэс та нугуудын

Номын биеийн огторгуйд айлдал энэрлийн үүлний
үзүүрт
Ямар мэт зохистой номхотгогдохууны газар дэлхийд
Аяндаа бүтсэн номын хурыг буулган соёрх.
Би бээр хэдий чинээ хураасан буян үүгээр
Шашин амьтан бүхнээ алин туслах хийгээд
Ялангуяа Гэтэлгэгч Сумадгирдийн
Шашны зүрхэн өнөд гийгүүлэх болтугай

МОНГОЛ ОРНЫ САН

Би ямагт нэгэн эгшин дор нэг нигуурт хоёр мутарт Арьяабал
бурхны дүрийг эрхшээмой.

Ариусгалын тахил балин гадаад дотоод нууцын
Агуу сүсэгтнүүдийн мөнхийн мэлмийг дүүрч
Цувралтгүй бэлэг билгийн рашааны усан далай
Цалгилан давлах тахил мэт болтугай.

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа агуу хүчит бүрэг хангай хийгээд
Алдарт бүрэн Орхон Сэлэнгэ мөрөн
Асарлах уул урсах ус бүхнээ оршсон
Ачит их навдаг шавдаг бүгдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Онон Алтай хавийн их уулс ус
Олноо алдартай Увс их арал тэргүүт
Ихэнх уул усан бүхнээ оршсон
Илч этгээдийн хамаг шадвагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хэнтий улаан сүрэг болон
Хэрлэн Туул Хөлөн тэргүүт
Догшин уул усан бүхнээ оршсон
Дорно зүгийн шавдаг бүхнийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа

Умар зүгийн монгол орны их сүлдэн тэнгэр
Уул хангай ханы дөрвөн их тэнгэр
Эх хөвгүүн гадаад дотоод түшмэл
Элчис үйлчний нөхдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Бас бус дөрвөн зүг найман зовхисын
Бараантан шовхрох их хайрхан
Ус гол их мөрөнд оршсон
Улс орны тэнгэр шавдаг хамгийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Ялангуй ба бүрний нөхөр сэлт
Ямарваа шүтээн мөр үйл хамаг гуравнаа
Алинд ч оршсон энэ зүгийнхээ
Алдарт орны тэнгэр хамаг шавдагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хангай ханы аймагт харъяалагдсан
Хань болох Идэр Тэрх хоёр
Хас өлзийт Цагаан нуур Чулуутын
Хамаг шавдаг орны тэнгэрийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Даллага авах

Хоёр түүтгэрээс ариуссан номын шим
Хэлбэрэлт үгүй бат бүхний суурь
Өндөр үгүй бат бүхний суурь
Өнөөдрийн идээр даллан авъяа

Хурай Хурай Хурай

Ариун огторгуйн төв хүчнээс
Алаглах солонго зуран хээлсэн мэт
Өмнүүрхэн ургах хишиг бүгдийг
Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Асар арвин төгс долоон эрдэнээр
Аварга их тивүүдийг эрхшээгч
Өнхрөх хүрдийг эрхшээгч хишгийг
Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Олноо өргөгдсөн хаанаас эхлээд
Оргил эхт Гангын урсгал мэт
Өнөд үргэлжлэх хишиг буяныг
Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Гурван сургаалын ёзоорыг баригч хөвүүн
Гунхашгүй мөчрийн үзэсгэлэнт нахиа
Хоёр зэргийн эцэст хүрсэн үрээр
Хосгүй үзэсгэлэнт төгс номын хишиг ба
Үхлийн эзний аймгийг ч ялсан
Үхэлгүй бүтээх насны хишиг
Өнөд оршоох буян заяаг ч
Өнөөдрийн идээр даллан авмуй

ДАШ БУЮУ ӨЛЗИЙ ОРШООЛГО

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр
Шашныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч
Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон
Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай
Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад
Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба
Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг
Зүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай
Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд
Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд
Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад
Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай
Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санасанаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистэдлэн соёрхоо
 Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
 Эс төрсөн нь төрөх болтугай
 Эрт төрсөн нь доройтолгүй
 Дээш дээш арвижих болтугай
Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай
Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтаны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин, ад, хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ
Эцэг, эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод
Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршоноор
Өглөгийн эзэн нөхөр сэлт нүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай
Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай

Бишрэнгүйгээр мөргөж, тахиж наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой
Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт арвижиж
Хориг гэм үгүй язгуурын явдал үргэлжид тасралтгүй
Хоног өдөр бүхэнд Зонхабын шашны номын дуу дуурсаж
Хотол чуулганы цогоор цэнгэхийн өлзий хутаг орштугай.

ГЭГДОР БУЮУ СААД ТОТГОР УЧРУУЛАГЧДАД ӨРГӨХ ТАХИЛГА.

Нэгэн агшинд би бээр гурван ертөнцийг эзэгнэх хилэнт дүрийг
эрхшээмой.

Өөрийн таалалын ХУМ үсгээс гэрэл цацарч хилэнтийн
чугуулганыг урин залж өмнийн огторгуйд оршоомой.

УМ -БАЗАР –МАХА- ГОРДО- РАЗА- СА-ВА-РЭ- ВА-РА-
БАЗАР-СА-МАЯ –ЗА-ЗА

ХУМ –

Билиг билгийн галтгуу бадран очлоод
Бараан мунхаг хүсэл бүгдийг шатаагаад

Уурт хилэнт аюул бүгдийг дарж

Ухаант баатар алдраа дурсгаж

Буруу тэрсүүдийг барин номхотгож

Бурханы язгуурт дийлэн мөргүүлж

Номхорсон тэрсүүдийг дахин залж

Ном ёсчилон тахил өргөмү

УМ-БАЗАР- МАХА –ГОРДА- РАЗА- СА-ВА-РЭ –ВА –РА-
САДА-ГАРАМ- АРГААМ –БРАЙДИЙН –ЗА –СУХА

Дахин зүйж уншихуй

АРГААМ ,БААДЭЭМ,ВҮСБИ,ДҮЙВИ, АЛОГЭ, ГАНДЭ,

НЭВДЭ, ШАВДА БРАЙДИЙН ЗА СУХА

Магтал ануу

ХУМ

Хоосон чанар хоёр үгүйн агаараас

Хорвоогийн явдлыг ёсчилон гүйцээгч

Арга мэргэн аюунгүй лагшинг

Авир сүрээр бадраагчид мөргөмү

Билгийн амгалан тогтвортойн агаараас

Бүхий л лагшин бөх бат хүчтэй

Зарлагын лууны хүрхэрэх дуунаар
Зөвхөн эрхэндээ хураагчид мөргөмү
Хосгүй билгийн авъяасаар цэнгэж
Хорт мэс элдвийг гартаа барин
Муу сэтгэлийг үндсээр нь таслагч
Могойн хороор цэнгэгчид мөргөмү
Галавын гал мэт бадарсан хорвоогоос
Гайхамшигт баатар мэт хөлөөр бүжигч
Нар сар бадарсан мэт хилэнт мэлмийгээр
Нааш сөрөгчидийг номхруулагчид мөргөмү
Дотоод энергээ гал мэт бадрааж
Дохих цахилгаан мэт соёо нь гялалзаж
Аймшигт луу мэт архиран дурсгагч
Аюултайг номхотгогч таныг магтая
УМ-БАЗАР-АМРИТА-ХУМ гэж *ариулаад*
УМАА –САВАВА- ШҮДЭ-САРВА –ДАРМА-САВАВА –
ШҮДЭ-ХУМ гэж *арвидуулаад*

Хоосон чанарын агаарт УМ үсгээс гарсан их эрдэнийн сав агуу уужим нугуудын дотор УМ үсэг гэрлэн дор шингэснээс тэнгэрийн зайгаар бүрдсэн балин идээ тунгалаг их амгалантай үүдэх болмой.

УМ-АГАРОМУ-ХАМ-САРВА-ДАРМА-НАМ-АДЪЯА-НҮДВА-НАДДАМ-УМААХУМ-СУХА гэж *гурав уншиж адислаад*

Өөрийн таалалын ХУМ үсгээс гэрэл цацран хатууд оршихуйн зан үйлд хориг саад болох бүгдийг өмнөө авчирмой.

УМ-САРВА-ВИГНА-НАМА-САРВА-ДАТА-ГАДА-ВО-ЮУ ВИ-ШҮ –МҮХИ-БА-ЯА –САРВААН-ДАДХАМ-ҮДГАДЭ-ВАРАНА –ХЭМ-ГАГАНА-ХАМ-СУХА

гэж гэгдэрийг өөр лүгээ харуулан барьж нар зөв гурав эргүүлэн таринаа гурав уншина.

УМ - СУМВАНИ –СУМВАХАМ-ГЭРХАНА-ГЭРХАНА ХУМ – ГЭРХАНА-ВАЯА-ГЭРХАНА-ВАЯА- АНА-ЯАХА –ВАГА ВАНА-ВИДА –РАЗА-ХУМ-ПАД гэж *гэгдэроо цааш харуулан нар буруу гурав эргүүлэн таринаа гурав уншин гаргана.*

Хот мандалыг газарт байгуулж
Хосгүй бурхадыг бүгд сонсон
Сахих үед маань саад бололгүй
Салаж одмой өөр газарт

Бурханы зарлигийг эс дагваас
Билигт очир бадарсанаар
Бүгдийн толгойд мэс хүрвээс
Бүртийх ч зүйлгүй болохыг санаарай

УМА-СҮМВАНИ –СҮМВАХАМ-ГЭРХАНА-ГЭРХАНА ХУМ –
ГЭРХАНА-ВАЯА-ГЭРХАНА-ВАЯА- АНА-ЯАХА –ВАГА ВАНА-ВИДА
–РАЗА-ХУМ-ПАД

Гэж гүгэл үнэртүүлж ,юунгар цацаад хонх дуугаргана.

Дээр дор зүг бүхэнд очирлож
Дэргэд таван өнгийн гал мэт бадарч
Зай завсаргүй хүрээлэн битүүлж
Зангидсан хорлон хүрээнээс бүү хэтэр

УМ-БАЗАР-РАГЧА-РАГЧА

ХАТУУД ОРШИХҮЙН ЗАН ҮЙЛ БУМБА БҮТЭЭХҮЙН ЁСОН

*Бэлтгэл ануу цорготой лай бумба сайтар угаан гүгэлээр
утаад юунгар цацаж УМ-БАДМАНДА-ГЭРДЭ-ХУМПАД
-хэмээн тарина өгүүлэж ариулаад бадма наран дэвсгэр бээр
байрлуулж бумбаны тэмдэг зүүх буюу зураад хүзүүгээр нь уях ба
УМ-БАЗАР-ЖИХА-РҮДА-МА-ДЭ-ШАМБАНДА-ХУМ- хэмээн
будаа цацна.*

*Адуу үхэр илжиг тэргүүтэн яваагүй цэвэр ус дэвсангаар
ариулан 25 зай хийж бумбаа дүүргээд өөр лүүгээ харуулж тавиад
өмнө нь тахил тавьж дүнчой нд рашаан хийж дээр нь сунтаг
очир тавина.*

Уншлага нь.

УМ-БАДМАНДА-ГЭРДЭ-ХУМ гэж ариулаад,
УМ-САВАВА-ШҮДЭ-САРВА-ДАРМА-САВАВА- ШҮДЭ-ХАМ

Бумба-хоосон чанарт оршоод хоосон чанарын агаараас
БАМ-үсэгнээс их эрдэнийн цагаан бумба ходоод томтой хүзүү
урттай, амсар дэрвэгэр, тэргүүтэй бумбаны тэмдэг төгөлдөр
болмой.

УМ-ДАДЭ-ДАДЭ-МАХА-ДАДЭ-СУХА. Ганга мөрөн тэнгэрийн
рашаан бумбын рашаантай ялгалгүй болмой.

Бумбын дотор тэмдэгийн оронд элдэв цэцэг нарны хот мандалын дээр –ХЭРЭ-үсгээс омогт ДАМДИН бурхан улаан лагшинтай нэг нигүүртай соёо ихээр арзайсан гурван мэлмийтэй, үс гээг дээш босон бадарч тодорсоны төвөөс ногоон морин толгойтой. Хоёр мутартай баруунаараа бадам цэцэг бэлгэдэн барьсан,зүүнээрээ зүрхэн тушаа дэгзүвийн мутарлагтай, чимэгт тодвотой. Барын арьсан хормогчтой баруун бойвоогоо хумисан зүүнээ жийсэн галбадарсаны төвд оршиж тэгүүний оройд УМ-цагаан үсэг, хоолойд “А” улаан үсэг,зүрхэнд хум хөх үсгээр гэрэлтэж таалалаас хэрэ-үсэг гэрэл цацран өмнийн огторгуйд залрах Арьяабал бурхан залрагтун.

УМ-САРВА-ДАТА-ГАДА-ВАДЭМ-БАРАИДИИНЗА-ХУМ-СУХА-АНЗАМАНАМ-

АРГАМ-

БАДЭМ-

БҮСБИ-

ДҮЙВИ-

АЛОГЭ-

ГАНДЭ-

НЭВДЭ-

ШАВДА-барайдийнза хум суха

Өмнийн Арьяабал өөрийн бие дэх бурханд уусах болмой.

УМ-САРВА-ДАТА-ГАДА-АРГАМ-БРАЙДИЙН ЗА СУХА

БАДЭМ-

БҮСВИ-

ДҮЙВИ-

АЛОГЭ-

ГАНДЭ-

НЭВДЭ-

ШАВДА-

Аюулт цагийн гал мэт бадарсан лагшинт

Архиран хүрхэрэх аялгуут зарлигт

Асрал энэрэлийн жишэхэд бэрх таалалт

Аржал омогт дамдин бурханд мөргөө.

Хэмээн магтаад

Ум базар амрида удга та хум умаа хум-7 удаа тоолоод

Дүнчой буюу бумбаны амсар дээр адислах дунгын билиг билгийн рашааны мөн чанартай очирын тоос шиг маш нарийн байдалд оршмой

хэмээн дүнчойгоо жанлавлана

”хум” хэмээн сүнтогоос зүүн гараар барьж баруунаар эрхээ

тоолон-

өөрийн таалалаас гэрэл цацрах сунтагийн утас эрчлэн бумбан доторхи тэнгэрт дамжигдан тэдгээрийн таалалаас тарины эрхэн хөвөрч гэрэлтэн цацарч бурхан бүгдийн адистидийн хүчээр билгэ билгүүний мөн чанартай болж бумбын усанд шингэмой

гэж бодоод-

ХЭРЭ-ВАЗАР ГОРДО ХАЯНХИРВА ХҮЛҮ ХҮЛҮ-ХУМ-ПАД-
болон

УМ-БАДМАНДА-ГЭРДА-ХУМ-ПАД-*гэж 108 тоолж, игжа*
Бадамсаду, тарина уншина.

УМ-БАДМА-САДУ-САМАЯ-МАНУ-БАЛАЯ-БАДАМ-САДУ-ДЭН
ЭИВА ДЭСТА-ДЭРДА-МИВА-СУДАХИ, МИВА-СУХИ-МИВА-
АНУРАГДА САРВААН СЭДЭ-МИВАРЯЦИМА САРВА-ГАРМА-
СҮЗЭМИ-ЗЭНДИН ШРИ ГҮРҮ ХА-ХА-ХО-САРВААН-ДАТА-ГОДА-
БАДАМ-МАМИ МУНЗА БАДАМ МАХА САМАЯ САДУУН А-ХУМ.

Сунтагаа хураагаад:

ХУМ-гэж 7 уншаад дүнчойгоос бумбанд Аргам өргөөд

УМ-БАДМАНДАДЭ ХУМПАД-тоолоод Бумбанд цагаан цэцэгэ

3н удаа өргөөд

УМАА-САРВА-ДАТА-ГАДА-БҮСВИ

ДҮЙВИ

АЛОГЭ

ГАНДЭ

НЭВДЭ ШАВДА

БРАЙДИЙН ЗА СУХА

гээд лай бумбаа барин хот мандалыг нар зөв тойрно.

УМ-БАДМАНДАГЭРДЭХУМ ПАД

Хязгааргүй орчлонгийн хот мандал орох үйл гүйцээгүй нугуудын дотор саад арилж үйлсийг дэлгэн зохио.

Бумбан дах тэнгэр билиг билгийн мөн чанартай оронд заларч, тангарагтан гэрэлд шингэн бумбын ус лугаа амт нэгэн болж, тэмдэгт тэнгэр гэрлэнд шингэн мутарын тэмдэгийн байдалтай болмой.

ТҮЙ БУЮУ УГААЛ ӨРГӨХҮЙ

Тэгүүнчилэн ирэгсэн бурхан бүгд бээр надад илт авшиг
хайрлан соёрх хэмээбээс бурхадын таалалаас гойгарму буюу
цагаан баринтагт тэнгэр тэргүүт охин тэнгэр нугууд бээр рашаан
дүүрсэн Бумба бариад-

Тэр мэт бурхан мэндэлмэгц
Тэнгэр нугууд угаал өргөсөн адил
Тэнгэрийн ариун рашаан дор
Тэгүүнчилэн би бээр угаал соёрхоё

УМА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-А-ХУМ
ТҮЙ буюу угаал өргөхүй

Бурханы лагшин зарлиг таалал хир үгүй ч
Бусдын бие хэл сэтгэлийг ариулахын тухайд
Бурханы лагшинд угаал өргөснөөр
Бүхий л хүмүүний сэтгэл ариустугай

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Огоот төгс лагшинт тан дор
Орчлонгийн хүлээс үгүй ч гэсэн
Адаг биднийг ариулахын тухайд
Ариун усаар соёрхол өргөө
УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Эрхэм бурхан шавь нугуудад
Эрдэнийн бумбандах ариун усаар
Сэтгэл зохисоор дүүргэх лус нь
Силнэнгийн дуутай хамт угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Өглөгийн чанарт энэ усаар
Өөдгүй харамын хирийг угааж
Өгөгдэхүүн болсон цэвэр усаар
Өөр бусдад угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Шагшаабодийн чанарт усаар
Шантрах муу гэмээ ариулаад
Сахилын цэвэр энэ усаар
Сахиагүй бүгдэд угаал өргөмү

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Тэсвэрийн чанарт энэ усаар
Тэсэшгүй уурын гэмээ ариулаад
Асралын чанарт энэ усаар
Амьтан бүхэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Хичээлийн чанарт энэ усаар
Хойшлуулахын залхууг арилгаад
Хичээнгүйн цэвэр рашаанаар
Хотлыг шамдуулах угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГУЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Самадийн чанарт энэ усаар
Саад алгасрал гэмийг арилгаад
Бясалгалын үнэрт энэ усаар
Бясалгаагүй түмэнд угаал өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГУЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА
Ухааны чанарт энэ усаар
Ухаараагүйн гэмийг арилгаж
Увидаст энэ рашаанаар
Ухааны хур буулган өргөмой

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГУЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Угаалын дээд цог төгөлдөр
Таалал ханьцасгүй энэ усыг
Билгээр адислан рашаалсанаар
Бүгд хүсэл биелүүлж хайрла

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГУЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

МАНДАЛ ӨРГӨХ ЁСОН ОРШВОЙ

Орон дэлхийг өргөн айлтгомой.

Ум базар бүмэ-а-хум

Их эрхэт алтан дэлхий .

Ум базар рэ-хэ а-хум

Гадуур төмөр уулаар эргэн тойрон хүрээлсний төвд,

Уулсын хаан Сүмбэр уул, Дорноо үлэмжийн биет, Өмнөө Замбуу тив, Өрнөө Үхэр эдлэгч тив, Умараа Муу Дуут тив болон Биет хийгээд Үлэмж биет завсрын тив, Дохиурт хийгээд бус дохих завсрын тив, Хэлбэрэлт хийгээд Дээд мөрт зорчигч завсрын тив, Муу дуут хийгээд муу дуутын нөхөр завсрын тив, Э р д э н и й н уул, Галбарагча мод, Гаминдини үнээ. Эс тарьсан тутарга, Хүрд эргэнэ, Чандмань эрдэнэ, Хатан эрдэнэ, Түшмэл эрдэнэ, Заан эрдэнэ, Морь эрдэнэ, Баатар эрдэнэ, Их сангийн хумх, Үзэсгэлэнт эх, Эрхич эх, Дууч эх, Бүжигч эх, Цэцгэн эх, Хүжирч эх, Үнэртэн эх, Наран, Саран, Эрдэнийн шүхэр, Хамаг зүгээс сайтар ялгагч ялгуусны тэмдэг, Төв дунд тэнгэр хүмүүний хотол төгс цог учрал бүрдсэн эдгээрийг ачит ёзоорын ба дамжлага сэлтийн цог төгс лам дээдэс хийгээд, Итгэлт нигүүлсэнгүй Арьяабал нөхөр лүгээ сэлтэд өргөмүй. Их нигүүлсэнгүйгээр амьтны тусад таалан соёрхоо. Таалан соёрхоод би тэргүүтэн хамаг амьтныг адистэдлэн соёрхоо.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд

Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг

Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр

Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр

Шашиныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч

Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон

Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай

Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад

Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба

Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг

Зүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай

Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд

Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд

Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад

Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай

Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санасанаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистлэн соёрхоо.

Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
Эс төрсөн нь төрөх болтугай
Эрт төрсөн нь доройтолгүй
Дээш дээш арвижих болтугай

Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай

Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтаны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин,ад,хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ

Эцэг, эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод
Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршсоноор
Эндүүрэлгүйгээр тэдний ерөөл бүтэх болтугай

Өглөгийн эзэн нөхөр сэлт нүүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай

Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай

Бишрэнгүйгээр мөргөж, тахиж, наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой

Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт аривжиж

Охин тэнгэр чамд өчин залбирах нь
Насанд тотгордогчдыг амирлуулагч хийгээд
Өвчин зовлонууд бүгдээс хүчин төгөлдөр чи бээр авран соёрх

Дээд хийгээд ерийн хамаг шидсийг надад хоцрол үгүй
өршөөн соёрх

Гийгүүлэгч эх чамд сүслэн үйлдэгч түүнийг хөвгүүн мэт
асран өршөө

Би ч чамд өчин залбирснаар Нигүүлсэхүйн гохоор барин
соёрх

Охин тэнгэр нь саран мэт өнгөт
Өчүүрхэн номхотгосон дүр байдал лугаа төгссөн
Үлэмж биедээ хамаг чимгүүдээр чимсэн үзэсгэлэнт
Хэвийн хормогчоор хормогчилсон лянхуа саран
дэвсгэрийн дээр

Очирын завилалаар суусан Нэгэн нүүр хоёр мутарт
мишээхүй байдалт

Гурван цагийн бурхадыг үүсгэгч эхОхин тэнгэр чамд
насанд сөгдмүй

Чамайг хувийн төдий магтах нь Ба бүрэн бодь хутагийг
бүтээхэд

Энэ цагаас барьж бодь хутаг хүртэл Үл зохилдохуй
зүгнүүдийг амирлуулан

Зохилдохуй шалтгааныг хотол төгсгөн соёрхоо

Хэмээн гэтэлгээгч цагаан дар

Эхийн магтаал үүнийг богд Гэндэнжамц бээр зохиов.

АДИСТЫН ДЭЭДИЙГ ХАЙРЛАГЧ ЭХ

Адистын дээдийг хайрлагч ихэс багш нар болон
Авралын хурыг буулгагч амирлангуй ба догшин тэнгирс
Барцад бүхнийг арилгагч дагнис чойжин нугууд
Бишрэнгүй бээр бие сэтгэлээрээ мөргөн залбирья
Ариун сэтгэлээр бэлдсэн тахилын чуулганыг
Агуу огторгуйд дүүрэн түгээн дэлгэрүүлж
Алс хэтээс хурсан нүгэл хилэнцийг тэвчин
Аливаад дуурсагдах буяныг даган баясмуу

Асар дэлгэр номын хүрдийг эргүүлэн соёрхооч
Ачит тэр хүрд орчлонгийн эцэс хүртэл оршиг
Аяа үүгээр гийсэн буяны алив цогцос
Анхлан бүхний ухааныг гийгүлэн тэтгэж

Ашид билгийн гэгээг гэрэлтүүлэхээр зорь тугай
Мунхаг цагийн их харанхуйгаар бүрхэгдсэн энэлсэн
Муу заяаны туйлыг нигүүлсэнгүй сэтгэлээр авар
Үйлийн үрийн гасланг сэтгэлээр боловсорсон

Үнэхүү зовлонгийн их түймрийг намжааж
Өш хонзонгийн зовлонт сэтгэлийг арилган
Өрөвч ухааны гайхамшигт цогцос дэлгэрэх
болтугай

Аврагтун аврагтун үнэн итгэлт дээдэс минь
Болгоогтун болгоогтун их нинжийн сан минь
Эндүүрэл алгасралгүй эртний зарлиг сонс
Эхлэн таалан соёрхож авралаар түргэн тэтгэ

Ариун шашны гэрэл арван зүгт дэлгэрч
Амьтан бүхэн амгалангийн цогийг дуурсган
Алмад түүтгэрийг зогсоох билгийн хутгийг
Асар түргэн дэлгэрүүлж хайрла

Дээд гурван эрдэнийн адистэд хийгээд
Дээдийн номын урвалтгүй барилдлагааны хүч
Хүндэтгэн сүслэн сахих бидний үйлсээр
Хүсэл бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай
Аврал бүхнийг хураасан багшийн адистэдээр
Ахуй үесийн доройтол бүхэн амирлаж
Хорвоод сайн үйлс сүндэрлэн бүтэж
Хотлоороо цэнгэхийн өлзий орштугай

МАНЗ БУЮУ ЦАЙ УУХ

Уншлага нь
Авралын дээд Аръяабал бурхандаа
Амтат идээний дээдээ өргөмүү
Ашдын билиг бүхэн дэлгэрч
Адистэд жанлав орших болтугай

БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРЭХИЙН ЕРӨӨЛ

Баатар долоон бурханд мөргөмү
Амьтны тусд урьд би
Аль бэрх хатуужлыг эдлээд
Амар жаргалаа зориулсны хүчинд
Ариун шашин өнөд бадартугай

Өвчтөний тусд урьд би
Өөрийн амь амьдралын зольж
Үгээгүй амьтныг эмнэсний тулд
Үнэн шашин өнөд бадартугай

Эхнэр хийгээд хөвгүүд охид
Эд эрдэнэ, хөлөг хэрэгслээ ч
Эгнэгт гэгээрлийн төлөө зольсноор
Эрхэм шашин өнөд бадартугай

Эцэг, эх, ширвага, брадига
Энэрэлт бурхан, арш дээдэст
Эндэлгүй би вээр тахил өргөснөөр
Эрдэнэ шашин өнөд бадартугай

Олон сая галавт би
Онц элдэв зовлонг амсч
Оюун гэгээрүүлэх номыг эрснээр
Онол шашин өнөд бадартугай

Асар нарийн ёс журам
Аливаа хатуужлыг үргэлж сахин
Арван зүгийн бурхадыг тахиснаар
Аврал шашин өнөд бадартугай

Эргэж буцахгүй хичээл зүтгэлээр
Эсрэг хүчин бүхнийг ялж
Эндүүрч төөрөгсдийг аварсан тул
Эрдэмт шашин өнөд бадартугай

Хүлцэл тэвчээрийг үргэлж эрхэмлэн
Хөнөөлт сэтгэлийн өвчинд баригдсан
Хөөрхий дордсыг уучлан хайрласнаар
Хүндэт шашин өнөд бадартугай

Ганга мөрний хумхийн тоо шиг
Дээд түвшний дияан бясалгалыг
Гаргууд сайн эзэмшсэн тул
Гайхамшигт шашин өнөд бадартугай

Билиг ухаан нээхийн тулд
Бэрх хатуужлаар аглагт сууж
Бичиг шаштир судалсны хүчинд
Бишрэлт шашин өнөд бадартугай

Өршөөлт энэрлээр мах цус
Өнө амьдрлаа ч огоот зориулж
Үе мөчөө харамгүй өгснөөр
Үнэн ном машид дэлгэртүгэй

Алдас нүгэлтнийг урьд би
Агуу хайраар асран сэнхрүүлж
Аль зохих замд нь оруулснаар
Алдаршгүй номын өглөг арвижтүгэй

Арга билгийн хүчээр би
Атхаг үзлээс бусдыг чөлөөлж
Ариун үнэнд залуурдсаны тулд
Авралт ном үлэмж дэлгэртүгэй
Хураах дөрвөн үйлсээр би
Хорсол тачаалын галаас аварч
Хор хилэнцийн хүчийг ялснаар
Хувьт шавь нар минь өнөд орштугай
Буруу зөрүү номтныг би
Буртагт үзлийн уснаас гэтэлгэж
Буцалтгүй үнэн үзэлд оруулснаар
Буянт нөхөд минь өнөд биширтүгэй

Бурхан шашин үүрд бадартугай

БОГД ЗОНХОВЫН ШАШИН ДЭЛГЭРЭХ ЕРӨӨЛ

Хамаг гэгээрэгсдийн оюун санааны эцэг боловч бурханы хүүгийн дүрээр тоо томшгүй ертөнцөд гэгээрлийг номыг түгээх ерөөл зориг үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Эрт урьд Эрхэт-охь бурханы өмнө тангараг өргөхөд Чин зоригтон хэмээн бурхад бодисатва нар алдар сууг нь дуурсгасан үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Ариун үзэл онол зам мөрийн уламжлалыг дэлгэрүүлэх ерөөлөөр Бурхан багшид цагаан болор эрх өргөхөд нь номын лавай соёрхон зөн бошгыг үзүүлсэн үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Ариун үзэл нь буй, үгүй хоёрын туйлаас ангижирсан, ариун бясалгал нь саатал нойрмоглолын харанхуйг ярсан, ариун замнал нь Бурхан багшийн сургаалыг дагасан Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Номын дууг үлэмж сонссон мэргэн, сонссон утгаа сэтгэлдээ төлөвшүүлсэн ариун, тэр бүхнээ шашин амьтны тусын тулд зориулсан сайн чанарт Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Бурхан шашины жинхэнэ утгат ба татвар утга бүх сургаалыг харилцан харшилдалгүйгээр хувь нэгэн бодгалийн судлаж бясалгах гарын авлаг болгох ухаарлаар гэм алдаа бүхнийг хаасан Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гурван ай сав эш сургаалийг судлах, номлох буюу гурван ариун онол суртахууныг бясалган эзэмших эрдэм билиг, ид чадал хосолсон гайхамшигт замнал Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гаднаа сахил журамтны явдал ёсоор номхон дөлгөөн, дотроо бурханлаг дүрийн хоёр зэрэгт йога бясалгал төгөлдөр, судар тарнийн зам мөр харшилдалгүй эвлэсэн Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Угийн хөлгөнд номлосон хоосон чанар, үрийн аргаар нээх их амгаланд төгс төгөлдөр цогцлон найрсах найман түмэн номын чуулганы зүрхэн шим Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гурван төрөлхтөний гэгээрлийн замыг ивээн сахигчийн манлай Махагал, Бисарван, Эрлэг номын хаан тэргүүтэн тү

түмэн тангарагт сахиусны ивээлээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Цог жавхлант багшийн лагшин тунгалаг, өлмий батжиж, гэгээн эрдэмт, ариун сэтгэлт шашны залуурчид эх дэлхийд дүүрч, өглөгийн эзэн сүсэгтэн олны өмөг хүчин бадарснаар Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

ЗАЯ БАНДИДА ЛУВСАН ДАНЗАН ПҮЛЖИНЖИГМЭДИЙН ТӨРӨЛ ТУТМЫН ЗАЛБИРАЛ

Хутагтын оронд л бурхан заларч
Хувьтай түмэнд увдис хайрлахад
Эрдэнийн элс өргөн байрьж бодь сэтгэл үүтгэсэн
Эзэн хаан Жамсим Жамбад залбирнам

Бурхан багшийн номын рашаанаар
Бүх дэлхий нийтээр чийглэгдэх
Гаслант хүмүүсийг зовлонгоос тэтгэгч
Гайхамшигт хаан Ашока-д залбирнам

Эрдэнэ гуравт хувиралтгүй сүсэглэж
Энгийн нүдэн дор энэрхүйн хүү шиг тэтгэн
Чөлөө учрал бүрдсэн оронд мэндэлсэн
Чимэг үзэсгэлэнт Това Самбууд залбирнам

Хутагтын орны дээдсийн хөрөнгөнөөс
Хувиар хүмүүст өглөг тэргүүтнийг гүйцээж
Арчаагүй түмний тусад үр эд хайрлагч
Агуу Шумбугаараад залбирнам

Цаст түвдийн баруун хойд зүгийн
Цагийн муугийн Ладак шавь нарыг
Хилэнт дүрээр номхотгон зассан
Хосгүй ловон РаднаСэдэд залбирнам
Энэтхэг орны өндөр язгуурт мэндэлж
Энэлсэн түмэнг гангийн рашаанаар сэрүүцүүлж
Дээдсийн мөргийг нээгч тэрэг орчлонгийн нүдэн
Даяанч Лодойдамбын өлмийд залбирнам

Байдал нь шагшаа бодь лугаа төгөлдөр
Бясалгал ухаан нь үнэрт зандан мод адил
Дэлбээлэх цэцгийн үнэр нь анхилам
Дээдэс Содном Балтүв дор залбирнам

Цог төгөлдөр охин тэнгэрийн адистэдээр
Чугуулган үйлсийн их далайд
Цэцнээр гатлах онгоцыг жолоодогч
Цандмань эрдэнэ бүдэн гэгээн залбирнам

Цаст түвдэд залрах замыг анхан нээж
Цуут ванчин богд Ашоко хэмээд лүндэгнэж
Амьтны тусыг хийж мөнгөн суврага бүтээсэн
Ар халхын хөндүүлэн цохур ноёнд залбирнам

Хоёр дээдэс ванчин далай ламын
Хувь төгөлдөр шавиар илт үнэлэгдэж
Ариун номын хурыг хутагтаа буулгагч
Алдарт Зая Лувсанпэрэнлэйд залбирнам

Урьдын дээдсийн мөрөөр Түвдэд заларч
Урсах гангын рашааныг нутагтаа салаалан
Агь тарнийн номыг эцэгслэн агууг сахигч
Аглаг даяанч Лувсаннамжилд залбирнам

Хол тасран түрүүлэх ажнай хүлэг шиг
Хосгүй ядам сахиустай гүн нөхөрлөж
Судар тарнийг эндүүрэлгүй эцэслэсэн
Суут Лувсан Жигмэд Доржид залбирнам

Зая бандидын алдарт шашны хэнгэргийг
Замхрал үгүй арвидуулж зохиох үүрэгт
Амьтныг тэтгэгч билэг төгөлдөр багш
Ачит Лувсан Няндаг дор залбирнам

Хувилгаан журамт лагшинг эргэшээж
Хөг яруу зарлигаар олонд алдаршсан
Шоронд залравч энрэхүйн таалалтай
Шамдалт дээдэс Жамбацэрэнд залбирнам

Ардчиллын ногоо Монголд үрсэлж
Ардууд сүсгээр хойд дүрийг хайхад
Далай багшаас Архангайд энэ хэмээсэн
Данзанпүлжин Жигмэд дор залбирнам

Учир шалтгаан бүрдсэн Монголд
Уг санааг ерөөлчилөн бүтээсэнд
Зая Бандидын дүр бүхэнд залбирнам бид
Заяат дээдийн номын дэлгэрүүлж адисла

МЭГЗЭМ

**Мэгмид зэвий дэрчин жанрайсиг
Дэмид чинбу банбу жамбиян
Ганжин хайвй зүгжин зонхава
Лувсан дагби шавла солбаандэв**

ДҮНЧҮҮР МААНИ

Нэг зуун бодьсад ба
Нэг зуун бурхан байна
Нэг зуун нэг мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр зуун бодьсад ба
Хоёр зуун бурхан байна
Хоёр зуун хоёр мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван зуун бодьсад ба
Гурван зуун бурхан байна
Гурван зуун гурван мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн зуун бодьсад ба
Дөрвөн зуун бурхан байна
Дөрвөн зуун дөрвөн мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Таван зуун бодьсад ба
Таван зуун бурхан байна
Таван зуун таван мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан зуун бодьсад ба
Зургаан зуун бурхан байна
Зургаан зуун зургаан мянган Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Долоон зуун бодьсад ба

Долоон зуун бурхан байна
Долоон зуун долоон мянган Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман зуун бодьсад ба
Найман зуун бурхан байна
Найман зуун найман мянган Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн зуун бодьсад ба
Есөн зуун бурхан байна
Есөн зуун есөн мянган Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Нэг түмэн бодьсад ба
Нэг түмэн бурхан байна
Нэгэн түмэн нэгэн буман Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр түмэн бодьсад ба
Хоёр түмэн бурхан байна
Хоёр түмэн хоёр буман Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван түмэн бодьсад ба
Гурван зуун бурхан байна
Гурван зуун гурван мянган Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн түмэн бодьсад ба
Дөрвөн түмэн бурхан байна
Дөрвөн түмэн дөрвөн буман Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Таван зуун бодьсад ба
Таван зуун бурхан байна
Таван зуун таван буман Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан зуун бодьсад ба
Зургаан зуун бурхан байна

Зургаан зуун зургаан буман Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Долоон зуун бодьсад ба
Долоон зуун бурхан байна
Долоон зуун долоон буман Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман зуун бодьсад ба
Найман зуун бурхан байна
Найман зуун найман буман Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн зуун бодьсад ба
Есөн зуун бурхан байна
Есөн зуун есөн буман Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Нэг буман бодьсад ба
Нэг буман бурхан байна
Нэг буман нэг сая Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр буман бодьсад ба
Хоёр буман бурхан байна
Хоёр буман хоёр сая Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван буман бодьсад ба
Гурван буман бурхан байна
Гурван буман гурван сая Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн буман бодьсад ба
Дөрвөн буман бурхан байна
Дөрвөн буман дөрвөн сая Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Таван буман бодьсад ба
Таван буман бурхан байна
Таван буман таван сая Арьяабал

Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан буман бодьсад ба
Зургаан буман бурхан байна
Зургаан буман зургаан сая Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Долоон буман бодьсад ба
Долоон буман бурхан байна
Долоон буман долоон сая Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман буман бодьсад ба
Найман буман бурхан байна
Найман буман найман сая Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн буман бодьсад ба
Есөн буман бурхан байна
Есөн буман есөн сая Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Нэг сая бодьсад ба
Нэг сая бурхан байна
Нэг сая нэг жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр сая бодьсад ба
Хоёр сая бурхан байна
Хоёр сая хоёр жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван сая бодьсад ба
Гурван сая бурхан байна
Гурван сая гурван жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн сая бодьсад ба
Дөрвөн сая бурхан байна
Дөрвөн сая дөрвөн жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум

УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Таван сая бодьсад ба
Таван сая бурхан байна
Таван сая таван жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан сая бодьсад ба
Зургаан сая бурхан байна
Зургаан сая зургаан жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман сая бодьсад ба
Найман сая бурхан байна
Найман сая найман жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн сая бодьсад ба
Есөн сая бурхан байна
Есөн сая есөн жива Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Нэгэн жива бодьсад ба
Нэгэн жива бурхан байна
Нэгэн жива нэгэн дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр жива бодьсад ба
Хоёр жива бурхан байна
Хоёр жива хоёр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван жива бодьсад ба
Гурван жива бурхан байна
Гурван жива гурван дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн жива бодьсад ба
Дөрвөн жива бурхан байна
Дөрвөн жива дөрвөн дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/

Таван жива бодьсад ба
Таван жива бурхан байна
Таван жива таван дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан жива бодьсад ба
Зургаан жива бурхан байна
Зургаан жива зургаан дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Долоон жива бодьсад ба
Долоон жива бурхан байна
Долоон жива долоон дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман жива бодьсад ба
Найман жива бурхан байна
Найман жива найман дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн жива бодьсад ба
Есөн жива бурхан байна
Есөн жива есөн дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Нэг дүнчүүр бодьсад ба
Нэгэн дүнчүүр бурхан байна
Нэгэн дүнчүүр дүнчүүр дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Хоёр дүнчүүр бодьсад ба
Хоёр дүнчүүр бурхан байна
Хоёр дүнчүүр дүнчүүр дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Гурван дүнчүүр бодьсад ба
Гурван дүнчүүр бурхан байна
Гурван дүнчүүр дүнчүүр дүнчүүр Арьяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Дөрвөн дүнчүүр сая бодьсад ба

Дөрвөн дүнчүүр бурхан байна
Дөрвөн дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Таван дүнчүүр бодьсад ба
Таван дүнчүүр бурхан байна
Таван дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Зургаан дүнчүүр бодьсад ба
Зургаан дүнчүүр бурхан байна
Зургаан дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Долон дүнчүүр бодьсад ба
Долоон дүнчүүр бурхан байна
Долоон дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Найман дүнчүүр бодьсад ба
Найман дүнчүүр бурхан байна
Найман дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Есөн дүнчүүр бодьсад ба
Есөн дүнчүүр бурхан байна
Есөн дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/
Арван дүнчүүр бодьсад ба
Арван дүнчүүр бурхан байна
Арван дүнчүүр дүчүүр дүнчүүр Аръяабал
Ум а хри бадмэ нирди шари хум
УМ МА НИ БАД МЭ ХУМ 3/удаа/

ҮНДСЭН ӨДРИЙН УНШЛАГА АНХНЫ ТАСАЛГААТ ЧОГО

1. СОЖИН АВАХУЙ

Арван зүг дор оршсон Бурхан бодь садва бүгд дор бодь хутагийг онохуй хүртэл би ямагт цаг бүхэнд алгасрал үгүй тахил өргөн надад дор шидэс бүтээлийг ханьцаш үгүй хайрлан соёрх.

Бүх амьтаныг гэтэлгэх хүслээр бурхан ном хуврага, гурав дор Бодийн хутаг олохуй хүртэл Бат сэтгэлээр би бээр аврал одуулмой.

Ухаарч нинжин их сэтгэлээр Ухрангүй шамдан амьтанд тусламой.

Бурханы оронд оршиж Бүгдээрээ бодь сэтгэлийг үүсгэмой.

Бурхан ном хийгээд чугуулганы дээд дор бодийг хүртэл би бээр итгэмой.

Бусад хийгээд өөрийн тусыг бүтээхийн тулд би бээр бодийн сэтгэлийг үүсгэмой.

Арван зүг ямагтад оршсон.

Агуу бурхан бодьсадва заларсны дунд.

Өөрөө бодьсадба болохийн тухайд.

Өнөөгөөс бодь сэтгэлийг үүсгэе.

Сахил авах тайлбар сэлт.

Эхлээд багшийн өмнө нигүүлсэнгүй сэтгэлээр биширч намайг тойроод бурхад бодьсадва хүрээлэн буй гэж бодоод гурав мөргөж, багшийн урьд сахил өгнө үү хэмээн мандал өргөсний сүүлээр би тэргүүт огторгуйн энтэй тэнцэхүй хамаг амьтаны тусын тухайд бурханы хутаг олох болтугай түүний тухайд маргааш өглөө нар мандтал сахил авч ёсчилон сахих хэмээн бодоод

Арван зүгт оршигсон бүгд бурхад

Архад бодьсадва надад таалал соёрх

Ачит Ловон багш таалал соёрхоо

Тэр мэт урьдын ялж төгс нөхцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн

Үнэхээр тугуулгасан Бурхан Дажан хэмээх адил, их заан, их ажил хийсэн үүрэг үүрсэн өөрийн тусыг сүүлд олоод орчлон бүгдийн үйлийг зогсоон, үнэхээрийн зарлиг, сайтар тийн гэтэлгэхийг таалалдаан барин, сайтар гэтэлгэхийн энэрэнгүйн ухаан тэдгээр бээр хамаг амьтны хэргийн тухайд, туслахын тулд, гэтэлгэж үйлдэхийн тулд, зудгүй байхын тухайд, өвчингүй байхын

тухайд Бодийн зүгийн номыг огоот төгсгөхийн тухайд, ханьцашгүй, үнэхээр төгссөн бодийг магадтай олохын тухайд сахил авч ёсчилон дагагч...../Нэрээ оруулж унших/ бээр энэ цагаас эхлэн маргаашийн мандах наран хүртэл хамаг амьтаны хэргийн тухайд, тэдэнд тус хүргэхийн тухайд зовлонгоос гэтэлгэхийн тухайд, зуд турхангүй байхын тухайд өвчин хуучгүй байхын тухайд бодийн зүгийн номыг огоот дэлгэрүүлэхийн тухайд, ханьцашгүй бодийг магадтай олохын тухайд, сахилийг ёсчилон авч үйлдмой.

(3-н удаа унших)

Сүүлийн удаа уншиж дуусмагц өөрийн бие сэтгэлд сахил төрлөө гэж баясал бясалгаад, Багшаас,, Арга энэ болой” гэхэд сайн болой” гэж хариулж үүлдээд сахил төрүүлээд. Бодь сэтгэл төрсөн анхны санааг сайтар тодруулж эртний архад нар амь тасдахаас эхлэн арван 10 нүгэл тэргүүтнийг бие хэлний унал бүгдийг тэвчиж сэтгэлээрээ тэр бүгдээс буцсан ёсчилон би бээр тухайд нэг өдөр тэвчиж сургаалийг ёсчилон сахимой гэж санаандаа баттой бодоод:

Унших ануу.

Тэгээд амьтны амь тасдах үгүй
Тэнэглэж хулгай хийх үгүй
Худал үгийг машид тэвчиж
Хуурмаг гэмийг санан гэмшиж

Архи сархадийг огоот тэвчиж
Алдаас өндөр суудалд суулгүй
Үдээс хойш хоол идэлгүй
Үнэр эрх гоёлыг болон

Үймүүлэх бүжиг шийг тэвчиж
Үнэхээр Архад дээдсийн журмаар
Тэрчилэн олон нүгэлийг тэвчиж
Тэргүүн бодийг олох болтугай.

Орчлонгийн бүхий л зовлон
Оломгүй далайгаас гэтэлтүгэй

Тарниа даган уншина

УМ АМУГА ШИЛА САМВАР ВАРА ВАРА МАХА ШҮДЭ
САДУ БАДМА” ВИ” ВҮ” ХИДА” ВҮЗА” ДАРА” ДАРА” САМАНДА,
АВОЛОГО” ДЭ” ХУМ” ПАД СУУХА.

Хэмээх Шагшаа бодийн тарни эгүүнийг багшийг даган 21 удаа уншсаны дараа

Сахилаар Шагшаа бодь гэм үгүй
Сайтар ариусан төгөлдөршиж
Омогийн сэтгэл үгүй болж
Огоот билиг баримад олтугай
Гурван удаа мөргөнө

Тайлбар

Хэмээн ерөөл тавин нэг удаа багшийн өмнөөс аман авч шүтээний өмнө сахин омог юугаа рашаанаар угааж тангараг дамцагаа сахиж бурхан дор мөргөн тахиж итгэл одуулан шүтээнээ Арьяабал бурхан илт байна гэж бодоод бие хэл итгэлээрээ сүсэглэн гурав мөргөж анхны санаагаа ариун байлгаад

БАГШ БОЛГООН СОЁРХОО гэж шавь нар хэлэхэд
ловон бээр **АРГЫН ДЭЭД БОЛОЙ**
гэхэд **САЙТАР САХИН ДАГАМОЙ** гэж шавь нар хариулна.

Тэгээд амьтаны амь тасдах үгүй
Тэнэглэж хулгай хийх үгүй
Худал үгийг машид тэвчиж
Хуурмаг гэмийг санан гэмшиж

Архи сархадыг огоот тэвчиж,
Алдаас өндөр суудалд суулгүй
Үдээс хойш хоол идэлгүй
Үнэрт тамхи гоёл чимэг

Үймүүлэх бүжиг шийг тэвчиж
Үнэн архад дээдэсийн журмаар
Тэрчилэн олон нүгэлийг тэвчиж,
Тэргүүн бодийг олох болтугай

Орчлонгийн бүхийл зовлонгийн
Оломгүй далайгаас гэтэлтүгэй.

Хэмээн 3 уншиж дуусмагц сахил төрсөн гэж бодоод урьдын адил ерөөл магтаал үйлдэх нь тэгчин сожин буюу нэг өдрийн сахил мөн болой.

Зод буюу авидармын тайлбараас буяны үндэс нугуудыг ч сахиж сэргээж үйлдэх тухайд сожин буюу сахил хэмээнэ тиймийн тухай бурхан багш сожин олон удаа авсан байдаг.

Мөн буян багатайг арвидуулах хийгээд нүгэл гэмийг наманчилах чухалтай гэж 8н санваарийн номонд зарлигласан буй заа.

Гармашадүв- бээр 3-н суртгааль болох шагшаабодь, бясалгал билгүүн 3н суурь үлэмжийн сургаалтай адил хэмээжээ.

Зод буюу авидармаас-Шагшаа бодийн гишүүн, сэрэмжийн гишүүн, номхотгох гишүүн тэрчилэн 8-н сахилийн үес мэт хорхойний амь тасдахаас эхлэн амьтан бүгдийн амь тасдах, бусдын өгөөгүй зүйлийг авахаас эхлээд бүх хулгай, ариун бус явдал, худал хэлэх зэрэг болон согтууруулах ундаа архиний язгуур бүгдийг тэвчих, гишүүн чухаг дэгээд гураваас бусад тохиолдолд бүжиг, дуу, хөгжим, уурлах, тачаах, хүнээс онцгой гоёл чимэг зүүх, биендээ гаж үнэр түрхэх сүрчих гар хөл хүзүүндээ чимэг зүүх зэрэг гоёлыг хорих, эрдэнийн чимэгт ширээнд тэр тусмаа дохойгоос өндөр суудалд суухгүй байх сахилын хугацаанд үдээс хойш сүү тараг мэт халбага тогтох болон будаа зэрэг ямар нэгэн идэх зүйлийг тэвчих ба цаг бусын хооллолт тэвчих эдгээр тэвчигдэхүүн анхны дөрөв, шагшаа бодийн 5-р нь сэрэмж, үлдсэн гурав нь номхотголийн гишүүнд хамрагдана. Найман сахилын үед бодь сэтгэл анхны санааг заавал хэрэгтэй гэдгийг анхны сахил буюу равжүнгийн сахил увашийн сахил нь 8-н гишүүнийг ам авдаг сахидыг ч энэ үе дэх сожингийн сахил бодийн сэтгэл төрөх анхны санааг машид хэрэгтэй хэмээн хамаг амьтны тусын тулд гэж бодох нь хүч аньс ихтэй мөн түүнчилэн багшийн өмнө ам авч сахих нь машид тус эрдэм ихтэй гэж хэлдэг энгийн хүмүүс хот мандалийн тахилыг адистэдлэж чадахгүй учир Би ямагт нэгэн эгшин бээр Аръяабал бурханы лагшинг эрхшээж байна хэмээн бодож УМ БАДМАНДА ГЭРДЭ хум пад.

хэмээх тарнийг өгүүлэхийн цагт өөрийн зүрхнээс хилэнт тэнгэр (тову тэнгэр) тоолшгүй цацарч тахилын ойр орших түүтгэрийг далай цаад уруу хөөсөн гэж бясалгаад

2. ЛАМАН ЧОДВО БУЮУ БАГШИЙГ ТАХИХУЙ

Агуу Их амгалангийн агаараас өөр ямагтаа багш бурхан
Алин түүн дор тодорсоны лагшингаас гэрлийн цацраг чуулган
Арван зүг дор цацарч сав шимийг адистэдлэснээр
Арвин эрдмийг байгуулан хотол чуулган болмой

Машид цагаан их буяны сэтгэлийн агаар ямагтаас
Би лугаа огторгуй чацуу эх болсон амьтан нугууд
Магадтай хэзээ олох бодийн шимийг хүртэл
Багш чухаг дэгээд гурав дор авралыг одуулмой

Багш дор мөргөмөй
Бурхан дор мөргөмөй
Ном дор мөргөмөй
Хуврага дор мөргөмөй

3 удаа унших

Эх болсон хамаг амьтаны тусын тулд
Эгнэгт би ямагт бурхан болоод
Амьтан бүгд багш бурханаа дээдэлж
Ачитны дээд дор байгуулж үйлдмой

3 удаа унших

Амьтан бүгдийн тусын тулд би бээр энэ нас ямагтад түргэнээс
түргэн дор уугуул бурханы хутгийг илт дор үйлдмой
Эх болсон амьтан бүгдийг зовлонгоос гэтэлгэж
Энх амгалангийн бурханы газар дор байгуулъя
Тиймийн тулд гүнзгий мөр багш бурханы егүзэрийг анхааран
авах дор суралцаж үйлдмой

УМ А ХУМ (3 удаа)

Мөн чанар билгүүн дор, байдал нь дотоодын тахил хийгээд
тахилын эд тус тусын байдал, үйлдэх хүч Зургаан эрхтний
явдалын орон дор амгалан хоосонгийн билгүүн үүсгэснээр газар
хийгээд завсарын үзэгдэл Огторгуйн эн бүгдийг огоот дор түгсэн
гадаад хийгээд дотоод нууцын тахилын үүл Тангарагийн эд,
мэлмийн болгоот сэтгэлд багтах үгүйгээр дүүрмой.

Амгалан хоосон ялгалгүй Бурханы мөр уужим Самандабадрын
тахилын үүл жигдэрсний төвд

Цэцэг, навч, үрээр огоот үзэсгэлэнтэй болсон 9 хүслийн
галбирваасан модны үзүүрд

Арслантай эрдэнээр их бадарсан ширээ болон үүл, нар, сар,

дэлгэсний дээр.

Гурван ач лугаа төгөлдөр ёзоорын багш бурхан бүхний мөн чанарын байдалтай

Гэлэн дүр эл шарыг барьсан нэгэн нигүүрт, хоёр мутар баясангуй дүрээр гэрэлтэн

Баруун мутраа номыг номлосон, зүүн мутраараа тэгшид агуулсан рашаанаар дүүрсэн бадар аягыг барьсан

Гүргүмийн өнгө лугаа төгөлдөр, 3 номын хувцсыг асаасан алтан овоодойгоор тэргүүнээ чимсэн

Таалалдаа түгээмлийн эзэн Очир баригчийн эрхэт нэгэн нигүүр 2 мутарт хөхөмдөг лагшинтай

Очир хонхыг бариад, Енчүгма-г чүдлээд хамт төрсөн амгалан хоосонгийн цэнгэлээр баясаж

Нэн олон эрдэнийн чимгээр хээлж, тэнгэрийн эд торгон баринтагийг асаан (дээл өмссөн)

Лагшин найргийн чимэг төгөлдөр гэрлийн тусгал мянгыг бадрааж, таван солонгоор хүрээлсний голд

Очир завилгааны ёсоор оршсон цогцос нугууд язгуур таван бурхан

Дөрвөн махбодь дөрвөн эх, судас шөрмөс, үе, нугууд нь бодьсадва бодитой

Шар үс нь архад хоёр түмэн нэг мянган гишүүн хилэнт эрхэт ямагту

Гэрлийн тусгал зүг бүрийг тэтгэгч ягчис нууц ертөнц нугуудын өлмийн дэвсгэртэй

Тойрон хүрээлж дараалах ёсоор үндэсний багш ядамын мандалтай

Бурханы бодьсад баатар дагинас шашныг сахигч бээр хүрээлэн оршсон.

Тэдгээр нугуудын гурван үүд, очирын тэмдэгт “хум” үсэгийн гэрлэн гохоор

Мөн чанарын орноос билгүүн нугуудыг урин залж, ялгалгүй баттай болмой

Бодит бүгд мөн чанартаа одох ирэхээс хагацсан ч

Элдэв шавийн санаа сэтгэлд тааруулан

Болгоолж нигүүлсэх их энэрэнгүй үйлстэн

Итгэл авралт багш дээдэс залран соёрхоо

Хотол чуулган сайн амгаланг гарахын орон гурван цагийн

Хамаг үндэсний багш ядам, чухаг дэгээд гурав дор

Баатар дагинас, номын тэтгэгч, сахиусны чуулган сэлт

Бат нигүүлсэхүйн эрхэн дор энд заларч оршоомой

УМА –ГҮРҮ- БУДДА –БОДИ- САДУ- ДАРМА- БАЛА- САВАРИ- БА-
РА –Э- ХАЯ- ХИ ЗА-ХУМ- БАМ -ХО

Мөргөлийн гишүүн ануу:

Алины их нигүүлсэнгүйн их амгалангийн агаарт
Гурван лагшингийн хутаг дээдийг ч агшин дор
Хайрлан зохиогч багш их эрдэнэ мэтийн лагшинт
Очирын өлмийн лянхуад мөргөмүү

Хязгааргүй бурхан бүхний билгүүн нь
Хэнийг ч номхотгох юун дор ч ургахын уран аргын дээд
Эл шарыг барихын бүжиглэлээр нэн цэнгэсэн
Итгэл авралт дээдсийн өлмий дор мөргөмүү

Гэм бүхний авъяас сэлтийг сурвалжаас нь гаргах бөгөөд
Хязгааргүй эрдмийн их эрдэнийн чуулганы сан
Тун амгалан хоцроолгүй гардагийн ганц үүд
Гэтэлгэгч багшийн өлмий дор мөргөмүү

Тэнгэр сэлт багш бурхан бүхний бодитой
Түм найм, дөрвөн мянган дээдийн ном гарах орон
Асар хутагтын чуулган бүхний төвд ив илхэн
Ачтан багш нугууд дор мөргөмүү

Их гурван цаг арван зүг дор оршсон багш хийгээд
Их эрдэнэ дээд гурав мөргөх зохистой бүгд дор
Сүжиг биширэл магтаалын эгшигт далай мэт
Сацуу орны тоосын тоогоор хувилаж мөргөмүү

Тахил өргөхүйн гишүүн

Аврал итгэлт тэтгэгч багш нөхөр сэлт дор
Арга Элдэв тахилын үүл олныг өргөх нь
Сайтар байгуулсан их эрдэнийг гэрэл бадарсан уужим савнаас
Сайх ариун үүтгэгч дөрвөн рашаан чөлөөтэй бууж
Үндэс голыг дамжин сайтар хэлхэн арвижуулсанаар
Үзэсгэлэнтэй цэцэг навч, газар хийгээд завсрыг дүүрч
Зуураас үнэртэх хүжсийн утаа цэнхэртэж
Зуны хөх үүл мэт бурханы мөрийг ариусгаж

Нар, сар, эрдэнэ машид бадарсан зулын чуулган
Нилэнхүй ертөнцийн харанхуйг гийгүүлэн баясаж
Гавар, зандан, гүргэмийн үнэр анхилан түгэж

Газар ус, их далайг эргэн тойрон бүгд эргэлдэж
Зуун амтатын шим төгөлдөр идээ сэлт, ундаа хийгээд
Зуур тэнгэр хүмүүний амны идээ сүмбэр уул мэт овоолж
Элдэв хөгжим энд тэндгүй яруу сонсогдож
Эгшиглэх авиа гурван газар ертөнцийг дүүрч
Дүрс, дуу, үнэр амт хүрдэхүүний цогийг баригчийн
Дотно гадна таван хүслийн охин тэнгэр зүг бүхэнд түгэж

Зуун жива гольт дөрвөн тив, Сүмбэр уул сэлт
Их долоон эрдэнэ ойрын эрдэнэ тэргүүтэн
Зоныг баясгаж үйлдэхийн сав шим хотол чуулган
Их тэнгэр хүмүүний төгс эдлэл хүсэл бүхний чуулган

Сүжгийн сэтгэлээр гайхамшигт орны дээд болсон
Сод аврал нигүүлсэхүй их чуулсан дор өргөж үйлдмөй..

Бодитой бэлтгэсэн сэтгэлээр хувилгасан эрдэнийн далайн олом

Орчлон нирвааны нэн цагаан зохист тахилын идээ
Бүхний сэтгэлийг булаах мянган навч дэлгэрсэн
Орчлонтон хийгээд ертөнцөөс гэтэлсэн өөр бусдын

Гурван үүдийн буяны цэцэг юун дорч дуртмал алаглаж
Гол мөрөн мэт тахилын үнэр ханхалж, бумаар түгээд
Гурван сургаал, хоёр зэрэг, таван мөрийн үр төгөлдөр
Гайхамшигт цэцэрлэгийг багшдаа өргөн баясгамой

Зээглэх Гүргүмийн өнгө төгөлдөр сайхан үнэртэн
Зуун амтаны охь хятад цайны дээж хийгээд
Таван гох хийгээд таван зул тэргүүтэн
Тахья таныг арилгах, онох, бадрахын рашааны далайгаар
Сэтгэлд зохистой идэр залуугийн цогийг баригч
Санал хүслийн ид заль төгөлдөр лагшинт
Орон, очир, хамт төрөлтийн эрхэт элчийн чуулган
Онцгой гуа илбийн мутарлагт нугуудыг өргөмүй

Хилэнцээс хагацсан хамт төрсөн амгалангийн их билгүүн
Хэн бүхэн мөн чанарын цацрал лугаа хагацсан хоосон чанар
Ялгалгүй аяндаа бүтэх, өгүүлэх, санах, ярихаас хэтэрсэн
Ямагт дээдийн утга бодь сэтгэл дээдийг тан дор өргөмүй

Нисваанисын бүх өвчнийг дардаг
Нэн сайн эм тус бүр элдэвийг хийгээд
Таныг баясгахын тулд биеэ боолонд өргөө
Там хэзээ дуустал албатан дор барин соёрхмой.

3. ДҮНШАГ БУЮУ УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Хамаг амьтан цаг цагт цаглашгүй ачит лам багшдаа итгэмүү
Бурханд итгэм үү Дээдийн номд итгэм үү Бурсан хуврагуудад
итгэм үү

Их Багш ялж төгс нөгцсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан,
үнэхээр төгссөн, цогт ялгуулсан бурхан Шагжтүвийн өлмийд мөргөм үү.

Түүнчлэн заларсан очирын зүрхээр сайтар эвдэгч танаа мөргөм
үү

Түүнчлэн заларсан эрдэнийн гэрэл цацруулагч танаа мөргөм
үү

Түүнчлэн заларсан лусын эрхшээлт ялгуулсан танаа мөргөм
үү

Түүнчлэн заларсан баатаруудын өмөгт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан баясгалант цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан гал эрдэнэ танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан эрдэнэ саран гэрэлт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан үзсээр их туст танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан саран эрдэнэт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан хиргүй тунгалаг танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогийг хайрлагч танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан асар ариун явдалт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан ариунаар өгөгч танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан усан тэнгэр танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан усан тэнгэрийн тэнгэр танаа мөргөм

Түүнчлэн заларсан сайн цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогт зандан танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан хязгааргүй жавхлант танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогт гэрэлт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан гаслан үгүйн цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан хурьцахуй үгүйн хөвүүн танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогт цэцэгт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан ариун гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч танаа

мөргөм үү

Түүнчлэн заларсан лянхуан гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч

танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан эдийн цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан дурьдахуйн цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогт билэг найраг нь ихэд даяар алдаршсан танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан эрхт оройн ялсаны тэмдэг хаан танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан сайтар дарагч цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан дайснаа машид ялсан танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан сайтар даран ажирсан цогт танаа мөргөм

үү

Түүнчлэн заларсан эрдэнийн лянхуагаар сайтар дарагч танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан дайснаа дарж үнэн төгссөн бурхан, эрдэнэ хийгээд лянхуан дээр сайтар саатан заларсан уулсын хаан хэмээх алдарт танаа мөргөм үү

Тэдгээр бурхад тэргүүтэй 10 зүгийн ертөнцийн оронд түүнчлэн заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгссөн, ялж төгс гэтэлсэн бурхан аль төдий заларсан бөгөөд ахуй залран буй ялж төгс нөгцсөн тэдгээр бурхад намайг таалалдаа багтаан соёрх оо.

Миний энэ нас хийгээд эхлэлийн хязгаар үгүй төрлөөс

Энэ орчлонд орчин төөрсөн төрөл тутамдаа

Элдэв хилэнцэт үйл үйлдсэн хийгээд

Элдэвлэн бусдыг хилэнцэт үйл үйлдэхэд хүргэсэн

Эл бас хилэнцэт үйлэнд даган баяссан буюу

Тахил шүтээний эд буюу

Түүнчлэн бурсан хуврагийн эд бөгөөд

Арван зүгийн бурсан хуврагуудын

Алив эдэд шунан булаах хийгээд

Аль бусдаар булаалган үйлдэх ба

Аль хэн нэгэн булаан үйлдэхүйд даган баяссан

Завсаргүй таван нүглийн үйл үйлдсэн буюу

Зориуд бусдыг үйлдэхэд хүргэсэн хийгээд

Заримууд үйлдэн байхуйд даган баяссан

Арван хар нүглийн мөрд чанх орсон хийгээд

Арван хар нүглийн мөрд бусдыг оруулсан ба

Аль бусад орж байхуйд даган баяссан юм уу

Аль нэг хилэнцэт үйлийн түйтгэрээр

Ашид миний сэтгэл тамд очих буюу

Адгуусны төрөлд одох эсвэл

Ашид өлсөн цангах бирдийн орноо төрөх

Бурхан заларч номоо номлоогүй
Бурангуй харанхуй буйд оронд төрөх буюу
Тэрс номлолт лалын орноо төрөх
Урт наст тэнгэрийн орноо төрөх ба
Улмаар эрхтэн дутуу болон төрөх
Угаас буруу үзлийг баримтлагч болох
Бурхан заларч номоо номлохуйд
Баясах сэтгэл үл төрсөн гэх мэт
Барагдашгүй муу үйлийн түйтгэр буй тэдгээр бүхнээ
Билгэ билгүүнт бурхан Билгэ билгүүний мэлмийн Их эрхэт
Үнэн шалгуурын мөн чанарт
Үнэн болгоолтоор болгоогч тэдгээрийн мэлмийн өмнө
Гэмшин наминчилмуй Арилган наминчилмуй
Үл нуух болой. Үл хаацайлах болой
Хойшид ч таслан боомтильё.

Ялж төгс нөгцсөн бурхан бүгд намайг таалалдаа багтаан
соёрх

Миний энэ төрөл хийгээд
Магад эхлэлийн хязгаар үгүй цагаас
Мунхран мунхран орчлонд орчин орчин
Төрөл бүхэндээ бусдад ядаж түдэвч
Адгуусны оронд төрсөн амьтаст
Өчүүхэн төдий идээ хоол өгсөн буяны ёзоор юу буй
Өөрөө би Шагшаабадыг сахисны буяны ёзоор юу буй
Үнэн ариун явдал мөрөөр явсан буяны ёзоор юу буй
Үнэнхүү гэтлэхүйн мөрд бусдыг оруулан
Үйл сайны үрийг боловсрохуйд найралдсаны буяны ёзоор юу

буй

Өөртөө дээд бодийн сэтгэлийн үүсгэсэн буяны ёзоор юу буй
Өнөд ханьцашгүй билгэ билгүүний буяны ёзоор юу буй тэр
бүхнээ нэгнээ хураан цогцлуулж Ханьцаш үгүй Үнэлш үгүй
Дээдийн ч дээд Багшийн ч багшид Тэр бүхэлд зориулан
басхүү Тэнцэшгүй үнэн төгс бодь хутгийг олохын тулд зориулъя.
Ямар мэт урьд цагт заларсан бурхад төгс зориулсан хийгээд
Ямар мэт ирээдүйд залрах бурхад төгс зориулах хийгээд
Ямар мэт өдгөө залран буй ялж төгс нөгцсөн бурхад
Ямар мэт төгс зориулсан тэр мэт
Би бээр өдгөө зориулъя
Хилэнц унал бүгдийг тус тусад нь наминчилъя
Хэн буян үйлдэнэ тэр бүхэнд даган баясья
Хамаг Бурхадад номоо номлохыг сануулан дуртгая

Хэзээд соёрхол талбия
Ханьцашгүй дээд билгэ билгүүнийг би олох болтугай
Хүмүүний дээд одоо залран буй ялгуулсан бурхад аль
Хэдүй заларсан хийгээд ирээдүйд залрах
Сайшаалт эрдэмт хязгааргүй далай мэт бүхэнд
Сайтар алга найралдуулан залбираад авралыг ихэд айлтгам
уу би

**Ум сарва дата гада идам гүрү радна манда-ла хам-нир-яа
да-яа-ми**

4. ЖИВШАГ БУЮУ ЕР УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Ү ха-лаг. Очир баригч их багш тэргүүтэй 10 зүгт залран буй
хамаг бурхан, бодьсадва нар хийгээд ариун аяга тахимлэг (гэлэн)
нар минь намайг таалалдаа багтаан соёрх оо!

.....хэмээх нэрт миний эхлэл үгүй цагаас төрөл тутамдаа
өдгөөг хүртэл хүсэл шунал уур хилэнц мунхагийн эрхээр бие хэл
сэтгэлийн үүднээс 10 -н хар хилэнц нүгэл юуг үйлдсэн хийгээд
завсаргүй 5-н нүгэл үйлдсэн хийгээд завсаргүй 5-н нүглийн шадар
5-н нүглийг үйлдсэн хийгээд

Ангид гэтэлгэгч санваартай харшилсан

Бодьсадвын сурталтай харшилсан

Тарнийн тангарагтай харшилсан Эцэг эхээ үл хүндэтгэсэн

Орон хийдийн хамба багшийг үл хүндэтгэсэн

Ариун явдалт буяны садан юуг үл хүндэтгэсэн

Чухаг дээд гуравт хорлол үйлдсэн Дээдийн номыг тэвчсэн

Хутагтан хуврагуудыг басамжилан доромжилсон

Амьтанд хорлол үйлдсэн тэргүүтний

Хилэнц нүглийн үйлийн чуулган хэдийн чинээ үйлдсэн хийгээд
бусдыг үйлдэхэд хүргэсэн, бусдууд үйлдэхүйд даган баяссан
тэргүүтэй Товчилбоос илт өндөр (тэнгэр ба хүмүүний төрөл)
хийгээд тонилохуйн (орчлонгоос оюун санаагаараа гэтлэх) тотгор
болсон орчлонгийн төрөл хийгээд муу заяаны шалтгаан болсон
гэм уналын цогц хэдий чинээлэг би үйлдсэн тэр бүхнээ Очирт их
багш тэргүүтэй 10 зүгт залран буй бурхан, бодьсадва нар хийгээд
ариун хуврагуудын мэлмийн өмнө гэмшин наминчилъя.

Үл нуух болой. Арилган наминчилъя. Хойшид ч таслан
боомтилъя. Гэмшин наминчилж амгалант оронд зорчоод үл
гэмшсэн, үл наминчилсан нь үгүй болой.

Арван зүгийн бурхад бодьсадба
Ачит, Барэдига, сурч боловсорсон
Амьтан бүгдийн буян аль бээрч
Аминчилан би бээр даган баясаму
Орчлонд хаана ч зул болон бадарч
Оройноос бурхан болохоор яаралгүй
Номой дорой над мэт бүгдэд
Номын хүрдийг зогсолгүй эргүүлэн
Гаслангаас гэтэлгэх замыг заан
Гагцхүү хамаг амьтны амгалангийн тулд
Галав олон оронд тоосны тоотой адил
Гар хумхилгүй залбирч үйлдэе би
Мөргөн тахин номончилан
Мөнхүү даган дурдан баясан залбирснаар
Өчүүхэнч төдий буян юу хурааснаа
Өрөвч энэрэлээр бодь дор зориулмой.

5. ЛАМАН ЧОДВО БУЮУ БАГШИЙГ ТАХИХУЙ СУДРААС ХИЛЭНЦЭЭ НАМАНЧЛАХЫН ГИШҮҮН

Тэргүүлэшгүй цагаас нүгэл хилэнцийн үйлийг
Үйлдсэн ба үйлдэхийг захисан, даган баяссан бүгдийг
Их нигүүлсэнгүй төгөлдөрийн мэлмийн өмнө
гэмшихийн сэтгэлээр
Наминчлахгүй бөгөөд хойшид ч үйлдэхгүй санваар
авах болмуу

Даган баясахын гишүүн

Мэдэгдэхүүн мөн чанар тэмдэг лугаа хагацсан ч
Мэдрэх зүүд ямарчилан төрөлхийтэн бүгдийн
Амгалан баясгалан ургасны нэн цагаан буян дор
Ашид би сэтгэлээрээ даган баясамой.

Номын хүрдийг эргүүлэхийг сануулахын гишүүн

Гайхамшигт мэдэл энэрэлийн үүл бумаар жигдэлсэн ба
Гүнда- цэцэрлэг мэт хамаг амьтаны тус амгаланг
Үүсгэх өнөд оршуулах арвижуулахын тухайд
Үнэхээр гүн дэлгэр номын хурыг буулгаж соёрх

Соёрхолыг талбихын гишүүн

Очирын лагшин дор төрөх үхэхийг үл эрхшээсэн ч
Огоот хослон орох эрхийн бурханы бат хайрцаг мэт
Миний сүсэг ямарчилан орчлонгийн хязгаарыг хүртэл
Муу гаслангаас хамгаалахын мөр дор оршин соёрх

Буянаа зориулахын гишүүн.

Тэр мэт мэндэлсэн нэн цагаан буяны чуулган
Тэрчилэн гурван ач төгөлдөр багш бээр
Төрөл тутамд хагацалгүй даган барих ба
Төв үзэлт очир баригчийн эрхийг олох болтугай

6. АРЪЯАБАЛ БУРХАНЫ БАЛМУЙ ЁСНЫ БАГШИЙН ДАМЖЛАГА СЭЛТ

Асар ариун номын тэнгэр
Асар ариун номын лагшин тэнгэрийн зам уужим илт
Аяндаа энэрэхийн үүлэн цогцос мянгаар жигдрээд
Хязгааргүй амьтанд туслах амгалангын их хурыг
Хоромхон буулгах лянхуа баригчид аврал соёрхол талбимой

Тийн гэтэлгэхийн дээд тэрчлэн балмуу мэт
Ухааны таван орныг эзэмшигч зандраа гүмара
Тэсвэр хичээл сүжгийн хүчит хутагт Ишсан гэх
Амьтны ураг садан гурав дор соёрхол талбимой
Мэргэний дээд Балбуу Бониба хийгээд
Хутагтын дээд намрал Даваажанцаны өлмий
Бүтээлийн эрхэт Нипугцорж хэмээн алдаршсан
Эх гурван Бодьсадвад соёрхол талбимой
Бурханы шавь Дүнзэнсурваа Доржэжал болон
Мэргэн их хуврага Шандандайжигийн өлмий
Чүлтэм хийгээд Түгжийжанчивбал болон
Нирвааны замыг гийгүүлэгч гурав дор залбирмой
Хязгаарлашгүй Егүзэр Балжирдэжимба
Ядам тэнгэрт бараалхсан Жанчивбар болон
Эрдэм эрдэнийн санг эрхшээгч Шийравбум
Амьтны хүслийг хангагч гурав дор залбирмой
Бодь сэтгэлийг эрхшээн баригч Тогмидсан
Манзушир бурханыг баясгагч Шийравбал
Амьтан бүхнийг нинжээр энэрэгч Чүлтэмцан

Бусдын тусыг бүтээгч гурав дор залбирмой
 Амьтныг татагч дээд Ёндонренчин болон
 Бурханы шашныг дэлгэрүүлэгч Ванчүгжи
 Хязгааргүй амьтныг аврагч Жавчигбал
 Иш онол үзүүлэгч гурав дор залбирмой
 Бэрхийг номхотгон бүтээгч Бавуубинсава
 Хувь төгөлдөр хүслийг хангагч Санжээиш
 Мэдэгдэхүүн бүхнийг болгоогч Лувсанчойжин гэх
 Тийн удирдагч дээд гурав дор залбирмой.
 Бүтээлийн дээдийг олсон Дамцагдорж
 Язгуур бүхнийг эрхшээсэн Лувсаниш
 Сам бүхнийг тодруулан зохиогч Доёдхайдав
 Шашны гурван зул дор залбирмой.
 Хэл эрхэт Сүрпүд Ава Чинрав тэргүүт
 Ойр морилох балдан Жишүг хийгээд
 Сайн хувьт тийн амирлуулагч Лүндог
 Тодруулан зохиогч гурав дор залбирмой.
 Бүхнийг мэдэгчийн агаараас гэрэлтэх Чойнод
 Хослон барих ухаант энэрэлийн хүрд
 Шүтээнд шүтэгдэх огоот хутагтын дээд
 Тийн болгоогч дээдэс далайд залбирмой.
 Алдар нь түгэж огторгуй мэт болсон
 Асар ариун нирвааны Гуусан болсон
 Мэргэн арга буяны садан төгөлдөр багш нар
 Хоёр түүтгэрийг арилгаж адистэдэлмой

7. АРЪЯАБАЛ БУРХАНЫ МАГТААЛ

Хутагт Их нигүүлсэгч Нүдээр-Үзэгч
 Хиргүй лавайн өнгөт дээд сайн дүрст
 Асар арилсан гэгээн гэрлээр сарны төвд үзэсгэлэнтэй
 Аяа ямар мэт огторгуйд мянган нар мандсанчлан
 Мянган гэрлээ бадруулсан үлэмж их баатар
 Гурван ертөнцийн газарч багш хэмээн алдаршсан
 Гурван ертөнцийн амьтан бүхний ганц садан
 Магадтай асрал итгэл Их нигүүлсэгч та таалагтун.
 Би бээр тэргүүлшгүй цагийн хязгаараас
 Буруу мөрд орон хүлээст орчлонд төөрлөө
 Урьдаас буруу үйлийн хилэнцээр гутаж
 Улмаар үйлдсэн нүгэлдээ ихэд сайрхлаа.

Олонтаа давтсан тийм үйлийн эрх хүчээр
Орчлонгийн зовлонгийн далайд живлээ
Уур хилэн бадарсан сэтгэлээр үндсээ шатаалаа
Уршигт мунхагаар оюун билэг минь мунхарлаа
Хүсэл тачаалын далайд сүнс минь живээд
Хөөрөн ихэрхэх омгоор муу заяанд уналаа
Найдангуйн улаан хуйгаар орчлонд хийсч
“Би”-д барих үзлийн бат гинжээр хүлэгдлээ.
Галт гуу мэт шуналын хавцгайд унаад
Хатуу зовлонгийн хүчир намагт шигдлээ
Усан язгуурт сэрүүн чийг доороос хайрлаа.
Жихүүн хүйтэн салхи гаднаас шавхуурдлаа
Бүхнээс хямралдагч хий дотроос бослоо.
Аяа тэр мэт зовлон тэсэхүйеэ бэрх боловч
Авсан тангараг санваараа эвдэж яахин болмуй
Хамаг зовлонгоор золин тангараг санваараа сахиад
Хүсэхгүй сүсгээр дээд Хутагтыг үл орхивоос эл
Хутагт итгэл амьтны тусыг юунд үл зохиомуй
Ханьцашгүй асрал минь намайг яахин үл нигүүлсмүй
Мунхаг над мэт их хилэнц нүглийг үйлдсэн
Муу үйлийнхээ эрхээр цөвүүн ийм цагт төржээ
Төрсөндөө гашуудаж, муу үйлэндээ гэмшивч
Төлөөст орчлонгийн үйлийн эрх хуурмаггүй.
Үйлийн үрийн хүч догшин голын ус мэт
Үйлийн эрхийн урсгалыг нь буцаахад маш бэрх
Үнэн зарлигтай учравч ёсоор явж чадсангүй
Үзтэл бие, хэл, сэтгэл үйлийн эрхэнд оржээ.
Хилэнцэт үйлийн эрхийн их түймэр бадарсанд
Хэрэгт сэтгэлийн ногоо минь үнс чандар боллоо
Цогцос илбийн энэ бие үл тэсдэх аваас
Асрал итгэл нигүүлсэхүйт минь тэснэ үү
Нар мэт гэгээн гэрэлт, сар мэт тунгалаг тодорхой
Нигүүлсэхүйн нүүрийг чинь үзэхийг хүсэн эрэвч
Тэргүүлшгүйгээс нүдэнд минь мунхагийн цагаа
Тогтон сохроод усны хөөсийг ч олж үл харна би.
Амьтны итгэл минь та эдүгээ хаана заларнам
Амаргүй хатуу зовлон минь тэсэшгүй байнам
Айн ширвээтэж, чичрэн дагжнам
Асгартал уйлан энэхүү дуугаар бархирнам
Асар эмгэнэхийн эгшгээр энэлэн дууднам
Амаргүй хатуу зовлон минь тэсэшгүй байнам

Айн ширвээтэж, чичрэн дагжнам
Асгартал уйлан энэхүү дуугаар бархирнам
Асар эмгэнэхийн эгшгээр энэлэн дууднам
Асрал итгэл нигүүлсэхүйт минь сонсоно уу
Хэзээ үхэж бие арилжих цаг ирэхэд
Хайрт ураг саднаас хагацан эрлэгт хөтлөгдмүй
Тэр цагт ертөнцийн элгэн саднууд ханилан дагахгүй
Үйлийн эрхээр би өөрөө ганцаараа тэнэж одмуй
Аяа тэр цагт надад итгэл аврал байхгүй аваас
Асрал итгэл та минь намайгаа орхино уу
Үйлээр нэрвэгдсэн төрөлхтнүүд надтай адил
Тэргүүлшгүй цагаас чанх буруу атгагаар
Төөрч, гурван ертөнцийн орчлонгийн шавраас
Үл гаран, цаглашгүй галвын төрлүүдэд
Хэдий чинээ биеийг аван басхүү үхсэний
Хэрзгэр ясыг нь овоолвоос Сүмбэр уул мэт
Хар цусыг нь цуглуулваас Сүн далай мэт
Хийсэн үйлийг нь хурааваас санаанд багташгүй.
Гурван ертөнцийн тоогоор төрлийн амсар дамжив
Махарч үйлдсэн үйл нь хэрэг тусгүй замхарна
Гагцхүү тэдгээрийн дотор
Магад дээдийн дээдэд
Өчүүхэн төдий ч зорьсон буй аваас
Өнөд түүн дор нь нэгэн хэрэг буйяа.
Мах цусан биеийг аваад орчлонд тэнэж
Маш ширүүн зовлонгоор сансрын гянданд хоригдсон
Хүлцэн тэсэшгүй зовлон энэ мэт бөгөөс
Хамаг гэм эргүү өөрийн үйлнээс гарчээ
Нигүүлсэхүйгээр муу үйлийн цуврилыг таслаад
Нисваанист үйлийн хийг буцаан соёрхогтун
Нисваанист ийм үйлийн хий хүчтэй болж
Мунхагийн харанхуйд ашид тэнэвээс минь
Бэлгэ билгийн зулын гэрлээрээ гийгүүлэхгүй юу
Буруу гэмийн үйлийн үрийг үл тэсдэх аваас
Их нигүүлсэгч та бээр үйлсээ зохиохгүй юу
Тэвчихүйеэ бэрх гурван хорын өвчнөөр энэлвээс
Их нигүүлсэхүй мэргэн аргаараа эдгээхгүй юу
Тэдрүү буруугийн халил гууд унаваас ч
Нигүүлсэхгүйгээр түргэн ирж аврахгүй юу
Хатуу зовлонт үйлийн эрхийн гал бадарваас
Нигүүлсэж, сэрүүн хураараа унтраахгүй юу

Гурван ертөнц дэхь орчлонгийн зовлон арилсаар
Хэзээ өөрийн үүрийг олсон тэр цагт
Хутагт Их нигүүлсэгчээс эрэхийн хэрэг юун
Амьтан үйлээр арилсан газарт агуулагдваас
Хутагтын нигүүлсэл түүнд ямар хэрэгт.
Дээд хутагт та нигүүлсэхүйн хүчит бөгөөс
Дэмий тэгш сац орхилго зохиолгүй
Ил голт зүрхнээсээ болгоогтун, Ялгуусан бурхан минь
Хутагт Аръяабал дор уйлан залбирахын үүднээс магтсан,
Сургаалын багш Зандрагирди бээр зохиосон төгсвэй.

8. ИХ НИГҮҮЛСЭГЧИЙН БҮТЭЭЛИЙН АРГА

Өмнийн огторгуйд Хутагт Нүдээр-Үзэгч
Нэгэн нүүр дөрвөн мутарт, үндсэн хоёр мутраар алгаа
хавсарсан

Үлдсэн хоёроор болор эрхи, лянхуан модон барин
Авралын орны далайсаар хүрээлүүлэн орших боллоо.
Лам бүгдийн хураангуй итгэл Нүдээр-Үзэгч
Ядам бүгдийн хураангуй итгэл Нүдээр-Үзэгч
Бодисатва бүгдийн хураангуй итгэл Нүдээр-Үзэгч
Шравага, братигабуд бүгдийн хураангуй итгэл Нүдээр-Үзэгч
Номын сахиусан бүгдийн хураангуй итгэл Нүдээр-Үзэгч
Өчирлөг талбимуй, нигүүлсэхүйн мэлмийгээр үзэгтэн
Энэ насны үзэгдэл шуналыг огтлохуйяа адистидла.
Муу заяаны төрлийг түрдэтгэн адистидла
Үйл нисваанисын хирийг арилган адистидла
Сансрын их далайгаас гэтэлгэн адистидла
Дээд бодь сэтгэл төрүүлэн адистидла.
Үнэхээр үзлийг онохуй дор адистидла
Хослон орсоны хутгийг олуулан адистидла
Тэр мэт өчирлөг талбиснаар зүрхний Хри үсгийг
Зургаан үсэгтийн тарни тойрон эргэлдсэнээс
Гэрэл сацран, Ялгуусан бүгдийн адистидийг
Хурааснаас буусан рашаанаар амьтан бүхнийг гэтэлгэлээ
Тэднээс өөрөө хийгээд огторгуй дүүрэн авралын орон
Зургаан зүйл амьтан бүгд зэрэг уншихуйгаар санан
маанийн зургаан үсгийг тоологтун.
Эдүгээгээс хойш үхэн егүүтсэн тэр даруйдаа
Эндүүрэлт зуурдын үзэгдлээр төөрөлгүй

Хутагт Нүдээр-Үзэгч итгэлийг даган
 Сухавадийн оронд төрөх болтугай.
 Ялгуусаны баясгалант сайн хот мандалд
 Маш үзэсгэлэнт дээд лянхуагаас мэндэлсэн
 Ялгуусан Гачаалгүй гэрэлт Авид бурханы ил
 Эш үзүүлэгдэхийг ч би тэнд олох минь болтугай.
 Баатар Зөөлөн итгэл бээр ямагт мэт айлдсан лугаа
 Тэдгээр бүгдийг даган суралцахын тулд
 Эдгээр хамаг буянаа зорин ерөөмүй
 Гурван цаг дор заларсан Ялгуусан бүгд бээр
 Ерөөл алиныг дээдээр сайшаасан түүгээр
 Би бээр ч буяны ёзоор эдгээр бүхнээ
 Сайн явдалд огоот зорин ерөөмүй.

9. БОДЬ МӨРИЙН ГУРВАН ЭРХЭМ ЗҮЙЛ ОРШВОЙ

Оройн дээд гэтэлгэгч багш нарт мөргөмү
 Авралт Бурханы сургаалын шим утга,
 Ачит бодьсатва нарын сайшаасан зам
 Ариун нирвааныг хүсэгчдийн орц олмыг
 Аль чадахын хэрээр номлосугай, би.
 Цөхрөм орчлонгийн жаргалд шунан тачаалгүй,
 Чөлөө учралын тусыг үйлдэхэд хичээснээр
 Бурханыг баясуулах замд сэтгэлээ тушаасан
 Буяны хувьтнууд бууршгүй сүжгээр сонсогтун.
 Орчлонгын далайд магад гарахын санаагүйгээр
 Охь сайныг эгээрэвч амирлах аргагүй,
 Олон амьтад ч орчлонд шунах сэтгэлээр
 Онцгой хүлэгдсэнд анхлан магад гарахыг эрэлтэй.
 Олдоход бэрх чөлөө учрал, насад завгүйг
 Оюундаа тунгааваас энэ насны шунал буцна.
 Омтгойгүй үйлийн үр, орчлонгын зовлонгуудыг
 Ойндоо шингээвээс хойтын шунал ч буцна.
 Ийнхүү бясалгасаар орчлонгын хотол чуулганд
 Эрэмшил бахдал агшин зуур ч төрөлгүй,
 Эгнэгт өдөр шөнөгүй нирвааныг эгээрвээс л
 Эрхэм магад гарахуйн санаа төрсөн нь тэр буй
 Магад гарахуйн буянт санаа түүнийгч

Машид ариун бодь сэтгэлээр эс үзүүлвээс
Хотол чуулсан бодь амгалангийн уг болохгүй тул
Хосгүй бодь сэтгэлийг ухаантнууд үүсгэлтэй
Хүчир дөрвөн мөрний урсгалд автаад,
Хүлцэшгүй бэрх үйлийн хүлээсэнд чангалагдсан,
Хөнөөлт минийрхэх үзлийн шоронд хашигдаад,
Хөшүүн балар мунхгийн харанхуйд бүрхэгдсэн
Эцэс мухаргүй орчлонд төрөн төрсөөр
Эгшин ч амсхийлгүй гурван зовлонд нэрвэгдэгч
Энэ мэтийг ахуйт эх болсон амьтдын
Эмгэнэлт төрхийг санаснаар бодь сэтгэлийг үүсгэмүү.
Ахуй ёсыг оносон билиг эс төгөлдөржвөөс
Ариун магад гарах, бодь сэтгэлийг бясалгавч
Аюулт орчлонгийн үндсийг тасалж чадахгүй тул
Алимад шүтэн барилдлагыг онох аргад шамдалтай.
Сансар, нирвааны хамаг юмс үзэгдлийн
Шалтгаан, үр нь хэрхэвч хуурмаггүйг ухаараад,
Аливаа зоригдлын тушаа бүхнийг эвдэлсэн
Аяа, тэрээр бурхныг баясгах мөрт оршжээ.
Алимад хуурмаггүй шүтэн барилдагч үзэгдэл хийгээд
Ам авахаас ангижирсан хоосны хоёр ухаарал нь
Хэдий болтол тусгаар ангид оршихуй
Төдий болтол Бурханы тааллыг онохгүй.
Хэзээд өрөөсгөлөөр үзэхгүй, нэгэн зэрэг
Хэлбэрэлтгүй шүтэн барилдлагыг таних зуурт
Магад мэдлийн орны баригдал бүгд эвдэрвээс л
Мадаггүй үнэн үзлийн шинжлэл төгссөн нь тэр буй
Басхүү үзэгдлээр буйн хязгаарыг арилгаж
Батгүй хоосноор үгүйн хязгаарыг огоорч,
Хоосон чанар шалтгаан, үрд ургах ёсыг мэдвэл
Хотол туйлшрагч үзлийн эрхэнд үл орьюу.
Тэр мэт бодь мөрийн гурван эрхэм зүйлийн
Тэмдэгт оньс бүгдийг ямарчлан онохын цагтаа
Аглагийг шүтэж, алдаршгүй хичээнгүйг үүсгэснээр л
Ашдын хэргээ түргэн бүтээгтүн, хүү минь.

10. ШҮТЭН БАРИЛДЛАГЫН МАГТААЛ

Намо гүрү Манзугохаяа
 /Багш Зөөлөн цогт дор мөргөмү/
 Нэвтэрхий болгоох нь ижилгүй мэргэн,
 Нигүүлслээр номлох нь хосгүй заагч,
 Нягт шүтэн барилдахуйн ёсыг
 Нээн, сургасан Ялгуусанд биширмү.
 Ахуй ертөнцийн доройтод бүгд
 Андуу мунхгаас үндэслэх бөгөөд
 Алимад шүтэн барилдлагыг мэдсэнээр л
 Аюул түүнийг няцаахыг зарлиглажээ.
 Үүнээс үүдэн ухаантан бүгдээр
 Үлэмж шүтэн барилдлагын мөрийг
 Таны шашны оньс хэмээн
 Таалахгүй байж яахин чадах.
 Магад иймээс итгэлт таныг
 Магтахыг хүссэн хэн нэгэнд
 Эл шүтэн барилдлагыг номлосноос тань
 Илүү гайхамшиг олдоно гэж үү.
 “Аль аль шалтгаанд харгалзсан
 Тэр бүгд нь хоосон чанартай”
 Энэ айлдвараас үнэ цэнэтэй
 Эрхэм номлол юу байх вэ.
 Эгэл нялхасын хувьд энэ нь
 Эцэст баригч хүлээсийг бататгана.
 Эрдэмт мэргэдийн хувьд тэр нь
 Эндүүрлийн тор бүгдийг таслана.
 Зүйтэй номлол бусдад үгүй,
 Зөвхөн таныг л “Багш” хэмээлтэй,
 Зүдэг үнэгийг “арслан” гэсэн шиг
 Зөрүү тэрсүүдэд зусар үг.
 Гайхамшигт багш, гайхамшигт аврал
 Гайхамшигт өгүүлэгч, гайхамшигт итгэл
 Эндүүрэлгүй шүтэн барилдлагыг номлосон
 Ижилгүй багш тандаа мөргөмүү
 Ачлан ивээгч таны айлдсан
 Амьтныг эмнэх сургаалын шим
 Агуу хоосон чанарыг танихад
 Адилтгашгүй дээд нотолгоо болсон
 Харилцан шүтэлцэхүйн жам ёсыг

Харш бөгөөд бүтэхгүйгээр үзвэл
Хамгийг айлдагч таны зарлигийг
Хаанаас зөв ойлгох билээ.
Таны болгоосноор хоосон чанарыг
Шүтэн барилдлагын утганд ухаарвал
“Өвөр чанар хоосон” лугаа
“Үйлдэгч, үйлдэгдэхүүний зохицол” харшлахгүй.
Үүнээс эсрэгээр үзэх аваас
Хоосон тул үйлдэгдэхүүн бус,
Үйлдэгдэхүүн бол хоосон бус,
Үгүйсгэл, туйлшралын ангалд унаюу.
Учир тиймээс таны шашинд
Шүтэн барилдахуйн үзлийг дээдэлсэн.
Угтаа огт байхгүй ч бус
Уул чанараараа байгаа ч бус,
Тулгуургүй огторгуйн цэцэг мэт
Тусгаар орших нь байж болшгүй
Угаасаа бүтсэн бол тэр нь ч
Учир шалтгаанд харгалзахтай харшилна.
Иймийн тул шүтэн барилдлагаас
Ангид зүйл нэгээхэн ч үгүй,
Тиймийн тул хоосон чанараас
Ангид зүйл ч бас үгүй.
Мөн чанарыг буцаашгүй тул
Мөн чанартай зүйл байхуул
Эгнэгт гаслангаас нөгчих аргагүй,
Элдэв цацралаас ч ангижирч чадахгүй.
Аяа, тиймээс, арслангын дуугаар
“Ахуй чанар хоосон” хэмээн
Ахин, дахин мэргэдийн чуулганд
Алгасалгүй номлосныг тань хэн эсэргүүцнэ
“Ямарваа мөн чанаргүй” хийгээд
“Янагуухь энэ, тэр шүтэлцсэн
Хамаг ялгаврын зохицол” хоёр нь
Харшлахгүй хурахыг өгүүлэх юун.
“Шүтэн барилдахуйн учир шалтгаанаар
Туйлшрагч үзлээс гэтэлнэ” хэмээсэн
Эрхэм айлдвар тань итгэлт таныг
Эгнэшгүй өгүүлэгч болохыг нотолуу.
“Эл бүгдийн чанар хоосон”
“Энэ үр нь энэ шалтгааных”

Ийм хоёр ондоо магадлал
Эсрэг тэсрэггүй нөхөрлөж болох
Үүнээс илүү сонин юун
Түүнээс илүү гайхамшиг юун,
Үүгээр нь л таныг магтах аваас
Үнэнхүү магтаал, өөрөөр бус.
Адаг мунхгийн зарц болж
Аюумшиггүй таньтай мөчөөрхөгчид
Ахуй чанар хоосны дуунд
Амаргүй болоход гайхах юун.
Харин таны эрхэм сан
Шүтэн барилдлагыг зөвшөөрөх атлаа
Хоосон чанарын дуурьсгалд уурсах
Хоёрдмол санаанд л гайхнам, би.
Мөн чанаргүйн мөрт хөтлөх
Мөхрөлтгүй үүд шүтэн барилдлагыг
Мөчид ухаарч, нэр төдийгөөр нь
Мөн чанартайд баримтлагч тэднийг
Агуу хутагтнуудын сайтар зорчсон
Адилтгашгүй дээд орц олом,
Аврал таныг баясуулах замд
Арга юугаар хөтлөнө билээ.
Засвар, тулгуургүй мөн чанар
Засвар, тулгуурт шүтэн барилдлага
Харшилдаж эсэргүүцэлгүй нэг сууринд
Хаанаас цуг оршиж чадах вэ.
Үүний учир шүтэлцсэн бүгд
Өвөр чанар угаас хоосон ч
Өнгөц тэр мэт үзэгдэх нь
Үнэндээ илбэ шиг болохыг зарлигласан.
Эрхэм таны аливаа номлолоос
Эсэргүүцэгч нэгээхэн бээр зөв зүйтэй
Эргэлзээт асуудал олшгүй гэсэн нь ч
Энэхүү учраар тайлагдах буйза
Яагаад гэвэл, энэ л номлолоор
Ямарваа ил, далд юмст
Хийсвэрлэл хийгээд үгүйсгэлээр хандах
Хийдэм ташааг арилгах болно.
Ижилгүй өгүүлэгч болохыг тань нотлох
Эл шүтэн барилдлагын мөрөөр
Эрхэм зарлиг бусдыг ч жишээд

Эндүүгүй үнэнд нь итгэмж төр юу.
Утгачлан болгоож, учирлан номлосон
Ачит таныг даган суралцахад
Уршигт гэмийн үндэс таслагдсанаар
Уруу, дорой бүхнээс ангижирна.
Билгүүн сургаалаас тань гадагш зүглэвээс
Бэрхшээл зүдрэлийг өчнөөн эдлэвч
Бишид гэмийг улмаар даллаж,
Би г баримтлагч үзлийг бататгана.
Аяа, энэ хоёрын ялгааг
Аливаа ухаантан таних буйза,
Ясны угаас тэр цагт
Яахин таныг үл биширнэм.
Энгүй олон зарлигыг тань хэлэлтгүй,
Эгэл нэгэн зүйл утганд ч
Энгүүн ерөнхий ухаарлыг олоход
Энх амгалангийн дээжийг хүртдэг.
Ээ халаг, оюун минь мунхарчээ,
Энэ мэт эрдмийн цогцод
Эрт өнөөс залбирсан боловч
Эрдмийнх нь хувь төдийг ч эрсэнгүй.
Хэдий тэгэвч эрлэгийн ам уруу
Хэзээд зүглэсэн амиа алдаагүй дээр
Өршөөлт танд өчүүхэн итгэснээ
Өлзий буян хэмээн омогшном.
Заахаас шүтэн барилдлагыг заах,
Ухаарахаас шүтэн барилдлагыг ухаарах нь
Орчлон ертөнцөд ялгуусны эрхэт шиг
Охь түүнийг та л айлдана.
Гайхамшигт таны зарлиг бүгд
Шүтэн барилдлагыг ухуулах бөгөөд
Гаслангаас гэтэлгэхийг зорьсон танд
Амирлуулагч бус зохиол үгүй.
Аяа таны ариун сургаал
Аливаа бодгалийн сонорт хүрвээс
Алгасалгүй тэдний зовлонг арилгахуй
Аялдан бишрэхгүй хэн байх вэ.
Эсэргүүцэгч бүхнийг сөхөөн гартаах,
Эх, адаг харшилж хутгалдаагүй,
Энгүй хоёр тусыг соёрхогч
Энэхүү сургалт урамшив, би

Ачит та үүний тулд л
Амь бие, амраг садан
Алив баялгаа тоолшгүй галавт
Ахин дахин олонтаа зольсон
Гоц чухал эрдмийг нь үзсэнээр
Гохонд баригдсан загас мэт
Таалал тань татагдсан энэ номыг
Танаас сонсох хувь минь дутжээ.
Энэ гомдол энэлгээний хүчээр
Энхрий үрээ санан мөрөөсөх
Эхийн сэтгэл шиг эгээрэл хүслээ
Эгшин ч үл орхиж чадъяу.
Бас ч үүнд, зарлигийг тань санаваас,
Бадрангуй жавхлант лагшин найраг
Бахдам гэрлийн тороор хүрээлэгдсэн
Багш та, эсэруагийн эгшгээр
“Утга энэ нь ийм” хэмээн
Учирлан айлдахуйн дүр хөрөг
Санаанд минь ургамагц халуун энэлгээ
Сарны гэрэлд эмнэгдэх мэт.
Зүйрлэшгүй эрхэм уг номлолыг
Зүдэг мөхөс зарим хүмүүс
Зүлэг ширгийн хүлэс өвч шиг
Зүйл бүрээр орооцолдуулсан аж.
Үүнийг үзээд миний бие
Үй олон мэргэдийг даган
Өчнөөн шамдлаар ахин дахин
Үнэн голч тааллыг тань эрлээ.
Ийнхүү өөрийн болоод бусдын
Элдэв зүйл аймаг үзэлтний
Эрхэм гол шаструудыг судалсаар
Эргэлзлийн торонд сэтгэл минь энэлсэн
Бурханы шашны дээд хөлгөний
Буй, үгүйн хязгаарыг огоорч
Нарийвчлан тайлбарлах бошгыг олсон
Нагаржунайн үзлийн гүндаа цэцэрлэгч
Тунгалаг оюуны дэгжмэл мандал
Туж зарлигийн огторгуйд торолгүй
Туйлшрагч сэтгэлийн харанхуй арилгаж,
Тусгүй өгүүлэгчдийн оддыг бөхөөсөн
Цогт сарны (Чандрагирди) сайн номлолын

Цолгин цагаан гэгээ туссаныг
Авралт багшийнхаа ачаар үзмэгц
Агсагадсан сэтгэлийн минь алжаал тайлагдлаа.
Үйлс зохиол бүгдийн дундаас
Үнэн зарлигийн зохиол дээд.
Үлэмж тэр нь энэ л учраас
Үүнээс л мэргэд Бурханыг дурдую.
Түүнийг даган хувраг болж,
Төгс зарлигийг нь багагүй судалсан,
Йогт хичээгч нэгэн гэлэн
Их аршдаа ийнхүү биширнэм.
Эгнэшгүй Бурханы шашинтай учирсан минь
Эргэлзээгүй багшийн л ач тул
Энэ буянаар ч амьтан бүгд
Эрдэмт багшаар удирдуулахыг ерөөнөм.
Авралт шашин орчлон эцэслэтэл
Атхаг муугийн салхинд ганхалгүй,
Ариун чанарыг нь ухаарч мэдээд
Бурханд итгэгчдээр дүүрэх болтугай.
Шүтэн барилдахуйн чанарыг тодруулсан
Бурханы сургаалыг төрөл тутамд
Амь биеэ зориулан дээдлэхдээ
Агшин зуурч алгасрахгүй болтугай.
“Аврагч тэрээр цаглашгүй зүдэрч,
Асар хичээлээр бүтээсэн хүнийг
Арга юугаар арвижуулах вэ” хэмээн
Өдөр шөнөгүй шинжлэх болтугай.
Үлэмжийн сэтгэлээр үүнд шамдаваас
Эсрүн, Хурмаст, ертөнцийг тэтгэгчид,
Эрхин Махгал, номыг сахигчид
Эндэлгүй мөнхөд нөхөрлөх болтугай.

11. НОГООН ДАР-ЭХИЙН МАГТААЛ

Ум! Гэтэлгэгч Эх Хутагт Дарь Эхэд мөргөмүй.
Мөргөмүй! Орчлонгийн зовлонгоос түргэн баатарлан гэтэлгэгч

эх

Мэлмий нь агшнаа цахилах гилбэлгэн мэт эх
Гурван ертөнцийн итгэлийн нигурийн лянхуан
Тоорийн ишнээс гарсан эх
Мөргөмүй! Намрын саран мэт бүхнээ дүүрэн
Зуунтаа давхарласан нигурт
Мянга мянган оддын чуулганаар
Машид ялгарсан бадрагч гэрэлт эх
Мөргөмүй! Шаргал хөх уснаас мэндэлсэн лянхуагаар
Мутраа нэн чимэглэсэн эх
Өглөг хичээл хатуужлыг эдлэн амирласан
Тэвчээр дияны явдлын орон ямагт эх
Мөргөмүй! Түүнчлэн ажирсны үнэр нь
Түрдэх хязгааргүй ялгуусан явдалт эх
Хамаг чанадад хүрэхүйг олсон бодьсатва нар
Хэзээд машид шүтэн дээдэлсэн эх
Мөргөмүй! Дүд да ра хум үсгээр
Хүсэхүй зүг бүхэн огторгуйг дүүрэгч эх
Долоон ертөнцийг өлмийгөөрөө дараад
Даруй хоцроол үгүй бүгдийг ирүүлэн чадагч эх
Мөргөмүй! Хурмаст гэл тэнгэр Асур хийгээд
Хий тэнгэр элдэв эрх баялагт тэнгэрүүдэд тахигдсан эх
Жүмбо роолан Диса нар хийгээд
Ягчисын чуулганы өмнөөс магтсан эх
Мөргөмүй! Драд хэмээх хийгээд пад хэмээхээр
Чинадасын заслан хүрдийг машид эвдэгч эх
Баруунаа хумьж зүүнээ жийсэн хөлөөр дарж
Шатаамал гал сүлжилдэхүй машид бадрагч эх
Мөргөмүй! Дүрэ-гээр их аюулт шимнусын
Дарагдашгүй баатарыг магад дарагч эх
Уснаас мэндэлсэн царайгаа догшин дүртэд зохиож
Улмаар бүх дайсныг үлдээл үгүй бусниулсан эх
Мөргөмүй! Гурван эрдэнэсийн бэлгийн мутрын
Хуруугаар зүрхэндээ магад чимэглэсэн эх
Хоцроол үгүй зүгийн хүрдээр чимэглэсэн
Хэзээд өөрийн гэрлийн чуулганыг үймцүүлэгч эх
Мөргөмүй! Түмэнтээ машид баясгалант жавхлантайяа

Тэргүүн титмийн гэрлийг зэрэглэсэн эрхитэй эх
Инээн маш инээн Дүддара бээр
Муу шулмас болоод ертөнцийг эрхэндээ зохиосон эх
Мөргөмүй! Газар дэлхийг тэтгэгч аймаг чуулгануудыг
Гүйцэд ирүүлэн чадагч эх
Хилэн ууралтыг үйлдэж хум үсгээр
Хоосрол үгүйрлээс хамгийг нэн гэтэлгэгч эх
Мөргөмүй! Шинэ сараар титэмлэн чимэглэсэн үзэсгэлэнтэйеэ
Тунамал чимгүүд нь тунгалаг бадрангуй эх
Үсний доторхи Ханьцашгүй Гэрэлтээс
Үргэлжид машид гэрлийг бадруулан зохиогч эх
Мөргөмүй! Эцсийн Галбын бадрах гал мэт
Энгүй бадрах эрхэсийн төвд залрагч эх
Баруунаа хийж зүүнээ хумин хүрдэн эргүүлхүйеэ баясгалант
Бүхнээс буцаахуйяа бэрх дайсныг омгийг баатарлан дарагч эх
Мөргөмүй! Газар дэлхийн элгийг мутрын
Алга бээр дэлдэн өлмий занчигч
Ууралтыг үйлдэж Хум үсгээр
Долоон зэрэг бүгдийг дарагч эх
Мөргөмүй! Амгалант эх, буянт эх, амирлангуйн эх
Ашид гаслангаас гэтэлсэн амирлангуй авирт чанарт эх
Суха Ум лугаа үнэнхүү төгссөн тул
Самуун их хилэнцийг дарсан чанарт эх
Мөргөмүй! Хамгаас бүжихүйг таалан баясаад
Хэтэрхий дайсны биеийг сайтар дарагч эх
Арван үсэгт арвис тарнийг байгуулсан
Ухааны хум үсгээр хамгийг гэтэлгэгч эх
Мөргөмүй! Дүрэ хөлөө дэлдэснээр
Хум дүрт хөрөнгө үсэгт эх
Сүмбэр уул Мандара Гэлаша хийгээд
Гурван ертөнцсийг хөдөлгөх чанарт эх
Мөргөмүй! Тэнгэрийн нуур дахь дүртэй
Гөрөөсөн бэлгэтийг мутартаа агуулсан эх
Да ра хоёрыг өгүүлэх пад үсгээр
Хор бүхнийг үлдээлгүй эвдэгч эх
Мөргөмүй! Тэнгэрийн чуулган,хаад хийгээд
Тэнгэр хийгээд хүмүүн буюу тэрбээр шүтэгдсэн эх
Хамгаас хуяг мэт бат баясгалант сэвжидтэйеэ
Тэмцэл хэрүүл болоод муу зүүдийг арилгагч эх
Мөргөмүй! Нар саран тунгалаг түгээмэл
Хоёр мэлмийд нь гэрэл тодорсон эх

Ха ра хоёрыг өгүүлэн Дүд дара-гаар
Хүчтэй хатуу хижиг өвчнийг арилгагч эх
Мөргөмүй! Тэр ямагт гурвыг зохиосон
Тэнцэшгүй амгалангийн хүч лугаа үнэхээр төгс эх
Ад хийгээд ролан ягчисын чуулганыг
Аюутган дарагч дээд Дүрэ чанарт эх
Язгуурын арвис тарниар магтахуй хийгээд
Мөргөхүй эдгээр нь хорин нэг болой.
Охин тэнгэр танаа онц бишрэл төгс тул
Оюун төгс алин бээр чухам өгүүлэх бөгөөд
Үдэш орой, үүр цүүрээр зоригоор босоод
Санаваас аюул үгүй бүхнийг хайрлана
Нүгэл хилэнц бүхнийг машид амирлуулж
Нийт муу заяа бүхнийг эвдэгч чанарыг олсон билээ
Долоон голди тоот ялгуулсадууд
Даруй эрх авшиг хайрлах больюу
Түүнээс ч үлэмж эрдмийг олох хийгээд
Түргэнээ бурханы хутагт эцэст одмуй.
Илд хатуу хор
Бат хатуу орших бус бээр яван
Зориуд найруулсан ба цулуйдсан хорыг ч
Зөвхөн санах төдий арилгах хүчийг олмуй
Ад хийгээд хишиг, хороор нэрвэгдсэн
Аюумшигт зовлонгийн чуулганыг сайтар тэвчээд
Аль амьтан бусад тэдгээр бас
Хоёр, гурвантаа басхүү долоон удаа илт өгүүлбээс
Хөвүүн хүсээч нь хөвүүнийг олж
Эд баялгийг эгээрсэн нь эдийг ямагт олоод
Эдлэхийг хүссэн бүхнээ олох больюу
Элдэв тотгор бүхнийг тус тусад нь даран үгүй болгою.

12. ДЭЭРХИЙН ГЭГЭЭНТЭН ДАЛАЙ БАГШИЙН АЙЛДСАН МОНГОЛЫН ИХ БОГДЫН ХОЙД ДҮР ЭХ НУТАГТАА ТҮРГЭН ЗАЛРАХУЙН ЗАЛБИРАЛ

Яруу эгшиглэнт бурхан багш
Ялгуусан ванчин далай лам
Гүнчиндолбуу гэндэндүв тэргүүт
Гүйцэт дамжлагын багш нар
Мэдэхүйн нарны хурц гэрлээр
Мэдэхгүйн харанхуйг эцэслэн хөөгч
Манзушир мэт хэтийтсэн замналд
Манлай богдын өлмийд залбирнам
Уужим орчлонг бүхэлд нь ялган
Ухааруулах тааллыг үүрэглэн авсан
Удамт монголын их богд минь
Удалгүй түргэн заларч соёр биднээ
Гэм бие хэлний нүглийг галагшлуулж
Гэнээн бодь бусдын тусыг дотогшлуулж
Нууцыг уламжлан егүзэрт хүрсэн
Нигүүлсэнгүй шашныг тэтгэгч та залрагтун
Номлол нь ухаантны сонорын мялаалга
Номхотгол нь бул хадыг ч тээрэмлэгч
Аялгуун асар тэнгэрийг ч алмайруулам та
Ажралгүй заларч шашинаа дэлгэн зохио
Носын ёс сонортохуйн далайгаас хэтийдсэн
Наминчлал нь эндүүрэн үзэхийг огоорсон
Нотлохуй дор тус бясалгалыг эрхшээсэн
Ном дээд хувилгаан та түргэн залраг тун
Шашны алдар гала загдын ёс
Шамдан боловсрох авшиг үндэс
Гэтэлгэн найруулга хөтөлбөр сэлтийг
Гэгээрүүлэн бадраагч та түргэн залрагтун
Барилдлагат шавь нарын чинь сүсэг
Бат хуурмаггүй гурван эрдэнийн адистэд
Бадрангуй цогт охин тэнгэрийн хүчээр
Буян ерөөл саадгүй түргэн биелтүгэй

13. МААНИЙН СУРГААЛ

Ачит багшаа биширч
Авралт бурхандаа мөргөө
Ариун номоо дээдэлж
Асралт хуврагтаа сүслэе
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Цагаан сүүгээр тэжээсэн
Ээжийн ачийг яндашгүй
Гэгээн номоор гийгүүлсэн
Багшийн ачийг хэмжишгүй
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Салхинд хөөгдсөн үүл шиг
Сарниж одох нас минь
Усанд тогтсон хөөс шиг
Урваж одох бие чинь
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Ашиг алдрын зэрэглээг
Хөөж яахин гүйцэх вэ
Аминч хүслийн цангааг
Тайлж яахин барах вэ
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Хөнгөн савсаг явдал
Түмний шившиг бус уу
Хүчир догшин авир
Төрийн гутаал бус уу
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Мөнгөөр аргалж болдоггүй
Мөнх бусыг санаарай
Өнгөөр хуурч болдоггүй
Үйл үрийг бодоорой
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Энэ ертөнцийг мэхлэвч
Эрлэгийг мэхэлж чадах уу
Эцэс жаргалыг горьдовч
Тамыг алгасч дөнгөх үү
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Үхэх төрөхийн орчилд
Үнэн чанарыг таниасай
Жаргах зовохын ээлжинд

Буян нүглийг ялгаасай
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Арван хар нүглээ
Гэмшин байж наминчлаарай
Арван цагаан буянаа
Баясан байж хөгжөөгөөрэй
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Өглөгийн үрээр баяжина л
Хомхой сэтгэлээ даралтай
Үнэн журмаар дэвжинэ л
Хуурмаг явдлаа орхилтой
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Өглөг өглөгийн дээд нь
Номын өглөг юм шүү
Өмөг өмгийн дээд нь
Ламын өмөг юм шүү
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Хүлцэхүй бэрх үйлийн
Хүлээс бүгдийг таслаюу
Хөшүүн балмад нисванис
Бүрхээс бүгдийг арилгаюу
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Өөрийн төлөө явсаар
Өөдлөх нь үгүй зүдэрдэг ээ
Өрөөлийн төлөө явсаар
Уруудах нь үгүй дэвшдэг ээ
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Энэрэл хайрын хураар
Хилэнгийн түймрийг дараарай
Эрхэм билгийн гэрлээр
Мунхагийн харанхуйг үлдээгээрэй
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Адгуу догшин сэтгэлийн
Жолоог залахад бэрх шүү
Арга билгийн ухаанаар
Аяыг нь тааруулж номхтгоорой
УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/
Үнэн гэж үзэгдэвч
Үнэмлэхүй утгыг эрээрэй
Би хэмээн хөөрөмшивч
Билиг барамидыг судлаарай

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

Ухаан шинжвэл хоосон

Усанд туссан сар аа

Нотлон шинжвэл хоосон

Нойронд ургасан зүүд ээ

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

Ариун бодийн мөрдөө

Алгасрал үгүй шамдалтай

Арилсан хутагтын номдоо

Алдралт үгүй хичээлтэй

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

Эцэг Богд ламаа

Эгшиг шүлгээр тахиму

Эх болсон амьтнаа

Энэ сургаалаар ачилму

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

Агшин ч үл хагацан

Арьяабал минь тэтгээрэй

Аюул бүхнээс холтгон

Адистид юугаа хайрлаарай

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

Шинэхэн тараг шиг буян нь

Бодийн хөрөнгө болтугай

Шижир алт шиг онол нь

Амьтны эм болтугай

УМ МАНИ БАДМЭ ХУМ /4/

14. ЛАМАН ЧОДВО БУЮУ БАГШИЙГ ТАХИХУЙ СУДРААС БАГШИЙГ ШҮТЭХ ЁС

Эрдэм гарах үндэс шагшаабадын их далайг

Эрдэнийн чуулганаар огоот увидаслан сонсож

Эл шарыг баригч хоёрдугаар бурхан багш

Энд винайг сахиулан адислах соёрхол талбимой

Алин лугаа төгөлдөр дор Бурханы мөрийг

Анхлан заахын зохист арван эрдэм төгссөн

Дор хоцроолгүй Бурханы орлогч номын багш

Дээд хөлгийн буяны садан дор соёрхолыг талбимуй

Гурван үүдийг сайтар боох оюун тэвчээр төгссөн
Гэм башир арга үгүй тарни дандарыг мэдэх ба
Тэр ямагт хос арвыг зурах ба номлохдоо мэргэн
Тэмдэгт очир баригч эрхэм дор соёрхол талбимуй

Бурхан олон заларсан ч эс номхотгох
Бурангүй бэрх цөвүүн цагийн амьтан дор
Бурханы сайн мөрийг ямарчлан заасан
Бурханы шашины нар шингэх тэр цагт
Булт аврал үгүй олон амьтан дор
Бурханы сургаалыг ойртуулан бүтээн зохиогч

Гурван цаг арван зүгийн бурхан бүгдээс
Гагц багшийн шар үсний нүх төдий бодол ч
Гарцаагүй буяны орон гэж сайшаагдсан
Голч аврал багш дор соёрхол талбимой

Амгалан ажирсан лагшин чимгийн хүрд
Арга мэргэн ирт хувилгаанаар гунхалзсан
Амьтаныг эгэлийн ёсоор татан зохиогч
Аврал итгэлт багш дор соёрхол талбимой.

Таны цогцос махбодь төрөн түгэх гишүүн нугууд
Таван язгуурын бурхан, эцэг эх, бодьсатва
Хилэнт эрхтэний мөн чанар дээд гуравын
Хүнлэг чанарт багш дор соёрхол талбимой

Бүхнийг болгоогч билгийн цэнгэлээс гарсан
Бүрэн хот мандал хүрдний мөн чанарт тэр
Зуун язгуур түгээмлийн эзэн очир баригчийн эрхэм
Зэрэгцэн олох анхны итгэлт дор соёрхол талбимой

Түйтгэр үгүй хамт төрсөн баясгалангийн цэцэрлэг лугаа
Төв ялгалгүй сав шим бүхэн дор түгээмэл эзэн
Эх адгаас хагацсан бүхний сайн дээдийн утга
Эх бодийн сэтгэлээр тан дор соёрхол талбимой

Таны багш, таны Ядам, таны ханда таны сахиус мөн бөгөөд
Одооноос аваад бодийг хүртэл таниас бусад аврал үгүй
Энэ зуурд хойдын төрөлд энэрэлийн дэгээгээр татамой

Орчлон нирвааны аюулаас гэтэлгэх, шидийг хайрлагч
ашдын нөхөр дор сахимой

Тэрчилэн гурван удаа соёрхосны хүчээр
Багшийн лагшин зарлиг тааллын орон нугуудаас
Рашааны цагаан, улаан, хөх гурван гэрэл
Зэрэгчилэн нэгэн зэрэг гарсанаас би ямагтын
Гурван оронд зэрэг буюу нэгэн зэрэг уусаж
Дөрвөн түйтгэр арилгах нэн арвин дөрвөн авшиг авч
Дөрвөн лагшинг олж, багш бээр баясангуй байдалтай
Шингэн адистэдэлмой

УМАА САВАВА, ШҮДЭ, САРВА, ДАРМА, САВАВА, ШҮДЭ
ХУМ, хоосон чанар хувираад , хоосон чанарын агаараас БҮРҮМ-
үсгээс их эрдэнийн сав уужим их нугуудын дотор УМ үгнээс
гэрэлтэн хайлан гарсан усан тахил аргам, бадэм, цэцэг, хүж,
зул, үнэрт усан, идээн, дуун тахил нугууд мөн чанар хоосон,
байдал, нь тус тусын хэлбэртэй, үйл нь цувиралтгүй амгалангийн
ялгамжаатай гүүсан хөрөнгө болмой гэж Аргам, Бадам, буйви,
Дүйви, алагэ, гандэ, нивдэ, шавда-тус бүрийг адисламой

Бурхан ном хийгээд чугуулганы дээд дор
Бодийн хутагтийг олохуй хүртэл би бээр итгэмой
Миний өглөг тэргүүтэн эдгээр еэр
Хамаг амьтны тусын тулд бурхан бүтэх болтугай
3 удаа уншина

Амьтан бүгдийг гэтэлгэх хүсэл санаагаар
Авралт бурхан хуврага дор
Бодийн шимийг олох хүртэл
Бүгдээр танд аврал одуулая
Билиг билгүүн нинж сэлтийг
Бүхий л амьтаны тусын тухайд
Бурхан таны өмнө номинчилж
Бодийн сэтгэлийг үүсгэж үйлдмой .

Би ямагт арьяабал бурхнаас тодорсон таагалалын саран
дэвсгэрээс "хэрээ" үсэг цагаан өнгийн гэрэл цацарч, мөн чанар нь
багш хутагт Арьяабал 11 нигүүртийн байдлаар язгуур дамжуулагч
багш нар тэнгэрийн чугуулган нөхөр сэлт, едам бурхад, бодьсадва,
баатар, дагинас номыг тэтгэгч сахиус бүгд хүрээлэн урин
залрагтун.

Өмнийн огторгуйд Бадма цэцгийн иш уужим агуу дэлбээ нь
мянган газар оршиж дээр нь залармой

гэж бодоод долоон гишүүний дараалалаар: Буян хураахын анхны гишүүн болох мөргөл ануу:

Хамаг бурханы хураасан лагшин
Хас очирьг барих мөн чанарт
Чухаг дээд гуравын үндэс
Чухал багш нарт мөргөмөй.
Багшийн лагшин очир мэт
Бат үзэсгэлэнт хүчийн дээд
Санаанд багтамгүй эрдэмт
Сайн багшийн өлмийд сөгдмү
Яруу зарлиг нь асурын эгшиг
Ямагт арслангийн хүчит дуугаар
Тэрсүүд гөрөөс шиг дайжих
Тэргүүн багшийн зарлигт мөргөмү
Огторгуй адил таалалт багшийн
Онц амгалан мөнх бусын агаарт
Бахдам гурван намтарын орон
Багшийн таалалд мөргөмү
Орших гурван цагийн номын лагшин
Олон амьтныг энэрэн болгоогч
Огторгуй мэт уужим таалалт
Одбагмид бурхан дор мөргөмү
Мянган мутарт Загарбардийн хаан мянга
Мянган мэлмийг сайн хувьт бурхан мянга
Мянга мянгаар болгоогч их гуу сан
Маанийн тарнит арьяабалд мөргөмү
Дагинисийн эрхэм Лачамгара болон
Даамай язгуурт Ванчин Даваа тэргүүт
Ишсамбуу жалцан багш нар
Ишийг дамжуулагч нугуудад мөргөмү
Аяндаа урсах энэрэл Арьяабал
Ариун болгоогч хутагт Манзушир
Аюумшигийг болгоогч хүчит очирваан
Алдарт богд Зонховаад залбирмуу
Богд энэрэлт итгэл төгөлдөр
Бүхнийг болгоон үзүүлэгч
Буян эрдмийн далайн суурь
Бурхан нугуудад мөргөмү
Ариусган шунал хүслээс хагацааж
Арван буянаар муу заяаг хөөгч

Тус бүгдийн нэгэн дор хураасан
Туйлын дээд ном дор мөргөмү
Сайнаас сайн замыг үзүүлэгч
Сургаал ариуны оронд орших
Хосгүй эрдмийн төгөлдөр орон
Хуврага олон дор ч хүндлэн мөргөмү
Арга ухаан энэрэлээр шагжа язгуурт төрсөн
Атгат бусдад үл дийлдэх тэрсүүдийг номхотгох
Алтан уул мэт үзэсгэлэнт лагшинт
Ариун идээт хааны Бурхан хөвүүнд мөргөмү
Цац орчлонгийн эрхэм удирдагч бурхан Цэвагмид
Цаг бусын үхэл бүгдийг дарах чадалт
Аврал үгүй зовлонт нугуудын итгэл
Авирмида бурхан дор мөргөмү
Асарал энэрэл бүгдэд тэгш бурхан
Алдар нь сонсогдмогц аюул зовлон арилгах
Гурван хорын өвчнийг анагаах оточ
Гуа биндэръяан гэрэлтэд мөргөмү
Идэрийн цог заль төгөлдөр лагшинт
Иш билгийн чимэгт их зулаар
Мунхаг орчлонг нэлд нь гишгүүлэгч
Манзушир бурхан дор мөргөмү
Бурхан бүгдийн магтаалын орон
Бүх эрдмийг хураасан сан
Мэлмийгээр болгоогч алдар соёрхогч
Мөнхийн энэрэлт Арьяабалд мөргөмү
Арслангийн дуут болон Зэндмэнэ эрдэнэ
Ариун бадмаар бүжигч, мэшол хийгээд
Донёдшагба бас хала хала тэргүүт
Дотно Арьяабалын нөхдөд мөргөмү
Бадам чимэгт дорж чойванчүг
Бас хари хари уул эрхшээгч
Арван зүгт орших энэрэлийн эзэд
Арьяабал бурхан нугуудад мөргөмү
Үйлээс гэтэлгэгч дарима дархи
Аюулаас аврагч дүдари дархи
Өвчнөөс анагаагч дари дархи
Үзэсгэлэнт цагаа дарь эхэд мөргөмү
Хүч бүгдийг эрхшээгч
Хамаг тарнийн хаан
Номхотгоход бэрхийг номхруулагч

Ноён Очирваань бурханд мөргөмү
Тэргүүнээр мөргөсөн бүгд буян
Тоосны тоогоор дээшлэн арвидаж
Биеэрээ сөгдсөн тэр агшин бээр
Бишрэлийн дээдээр мөргөмү

*Хэмээн өөрийн биеээр мөргөхийн хамт, хамаг амьтан бүгд
мөргөж магтаж байна гэж бодоорой*

Тахилын гишүүн ануу:

Өөрийн зүрхний толиноос “Хэрэ” ,үсэг гарч тахилын тэнгэр
нугууд бээр тахин үйлдмөй

*хэмээн бодож тахилын эд зай өнгө бүрээр хослон огторгуйн
энтэй адил дүүрч байна гэж ,Аргам тахил өмнө нь Вадэмийн
тахил өлмийд нь цэцэг хүзүүнд нь үнэртэн хамарт нь, зул өмнө
нь бадрааж, идээ нигүүрт нь хөгжим сонорт нь цувралтгүй
амгалангаар баясан өргөж байна гээд УМ АРЪЯА ЛОГА ШҮРЭ-
АРГАМ БАДЭМ, ВУВИ, ДУБИ, АЛОГЭГАНДЭ, НЭВДЭ, ШАВДА,
-ВАРЭДИЙН ЗА СУХА дээрх тахилыг тус тусын чагжа буюу
гарын хөдөлгөөнөөр өргөх үед тааруулан үйлдэнэ.*

Цэцэгэн эрхэн их тахил

Цэвэр зайтай үнэртэн хүж

Бадрах зул хөгжим өргөлөөр

Бурхан нугуудыг тахиж үйлдэе

Дээдсийн баринтаг үнэртний дээд

Дэлгэн зээглэх унжуурга сэлт

Бахдам онцгой дээд бүгдээр

Бурхан нугуудыг тахин үйлдэе

Тахилган тахил ханьцашгүй их бээр

Тэдгээр бурхан бүгдэд сүжиглэн

Сайн явдлын бишрэлийн хүчээр

Сайх бурхадыг мөргөн тахья

Хэмээн мандал өргөмү

Номончилох гишүүн ануу:

*Тайлбар сэлт- Би болон эргэн тойронд буй хамаг амьтан
урьд хураасан нүгэл хилэнцийг гэмшин харьж хойшид гаргалтгүй
байна хэмээн бодохын агаараас*

Уурлах тачаах, мунхагын гэмээр

Урьд бие хэл сэтгэл гурваар

Би ямагт хилинц унал хийснээ

Бүгдийг гэмшин тус тусд нь номончилмой

#####

Арван зүгийн бурхад бодьсадба

Ачит, Барэдига, сурч боловсорсон
Амьтан бүгдийн буян аль бээрч
Аминчилан би бээр даган баясаму
Орчлонд хаана ч зул болон бадарч
Оройноос бурхан болохоор яаралгүй
Номой дорой над мэт бүгдэд
Номын хүрдийг зогсолгүй эргүүлэн
Гаслангаас гэтэлгэх замыг заан
Гагцхүү хамаг амьтны амгалангийн тулд
Галав олон оронд тоосны тоотой адил
Гар хумхилгүй залбирч үйлдэе би
Мөргөн тахин номончилан
Мөнхүү даган дурдан баясан залбирснаар
Өчүүхэн ч төдий буян юу хурааснаа
Өрөвч энэрэлээр бодь дор зориулмой.

*Үүгээр долоон гишүүний дарааллаар үүлдсэн болой буян
Тэгээд шагшаабадийн тарина 21 удаа уншина*

УМ,АМУГА'ШИЛА'СААМБАР'БАРА'БАРА'МАХА'ШУДА'САДУ'БА
ДМА БИ, БҮ, ХИДА, БУЗА, ДАРА, ДАРА, САМАНДА, АВОЛОГЭДИ
ХУМ ПАД СУХА

Сахилаар шагшаа бодь гэм үгүй
Сайтар ариусан төгөлдөршиж
Омогшин сэтгэл үгүй болж
Огоот билиг баримадааг олтугай

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа
төгөлдөр болтугай

Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаан лугаа
хагацах болтугай

Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай

Хамаг амьтан ойр хол уурлах дурлах хоёроос хагацаж тэгш
дор орших болтугай

*Хэмээн цаглашгүй дөрвийг бясалган өмнийн огторгуйн
Аръяабал бурханы хот мандал сэлт өөрийн орон дор
залартугай хэмээн бясалгана. Үүгээр бэлтгэл хэсэг, дуусаж,
бодит хэсэг эхлэхгүй дор хоёр анхан ануу өөртөө бурхад үүсгэх
дараа нь өмнөө бурхадыг үүтгэх лугаа хоёр болой*

ӨМНИЙН огторгуйд бясалгасан Аръяабал бурханы хот мандал
өөрийн оронд орштугай.

15. ДАГЖИД БУЮУ ӨӨРТӨӨ АРЪЯАБАЛ БУРХНЫГ ҮҮСГЭХҮЙ

Анхан нь-УМ-САВАВА-ШҮДА-САРВА-ДАРМА-САВАВА-ШҮДА-ХУМ

Би хийгээд бясалгагч тэнгэр нугууд:мэдэгдэхүүн бүгд мөн чанар нь хоосон чанар лугаа төгөлдөршин нэгэн чанар лугаа болтугай чинагш тэнгэр нугууд: хоосон чанарын агаараас УМ-МА-НИ-БАДМЭ-ХУМ гэх тарина тунгалаг байдалтай орчлонгоор түгэн дүүрэх болтугай

Энэ нь дуун тэнгэр болой.

Би хийгээд тэнгэр ямагт ялгал үгүй байдалтай болж өөрийн сэтгэлд саран хот мандал босгоны тарина тодорхой тунгалаг байдал дээр огторгуйд машинд ариусан мөнгөн ус алтан элсэнд наалддагчилан цагийн хэлхээ хээ зураг байлдалд байгуулагдах болтугай.

Энэ нь үсгэн тэнгэр болой.

Тэрбээр огоот хувирч болгоомол алт мэт бадарсан мянган дэлбээт бадам цэцгийн цоморлогоос УМ-МА-НИ-БАД-МЭ-ХУМ хэмээх тэмдэг төгөлдөршиж саран дэвсгэр маанийн тарни сэлтээс элдэв гэрэл цацарч үзүүрээс нь, хутагтын лагшин таалашгүй гарч огторгуйн эн бүгдэд түгэж бурхан бодь садва бүгд дор тахилын их үүлээр хувилан сайтар тахиж бас тэр их үүл хувирч рашаанаар бороо орж там тэргүүт амьтан бүгдэд зовлонгийн галаас амирлуулан үйлдээд, тэнгэрийн лагшин сэлт дахин хураагдаж өөрийн сэтгэлийн саран дэвсгэр маанийн хот мандалийн тарнийн эрхэн сэлтэд оршоод түүнээсээ хувилж элдэв цэцэг саран дэвсгэр дээр өөр ямагт хутагт Арьяабал бурхан цагаан лагшинтай, идрийн жавхаа гэрэлтэн цацрах арван нэгэн нигүүртэй, язгуурын нигүүр цагаан баруун нь ногоон, зүүн нь улаан, түүний дээр голынх нь ногоон, баруун нь улаан, зүүн нь цагаан, түүний дээрхи голынх нь улаан, баруун нь цагаан, зүүн нь ногоон нигүүртэй тэдгээрийн мэлмий өргөн үзэсгэлэнтэй, нигүүр бүгд мишгэлзэнгүй байдалтай түүний дээр хилэгнэсэн дүрт баруун нигууртай их соёо нь ярзайсан дүр лугаа төгөлдөр гурван мэлмийтэй улаан шаргал сэвлэг дээш шуугдан боссон түүний оройд амирлангуй улаан нигуурт шүхэр лугаа сэлт эрхшээсэн байдалтай, чимэг үгүй өлмий жийсэн дүртэй, анхны хоёр мутар зүрхэн тушаа номончилсон баруун хоёрдох мутраар эрх гуравдах мутраар чогжингийн рашааны тусал бэрдийн цангах зовлонгоос гэтэлгэж, дөрөвдүгээр мутраараа хүрд барьсан, зүүн хоёрдох мутраар

иштэй алтан бадам цэцэг тэвэрсэн, гуравдах мутраар дашмагтай үрэл барьсан дөрөвдүгээр мутраар нум сум барьсан, үлдсэн ёсон зуун ерэн хоёр мутар лянхуа цэцгийн дэлбээ мэт зөөлөн өглөгийн мутарлагтай, мутар бүгд алганы толиондоо мэлмийтэй, мутрууд, дээшээ шүхэрээс илүүгүй, доошоо өвдөгнөөс доошгүй, гөрөөсний арьсаар зүүн хөхөө хаасан, торгон шамтав хормогчтой, эрдэнээр хээлсэн алтан бус шаргал, эрх мэт үзэсгэлэнтэй, эрдэнийн титэм, ээмэг, хүзүүний зүүлт, мөрний, гоёл, бугуйвч, хөлний чимэгтэй, элдэв өнгийн даавуугаар баримтаг эрхшээсэнээс цагаан гэрэл цацармой.

гэж санах дүрсний тэнгэр болой-

Түүний оройд нь УМ үсэг цагаан, хоолойд”а” үсэг улаан, зүрхэн тушаа “хум” үсэг хөх, таалалын саран хот мандлын дээр “хэрэ” үсэг цагаанаар хувирч УМ-БАДМА-ҮДА-ВА-ЕЭ-СУХА хэмээн уншиж бадам цэцгээр зүрхэн тушаа, хүйсэнд, хоолойд мөрөнд хүрч адисламой

Гэх нь мутарлаг тэнгэр болой-

Таалалаас ХЭРЭ үсэг гэрлээр цацарч мөн чанар нь хутагт Аръяабал бурхан нөхөр сэлтийн хамт эргэн залрах болтугай.

УМ,АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВАРА-ВАЗАР-САМАЯ-ЗА-ЗА ЗАА ЗАА-ХУМ-ВАМ-ХО- хэмээн өмнийн шибя буюу өмнө байгуулсан Аръяабал сэлт, өөрийн сэтгэлд байгуулсан дамцагва буюу тангарагтан Аръяабал хоёр хоёр зулыг нийлүүлэхэд дүрэлзэн манддаг шиг нэгэн дор ормой.

Гэж бодно- **Дахин таалалын ХЭРЭ** үсгээс гэрэл цацарч, Авид бурхан гололсон язгуурын таван бурхан нөхөр сэлтийг урин залмой. УМ-ВАНЗА-ГҮЛА-СА-ВА-РЭ-ВА-РЭ-АРГАМ-ВАДЭМ-ВҮВИ-ДҮВИ-АЛОГЭ-ГАНДЭ-НЭВДЭ-ШАВДА-брайдийн за суха-тахина

Хэмээн авшиг хайрласнаар рашаанаар бие дүүрч хир бүгд арилгаж, рашааны үлдэгдэл оройн оронд огоот хувирч оройд одбогмид бурхан, магнайд мижидба бурхан, баруун чихэнд ренжүн бурхан, ар дагзанд нанзад бурхан, зүүн чихэнд донёддүйва бурханы язгуураар чимэглэтүгэй.

Өөрийн таалалын саран дэвсгэр дээр өмнийн огторгуйн ишван буюу билиг билгийн бодьсадва хутагт Аръяабал цагаан нэг нигүүрт хоёр мутарын баруунаараа доош буулган алгаа дээш харуулсан, зүүнээрээ бадам цэцэг барьсан түүний таалал саран дэвсгэрт бясалгагч бодь садва “хэрэ” хэмээх цагаан үсгээр солонгорон гарах болтугай-

хэмээн бодож-тайлбарлан өөрийн тэнгэрийн лагшинг тодорхой тогтоон бясалгаад алдалгүй дүр төрхийг санан онцлон зүсэлвээс

тэнгэрийн бясалгал хэмээмүй,

цааш нь зургаан тэнгэрийг дараалан ургуулаж тэнгэр тус бүрийн лагшингийн өнгө мутарлаг тэргүүтнийг ялган тогтоож, олон төрлийн ой тогтоолтыг олон янзын байдлаар нь ургуулан бодож чадахыг самади бясалгал гэмой.

Самади бясалгалаар тэнгэрүүдийн лагшинг олон ажиглаж ялгалгүй нэгэн мөн чанарын үүднээс оршоох нь дияан бясалгал хэмээх хоёр хуваан үздэг бөгөөд ялангуяа хойд насанд сэтгэл орших орны тухайд амин судас орох зам хаагдах таарч хотол чугуулган бүрдэх ба тэдгээрийн насны тэнгэрийн лагшинд төвлөрөөд санан дурдлага орох ,орох үгүй нь үүднээс урьдын тэнгэрийн дүр байдлыг санан дуршаад бясалгалд живэхгүй хийгээд догшрох эрхэнд одолгүй, атгаг, мэдэмсэр тэргүүтэн дияаны үүлэнд мэргэшин лха тэнгэрийн байдал дүрийг бодьтой дадуулан төрүүлэж үйлдмой.

Цаашилбал өөрийн бие махбодийг өөрийн өчүүхэн бодлоос халиж хутагт нигүүлэнгүй Арьяабал бурхан илт заларч байна гэж омогшин хүчтэй хатуу бээр хослон суралцаж тус эрдэмийг бүтээмой.

Янагш утга нь хуурмаг мэт боловч чинагш бүтээл хоосон чанар лугаа төгөлдөр үлгэрлэвээс толинд өөрийн дүрс буусанчилан инагш утга хуурмаг боловч чинагш хоосон чанарыг барин толин дах дүр өөр зүйлийн бус зөвхөн хувь дүр мөн хэмээн гүн гүнзгий, нэгэн үзүүрт сэтгэлээр дадуулбаас егүзэрийн дамжлагын анхан шатны үе болой.

Зургаан бодийн үүднээс өөртөө үүсгэх тэнгэрийн бясалгал ануу их ловон санжайсан бээр доржнамжамтай холбон эхлээд түй буюу угаал өргөж, очирт олбогонд оршоод тахил, залбиралаар зургаан тэнгэрийг бясалган, хоосон чанарт үсэг аялгуу хэлбэрт болон мутарлаг тэмдэг бүгд зургаа нь Доржнамжамын дамжлага дэлгэрэнгүйн утгаас зарлигласан болой.

16. ДАГЖИДИЙН ЧОДВО ЖАНЛАВ БУЮУ АРЪЯАБАЛ БУРХАНЫГ ӨӨРТӨӨ ҮҮСГЭХИЙН ТАХИЛ АДИСЛАЛТ

Тэгээд өөрөө тэнгэр үүтгэхийн тахил нь –УМ БАДМАН ДАГЭРДЭ ХУМ ПАД хэмээх таринаар зорилго сэлтийн үүднээс тотгороо арилгаж ариусган САВАВА-хэмээх таринаар хоосрон ялгарч хоосон чанарын агаараас БҮРЭМ-үсгээс эрдэнийн их сав уужим нугуудын дотор УМ- үсэг гэрлээр хайлан Аргам тахил, Бадамцэцгэн тахил, хүжин тахил, зулан тахил, үнэртэй усан тахил, идээн тахил, эгшигт хөгжмийн тахил мөн, чанар нь хоосон чанарийн байдалтай тус тусын тахилын хэлбэртэй ялгамжаа нь цувиралтгүй амгалангийн гүү сан болтугай.

Аргэ-ахум, Бадээн-ахум, Бүйвээн ахум, дүйвээн-ахум, алогээн-ахум, гандэ-ахум, нэвдэ-ахум, шавда-ахум, тэргүүтэнийг хот мандлын тахил мэт өргөмөй.

УМ-Аръяа-Логи-Шүра-Сава-Рэварэ-Аргам, Бадэм, Бисви, Дүйви, Алогэ, Гандэ, Нивдэ, Шавда-А хум хэмээн дэс дараалан уншина. Дэлгэрүүлж урьд 4 шүлгээр магтан уншиж болно.

Магтаал нь.

Бурхан бүгдийн эрхэм дандар
Бүхий л дээд эрдмийн сав
Мэлмийгээр болгоогч хэмээх алдарт
Мөнхийн энэрэлт тан дор мөргөмөй.

Тарина таалахын адистэд ануу:

Алга хавсран залбирч

Ума-Гүрү-Сарва-Дата-Гада-Гаяа-Вага-Зэдэ-Бара-Мина-Сарва-Дата-Гада-Вазар-Вада-Ванданам-Га-Ро-Мэ

хэмээх багш- тэнгэрт ёсчилон мөргөж зохилдох гэж үйл бүгдийг нэмэн оруулж

Васу-Мада-Шри-Суха7 уншиж адэстэдлэнэ.

Өөрийн талаалын саран дэвсгэрт дияанч эцсийн тарина өгүүлж дуусмагц таринийн хэлхээ цагаан өнгө бээр нар зөв эргэн гэрэл цацарч, өөрийн биеийн дотор бүхэн дүүрч хилэнц бүгд арилж, гэрэл гадагш цацарч Аръяабал бурхан тоолшгүй олон цацарч хамаг амьтны хилэнц арилж, өлзий хутагтыг оршоож буцан таалалын хэрэ үсгэнд шингэмөй-

хэмээн бодоод-

НАМУ-РАДНА-ДАРА-ЯА, НАМА-АРЪЯА-ЗАНА-СА-ГА-РА, БИРААН-ЗАНА-БИХУ-РАЗА-ЯА, ДАТА ГАДА-ЯА, НАМ-САРВА-ДИТАГАДА-БИ, АРХАДИ-БИ, САМНИГ-САМБУДА-ЯА НАМА-

АВАЛОГАДЭ-ШУРА-ЯА-БОДИСАДУ-ЯА-, МАХА-САДА-ЯА, МАХА-ГАРУНИ-ГАЯАДАДЪЯАТА УМ ДАРА-ДАРА ДЭРЭ ДЭРЭ, ДҮРҮ-ДҮРҮ ЭНДА-ВАНДЭ, ЗАЛИ ЗАЛИ, БАРАЗАЛИ-БАРАЗИЛИ, ГҮСҮМИ, ГҮСҮМАБАРИ, ЭЛИ-МЭЛИ, ЗЭДЭ-ЗУЛА-МА-БА-НА-ЯА-СУХА

хэмээн урт тариньг бүтнээр нь уншаад хураангуйг 108 тоолж сүүлд нь хэмээн уншиж дутуу буруу уншсан нугуудаа адислана.

17. ДҮНЖИД БУЮУ АРЪЯАБАЛ БУРХАНЫГ ӨМНӨӨ БЯСАЛГАХ БҮТЭЭЛ АНУУ

Тамжид чинба Гэндүнжамц гэгээний айлдсанчилан

УМ-БАДМАНДА-ГЭРДЭ ХУМ-ПАД-

гэх таринаар өмнийн огторгуйн саад бүгдийг арилгаад

УМ-СУВА-ВА-ШҮДА-САРВА-ДАРМА-САВАВА-ШҮДА-ХУМ

хот мандал хоосон чанар дор оршовой-хоосон чанарын агаараас өөрийн тагаалалд “хэрэ” үсэгээс “бүрэм”-хэмээх цагаан үсэг тав бээр очлон цацарч түгээд, хот мандал дахин шинээр оршоомой-

тэгүүнчилэн огоот хувирч олон дэлбээт бадам цэцгийн төвд очирт цоморлогон хүйсэн дээр элдэв эрдэнээс бүтсэн орд харш дөрвөлжин дөрвөн үүдтэй, үүд тус бүр гоёмсог дааман хаалгатай хот мандалын төвд найман дэлбээт цэцгийн хүйсэн их эрдэнийн арслант ширээнд саран дэвсгэр, түүнийг тойрон дөрвөн зүгийн дэлбээ тус бүр саран дэвсгэрт арслан ширээ хийгээд төвийн арслант ширээн дээр” хэрэ”-гэх цагаан үсгээс найман дэлбээт алтан лянхуа мэт “хэрэ” үсэг тодрон тэгүүнээс гэрэл цацарч хутагтыг тахиад, амьтны тусын тулд нааш огоот хувилаж, хутагт Аръяабалын идэрийн цог залиар гэрэлтсэн цагаан лагшин арван нэгэн нигүүртай, гол нигүүр нь цагаан, баруун ногоон зүүн нь улаан, хоёрдугаар эгнээний голын нигүүр ногоон, баруун нь улаан, зүүн нь, цагаан, түүний дээд эгнээний голын нигүүр улаан, баруун нь, цагаан, зүүн нь ногоон, тэдгээр нигүүруудын мэлмий нарийн царай, мэгшгэлзэнгүй байдалтай, түүний дээр хилэнт баруун нигуур соёо шүд, ярзайсан гурван мэлмийтэй, улаан шаргал үсээ дээш боож тогтоосон, түүний магнайд амирлангуй улаан нигуур титэм сэлт лугаа тодорсон байдалтай, чимэг үгүйн анхны хоёр мутраар алга хавсран залбирч, барууны хоёрдох мутраар эрх, гуравдахиар тэгш агуулж түүнээс рашааны дусал

бэрдэд унаж бэрдийн цангааг тайлан, дөрөвдүгээр нь хорол барьж, зүүний хоёрдугаар мутраар алтан цэцэг, сэлт, гуравдахиар үрэл бумбатай, дөрөвдүгээрээр нум сум, барьж, үлдсэн, мутраар 992 бадам цэцгийн дэлбээ мэт сунган тэгш агуулах мутарлагтай мутар бүгдийн толионд тус бүр мэлмийтэй. Мутар бүгд дээшээ титэмээс хэтрэлгүй доош өвдөгнөөс илүүгүй, гөрөөсний арьсаар зүүн хөхөө хаасан, үзэсгэлэнт торгон хормойвчтой. Эрдэнэ чимсэн бүстэй, дээш босох сэвлэгтээ эрхэн чимэгээр чимсэн, их эрдэнийн титэм ээмэг, хүзүүвч, тохиовч, бугуйвч, хөлийн чимэгтэй, элдэв торгон баринтаг асаан гэрэл цацраасан, зүүндээ ХУМ-үсгээс гарсан “Мижидва” бурхан хөхөмдөг, баруун мутраар газар дарах мутарлагт зүүнээ тэгш агуулсан мутарлагт урьд зүгт дарам үсгээс Ренжүн бурхан шаргал, баруун мутар алгаа дэлгэн дээш харуулсан мутарлагт зүүнээ тэгш агуулсан мутарлагт, баруун талд -ум-үсгээс НАМНАН бурхан цагаан бодийн дээдийн мутарлагт хойд талд “А”үсгээс гарсан”Дондүв” бурхан ногоон баруун мутарт аврал өглөгийн зүүн нь тэгш агуулахын мутарлагт тэдгээр бүгд эрдэнийн чимэгт элдэв торгон баринтагаар гоёсон өлмий нь очир завилгаанд оршиж буйн үндсэн бурханы тагаалал лянхуа сарны дээр “ХЭРЭ” үсэг цагаан түүнээс гэрэл цацарч өмнийн бодлын орноос хутагт Арьяабал бурхан, арван зүгийн бурхад, бодьсадба нарын чугуулган сэлтийг урин залмой.

Хэмээн алга багахан хавсарч хоёр хуруу нийлүүлэн дээш доош ялимгүй хөдөлгөн урин залахын мутарлагтай хүж барин номончилж

Хамаг амьтан бүгдийн аврал болсон
Хийрхэл омгийг дарагч их тэнгэр
Ямагт бүгдийг үнэхээр болгоогч
Ялгуугсан эрхт бурхан та залартугай

Умаан арьяа-логи-шүра-са-ва-рэ-ва-ра-базар-сама-яа-за-за-

хэмээн ишван буюу өмнийн огторгуйгаас арьяабал бурханг урин зална.

ЗА-ХУМ-БАМ-ХО-

Дамцагба буюу өөрийн сэтгэлд байгуулсан Арьяабал бурхан, ишван буюу өмнийн огторгуйн Арьяабал бурхантай хоёр үгүйн агаараас нэгдэмой

Бурхад бүгдийн магнайд УМ-Үсэг цагаан, хоолойд”А” үсэг улаан, зүрхэнд “хум” үсэг хөх өнгөөр тодорч, “ дахин зүрхнээс “хэрэ” үсэг гарч гэрэл цацран Одбагмид бурхан голлосон язгуурын таван бурхан нөхөр сэлт залармой.

УМ-Банза-гүла-саварэвара - аргаам-баридан за суха.

-Бадээм-

-Гандээн-

-Бүсвээн-

-Дүйвэн-

-Алогээн-

-Гандээн-

-Нэвдээн-

-Шавдаан-хэмээн *тахиад*

Ялж төгс нөхчигсөн бурхан та энэ оронд илт авшиг хайрлан соёрхоо. хэмээн залбирсныг хүчин бээр тэдгээр бурхан нугуудын тагаалалаас цацран гарах гойгарму тэргүүтэй охин тэнгэр бээр рашаан дүүрсэн бумба бариад

Төрхдөө үзүүлсэн гайхамшгийг

Тэнгэр сэлт угаал өргөн хүндэлж

Ариун тэнгэрийн тэр рашаанаар

Амьтан бүхэнд угаалгыг соёрх

УМ-АА-САРВА-ДАТА-ГАДА-АВА-ХИ-ГАДА-СА-МАЯ-ШРИ-АА-ХУМ

хэмээн зарлигласан авшиг бээр биеийн дотор бүхэн дүүрч хир бүгд ариусч, рашааны үлдэгдэл оронд оршин хувирч Одбагмид магнайд, оройд мижэдба, баруун чихэнд ренжин,дагзанд нанзад, зүүн чихэнд Дондүв, бурханы титмэн чимэгтэй болмой.

18. ДҮНЖИДИЙН ТАХИЛ АДИСЛАМОЙ

УМ-БАДМАН-ДА-ГЭРДЭ-ХУМ-ПАД

УМАА-САВАВА-ШҮДО-САРВА, ДАРМА-САВАВА-ШҮДО ХУМ хоосон чанарын агаараас “Бүрүм” үсгээс их эрдэнийн уужим агуу их савын дотор УМ-үсгээс цацран хоёр усан тахил, цэцэг, хүж зул, үнэрт ус идээ, тэргүүтэй тахил дуу хөгжим өргөхүй мөн чанар хоосон ,авир байдал тус тусын үйлийг бэлгэдсэн буцалтгүй амгалангийн гүү сан болтугай.

Хэмээн тус тусын мутарлагтай уншина.

1.Аргээн аахум

2.Бадээн-аахум

3.Бүсвийн аахум

- 4.Дүйвийн-ахум
- 5.Алогээн-ахум
- 6.Гандээн-ахум
- 7.Нэвдээн-ахум
- 8.Шавдаан-ахумгээд цааш хүслийн таван тахил өргөнө

- 1.рүүбаан-ахум,
- 2.шавдаан-ахум,
- 3.Гандээн аахум
- 4.Расаан-ахум

5.Варшаан ахум, -хэмээн дүрс, дуу, үнэр, амт, мэдрэхүйн таван тахил өргөмөй

хэмээн адислаад энэхүү тахил өргөх үест тахилын охин тэнгэр өөрийн таалалаас цацран гарч идээ бүрийг барин өргөхөд орчлонгоор дүүрэн арвижиж байна гэж санан уншихуй:

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдэмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй

УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА–АРГААМ-
БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй

УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА–БАДЭЭМ-
БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй

УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА–Бүсви-
БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй

УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА–Дүйви--

БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА—Алогэ--

БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА—Гандэ--

БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА—Нэвдэ--

БАРИДИНЗА СУХА

Бурханы далайн тахилаас бүрдсэн
Бүхий орны тахилын далай сэлт
Эрдмийн далай бурхан нугуудад
Энгүй сүжигийн тахил өргөмөй
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА—Шавда--

БАРИДИНЗА СУХА

Буянт орны бурхан нугуудыг
Бодит сэтгэлээрээ дүрслэн санаж
Хоосон чанарын сэтгэлээр өргөснийг
Хосгүй амгалант та болгоон соёрхоо
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-САВА-РЭ-ВА-РА-РУВА-БАРИДИЙН

ЗА СУХА.

Буянт орны бурхан нугуудыг
Бодит сэтгэлээрээ дүрслэн санаж
Хоосон чанарын сэтгэлээр өргөснийг
Хосгүй амгалант та болгоон соёрхоо

УМА-АРЪЯА-ЛОГИ-ШҮРА-САВА-РЭ-ВА-РА-ШАВДА-
БАРИДИЙН ЗА СУХА.

Буянт орны бурхан нугуудыг
Бодит сэтгэлээрээ дүрслэн санаж

Хоосон чанарын сэтгэлээр өргөснийг
Хосгүй амгалант та болгоон соёрхоо
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШУРА-САВА-РЭ-ВА-РА-ГАНДЭ-
БАРИДИЙН ЗА СУХА.

Буянт орны бурхан нугуудыг
Бодит сэтгэлээрээ дүрслэн санаж
Хоосон чанарын сэтгэлээр өргөснийг
Хосгүй амгалант та болгоон соёрхоо
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШУРА-САВА-РЭ-ВА-РА-РАСА-
БАРИДИЙНЗА СУХА.

Буянт орны бурхан нугуудыг
Бодит сэтгэлээрээ дүрслэн санаж
Хоосон чанарын сэтгэлээр өргөснийг
Хосгүй амгалант та болгоон соёрхоо
УМА-АРЪЯА-ЛОГИ-ШУРА-САВА-РЭ-ВА-РА-ВАРША
-БАРИДИЙНЗА СУХА.

шавда-хэмээхийг уншихад хөгжим дуу өргөж үүлдмой.

Элдэв эрх нум мэт дэлгэрч

Энх амгалангийн үрийг түгээж

Оюун ухааны дээл өргөж

Онцгой тэсвэрийн бүсээр чимтүгэй

–барантаг өргөхүй- “**Ум базар бастрээн ахум суха**”

Билиг найрагт бурханы чимгийг

Бусад хүмүүс өмсч чадахгүй ч

Эрдэнийн чимэг өргөсний буянаар

Энгүй лагшинг олон болтугай **.Ум-базар-алам-гара-ба-бү-
хана-ахум-сухаа.**

–чимэг өргөмой-

Эрдэнийн чимэгт өлзийт бумба

Элдэв сайнаар дүүрсэнийг өргөө

Үйл нямангийн хир бүгдийг

Үлэмж бодийн рашаанаар арилтугай

УМ-БАЗАР-ГЭЛА-ША-АХУМ

19. МАНДАЛ ХУРААНГУЙ

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд
Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг
Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр
Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

УМАСАРВА ТАДАГАДА ЯДАМ ГҮРҮ РАДНА МАНДАЛА ХАМ НАРАЯ ДАРЯАМИ

Мянган мутарт загарбардийн хаан
Мэлмийгээр болгоогч сайн бурхан
Хаана , хэнд ч энэрэлийн гуусан
Хатан зоригт Аръяабал дор мөргөн магтая
Огторгуйн энтэй адил лагшинт
Одод солонго мэт тус тусдаа гэрэлтэх
Арга билгийн дээдийг эрхшээгч
Амгалант язгуурын бурхадыг магтая
Өөрт орших хийгээд өмнө орших Аръяабалын мутраас гарах
Энэрэлийн рашаан тасралт үгүй бууж бумбаа дүүргэмой

**Наму-радна-дара-яа-нама- аръяа-зана-са-гара-бира-зана-
бүха- раза-ла, датагада-яа, нама-сарва-датагадэ-би, архадэ-
би, сам-няга сам-бүди-би, нама-аръяа аво-логи-дэ-шүра-яа,
бодисаду-яа, маха-саду-яа маха-гаруни-гаяа, дад-ята ум-дара-
дара, дэрэ-дэрэ, дүрү, дүрү, эда-вадэ, зали-зали, баразали-
баразали, гүсү-ми, гүсү- мабарэ, эли-мэли , зэда-зула, ма-ба-
на-еэ-суха**

их тогтоол тариныг 108 унших бадамсаду- тарни тоолох.

Өмнийн рашаант бумба мөн чанар билиг билгүүн болгоон
авар байдал нь лагшин, зарлиг таалал бээр өвчин, ад, хилэнц
түүтгэр, бүгдийг ариусгах чадалт рашаан болох болтугай.

хэмээн бумбаа дүвлээд:

Өөрт байгуулсан Аръяабал Бурхан

Өмнөө байгуулсан Аръяабал бурханд шингэмой

Өөрийн оройн лянхуа саран дэвсгэр дээр гэлонма-балму
бээр машид гарасны хэргэл сэлттэй хоёр мутар бээр алга хавсран
зүрхэн тушаа залбирч буйгаар сэтгэлд оршитугай.

20. ЖИГДЭНГОМБО ХЭМЭЭХ АРЪЯАБАЛ БУРХАНЫ МӨРГӨЛ

*хэмээн өөрийн эргэн тойронд ээж аав болсон зургаан
зүйлийн хамаг амьтанг байгуулж тэгүүнд биетээрээ мөргөж,
хэлбэрээ магтаж, сэтгэл бээрээ сүсэглэж аврал одуулаад*

УМАА.Орчлонгийн аврал танд мөргөмүү
Гурван орчлонд байх багш нарыг магтму
Гуа тэнгэр эрхэм эсүра нарыг магтму
Ялгуугсан бурханыг ямагт магтан зохиомуй
Ямар мэт орчлонг болгоох танд дор мөргөмү
Тэгүүчилэн ирэгсний сайн лагшинг баригчү
Тэргэл гэрэлт нанвантаеэ титэмтүү
Баруун мутраар бэрдийн цангааг тайлагчү
Бас зүүнээр алтан лянхуаг чимэгчү
Үнэр анхилам улбар эрх баригчү
Үзэсгэлэнт саран гоо сайхан нигүүртүү
Агуу уужим цэцгэн чимгийг баригчү
Аман дотор бээн дун цагаан шүдэтүү
Ургах нар шиг улаан гэрлээр чимэгчү
Усан далайд бадам цэцэг дэлгээчүү
Намрын үүлний өнгө төгөлдөр идэрүү
Навчин чимэг мөрөн дөгөөн зүүгээчүү
Гарын толионд мэлмий бээрээ чимээчүү
Гөрөөний арьсаар хөх юугаа ороогоочү
Хосгүй эрдэнээр чих юугаа чимээчүү
Хиргүй бадам цэцгийн төвд оршоочү
Цоморлогоо тойрох дэлбээ мэт үзэмжээтүү
Цайран эрдэнийн алтан бүс бүслээчүү
Өнгө төгөлдөр торгон хормогч зүүгээчүү
Өнөд билгийн далай гэтлэгч бурхануу
Хоёр чуулганаар буян их хураагаачү
Хосгүй амгалант өвчин өвгөрөлийг арилгаачү
Ажил эцэслэгч дагинас үйлийг үзүүлээчүү
Амьтны дээд омогийг ялагч бурхануу
Хөлийн алтан чимгээр өлмийдэгээн зүүгээчүү
Хоолой эсүра мэт аглаг орон зохиогоочү
Галуун цуваагаар их заан шиг залраачү
Гайхам бүрэн шашин юугаа эрхэмлээчүү
Усан далайгаас сүү юугаа ялгаачү
Ургах нарнаар үргэлж босон бишрээчү

Аръяабалын ажлыг сэтгэлдээ төрүүлээчүү
Ашдийн магтаалыг ариун тодорхой үзүүлээчүү
Эр эм бүгд хүмүүн олонд туслаачү
Ирээдүй төрөх төрөл тутамдаа асраачү
Олигүй тааруу нь орчлонд олон төрөөчү
Овоо буянтай нь Аръябалтай учиртугай
21 удаа уншина, мөргөж

21. ЛАМАН ЧОДВО БУЮУ БАГШИЙН ТАХИЛЫН ХЭСГЭЭС (ШИНЧОГДАМБА)

Орны дээдэд, дээдэс хутагт багш дор
Олон тахиж бишрэн залбарисны хүчээр
Сайн амгалангийн ёзоор итгэлт та ямагт бээр
Сайтар баясан даган барих дор адистэдлэмой.

Нэг төдий олдсон чөлөө учралт энэ бие нь
Нэн олоход бэрх, түргэн эвдэрэх ёсыг мэдээд
Утга үгүй энэ насны ажил алгасрал бүгдийг
Утга төгөлдөр шимийг авах дор адистэдэлмой.

Муу заяаны зовлон бадарсан галаас айгаад
Мөдхөн чухаг дээд гуравт авралыг одуулах ба
Хилэнцийг тэвчиж, буян чуулган бүгдийг бүтээх дор
Хичээлийг цохлон авч үйлдэх дор адистэдэлмой.
Үйл хийгээд нисваанисын давалгаа хүчтэй хямарч
Гурван зовлонгийн олон матар бээр хөнөөж
Хязгааргүй аюул болох орчлонгийн их далайгаас
Гэтлэхийн хүсэл хүчтэй хатуу төрүүлэх дор адистэдэлмой.

Тэсэхэд бэрх шорон адил энэхүү орчлонг
Баясгалангийн цэцэрлэг мэт үздэг оюуныг тэвчээд
Гурван сургаал хутагтын эдийн гуу санг бариад
Гэтлэхийн дуазыг барих дор адистэдлэмой.

Доройтсон амьтан бүхэн миний л ээж гэж
Дахин дахин ачаар тэтгэсэн ёсыг санаад
Энэлэсэн хөвгүүнээ энэрэх эхчилэн дор
Энэрэнгүй сэтгэлийг завсар үгүй адистэдлэмой.

Зовлонг өчүүхэн төдий ч үл хүсэх бөгөөд
Амгалан дор хэзээ ч болио мэдэл үгүй ану
Би хийгээд бусад дор ялгамж үгүй тэгш хэмээн
Бусдад амгаланг үүсгэх дор адистэдлэмой.
Өөр ямагтыг үргэлж энхрийлэх ужиг өвчин энэ нь
Үл хүсэх зовлонг үүсгэдгийн уг гэдгийг ойлгоод
Уршигаар хөөгдсөн дор өсөнд барьж үйлдэх
Минимхийрэн барих их адыг дарахад адистэдлэмой.

Хамаг амьтанг эхчилэн барих амгалант оюун
Хязгааргүй эрдэм гардгийн үүдэнд дор үзээд
Амьтан бүгд миний эсрэг дайсан болсон ч
Амьнаасаа илүү оюун ухааныг адистэдлэмой.

Товчилбоос, нялхас өөрийн тус ямагт хийж
Бурхан бусдын тус ямагтыг зохиодгийг
Гэм хийгээд эрдмийн ялгааг онох оюунаар
Өөрийг бусдаар солин тэгшлэж чадахуйд адистэдлэмой.

Өөрийгөө ямагт магтвал буурал бүгдийн үүд
Өрөөлийг магтвал эрдэм бүгдийн суурь
Тиймийн тул өөрийг бусдаар сольдог егүзэр дор
Тэрчилэн анхаарч шимлэж үйлдэх дор адистэдлэмой.

Тийм бээр хутагт багшийн их энэрэлээр
Түйтгэр хилинц амьтны зовлон бүхэн
Хоцроолгүй над дор боловсрох хийгээд
Өөрийн амгаланг бусдад шилжүүлэж
Өрөөл бусдыг амгалан дор адистэдлэмой

Хорвоо Сав, шим, хилэнц үрээр дүүрээд
Хүсэшгүй зовлон хур мэт бууж болохноо ч
Муу үйлийн үр тасдахыг чухалд үзээд
Муу шалтгааны мөрийг үгүйсгэж адистэдлэмой.

Товчилбоос, сайн муу үзэгдэл юу ургасан ч
Ном бүхний шимийг анхааран авалт бээр
Түвшин бодийн сэтгэлийг арвижуулаж
Нийлэмжит сэтгэлийн амгаланг адистэдлэмой

Дөрвөн найрлага лугаа төгөлдөрийн уран аргаар
Даруй болон алсын алинд ч бясалгаж бэлтгээд
Оюун судлахуйн тангараг сургаалыг анхааран авах бээр
Онцгойлж чөлөө учрал тус үйлдэхэд адистэдлэмой.

Өгөх авахын хий дор унуулсан оньсон аргатан
Асрахуй хийгээд нигүүлсэхүй үлэмжийн санаагаар
Амьтан нугуудын орчлонгийн далайгаас гэтлэхийн тулд
Бодийн сэтгэл ямагтыг судлах дор адистэдлэмой.
Гурван цагийн бурхан бүхний зорчих нэг мөр нь
Ариун бурхан бодьсадын санваараар сэтгэлийг увидаслаж
Хөлгийн дээд шагшаабадыг анхааран авах дор
Хичээлийг цохлон авч үйлдэхэд адистэдлэмой.

Бие хийгээд төгс эдлэл гурван цагийн чуулган сэлт
Амьтан өөр өөрийн хүссэнийг бодитойгоор урвуулж
Тачаалтгүй өгөхийн сэтгэлийг арвижуулахын увидасаар
Өглөгийн барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Тусад гэтэлгэх, бодьсад, нууц тарнийн увидасын
Хууль цаазыг аминыхаа тухайтад ч үл өгөх бөгөөд
Буян ном хураах хийгээд амьтны тусыг бүтээх
Шагшаабадын барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Гурван орны төрөлхийтөн бүгд хоцроолгүй уурлаад
Гутаах хорих уурлах, занах хийгээд амийг нь тасалсан ч
Тусыг бүтээж үйлдэн хорлосны хариуг өгдөг
Тэсвэрийн барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Амьтан нэжгээд нэжгээдийн тухайд ч нэрмэлтгүй
Аюулт тамын галын дотор олон галав дор орших хэрэгтэй ч
Нигүүлсэнгүйгээр уйсахгүй бодийг хичээсэн
Хичээлийн барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Живэх, догшрох, алгасрахын гэмийг тэвчээд
Жинхэнэ юм бүхэн үнэхээр хоосны мөн чанар дор
Сайтар нэгэн бодол тэгш агуулах бясалгалаар
Самади барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Хоосон чанарыг тус тус онохуйн билгүүнээр
Татагдсан машид судлагдан их амгалан лугаа холбогдсон

Хоосон чанарыг тэгш агуулах огторгуйн егүзэр бээр
Тэргүүн билгэ барамидыг төгсгөх дор адистэдлэмой.

Гадна дотно юмс нугууд илбэ зүүд хийгээд
Тунгалагийн далайн дотор сарны дүрс ямарчлан
Тийн үзэгдэхнээн ч үнэн үгүй ёсыг оноод
Илбийн бясалгалыг төгсгөх дор адистэдлэмой.

Орчлон нирвааны мөн чанар хумхийн тоос төдий үгүй
Уг үр, шүтэн барилдлага хуурмаггүй хоёр
Харилцан харшлахгүй нөхөр дор ургасныг
Хосгүй Нагаржунайн таалал дор адистэдлэмой.

Түүнээс Очир баригч сартваахын ачаар
Дандарын аймгийн далайн төвийг гатлаад
Агуу шид бүтээлийн ёзоор тангараг санваарыг
Амь шигээ энхрийлэн барих дор адистэдлэмой.

Төрөх, үхэх, зуурдын бурханы гурван лагшин дор
Түр урвуулах анхдугаар зэргийн егүзэр бөгөөд
Эгэлийн үзэгдэл шунал хир бүхнийг судлаад
Эхэлж үзэгдэх бурханы лагшин дор адистэдлэмой

Зүрхний найман навчит Дүди судасны гол дор
Итгэлт таны өлмийн гэгээ байгуулахаас гарсан
Ил гэрэл, илбийн лагшин хослон орохын мөр
Илтэд урвуулаж энэ насан дор адистэдлэмой.

Мөрийн голыг эс барьж үхэхийн цаг ирвээс
Магад одуулах бурханы арга юүлэх ану
Таван хүчээр үнэхээр бэлтгэсэн увидас бээр
Тэртээх арилсан орон дор зорчуулж адистэдлэмой.

Товчилбоос, төрөх төрөл тутамдаа
Та бээр хагацалгүй дагуулан бариад
Таалал лагшин зарлиг нууцыг барихын
Том хөвүүн нь болгож адистэдлэмой.

Авралт та хаана илт бурхан болсон ч
Анд нөхөр нь ямагт би болох бөгөөд
Ахуй үес, эцэс хойтын хүсэл хоцроолгүй

Аяндаа бүтээхийн өлзий хутгийг хайрламуй.

Тэр мэт соёрхолыг тависан багш дээд
Тэрчилэн адислаж баясал оройдоо залж
Дахин бууж зүрхний лянхуар дамжин
Өлмийг гэрэлтүүлж бат оршуулж соёрхмуй
Ерөөл өргөхүй
Тэр мэт үйлдсэн нэн цагаан буян ч
Тэртээх гурван цагийн бурхан шавь сэлт
Зохиол ерөөл хоцроолгүй бүтээх хийгээд
Зөв иш онолт дээдийн ном барих уг дор зориулмой

Түүний хүчээр төрөл тутамдаа би бээр
Тэргүүн хөлгийн дөрвөн хүрд лугаа хагацалгүй
Магад гарах бодийн сэтгэл үнэн үзэл хийгээд
Мөр хоёрын зэрэгт зорчихын эцэст хүрэх болтугай.

22. ТӨГСГӨЛИЙН УНШЛАГА ЧОГО ЗАН ҮЙЛ ЗАЛБИРАЛ

Хутагт аръяабал энэрэлийн санта
Хотол олон над дор аврал соёрх
Би тэргүүт хамаг амьтан бүхнийг
Битүү хүлээст орчлонгоос гэтэлгэ
Тэнцэшгүй агуу гүнзгий бодийг
Түргэн дамжуулан төрүүлж соёрх
Тэргүүлэшгүйгээс хураасан үйлийн үрийг
Таалалын рашаанаар түргэн угааж
Татах нь баталгаатай ч сүжиг тааруутанд
Тэргүүн диваажин орныг сануулж соёрх
Аминдава, Аръяабал хоёр бурхан
Аль ч төрөлд минь буяны садан болж
Андууралгүй сайн замыг харуулж
Алс бурханы оронд оршоож соёрх

*Хэмээн хүчтэй хатуу залбирч болон өргөх ануу: эхлээд ядам
сахиусанд рашаанаар сүрчин*

Ум бадмандагэрдэ хум пад, ум савава-шүдо-сарва-дарма-

савава-шүдо-хум

хоосон чанарын агаараас бүрэм үсгээс гарсан их эрдэнийн сав уужим агуу ихийн дотор ум-үсэг гэрлээр хайлан шингэрч цувралтгүй амгалангийн идээ балин билиг билгийн рашааны далай болтугай.

УМ-АА-ХУМ хэмээн 3 уншин адислаад

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-ЕДАМ-БАЛИМДА-ХА-ХА-ХА-ХЭ-ХА-ХЭ

гэж 3 уншаад балин өргөмөй.

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА. АРГАМ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА. БАДАМ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА. БҮСВҮЙ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА. ДҮЙВИ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА. АЛОГЭ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА ГАНДЭ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА НЭВДЭ-

УМ-АРЯА-ЛОГИ-ШҮРА-СА-ВА-РЭ-ВА-РА-БАРИДИЙН ЗА СУХА ШАВДА-

хэмээн тахил өргөмөй.

Мянган мутарт Загарбардын хаан
Мэлмийгээрээ болгоогч энэрэлт бурхан
Хаана хэнд ч энэрэлийн гүү сан
Хатан зоригт Арьяабалдор мөргөн магтая.

Тайлбар 2-р идээ балинг өөрийн сахиусанд болон өөрийн сахиусанд болон махгал хандо сүрмаад эгшиний залбирлаар өөр өөрийн оронд нь өргөж баясгахуй дор бодоод

УМ-АГАРАМУ-ХАМ-САРВА-ДАРМА-НАМ АДЪЯА- НҮДЭДА-УМААХУМПАД- СУХА.

Гэж 3 уншина.

Дагинас сүрмаад идээ балин өргөхүй:

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-АРГАМ-

БАРИДИМЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-БААДЭМ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-БҮСВИ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-ДҮЙВЭ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-АЛОГЭ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-ГАНДЭ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-НИВДЭ-БАРИДИМ ЗА СУХА

УМ-ДАГИ-НИ-ШРИ-ДАРМА-БАЛА-СА-ВА-РЭ-ВА-РА-ШАВДА-БАРИДИМ ЗА СУХА

Цагаан зүгийг дэмжигч дагинас сахиус нугууд хүсэлийн таван эрдэм лугаа төгөлдөр тахил идээ зооглоод, шашин дэлгэрч амьтан, бүгд амгалан лугаа төгөлдөршин би тэргүүтэн амьтан бүгдийн санасан хэрэг сэтгэлчилэн бүтэхүй дор зохио

Тахил балин өргөлөг

Агарүму-хам-сарва-дарва-адъяа -Нүба-надада Нама-сарва-датаГада-авологиде” ум-самварСамвараа хум-

хэмээн 3-н удаа сагнахад савдаг, бүгд нүгнай буюу хатууд оршихуй ламын ойр байж үүлийг бүтээнэ хэмээн амлаж бүтээгчид ч нүгнээд сууж буй адил өргөж байхыг үлгэрээс татан үзүүлсэнийг санан ,тэнгэр лус савдагт тахил өргөх зохилтой.

Савдагт балин өргөлөг

Тэгүүнчилэн ирэгсэн Бурхан ренчин ман дор мөргөмүй.

Тэгүүнчилэн ирэгсэн Бурхан Сүгзэ дамбад мөргөмүй

Тэгүүнчилэн ирэгсэн Бурхан ,Гүжам лха-д мөргөмүй

Тэгүүнчилэн ирэгсэн Бурхан Жигва тамжиддан баралбаад мөргөмүй

Хүчит найман шивдаг тэргүүтэнд

Хүсэлийн таван эрдэнийн идээ өргөснөөр

Шашин дэлгэрч харш бүгд арилж

Санасан хэрэг сэтгэлчилэн бүтэг

хэмээн илт толинд тэнгэрийн дүрс ургахуй дор соёрхоод унших нь

Өөрийн таалалаас цацрах охин тэнгэр, рашаантай бумба
бариад

Өмнийн Аръяабал бурхан лам, едам баатар, дагинас,
сахиусанд угаал өргөж

Өрөөлд орших сэтгэлийн муу бүгд арилмой
Амьтаны зул Аръяабал бурхандаа
Анхилам үнэрт рашаанаар угаал өргөж
Адаг хүмүүний хир дэв оргүй арилж
Агуу ариун лагшинг олох болтугай.

**УМ-САРВА-ДАТА-ГАДА-АРЪЯА-ЛОГИ-ШУРА-
САВА-РЕ-ВАРА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-А-ХУМ**

Урьд өргөсөн угаалын үргэлжлэл:

Тэгүүнчилэн ирэгсэн бурхан бодьсадба
Тэрхүү бумбын ариун рашаанаар
Сэтгэлд зохистойгоор биеээ рашаалж
Сэнгэнэх дуу хөгжимтэй угаал соёрх

**УМ-САРВА-ДАТА-ГАДА-АРЪЯА-ЛОГИШУРА-
СА-ВА-РЭ-ВА-РА-АВЭХИ-ГАДА САМАЯ ШРИ-А-ХУМ**

Дүйдор буюу түйний хэрэгсэлээр толинд 5 газар хүрэхүй.

ДЭДАГ ГҮЛА ЦУНБА МЭДБИГО

ЗАНЛА ДЭРЭВ ГОВИ ГҮЧИНО

УМ ХУМ ДАРАМ ХЭРЭЭН АГАЯА БИ ШОДОНАЯА СУХА

**УМ-САРВА-ДАТА-ГАДА-АРЪЯА-ЛОГИШУРА-СА-ВА-РЭ-ВА-
РА-ГА-ЯА**

БИ-ШҮД-ДА-НА-ЕЭ-СУХА

Хувцас өргөх ануу:

Элдэв эрх нум мэт дэлгэрч
Энх амгалангийн үрийг түгээж
Оюун ухааны дээл өргөж
Онцгой тэсвэрийн бүсээр чимтүгэй

чимэг өргөхүй:

Билиг найрагт бурханы чимгийг
Бусад хүмүүс өмсөж чадахгүйч
Эрдэнийн чимэг өргөсний буянаар
Энгүй лагшинг олох болтугай
Бидний буяны үйл эдгээрээр
Бурханы хутаг түргэн олтугай

Амьтанд туслах дээдийн ном зааж
Аюулт зовлонгоос ихэнхи нь гэтэлтүгэй
Төрөх төрөл тутам бүхэндээ
Төвшин ухаантай омог үгүй
Энэрэл ихтэй багшдаа сүсэгтэй
Энэрэнгүй Арьябалын тангарагтай болтугай
Таныг тахин залбирсны хүчээр
Тив дэлхийн хаа ч очсон бидэн
Өвчин ядуурал хэрүүл амираалд
Өлзийт номын буян арвижитугай
Тэргүүн бодийн их эрдэнээр
Төрөөгүй нугууд төрж дэлгэг
Төрсөн нугууд доройтол үгүй
Дээш дээшээ өсөн дэлгэртүгэй
хэмээн ерөөл тавиад: 3 унш.

игжа гурван удаа унших:

УМ БАДМА САДУ САМАЯА МАНУ БАЛАЯА

Ялж төгс нөгчүгсэн Арьяабал бурхан та надад дор аврал соёрхоо

Би тэргүүтэй анхлан суралцагсад унал, догширол буюу нойр хүрэх алгасрахын эрхээр бясалгал дияан тодорхой бус болох, таринаа, зөв хэллэггүй болох, уншлага орхих, тасрах, тэргүүт эмх замбараагүй үйл бүгдийг их нигүүлсэхүй, Арьяабал бурхан та өршөөж, хайрла. Бидний үйл хиргүй тунгалаг болохуй дор адислаж хайрла.

УМ-МА-НИ-БАД-МЭ-ХУМ

Хутагт арьяабал бурхан нөхөр сэлт бидний өмнө заларч лагшингийн хувиас цагаан рашаан бууж бидний биеийн гадна дотно завсар бүгдээр угаагдаж бие хэл сэтгэл бээр өвчин,ад, хилэнц сэлт үлдэгдэл үгүй арилтугай.

Бумбын рашаан түгээхүй:

3 удаа хүртээх ба эхнийх няман муу сэтгэл арилж, хоёр дахаар шид дэв арилж, гурваар номын лагшин төрлөө гэж бодоод

Би бээр Арьяабал бурханы өмнө ам тангарагаа сахиж, мянган мутарт их Арьяабал бурхан залраад үндсэн нигүүрүүд бие биедээ шингэсэнээр нэг нигүүрт хоёр мутартай болон хувирч ерөөл өргөмөй .

Арьяабал нэг нигүүрт хоёр мутартын омгоор:

Буян эдгээр түргэн биелэж

Бурхан Арьяабал бүтээд

Амьтад бүгдийг хоцроолгүй
Арилсан оронд зорчитугай
хэмээн бодит хэсгийн анхны үйл төгссөн болой
Бодит хэсгийн хоёрдугаар ануу.

УМА-БАДМА-ҮДА-БА-ЕЭ-СУХАХэмээн мутарлагатй угаал
уншиж

Бурхан ном хийгээд чугуулганы дээд дор
Бодийн хутгыг олох хүртэл би бээр итгэмой
Миний өглөг тэргүүтэн эдгээр еээрээ
Хамаг амьтаны тусын тулд бурхан бүтэх болтугай
Би ямагт нэгэн эгшин бээр Арьяабал бурхны лагшинг
эрхшээмой

Буян эдгээр түргэн биелэн
Бурхан Арьяабал түргэн бүтээд
Амьтан бүгдийг хоцроолгүй
Арилсан оронд зорчитугай.

23. ХУТАГТ САЙН ЯВДЛЫН ЕРӨӨЛИЙН ХААН (САНЖИД МОНЛАМ)

Орь болсон хутагт Манзушри дор сөгдмүй.

Арван зүгийн ертөнц дахиныг
Гурван цагт гийгүүлэн заларсан
Билэгт хүмүүний арслан бүгдэд
Бие, хэл, сэтгэлээр мөргөө
Сайн явдлын ерөөлийн хүчээр
Санаанд илхэн хамаг ялагчдад
Орон ертөнцийн хумхийн тоогоор
Олонтаа хувилан, сөгдөн мөргөө
Нэгэн хумхинд ч хумхийн тоот
Бодьсад нарын дунд бурхад заларсаар
Нилэнхүй их номын агаар
Нигүүлсэхүй ялагчдаар дүүрэх болтугай
Эцэс төгсгөлгүй магтаалын далай
Эгшгийн гишүүн далай дуугаар
Ариун бурхадын эрдмийг дуурьсгаж
Амгалан ажирсан бүгдийг магтая
Цэнгэлийн дээд бүхэн цогцолсон
Цэцэг, эрхи, хөгжим, шүхэр

Гэрэл гэгээ, анхилга хүжсээр
Гэгээн бурхдад **тахил өргөө**
Тааламжит өмсгөл, рашаан зоог
Талхлаг чимгийг сүмбэр уул шиг
Тансаг дээд үзэмж хийцтэй
Тахил болгон ялагчдад өргөө
Аль хэмжишгүй их тахилуудыг ч
Авралт тэдэнд сэтгэлээсээ зориулж
Ариун явдалд дуршин тэмүүлсэн
Агуу бишрэлээр мөргөн тахия
Шунал, хорсол, мунхагийн эрхээр
Бие, хэл, сэтгэлийн үүднээс
Бишгүй үйлдсэн хилэнц бүхнээ
Би нэгд нэггүй наминчилъя
Арван зүгийн бурхан бодьсад
Сурагч, төгсөгч ширвага, брадига
Амьтан бүгдийн сайн үйлс
Аль бүхийд **даган баясья**
Ариусан гийж, төөрөгдлөөс ангижирсан
Арван зүгийн ертөнцийн зулуудад
Аврал дээд **номын хүрдээ**
Алгасалгүй эргүүлэхийг **айлтган хүсье**
Нирваан дүр үзүүлэхийг болгоогчдод
Нийт ертөнцийн тоос шиг галавт
Амьтан бүхнийг тэтгэн залрахыг
Алгаа хавсран **өчин залбиръя**
Нирваан дүр үзүүлэхийг болгоогчдод
Нийт ертөнцийн тоос шиг галавт
Амьтан бүхнийг тэтгэн залрахыг
Алгаа хавсран **өчин залбиръя**
Мөргөн тахиж, гэмшин наминчлаад
Даган баясч, айлтган залбирснаар
Аливаа хураасан **буян бүхнээ**
Ариуслын дээдэд зориулъя, би
Эрт заларсан, эдүгээ оршигч
Арван зүгийн бурхадыг тахия.
Ирээдүйн бурхад ч үтэр түргэн
Эгээрлээ гүйцээж, гэгээрэх болтугай.
Арван зүгийн хамаг орон
Асар үлэмж ариун болоод
Бодь модноо морилсон бурхад

Бодьсад нараар дүүрэх болтугай
Арван зүгийн амьтан бүхэн
Ашид өвчингүй амар жаргаад
Ариун номын үйлс бүхэн нь
Ая найртай, сэтгэлчлэн бүтэг.
Гэгээрлийн замаар би замнаж
Орчил бүрт төрлөө мэдээд
Гэрээ орхисон үнэний эрэлд
Төрөл тутамдаа гарах болтугай.
Агуу гэгээрэгсдийг даган суралцаж
Ариун явдлыг төгс гүйцэтгэж
Ёс суртахууныг хиргүй ариусгаж
Ёс бусыг хэзээд тэвчсүгэй.
Тэнгэр, лус, чөтгөрийн хэл
Хүн бус болон хүний хэл
Алив бүхий амьтны хэлээр
Ариун номыг заасугай, би.
Элбэрэл журам, бирамидад хичээж
Эрдэнэт сэтгэлийг алдалгүй барьж
Эрхэм сайн чанарыг минь гутаагч
Элдэв буртагаас ангижрах болтугай.
Нар, сар огторгуйд тордоггүй
Лянхуа цэцэг усанд хиртдэггүй шиг
Зовлонгийн үүсгэл, шулмын үйлээс
Амьдралын тойрогт ангид явтугай.
Элдэв хэмжээст ертөнц бүхний
Эмгэнэл зовлонг машид амирлуулж
Энх зовлонг машид амирлуулж
Эгнэгт тэдэнд тусыг үйлдсүгэй
Буянт үйлсийг төгс дэгжээж
Бусдын явдалд зохилдон орж
Эрхэм сайныг үлгэрлэн үзүүлж
Ирээдүйн галав бүхнийг туулсугай.
Ялгаагүй над шиг гэгээрлийг эрэгч
Ялгуусан хөвгүүдтэй би нөхөрлөж
Ямагт бие, хэл, сэтгэлээрээ
Явдал, ерөөлөө нэгтгэх болтугай.
Өмөг түшиг болсон нөхөд
Үлгэр сайн явдлыг заагчидтай
Үргэлж би учрах бүртээ
Үнэн сэтгэлийг нь бүү цөхрөөг

Ариун сэтгэлт баатруудаар хүрээлүүлсэн
Авралт бурхадыг илхэн үзэхдээ
Айсуй цагийн галав тутамд
Агуу ихээр тэднийг тахисугай
Богд мэргэдийн номыг дээдэлж
Бодь явдлаар хотлыг гэгээрүүлж
Ирээдүйн тоо томшгүй галавт
Эрхэм үйлсийг дэгжээн явсугай
Эргэх хорвоогийн орчил бүхэнд
Эгнэшгүй буян, суу заль
Эрдэм ухаан, бясалгал, гэгээрлийн
Эрдэнэсийн баян сан болтугай.
Нэгэн хумхинд хумхийн тоот
Орон бүгдэд сэтгэшгүй бурхад
Бодьсад нарын дунд заларсныг
Бодь явдлаар яван үзсүгэй.
Үзүүр хязгааргүй зүг бүхэнд
Үсний энтэйд гурван цагийн
Далай бурхад, далай орнуудыг
Далай галбад үзэн зорчсугай.
Үг бүр нь далай мэт
Үлэмжийн чанар төгс аялгуу
Бусдын сэтгэлд ямарчилан нийцсэн
Бурханы зарлигийг ямагт сонстугай.
Цаг цагийн гэгээрэгсэд бүхний
Цаглашгүй номын хүрдийг эргүүлсэн
Оюун баялгийн эгшигт зарлигт
Ой ухааны хүчээр нэвтэрсүгэй.
Ирэх цагийн галав бүгдэд
Эгшин зуур би орсугай
Алимад гурван цагийн галвыг ч
Агшин төдийд туулан явсугай
Гурван цагийн гэгээн бурхдыг
Нэгэн агшинд би үзсүгэй
Илбэт чанарыг бясалгалаар эзэмшсүгэй
Гурван цагийн гэгээн бурхдыг
Нэгэн агшинд би үзсүгэй
Эгнэгт тэдний эзлэгдэхүүн зүйлсийг
Илбэт чанарыг бясалгалаар эзэмшсүгэй.
Гурван чанарыг бясалгалаар эзэмшсүгэй
Гурван цагийн ариун орныг

Нэгэн хумхинд илт бүтээж
Бүхий л зүгт тэр мэтчилэн
Бурхдын орныг байгуулах болтугай
Ирээдүй ертөнцийн зулууд дараалан
Гэгээрлийг олж, хүрдийг эргүүлж
Амирлангуйн туйл нирвааныг үзүүлэхэд
Аврал тэдний дэргэд явсугай.
Хамгийн хурдан хувилгааны хүч
Хамгийн үүд хөлгөний хүч
Хамгийн эрдэмт явдлын хүч
Хамгийн түгээмэл асрахуйн хүч
Хамгийн сайн буяны хүч
Харилтгүй бэлгэ билгийн хүч
Арга, билиг, самадийн хүчээр
Ариун бодийн хүчийг бүтээсүгэй.
Үйлийн хүчийг огоот арилгаад
Нисваанисын хүчийг оргүй дараад
Шулмын хүчийг үгүй болгосноор
Сайн явдлын хүчийг гүйцээсүгэй
Далай мэт орныг гийгүүлж
Далай мэт амьтдыг гэтэлгэсүгэй
Далай мэт номыг үзэж
Далай мэт билгийг оносугай.
Далай мэт явдлыг ариусган
Далай мэт ерөөлийг төгсгөж
Далай мэт бурхдыг тахин
Далай мэт галвыг туулсугай.
Алимад гурван цагийн бурхдын
Ариун явдлын ерөөл бүхнийг
Агуу сайн явдлаар гэгээрч
Алдалгүй би гүйцэтгэх болтугай.
Ялгуусан бүхний ахмад хөвүүн
Яруу алдар нь Самандбадра
Эрдэмт түүнтэй ижилсэхийн тулд
Эл буянаа сайтар зориулья.
Бие хэл сэтгэл болон
Явдал, орон бүгд нь ариуссан
Билгүүн сайн ерөөлт түүнтэй
Би ч бас адилхан болтугай.
Эрхэм дээд явдалын тулд
Итгэл Манзушрийн ерөөлийг тавьж

Ирээдүйн галав тутамд уйсалгүй
Эгээрсэн үйлсийг нь төгс гүйцээе.
Илт явдал нь цаглашгүй болоод
Ид хав нь ч хосгүй болтугай
Эн хэмжишгүй явдалд оршсон ч
Эрдэм чадал бүхнийг эрсүгэй.
Огторгуйн хязгаар хаа хүрнэ
Орчлонд ертөнц тэнд ч оршино
Зовлон төөрөгдөл хаа үргэлжилнэ
Зорьсон ерөөл минь тэнд ч хүрнэ
Арван зүгийг эрдэнэсээр дүүргэж
Ахуй цэнгэлийг хотлоор бүрдүүлж
Хумхийн тоос шиг олон галавт
Хутагт бурхдад өргөл болгосноос
Ерөөлийн хаан судрыг сонсож
Гэгээрлийн дээд хутгыг мөрөөсч
Бууршгүй сүжгийг нэгэнтээ л төрүүлбэл
Буяны дээд нь энэ болно.
Хэн ч гэсэн ийнхүү ерөөвөл
Хэзээд муу заяанд уналгүй
Хилэнцэт нөхрөөс ч ангижрах бөгөөд
Хязгааргүй гэрэлтийг үтэр үзнэ.
Эрхэм олзыг тэд эрхшээн
Энэ насандаа ч амар жаргаад
Самандбадра ямар мэтчилэн
Сааралгүй түргэн түүн шиг болно.
Үнэнийг ухаарахуй хэн нэгэн
Үйлийн таван адгийг үйлдлээ ч
Үнэн сэтгэлээс ийнхүү ерөөвөл
Өнөөх нүгэл нь төдхөн арилна.
Ухаан билиг, бие бялдар
Угсаа язгуур төгөлдөр болоод
Хар хорын хүчинд дийлдэлгүй
Хамаг гурван ертөнцөд шүтэгдэнэ.
Ариун бодь мод руу явж
Амьтны тусад тэнд суугаад
Аюулт шулмын хүчнийг ялж
Ариусан гэгээрч, үнэнийг номлоно.
Энэхүү сайн явдлын ерөөлийг
Эндүүрэлгүй тогтоож, уншиж, ухуулбал
Эцсийн үрийг нь бурхан л болгооно

Эргэлзэх хэрэггүй, дээд гэгээрэлд.
Манзушри баатар хэрхэн айлдсан
Самандбадра ч түүнчлэн ерөөсөн
Агуу тэднийг даган суралцахад л
Аливаа буянаа даатган зориулъя.
Гурван цагийн ялагч бүгд
Ерөөлийн хаанаар өргөмжилсөн тул
Энэ бүхний буяны үндсээ
Эрхэм сайн явдалд л зориулъя
Энэ нас минь эцэслэх үед
Элдэв түйтгэр бүхнээ ариусгаад
Эгнэшгүй гэрэлт бурханыг үзэж
Энх мэндийн оронд одсугай.
Эдгээр ерөөлөө тэнд хүрснээр
Илт болгон, төгс гүйцээж
Орчлон хэдий орших хугацаанд
Олон амьтанд туслан явсугай
Амар амгалан бурханы оронд
Ариун лянхуа цэцгээс мэндэлж
Аминдаваа бурханы илт бошгыг
Аяа, би бээр тэнд олсугай.
Онц эрхэм бошгыг олоод
Олон зуун голти хувилгаанаар
Оюуны хүчээр арван зүгт
Олон амьтны тусыг үйлдсүгэй.
Сайн явдлын ерөөлийг тавьснаар
Сая миний хураасан буянаар
Амьтан бүгдийн ч ерөөл буян
Агшин төдийд бүтэх болтугай.
Зорьж, сайн явдлыг ерөөснөөр
Зол буян хязгааргүйг олоод
Зовлонгийн далайд живсэн амьтад
Зохист Авидын орныг олтугай.
Эрхэм дээд ерөөлийн хаан
Энгүй амьтнаа тус болоод
Самандбадрын эгээрэл биелж
Саар заяа бүхэн хоосортугай.

24. ХУТАГТ МАЙДАРЫН ЕРӨӨЛ /САНЖААГҮНЛА/

Энэрлийн дээд бурхад
Тэнгэрийн мэлмийт арш нар
Их, бага хөлгөний
Эрдэмт хуврагуудад мөргөө.

Зовлонт төөргөөс аварч
Зол буяныг сэнхрүүлж
Үхэлгүйн хутагт хөтөлсөн
Үлэмжийн сэтгэлд мөргөө
Сэтгэлийн жолоо алдуурсан
Сэрэмжгүй үйлдэл бүхнээ
Гэгээн бурхадын өмнө
Гэмшин наманчилму, би
Гурван үүднээс ундарсан
Ариун үйл бүхэн минь
Үнэнд нэвтрэх гэгээрлийн
Үр хөрөнгө болтугай
Арван зүгийн ертөнцөд
Авралт бурхадыг баясгасан
Ариун өргөл бүхэнд
Ашид даган баясму
Буруу бүхнээ гэмшиж
Буян бүхэнд дуршиж
Бурхан бүхэнд мөргөснөөр
Билгийн чандад хүрсүгэй
Арван түвшинд оршигч
Арван зүгийн бодьсатвыг
Агуу гэгээрэлд хүрэхийг
Айлтган сануулъя, би
Хосгүй гэгээрлийг нээж
Хортон шулмыг ялж
Өвдсөн сэтгэлтнийг анагаах
Үнэнийн хүрдээ эргүүлэг
Номын хэнгэргийн дуугаар
Нойрссон амьтныг сэргээж
Сэтгэшгүй олон галавт
Сэхээрүүлэн залартугай
Шуналын балчигт живээд

Шулмын цаламд автаж
Эрх чөлөөгөө алдагсдыг
Энэрч болгоо дээдс минь
Хөө тортогт сэтгэлтнийг
Хөсөр бүү орхи
Хөөрхий тэднийг нигүүлсэн
Хүлээснээс чөлөөлж хайрла
Өнөө үед залрагч
Өнгөрсөн болон ирээдүйн
Үй түмэн гэгээрэгчдийг
Үлгэр дуурайл болгому
Зургаан бармидыг төгсгөж
Зургаан үйлтнийг аваръяа
Зургаан зөн билгээр
Гэгээн хутгыг олъё
Үүсээ ч үгүй, үүсэх ч үгүй
Чанар ч үгүй, орон ч үгүй
Мэдэгч үгүй, мэдэгдэхүүн ч үгүй
Хоосон утгыг танисугай
Сэрж сэхээрсэн мэргэд шиг
Сэтгэлтэн ч үгүй, амьтан ч үгүй
Эдлэгч үгүй, тэжээгч үгүй
Эзэнгүй чанарыг нээсүгэй
Би болон минийх гэх
Биет зүйл үгүйгээр
Хамаг амьтаныг эмнэх
Харамгүй өглөгийн өгсүгэй
Үнэн бодит чанаргүй тул
Эдлэгдэхүүн аяндаа бүтэж
Үзэгдэл бүхнийг тайлснаар
Өглөгийн чинадад хүрсүгэй
Алдас буртгаас ангид
Ариун утга төгөлдөр
Атхаг бардамнал үгүйгээр
Ёс суртлын чиндад хүрсүгэй
Шороо, ус, гал
Хий махбодь шиг урвалгүй
Тэчих ч, уурлах ч зүйлгүй
Тэсвэрийн чинадад хүрсүгэй

Уйгагүй хичээл зүтгэл
Унтуугүй урам зоригт
Бие, сэтгэлийн хатаар
Хичээнгүй чинадад хүрсүгэй

Илбэт чанарын бясалгал
Ид хавтны бясалгал
Эвдэршгүй очирт бясалгалаар
Дияаны чинадад хүрсүгэй

Гурван үнэний үүд
Гурван цагийн тэгшитгэл
Гурван ухааны үзэхүйгээр
Билгийн чинадад хүрсүгэй

Гэгээн бурхадын магтсан
Гэрэл жавхаа бадарсан
Сааршгүй бодьсатвын үйлсээр
Санаа зориг минь биелэг

Аяа, тийнхүү явсаар
Асрагч алдрыг олж
Зургаан төгс замналаар
Арван түвшинг өндөрлөө

Намо радна драяая, намо багавади, шагжамүни еэ, дата гатаяа, архадэ самъягасам буддаяа

Датьята ум азидэ, азидэ аваразидэ, азидэ заяа, хара хара, майдри авалогидэ, гара гара, маха самаяа сидди вара вара маха боди манда виза, мара мара, асмагам самаяа, боди боди маха боди суха

Ум мохи мохи маха мохи суха. Ум мүни мүни мара суха
(утга нь: Гурван эрдэнэд мөргөмү.

Ялж төгссөн, түүнчлэн ажирсан, дайсныг дарагч, үнэхээр туулсан, төгс гэгээрүүлсэн Шагжүмүни багшид мөргөмү

Ийм буюу

Ялагдашгүй, Ялагдашгүй, ялгуулсан тэрээр ялагдашгүй

Эзэгнэгтүн, Эзэгнэгтүн, асрагч мину, тольдогч мину

Бүтээгтүн, Бүтээгтүн, агуу тангараг ид шидийг

Дэлгэрүүл дэлгэрүүл үлэмж гэгээрэл зүрхэн шимийг

Санагтун санагтунбиднийг тангаргийг

Гэгээрэл гэгээрэл үлэмжийн дээд гэгээрэл орштугай)

Энэ буянаар бий болон бусад бүх амьтан нас эцэслэх даруйд төгс баясгалант тэнгэрийн оронд номын өндөрлөг гэгээн оронд мэндэлж, ялагдашгүй итгэлт майдарын ууган хөвгүүн болтугай.

Гэгээрлийн арав дах түвшинг эзэгнэгч, бурхан багшийн орыг залгагч таныг замбуу тивд морилж, арван хүчийг эрхшээсэн бодь хутгыг олох тэр цагт ариун номын рашааныг тань анх түрүүнд хүртэж, гэгээрлийн дээд үйлсийн туйлд хүрэх болтугай.

Энэ ертөнцөөс ангижрах даруй төгс баясгалант оронд мэндлэхдээ гэгээн итгэлт таныг баясган цэнгүүлж, бодь хутгын бошгыг хүлээн авсу, би.

25. БОДЬ СЭТГЭЛИЙН ЕРӨӨЛ БУЮУ ДАГИЙЖАНЧИВМА

Агуу бодьсатвын замналд орох
Ариун номын туурвил буянаар
Аливаа бүх оюун санаатан
Ариуслын замд орох болтугай

Зүг бүхэнд бие сэтгэлийн
Зүдгүүр зовлон эдлэгч хөөрхийс
Зүй төгс буяны минь үрээр
Зүйрлэшгүй жаргаланг олох болтугай

Үйлт орчлон хэзээд оршивч
Үгүйрч гансралгүй хамаг амьтан
Үлэмжийн дээд амар амгаланг
Үргэлж тасралтгүй эдлэх болтугай

Энгүй уужим ертөнц даянаа
Эвэршээлт там хэдий буйд
Энэлэн зовогч хөөрхий амьтас
Энхжин жаргалд умбах болтугай

Энэрэл хайртны үүлэн мандлаас
Эгээрлийн хур шаагин бууж
Халуунд ядагсад сэрүүцэх болтугай
Хүйтэнд зүдэгсэд дулаацах болтугай

Илдэн навчит балар шугуй
Инээд цалгисан цэцэрлэг болж
Элдэв хорын моголцог мод ч
Эрдэнэ жимст найлзуур болог

Ангир нугас хун галуудын
Аялгуу тансаг дуурьсал чимсэн
Анхилам цэцэгт тунгалаг цөөрмүүд
Аюулт тамд долгисох болтугай

Түймэрийн нурамд ч эрдэнийн санд
Түлэгдмэл газар ч болорын гадарт
Тээрэмдэгч уулс ч тахилын ордонд
Тийнхүү хувирч, бурхад залраг

Зэвт сумны аймшигт мөндөр
Балт хурын намираа болтугай
Зэвсэг барин тулалдагчид өнөөдрөөс
Цэцэг барин золголдох болтугай

Галын гуу шиг халуун
Хөлгүй уснаа живэгсэд
Гадар мах нь шувтар ч
Дотро яс нь цайгсад

Гайхамшигт буяны минь хүчээр
Тэнгэрийн биеийг олоод
Гангамсаг охин тэнгэрстэй
Зоргоор цэнгэх болтугай

Үй түмэн эрлэгийн
Тамлаач тоншоочдыг үргээн
Үлэмж гийгүүлэн амраах нь
Хэний эвээл бэ хэмээн

Өөдөө харсан амьтад
Очирваань залрахыг үзмэгц
Үнэн голоосоо баярлаж
Хилэнцээс хагацан дагатугай

Гэсэр цэцгийн хур
Хүжсийн устай бууснаар
Гэтэлшгүй тамын гал
Намжин бөхөхийг хараад

Гэнэтийн энэ амгалан
Юу болохыг сэхээрэхуй еэ
Гэсгээлт тамын амьтад
Лянхуа баригчийг үзтүгэй

Амьтан бүхнийг аврагч
Агуу бодь сэтгэлтэн
Аюул бүгдийг арилгагч
Бадрангуй залуу шанхтан

Амар жаргалыг түгээхээр
Биднийг зүг айсуй
Аяа, нөхөд минь айлтгүй
Бушуу нааш цуглагтун

Мянган тэнгэрийн титэм
Өлмий лянхуйд нь бөхийсөн
Мэлмийдээ нийгүүлслийн чийгт
Тэргүүндээ цэцэгсийн хурт

Охин тэнгэрсийн магтаал
Эгшиг дуурьссан ордонд
Орь манзушрийг хараад
Тамын амьтас шаагитугай.

Энэчлэн миний буянаар
Самандабадра тэргүүтэн
Элбэрэлт журамт дээдсийн
Ариун сэтгэлийн үйлсээс

Энх мэндийн анхилгат
Сэрүүн хур намирч
Энэлсэн тамын амьтад
Сэтгэл сэргэн цэнгээсэй

Адгуус амьтад бие биенээ
Алан идэхийн аюул төгсч
Ахуй чинээлэг умард тивийхэн шиг
Алжааж ядрагсад жаргах болттугай

Асран нийгүүлсэгч Аръяабалын мутраас
Асгаран буусан сүүн мөрнөөр
Ангасан бирдүүд ундлан цэнгэж
Ариун угаалаар сэрүүцэх болтугай

Чих дүлий нь дуу сонсож
Нүд балай нь хараа орж
Жирэмсэн эхчүүл маяа хатан шиг
Чилээ зовлонгүй нярайлах болтугай

Өмсөх хувцасгүй нь хувцастай болж
Өлссөн бүгд хоолтой болж
Ундаассан болгон устай учирч
Улам тансагийг эдлэх болтугай

Үгээгүй ядуус баяжих болтугай
Үймэрч гунигсад баясах болтугай
Өр нь эмтрэгсэд сэргэх болтугай
Өнийн жаргал бүрдэх болтугай
Өвдөж зовсон амьтан бүхэн
Үтэр түргэн эрүүлжих болтугай
Үйлт амьтны аливаа өвчин
Үргэлж хойшдоо гарахгүй байх болтугай

Эмээн цочигсод айдсаас ангижирч
Эрхээ алдагсад хүлээснээс хэлтэрч
Өчүүхэн буурайчуул хүчтэй болж
Өвөр зуураа найрамдах болтугай

Аянчин жуулчид зүг бүрт
Амар тайван зорчих болтугай
Аливаа санасан хэрэг зориг нь
Аяндаа шамдалгүй бүтэх болтугай
Хөлөг онгоцоор аялан явагсад
Хүссэн хэргээ сэтгэлчлэн бүтээгээд
Хөвөө зүгт саадгүй хүрч

Хүлээсэн садандаа золгон баястугай

Ээрэм холын замд төөрөгсөд
Ээлт сайн замчтай учраад
Элдэв араатан хулгайн аюулгүй
Энх амар одох болтугай

Хөдөө буйд, осолт газар
Хөтөш түшиггүй өтгөс нялхас
Хөлчүү согтуу солио өвчтөнийг ч
Хүлцэн сахитугай дээд тэнгэрс

Эрх чөлөөгүй бүхнээс гэтэлж
Итгэл хайр билгийг нээж
Эрхэм сайн үйл хэргээр
Эгнэгт төрлөө дурдах болтугай

Элбэг огторгуйн сан адил
Эд баялаг ундрах болтугай
Элдэв тэмцэл хөнөөл үгүй
Эрх зоргоор эдлэх болтугай

Үлбэгэр дорой алив амьтас
Үлэмжийн жавхланг олох болтугай
Өнгө зүс муугаар зовогсод
Үзэсгэлэн гоо төгөлдөр болтугай
Энэ ертөнцийн ядмаг эмс
Эр хүйстэн болох болтугай
Эгэл дордос өндөрт дэвшээд
Эзэрхэг омгийг ч дарах болтугай

Эл бүхий миний буянаар
Эх болсон хамаг амьтад
Эндэл хилэнцийг огоот тэвчээд
Эгнэгт сайныг үйлдэх болтугай

Энэрэл хайрыг хэзээч орхилгүй
Эрхэм замаас сэтгэл урвалгүй
Гэгээн бурхадын ивээл залуур доор
Гэмт шулмын үйлсээс ангижраг

Аль тэдгээр амьтан бүгд
Амьдрах эрчим цаглашгүй болоод
Амар жаргалыг үүрд эдэлснээр
Аймшигт үхлийн дуун тасраг

Ариун галбарагча модны цэцэрлэгт
Авралт бурхан бодисатва нар чуулаад
Аялгуу номын хөг дуурьслаар
Арван зүгийг дүүргэх болтугай

Алимад газар дэлхий бүхэнд
Арсайж барсайх өргөс хайргагүй
Алганы толио шиг тэгшхэн зөөлхөн
Ариун бэндэръяа чанарт болтугай

Амар амгалан номын хүрээлэнд
Асар олон бодь сэтгэлтэн
Алтан дэлхийн чимэг болж
Ариусал билгийн гэгээг түгээг

Судар номын гайхамшигт дуун
Шувуудын жиргээ моддын найлзаа
Гэрэл туяа агаар тэнгэрээс ч
Хэн бүхэнд сонстох болтугай

Хэзээд тэд бурхадтай учирч
Хиргүй ариун сэтгэлтэнтэй нөхөрлөж
Хэмжээлшгүй их тахил өргөлөөр
Гэгээрсэн дээдсийг тахиx болтугай
Тэнгэр хурыг цагт нь буулгаж
Тэжээл ургац хотол чуулаг
Эзэд хаад үнэн номоор
Энх амгаланг ертөнцөд түгээг

Эм домын хүчин бүрдэж
Тарни уншлага бүтэх болтугай
Элдэв дагинас мангас тэргүүтэн ч
Энэрэхүйн сэтгэл төгөлдөр болтугай
Аливаа амьтад зовлонгүй бөгөөд
Айдас доромжлолыг амсалгүй байж
Аюулт өвчин хилэнцээс ангид

Ашид сэтгэл тэнүүн явтугай

Амгалан хийдэд хурал ном
Аль сайнаар дэлгэрэх болтугай
Ачит хуврагууд ч ая найртай
Амьтаны тусыг бүтээх болтугай

Ариун гэлэн сахил хүртэгчид
Аглаг газрыг саадгүй олоод
Алгасангуй үйлийг сайтар тэвчээд
Амирлангуй сэтгэлээр бясалгал хийг

Ариусалд зорьсон гэлэнмаа нар ч
Ая эв нь сэтгэлчлэн бүтэг
Аливаа сахил санваартан бүгд ч
Алдас нүглээс хол яваг

Сахилаа алдагчид гэмшин ухаарч
Самуун нүглээ наминчлан арилгаг
Сайн заяаг ч магад олоод
Сахил журмаа буу сэвтээг

Үнэн номчид хүндлэл хүлээж
Өргөлийн идээгээр бүү тасраг
Өр зүрх нь ариун тунгалаг
Үйлс алдар нь түгэх болтугай

Тэвчишгүй муу заяанд зоволгүй
Тээрт бэрх хатуужилд зүдэлгүй
Тэнгэр заяатнаас ч илүү учирлаар
Дээд гэгээрэлд хүрэх болтугай
Амьтан бүгд ариун үйлээр
Агуу бурхадын тааллыг баясгаж
Аюулт мунхагийн нойрноос сэрсэн
Ашдын цэнгэлд умбах болтугай

Ариун сэтгэлт бурханы хөвгүүд
Амьтны тусыг сэтгэлчлэн бүтээг
Аврал болсон гэгээн бурхад
Амар жаргалыг бүгдэд түгээг

Өөрийн хүчинд найдагч нар ч
Үлэмж ариусалд хүрэх болтугай
Үргэлж бусдаас сонсогч нар ч
Өнийн гэгээрэлд хүрэх болтугай

Манзушрийн ачаар мөхөс би
Маш баясгалант түвшинг олтлоо
Өмнөх төрлөө тодхон санаж
Үнэн номын мөрийг хөөг

Эгэл боргил амь зуулгаар
Энх эсэн амьдрах болтугай
Ариусалд нийцэх тайван орчинг
Аливаа төрөлдөө олох болтугай

Эрхэмсэг дүрий нь үзэхийг хүсвэл
Эргэлзээ юугаа тайлахыг хүсвэл
Итгэлт манзушри тантай би
Эгээрсэн мөчдөө учрах болтугай

Арван зүгийн огторгуйн чинээ
Амьтан бүхний тусыг бүтээх
Ачит Манзушрийн гэгээн үйлстэй
Адилхан болог үйл хэрэг минь
Огторгуй хэзээд орших сацуу
Орчлонд амьтад эргэн төрсөөр л
Төдий хугацаанд би ч оршоод
Төөрөлдсөн тэдний замч нь болог

Зөндөө амьтаны зовлон бүгд
Зөвхөн над дээр боловсрог гэсэн
Зүйрлэшгүй энэрэлт бурханы хүү
Зүдэрсэн олныг амраах болтугай
Аливаа зовлонг анагаах эм
Амар амгалан бүхний ундарга
Ариуслын шашин даянд хүндлэгдэж
Ашдын цогоор дэлгэрэх болтугай
Ариун буяныг надад сэнхрүүлсэн
Авралт манзушрид мөргөм үү би
Ашид намайг өөд нь дэвшүүлсэн
Авралт бурхандаа сөгдмү би

26. ЭХЭН ЭЦЭС ЗАВСАР ГУРВЫН ЕРӨӨЛ БУЮУ ЧОГЖУЖАЛВАМА

Арван зүгийн төгс гэгээрэгчид
 Ариун замаар замнагч бүхэнд мөргөм үү
 Үйл зовлонгоос хотлыг гэтэлгэх
 Үлэмжийн хайраар ерөөл өргөө
 Гурван эрдэнэ арш нарын хүчээр
 Үнэн үгс минь биелэх болтугай
 Эргэх орчлонд төрөх бүрдээ
 Энэлэнт муу төрөлд уналгүй
 Эрхэм чөлөө учрал бүрдсэн
 Эрдэнэт хүний биеийг олох болтугай
 Төрсөн цагаас орчлонгийн таашаалд
 Төөрөлдөж шуналгүй, гэгээрэлд зорьж
 Ахуй зовлонг таньсан ухаарлаар
 Ариун замыг сонгох болтугай
 Гэрээ орхих цагт минь надад
 Гэр бүл садан нөхөд
 Эд баялаг ч тушаа бололгүй
 Эв тохиол санаснаар бүтэг
 Ариун гэгээн дээдсийн өмнө
 Ам тангараг өргөсөн сахилаа
 Амьд яваа насандаа би
 Алдас гэмээр хиртээхгүй байг
 Ариун сахилаа тулгуур болгож
 Агуу гүн хөлгөн сургаалыг
 Эх болсон амьтдын төлөө
 Элин галавт судлах болтугай
 Эш онолын эрдэм гийсэн
 Энэрэл төгс амирлангуй сэтгэл
 Бусдын төлөө чин зоригт
 Буянт багшийн эвээлд багтаг
 Зүрхний бишрэлт Дагдү –Үва
 Номын хутагт багшаа шүтсэн шиг
 Амь амьжиргаа бүхнээ зориулан
 Агшин ч гомдоолгүй багшаа баярлуулаг
 Гүн амгалан хоосон чанарын
 Чинад билгийг үнэн зөвөөр
 Дагдү –Үвад багш нь номлосон шиг
 Дандаа надан соёрхох болтугай

Бурхан багшийн тааллаас гажууд
Буй үгийн тууширалд унагах
Буруу номлогч уруу татагчдын
Буртаг надад бүү халдаг
Үргэлж хичээнгүйн сахин үлдээсэн
Үлэмж хайрын дарвуул хийссэн
Судлал бясалгалын хөлгийг жолоодон
Төөрсөн олныг зовлонгоос гаталгаг
Өргөн мэдлэг гүн ухаан
Өглөг буян ариун суртлаар
Оюун сэтгэлээ хөгжүүлэх тусам
Омогшил сагсуурлаас салах болтугай
Өрөөл бусдыг аялдан дагалгүй
Өөрийн ухаанаар утгыг нээгч
Ухаант мэргэдийн номын хурыг
Уйдахаа мартан сонсох болтугай
Сонссон зүйлсээ дөрвөн ухаанаар
Өдөр шөнөгүй
Нотлон шинжилж
Эцэст нь тулгасан оюуны хүчээр
Эргэлзээ бүхнээ тайлах болтугай
Гүн гүнзгий номын утгыг
Гүйцэд ухаарсан тэр цагтаа
Ашиг зугаанд автаж төөрөлгүй
Аглаг орчинд даяанчлах болтугай
Тэрчлэн сонсч, санаж, бясалгаснаар
Гэгээрлийн шим сэтгэлд мэндлэхэд
Ахуй орчлонгийн өнгөч үзэл
Аминчхан санаа бүү төрөг
Элдэв юмст өмчирхөж ханддаг
Эрүүл бус сэтгэлгээнээс салаж
Эдийн өглөгөөр бусдыг татаад
Эрдмийн өглөгөөр сэтгэлий нь ариусгаг
Ариусалд хүрэх чин эрмэлзлээр
Ам тангараг өргөсөн сахилаар
Аминд тулавч хэзээч гутаалгүй
Ариун хутгын тугийг өргөг
Өөрийг нь муулж доромжлогчдыг
Үзэх сонсох санахын цагт
Өширхөж уурлалгүй хариу тэдэнд
Өгөөмөр сэтгэлээр талархан хүлцэг

Олооогүй гэгээн ухаарлаа олж
 Олсон мэдлэгээ улам хөгжүүлснээр
 Олиггүй гурван залхуу занг
 Оргүй устган хичээнгүйг эзэмшиг
 Зовлонгоос гэтэлгэх билиг дутуу
 Амирлалаас гэтлэх энэрэл дутуу
 Хүлээс бологч дияаныг бус
 Хослон барилдсан бясалгалыг үйлдэг
 Гүн үнэмлэхүйн утгаас зүрхшээж
 Гүжир мөхөс хоосныг баримтлагч
 Жигт буруу үзэлд авталгүй
 Жинхэнэ хоосон чанарыг таниг
 Ариун ёсыг ичгүүргүй гутааж
 Авралтны сануулгыг аймшиггүй зөрчсөн
 Алгасангүй явдалт хувраг дүртнийг
 Алдасгүй замд оруулах болтугай би
 Буруу замаар үнэнд тэрслэгч
 Нүгэлт багш, шивэлт нөхрийн
 Уруу таталганд автагсдыг би
 Бурханы сайшаалт мөрөөр удирдсугай
 Аймхай үнэг шиг хуурамч номлогчдыг
 Агуа номлол тэмцэл туурвилын
 Арслангийн дуугаар буулган сөтгөж
 Алдаршгүй шашны дуазыг мандуулаг

Хаа төрөвч бурхан багшийн
 Ханашгүй номын рашааныг хүртэж
 Язгуур чинээ бие оюун
 Насан хутаг төгөлдөр болтугай
 Эд эзэмшил, амь биед минь
 Ээлгүй хорон сэтгэл өвөрлөж
 Элдэв бусаар намайг муулагчдыг ч
 Ээж шигээ хайрлах болтугай
 Өнө удалгүй тэдний сэтгэлд ч
 Өөрөөсөө илүү бусдыг хайрлах
 Үнэн ариун бодь сэтгэлийг
 Үүсгэж чадсанаар гэгээрүүлэх болтугай
 Эдгээр ерөөлийг үзэж сонссон
 Эргэцүүлж бодсон тэд бүгдээр
 Эгэлгүй бодь сэтгэлтний ерөөлийг
 Эргэлт буцалтгүй бүтээх болтугай

Ер бусын энэрлээс ундарсан
Ерөөл хүслийн дээжис үүгээр
Ариун ерөөлийн туйлд хүрч
Амьтан бүхний эгээрлийг хангасу.

27. ЭНХЖИНГИЙН ОРНЫ ЕРӨӨЛ БУЮУ ПҮЛЖИНМА

Гайхамшигт үйлсээр бүгдэд	Үлэмжийн цогийг соёрхогч
Ганцхан дурдсан төдийд ч	Үхлийн эзнийг үргээгч
Тэгш нигүүлслээр амьтдыг	Үр мэт энхрийлэгч
Тэнгэр хүмүүний багш	Цаглашгүй насад мөргөө
Энэрэлт бурхан багш	Олон зуун удаа

Эрхэсэг дээд орны охь манлайд өргөмжилсөн
Энхжингийн оронд төрөхийн эл хэдэн ерөөлийг
Элбэрэл журмын сэтгэлээр эвлүүлж холбон өгүүлье
Авах гээхийн учгийг мунхагийн манангаар халхалсан
Амар заяаны амийг хорслын мэсээр хөнөөсөн
Аюулт орчлонгийн гянданд шуналын цалмаар хүлэгдсэн
Ахуй сансрын далайд үйлийн усаар автсан
Өтлөх өвдөх зовлонгийн түмэн давлагаанд нэрмүүлж
Өршөөлгүй үхлийн матарт ахин дахин залгиулсаар
Өөд харшгүй зовлонгийн гачлант үүрэгт дарагдсан
Өмгөөлөх эзэнгүй би гаслан цурхиран дуудъяа
Эгээрэл хүслийг минь бүтээх итгэл найдвараа болгож
Энэлсэн амьтныг аврагч мөнхийн гэрэлт Аминдаваа
Эрх хүчин төгс үлэмжийн чанарт Арьяабал
Энэрэгч та бүхэндээ бишрэн залбирах аваас
Үй түмэн галавт хөөрхий биднийг тухайлж
Үлэмж хайраа ундраасан тангараг юугаа марталгүй
Жигүүртний хаан гарьд тэнгэр огторгуйд дүүлэх шиг
Жигт хувилгаан хүчээр энд морилж хайрла.

Нас эцэслэх цаг минь тохиоход, өөрийн болоод бусдын өнгөрсөн, одоо, ирээдүйн сайн үйлс буян бүхний нэгдмэл хүчээр би ууган хоёр шавь тэргүүтэн ариун нөхдөөрөө хүрээлүүлсэн Аминдаваа бурханыг ил тод үзэх болтугай.

Аяа, тэр цагт авралт тэднийг үзмэгц чин зүрхний сүсэг минь ударснаар нажид зовлонг биеэр эдлэлгүй ариун диваажинг сэтгэлдээ марталгүй амар тайван нөгчих болтугай.

Нас нөгчсөн даруйд найман их бодисатва хувилгаан шидээр залран ирж Энхжингийн оронд хөтөч болон хүргэх болтугай.

Энх мэндийн тэр оронд эрдэнийн лянхуа цэцгээс их хөлөгний дээдлэгч оюун билигтэн болон мэндлэх болтугай.

Мэндэлсэн даруйдаа тарни бясалгал, энэрэл хайр, суу заль төгөлдөр эрдмийн яндашгүй баян санг эзэмшиж, Агуу их Аминдаваа тэргүүтэн арван зүгийн гэгээн бурхад бодиства нарыг баясган, их хөлөгний сургаал бошгыг хүртэх болтугай.

Тэр бүх сургаал номын утгыг зүй ёсоор ухаарч, агшин зуурт тоо томшгүй ертөнцөд хувилгаан хүчээр зорчин, бодь сэтгэлтний гайхамшигт замналыг гүйцэтгэх болтугай.

Ариун дагшин оронд мэндэлсэн ч тэсгэлгүй энэрэл хайрандаа хөтлөгдөн, хувилгаан билгээр энэлэн зовлонт орнуудад очиж, оршин суугчдад тус тусын ойлгох хэлээр нь буян номыг сэнхрүүлж, бурхан багшийн баясгалан болсон гэгээрлийн замд оруулах болтугай.

Тэр бүх ялгуун үйлсийг даруй биелүүлэх үүднээс хязгааргүй олон амьтны тусын тулд төгс гэгээрсэн бурханы хутгыг түргэн зуур олох болтугай.

Үхэх цаг минь нэгэнт болбол
Үлэмж нөхдөө дагуулсан Аминдаваа
Үзэх нүдийг минь гийгүүлэн тодорч
Өршөөл сүсгээр сэтгэлийг минь бялхааг
Илбэ зуурдын үзэгдэл ургахад
Итгэлт найман бодисатва газарчилснаар
Энхжинд мэндлээд хувилгаан хүчээр
Энэлэнт ертөнцийн амьтдыг аваръя.

Тийм төгс дээд гэгээрэлд хүрч амжаагүй төрөл тутамдаа ч ариун сургаал номыг судлаж эзэмших зол завшаан бүрдсэн сайн төрлийг олох болтугай.

Тэр төрөл нь өндөр язгууртны долоон зүйл өлзий буян төгөлдөр болтугай.

Орчил тутамд урьд төрлөө учирлан санах насан хутгын зөн билгийг олох болтугай. Төрөл бүрдээ сансрын хүлээсний шимгүй хоосон чанарыг ухаарч, гэгээрлийн эрх чөлөө, баяр бахдалд сэтгэл булаагдан тэмүүлж, бурхан багшийн замнал ёсоор эгэл амьдарлаас татгалзан хувраг болох болтугай. Эрхэм номын амьдралд орсон үедээ сахил журмыг өчүүхэн ч хэртээлгүй, төгс төгөлдөр мөрдсөнөөр гэгээрэлд хүрсэн Минтүгба гэлэн мэт болтугай.

Бас төрөл тутамдаа төөрөгдөл, гэгээрлийн жам ёсыг угт нь тултал ухуулагч ном судрын үг, утга бүгдийг марталгүй тогтоох гайхамшигт ой билгийг олох болтугай. Өөрийн тогтоосныг бусдад зааж сургахдаа ч торж түгдрэх нь үгүй авъяас билгийг олох болтугай.

Бас төрөл тутамдаа баатарлаг тэргүүтэн бясалгалын эрдэм, бодит нүд тэргүүтэн үзэхүйн увидас, хувилгаан билиг тэргүүтэн зөн билгийн чадавхийг эзэмших болтугай.

Бас төрөл тутамдаа зөв, бурууг өөрийн хүчээр ялгаж чадах үлэмжийн билгийг олох болтугай.

Сансар, нирвааны маш нарийн хувь хэсгийг ч хольж хутгалгүй ялган таних тод билгийг олох болтугай.

Онож мэдээгүй буюу буруу мэдсэн, эргэлзэж тээнэгэлсээн санаа төрсөн даруйд тэр бүхнийг няцааж чадах түргэн билгийг олох болтугай.

Бусдын үзэл бодлоор шалгуур хийлгүй Бурхан багшийн сургаал номын үг, утганд торолтгүй нэвтрэх гүн билгийг олох болтугай.

Товчдоо, буруу цалгар оюун санааны бохирдлоос ангид ухаан билгээр ариун сургаалын үг, утгыг нээн мэдсэнээр уран аргат суу билгийн үүднээс бодь сэтгэлтний замнал бүхний туйлд хүрсэн Богд Манзушри мэт болтугай.

Тэр мэтчлэн үлэмж тод түргэн гүн билгийг төвөггүй олсноор хувьтныг дагуулж, хуурамч номлогчдыг няцаан, хурц мэргэдийг баясгахын үндэс, ариун сургаалд тулгуурласан номлогч, тэмцэгч, туурвигч цэц мэргэний туйлд хүрэх болтугай.

Бас төрөл тутамдаа хувиа бодогч явцуу сэтгэлийг огоорч, бодь сэтгэлтний их үйлсээс хойргоших буюу шантрах санаа бүхнийг таягдан хаяж, бусдын төлөө чин зоригт, уран аргат энэрэл нигүүлслийн үүднээс бодь сэтгэлийн замнал бүхний туйлд хүрсэн богд Арьяабал мэт болтугай.

Бас төрөл тутамдаа өөрийн болоод бусдын сайн сайхныг бүтээхдээ шулмын хүчин, тэрс үзэлтэн бүгдийг няцааж, уран аргат чадлын үүднээс бодь сэтгэлтний замнал бүхний туйлд хүрсэн Очирваань мэт болтугай.

Төрөл тутамдаа залхуугүй хичээл зүтгэлээр гэгээрлийн замаар замнахдаа би анх бодь сэтгэл өвөрлөсөн цагаас агшин зуур ч зорилгоо умарталгүй, агуу их хичээнгүйн үүднээс төгс гэгээрэлд хүрсэн ханьцашгүй Шагжа омгийн хаан \Шагжамүни\ мэт болтугай.

Төрөл тутамдаа бодь хутгийг бүтээхэд саад болох бие, сэтгэлийн өвчин энэлгээ бүхнийг дараад, алдрыг нь өгүүлсэн төдийд бие хэл сэтгэлийн зовиур бүхнийг анагааж чадах оточ Манал бурхан мэт болтугай.

Бас төрөл тутамдаа аль хүссэн чинээгээр насалж, алдрыг нь дуудсан төдийд цаг бус үхлийн аюул бүгдийг даран чадах Цаглашгүй нас \Аминдаваа\ бурхан мэт болтугай.

Насан хутагт минь элдэв зэтгэр тохиох цагт Цаглашгүй наст бурхан дөрвөн үйлсийн аль зохих гэгээн дүрээ үзүүлэхүйеэ үзсэн даруйд амь насны тотгор амирлах болтугай.

Учир тохиолд нийцүүлж ямарваа дүр үзүүлэвч түүнийг Аминдаваа бурхан мөн гэдгийг танин, чин үнэнчээр сүсэглэсний буянаар төрөл тутамд Аминдаваа бурхан миний багш болон учрах болтугай.

Бас төрөл тутамд миний амьдрал гэгээрлийн сайн сайхны ундарга болсон их хөлгөний эрдэмт багш намайг таалал баяслаар удирдан залах болтугай.

Ивээлт багшийнхаа залуур доор итгэл бишрэл урвалтгүй байж, үйл үйлдэл бүхнээрээ би баясах болтугай. Таалалд нь нийцэхгүй үйлийг агшин зуур ч бүү үйлдэг.

Багш минь надад ариун номын охь шим бүхнийг дутаалгүй еэ хайрлах болтугай.

Тэр бүгдийн утга чанарт нэвтэрч оюун сэтгэлдээ хоногшуулснаар төгс төгөлдөр болтугай. Буруу номлогч уруу татагчдын ятгалаг нөлөөнд агшин зуурч бүү автаг.

Төрөл тутамдаа үйлийн үрд итгэх итгэл, хүлээснээс ангижрах эрмэлзэл, бодь сэтгэл, үнэн үзэхүй бүхнийг ой тойндоо шингээснээр шамталтгүй үргэлж санаж сэрэх болтугай.

Төрөл тутамд бие хэл сэтгэлээр үйлдсэн миний буян бүхэн бусдын сайн сайханд тус болж, бурханлаг чанараа нээхийн үндэс болтугай.

Хэзээ гэгээрэх хүртлээ би
Гэгээн буянт төрлийг олоод
Урьд насаа санан дурсч
Номын амьдралаар амьдрах болтугай.
Тогтоол бясалгал зөн билиг
Ид шидийн эрдэм тоолшгүй
Ухаан хайр чадал эгнэшгүй
Ариуслын туйлд хүрэх болтугай.
Цаг бусын үхэл ёрловол
Цаглашгүй наст бурханыг үзээд

Үхэл эрлэгийн омгийг дарж
Үхэлгүй хутгыг түргэн олог
Итгэлт Аминдаваа төрөл тутамд
Их хөлөгний багш минь болсноор
Бурханы заасан буянт замаас
Нэгэн агшин ч няцалгүй явтугай.
Буурай амьтдыг хөсөр орхисон
Аминч сэтгэлийг хэзээд цээрлэж
Будилж төөрөлгүй уран аргаар
Бусдад туслахыг зорилго болгоё
Аюулт бэрх үйлийн үртнүүд
Алдар нэрийг минь дурдсан төдийд
Амар жимэр золыг олж
Ариуслын шатаар өгсөх болтугай.
Үлэмж сэтгэлтний үйлс замналаас
Үлгэр жишээлсэн энэ ерөөлөөр
Бурханы хүүгийн зам саадгүй
Буян өлзий сэтгэлчлэн бүтэг.
Шагжимүни, Аминдаваа, Майдар, Манзушри
Очирваань, Аръяабал бурхад бодисатва нарын
Ивээл барилдлага үнэнийн хүчээр
Эдгээр ерөөл түргэн биелэг.

28. ДҮЙНХОРЫН ЕРӨӨЛ БУЮУ ДИДАРЛХАГСАМА

Энэ адил хураасан буяны уулнаас
Өргөл бясалгалын хиргүй рашаан мэт
Өөрийн сүсгээр тогтоох булагийг
Өчүүхэнд барилгүй далайд цутгаад
Ямагт бусадтай учрах буян
Ялангуяа оюуныг удирдах хүчээр
Янагш чинагш төрөл бүхэндээ
Яруухан итгэлт багштай золготугай
Увидасын дээдийг хайрлах багшийн
Урьд номлосон авшигийн хураангуйг
Уйсалгүй хүртэх тэсвэр боловсорч
Ухаан минь тэлж зам нь тодортугай
Асар ариун 7 авшигийг хүртэж

Авирахуй бэрх 7 газарт хүрсний
Агуу хүчээр алмид түүтгэр арилж
Авьяас илтээр бүтэх болтугай
Оршихуй гэтлэхүй орчлонгийн
Охь болох авшиг хүртээд
Очирт 4 лагшингийн хөрөнгө бүрэлдэж
Онож сонсож бясалгахын ой ухаан тэлэг
Очирт их хөлгөөр орны дээдийг зүглэж
Онцгой сахил ариун бээр унаа юугаан тохируулж
Огоот ариун 4 авшигийг эрхшээж
Очирт суудалд залрах болтугай
Бие хэл сэтгэл юугаа билэг билгээр ариулаж
Зургаан язгуурын амьтан хүмүүнийг
Бясалгал ёгүзарын биед хувилгаад
Зэвэн үзүүрт очирын гэрлээр зэвхий шулмыг шатаатугай
Хязгааргүй огторгуй 4 мах бодийн
Хотол мандлыг очироор хүрээлж авхралсны төвд
Хүчит Доржшуг бурхан хүрээлэх 60 тэнгэрийн хамт заларч
Хаалга бүгдийг сахиж хавьтах адыг хөөсүгэй.
Адыг хөөсөн ариун огторгуйд
Ачит буяныг номчлон хурааж
Агуу чуулган илт төгсөж
Агаарт замхарав хотол мандал
Алгуур мандах алтан нар шиг
Аржал мандах алтан нар шиг
Агшин төдий бодийг олж.
Ариун нирвааны 4 ёгзорыг
Алдал үгүй эцэст хүргэж
Ашид амгаланг эдлэх болтугай.
Огторгуй салхи, газар, ус, шороо
Орчлонгийн сав шим уул ургамал
Оноож бие дээр зүйрлэж үзвээс
Орой дух, хоолой зүрх хүйс нуурын орон
Очирын лагшин ахуйн ёсоор
Онцгой бадам цэцэг наран саран дэвсгэр дээр
Очирын хүрээ орон бясалгаснаар
Оргих ромоо жама судсаар дамжиж
Очирт Ёгүзарын дээдийг олох болтугай
Хир үгүй эрдэнийн гэрэлт орд харшид орж
Хүрээт очир бясалгасны хүч.
Хаана ч бурхан болсон газар нь ариусхад

Харин нь өөрийн бие минь түүтгараас хагцаг
Арга билгийн тэмдэг агаар сэтгэлийн 2 үгсийг
Агшаан нийлүүлж хум үсгийг бясалгаад
Улаан эхийн цагаан эцгийн дусалыг
Уураглан нийлүүлснээр төв амгалан төрөг.
Байдал бүгдийн дээд төгөлдөр.
Бат амгалан галазагдын лагшин
Бүх талаас өөрийн язгуур сэлт
Бат амгалан тэнгэр бясалгахын хүч
Бадгар үйл байдал сэлт дараалан
Бас илт барихын хоосон дүрс үйл
Хувирахгүй хамт төрөхийн амгаланг эдэлж
Ханьцашгүй төгсөхийн зэрэгт хүрэх болтугай
Эр, эм тэгш оршихын хөрөнгөөс
Эхийн умайд тэнгэр оршоод
Өөр өөрийн оронд үүсгэхийн зэрэг бээрр
Өмний аглагт хот мандлыг байгуулж
Таван байдлаар бодийг олж бясалгаад
Таван цогцсоор нэгжээд эрхтэнг оноож.
Таван эрхтнээр таарах ажлыг эрхэлж
Тавтай замыг мэдэж төрөх болтугай.
Их амгалангийн хот мандалыг цэцэрлэгт
Эрхэм язгуурын Галазагда бурхан
Эргэлдэн ноцох их галын төвд оршин хүчээр
Их амгалангийн дусал дүрс дор оршоод замхархад
Охин тэнгэр нугууд яруу дууны эгшгээр
Одоо босож амьтны тус хийхийг айлтгахад
Очирт 5 бурхад босож дуудах залах хүлэх баясах амтлахаар
Омогт тавын тангараг лугаа онцгой таван үйлд шамдав
Тэр мэт хорин байдлын бодийг бясалгаж
Тэрчлэн авшиг айлдсан санамсарал ариунаар
Төдөлгүй бүтээх гишүүн үйлийг
Төвдөлгүй бясалгаж тус нь илт бүтэг
Арга билгийн огторгуйд адис тэдээр тэгш оршоож
Агаарын салхиар дүмүүн гал бадарч
Аяндаа дээшилж дүдиен замаар
Алхамаар ахиж баруун зүүн судасны замаа хорьж
Ахин түрж магнайд бодь сэтгэлийг үүсгээд
Аажмаар доошилж 4 баясал төрүүлэн
Аг тарнийн төгсхийн зэрэг 4 дуслын Ёгузор бүтнэ.
Ахиж энэ мэт дээшлэн заларах нь

Ачит эхийн бат баясал 4.
 Аминчлан бүтээх нарийн Ёгузорыг
 Хувилгаан адил үзүүлэх шид бээр.
 Хувьтай хүмүүн бодийг олтугай
 Товчилбоос энгийн нүдээр харах ус нь
 Төгсөхийн зэрэг төрөн боловсрох зам
 Гадна дотно ариусах суурь үйлдэх зэрэг
 Гагцхүү зохилдох 4-ийг дадуулахыг хичээ.
 Басхүү тарни тоолох гал мандал тахил өргөх дор.
 Баттай хичээллийн орныг эзэлж
 Баараагүй үйлдэх шидэс бүтээл бээр.
 Барагдашгүй амьтныг боловсруултугай.
 Эхний буяны Ёгузор анхан Санаа Самаади хоёр
 Дундах буян амин самбаа барих хоёр
 Эцсийн буян дурьдах бясалгах зам
 Эдгээр бэлтгэл зургаан гишүүнийг эгнэгт дадуултугай
 Хорин мянга зургаан зуугаар тоолох мал Бодь
 Хос улаан цагаан туслаар дээш доош гүйх зам.
 Уртасган давхарлахын хүчээр
 Унаган биений муу цогцос
 Уустугай мөнгөн усаар идэгдэх төмөрчилөн
 Хоосон чанарыг оносон хувирашгүй их амгалан
 Хорин мянга зургаан зуу үйлийн салхиар
 Хорих түүтгэрийн багчиг ямагт
 Хоромхон судалж бурхны лагшинг олтугай
 Энэ адил ерөөлийн орон саадгүй
 Их амгаланг олох замын дээдийг
 Эгэл хүмүүсийн эрдэнийн тивд хөтлөх
 Эхний хөтөч нь би байх болтугай
 Асар цагаан буяны чугуулганыг
 Авч хураасан атаг энэ ямагтыг би бээр
 Алт эрдэнийн сан шамбалд төрж
 Ахин доошлохгүй бурхны хутгыг болтугай.

*Лувсанчойжий жанцан богдын айлдсан өлзий оршуулагч
 үг буюу даш уншиж явах хүртэл бие хэл,сэтгэл гурваар
 тэнгэрийн омогшилийн агаараас буян үүлдэж бүтээ, Унтахын
 өмнө өөрийн таалалд цацрах цагаан гэрэл уусаж “хэрэ” үсгэнд
 дарааланшингэж огторгуйд солонго татах мэт болоод мөн
 чанар бээр хоосон гэрэл тодорхой хоосон чанарын агаараас*

сэтгэлийн орон унтах хүртэл сэтгэл алгасралгүй бурхад багш нартаа сүсэглэн нинжин сэтгэл бодь сэтгэл тэргүүтнийг буянт сэтгэлийн ялгаагаар бусад хүмүүсийг энэрэхүйн агаараас бодол өөрчлөлгүй байж унтаж чадваас онцгой хэрэгтэй .

Бодитой сахихын өдөр өглөө эрт гарын алга харагдах тэр эгшинд угаал үйлдэж УМ-БАДМА-ҮДА-БАЕЭ-СУХА-тэргүүт тариньг уншиж аврал итгэл одуулан шүтээний өмнө сонин буюу сахил аваад-тэгүүний газар орших болтугай-хэмээх хүртэл урьдах адил уншина. Магтаалыг тав буюу долоон удаа уншаад угаалын дараа өмнийн бүтээл зурмал хот мандал болбол:

Энэ адил дүрс хамт

Энгүй олны тусад залраад

Өвчин үгүй өнөд наслаад

Өөдрөг бүгдийг хайрлан соёрх

УМ-СУ-ВАРА-ДЭСТА-БАЗАР-ЕЭ-СУХА

гэх баЭлсэн хот, гандан бол Ишба-буюу өмнийн бясалгасан бурхадыг залруулаад Дамцагва буюу тангарагтан гэрлэнд уусаад өөртөө шингэж буй хэмээн бодоод дүл цэнгээ хураахдаа, бусад чогын адил үйлдээрэй. Бас бүтээлийн суурь мандал цомботой бол угаалын дараа

УМАА-

ТА амьтны тусыг зохион

ТА түмэнд шидэс бүтээл хайрла

ТА Бурханы орондоо заларсан ч

ТА Буцаж амьтны тусыг зохио

УМ-БАЗАР-МУ Ишээба-буюу-өмнийн бурхан өөрийн мөн чанараар заларч, дамцагва-буюу тангарагтан гэрэлэнд хувирч өөртөө шингээд өөрөө Арьяабал нэг нигуурт, хоёр мутарт болон хувирсны оройд УМ-цагаан, хоолойд “А” улаан зүрхэнд **ХУМ**-хөх өнгөөр гэрэлтэх болтугай.

29. ГОМБО САХИУС БУЮУ МАХАГАЛЫН МАГТААЛ

Хум.Түргэн зохиолт Нүдээр-Үзэгч дор мөргөмүй
Хөлийн бугуйвч лугаа сэлт Бинаяага гишгэсэн
Их хар нь барын арьсан хормогчит
Зургаан мутарт хийгээд асар могойгоор чимэгт

Баруундаа тонгорог, дундахаар эрих барьсан
Адагт дамар барьснаар чанга дэлдэн дуугаргасан
Зүүндээ гавал хийгээд гурван үзүүрт жад
Түүнчлэн цалам барьснаар хүлэн үйлдэгч
Догшин дүр байдалт, соёогоо тийн ярзайлгагч
Гурван мэлмийгээр хялайн, үсээ дээшид бадруулсан
Магнайдаа синдурраан сайн түрхлэгт
Оройдоо Агчованийн бат тамгат
Цус дусалсан тавин хүний толгойн сондортой
Хуурай таван эрдэнэсийн гавлан титэмтэй
Модноос заларч балин авсан зохионгуйтай
Цог төгөлдөр Зургаан мутартад мөргөмүй
Бурханы шашны догшин сахиус болоод
Чухаг дээдийн яруу алдрыг цуурайтуулан
Ба бүрэн багш шавь, нөхөд сэлтүүдийн
Муу нөхцөл бүхнийг буцаах хийгээд
Хүссэн шид бүтээлийг хоцроолгүй хайрлан соёрх
Ум.Бүтэх болтугай.
Аймшигт их үхээрийн доторх
Асар зандан шугуйн цэцэрлэгт
Ассан галвын гал мэт бадрангуйн төвд
Алжааст Бинаяагаан дэвсгэр дээр
Залрагч сүр жавхлант Махагал
Зургаан мутартын лагшин байдал нь
Зохист үхээрийн чимгээр чимсэн
Зарлигийн тэсдэшгүй хүрхрэлээр
Асар “Хум” ба “Пад”-ын дууг дуурсгасан
Арилсан таалал туурвилаас хагацсан ч
Аливаа бэлгэснийг үзүүлэгчийн үүднээс
Ахуй бэлгэсийг үзүүлэгчийн үүднээс
Ахуйн лагшин, зарлиг,тааллыг магтмуй.
Зургаан мутрын баруун эхний тонгорог барьснаар
Нисваанисыг ёзоороос огтлоод дайсанд далайгч
Удаахаар эрих барьснаар амьтны тус тоологч
Гутгаарын дамраар дагинасыг эрхэндээ хураагч
Ертөнцөөс нөгчсөний эрхин дор мөргөмүй.
Зүүн эхний цустай гавал барьснаар
Дайсан тотгорын тархины цусыг уугч
Удаах гурван үзүүрт жадаар гурван ертөнцийг эрхэнд хураагч
Гутгаарын цалмаар тангараг доройтсоныг хоцроолгүй хүлэгч
Адистид шид бүтээлийн сан дор мөргөмүй

Номын бие дор урвалт үгүйн тэмдгээр
Лагшингийн өнгө хөхөмдөг хар, маш бадрангуйт
Цус савирсан тавин толгойн сондортой
Барын арьс, олон могойн чимэгтэй
Махагал тан дор би мөргөн магтмуй
Бинаяагаан дээрээс гишгэснээр
Дайсан тотгорыг товроглогч
Амаа ангайн соёогоо ярзайлгаснаар
Тангараг доройтсоны цусыг сорогч
Их хүчит тотгорын эрлэг дор мөргөмүй
Гал мэт бадрангуй гурван мэлмийг хөдөлгөснөөр
Гурван ертөнцийг эрхэндээ хураагаад болгоогч
Оройн үсийг дээшид бадруулсан тэргүүндээ
Агчовани бурханаар маш сайтар чимэгт
Дөрвөн авшиг огоот төгссөн дор мөргөмүй
Хум.Босогтун босогтун, номын төвөөс босогтун
Сануулмуй сануулмуй, амьтны тусад сануулмуй
Таалал үндсэнд дурдатган даалгасан үйлсийг бүтээгтүн
Бүү алгасагтун бүү алгасагтун, Цогт Их хар аа!
Шагжаан арслангийн өмнө
Шашныг сахихаар ам авсан
Сайн ийм үйлсээ үрт болго
Дээд төрөлхтөн төгс оюунт хэн бээр ч
Магтаал үүгээр нэгэнтээ магтан үйлдвээс
Эцэг эх нь үр ачаа энэрэх ямарчлангаар
Цогт Их хар насад нөхөрлөн зохиогтун.

30. ДАШИ БУЮУ ӨЛЗИЙ ХУТАГ ОРШООХУЙ

Орчлон нирвааны нэн цагаан буян хэдий чинээгээр
Одоо энэ дор мэдээгүй гутамшиг бүгдээс хагацаад
Ахуй үес,эцэс хойтод сайн буян огторгуйн сан мэт
Ариун чуулганы цог өлзий хутаг орших болтугай

Хэмээн өлзий оршуулмой.

Тэр мэт хатууд оршихийн үйл хийх өдрүүдэд: Архи, мах, сонгино, сармис, лууван, дэл, буудай, болон өөрийн аманд зажлагдах зүйл бүгдийг тэвчих ба гурван цагаанаар бүтээгдсэн идээг голчлон нэгэн суудал дээр хооллож тэр үедээ идээ ундаа бүгд рашаан эрдэнэ хүртэж байсан хэмээн сүсэглээрэй

өөрийгөө Аръяабал бурхан хэмээн түүнд тахил өргөж байна гэж бодоорой. Гар дээрээс идээ идэхгүй байх цэцэг навч зулгаалгүй байх, үдээс хойш тараг, сүү, жимсний шүүс, уухаар болбол бурам сахар, зөгийн балаар амтлалгүй ловонгийн айлдсанчилан байх.

Илт сахихуй өдөр өглөөнөөс аваад ганц үрийн төдий ч идэх зүйл дусалын төдий ч шингэх зүйл уулгүй шүлс нусаа гадагш задгай хаялгүй байх.

Номын уншлагаас өөр дуу авиа гарган хоорондоо ярилгүй санаа бодлоо гадагш алгасруулалгүй төвлөрүүлэн байх хамгийн чухал.

Жигүүрээ дэвэн ниссэн шувуу буух газараа хүрч далиа хумьдаг шиг нэгэнт сахих ам авсан бол, дуустал нь номончилан байж, эцэст хүртэл харшлах шалтгаан бүгдийг тэвчиж өөрийн ловонгийн айлдвараар орой болтол дараа өглөө хүртэл ёсчилон сахих чухал хэрэгтэй.

Сахилын үед болон тарина тоолоход нойр хүрэх, хэрхэрэх, бөөлжих, доошоо унгах зэрэгт тэр даруй алга хавсран цомцойж сууж номончилох, хоёр гарынхаа зүүндээ ус хийж баруун гарын ядам хуруугаар дүрэн ам, хамарын, нүх, чихэнд болон толгойд хүргээд дараа нь 3н удаа ус сорон амаа зайлж уруулаар хоёр гурван удаа гадагш хаяж дахин тарина тоолоход найруулан үйлдэж болно.

Хатууд суухын өдөр ус бага байхдаа харшлахгүй. Тарина тоолох үед өөр бурханы залбирал тарина тоолох буюу сэтгэлээрээ залбирал тавибаас Агрэмчинму” буюу Тарины их тайлбарт заахдаа гэг тотгор ирэх, бие өвдөх, гэдэс мушгих, сэтгэлд уйсал төрөх ба уншлагын үед босож явах, бохир үнэр үнэртүүлэх зэргээс шөнө зүүдэнд ад орох зэрэг муу үйл мэдэгдэх тул сайтар үүлдвээс зохилтой.

Тарина тоолохдоо ч илүүдүүлж дутаалгүй тааруулах хэрэгтэй.

Уншлага хуралын цагийг хэлбэл өглөө нар мандаж нэгэн хүнд сүүдэр гарах хүртэл үдийн өмнөх цаг болой.

Үдээс хойш нь нэгэн хүний сүүдэр бүтэн гарсанаас нар жаргах хүртэл өдрийн цаг болой.

Өглөө нарнаас нар жаргах хүртэл өдрийн цаг буюу анхны цаг орой нар жаргахаас өглөө нар мандтал шөнийн буюу 2-р цаг, болой.

Муу зүүд зүүдэлвээс язгуурын эзэн Аръяабалын тарина уншваас зохилтой.

Тус эрдэнэ ануу. Хутагт Аръяабал бурханы айлдал хэмээх

дамжлагаас: Би бээр хатууд суубаас бодисадба бурхан бүгдийн их нинжин сэтгэлд орох билиг билгийн шимийг олох болой.Алин бээр сахих болой сахилтай учирсан оршсон ба элдэв зовлонгийн ерөндөг хамаг амьтан дор би бээр энэрэн оршоод, аварч садан болье, ягчис, мангас хилэнцэт нуугуудад ч энэрэлээр дуудан асралын сэтгэлээр хандая ханьцашгүй бодийн сэтгэл дор оруулая, Бурханы ирт хувилгаан ч их болой хэмээннэгэн удаа өгүүлэхэд үндэсний 4н унал ариусаж, завсаргүй таван нүгэл ч арилдаг учир ийн хэмээн шамдал ихээр үүлдвээс, ямар буян хураах нь ойлгомжтой.

Бурхад буяны үндсийг үүсгэж байхад тэгүүнд даган оролцож тарина тоолон бүтээхэд ямар буян ихтэй байхыг хэлээд яахав.

Санаа бүгд сэтгэлчилэн төгөлдөр болно. Хэн нэгэн бээр хатуужлийн тухайд шинийн 14,15 нд сууваас 40000 галавт хураасан нүгэл арилаж, бурханы алдарыг дуудваас буян ихийг хураана. Буцалтгүй өөдлөх мөрийг олно. Өвчнөөс гэтэлж хилэнц бүгд бие, хэл, сэтгэлээс арилж, чого номоо ёсчилон биелүүлбээс бурхныг хутаг олно хэмээн хутагт Арьяабал бурхны айлдвар байна.

Хутагт Арьяабалын чого шивму буюу уншлагын тайлал хэмээх сударт: Хэн нэгэн тарни уншиж, шинийн 15-нд суртгаалын найман суурийг барих, шинэ хувцас өмсөж рэнсэрэлтэй суварганы өмнө болон бурханы дүрийн өмнө цагаан зандан, элдэв цэцэг, үнэртэн хүж, зул өргөж, бурханд биширч үйлдэн тэгүүний тарина уншиж хот мандал байгуулж үйлдвээс завсар үгүй 5-н нүгэл, үйл түүтгэрээс хагацаж ариусгана гэжээ. Мөн бурханы бясалгалын хүчийг олно. Гэрлэн авшиг хүртэх хүчийг олно. Билиг барамидыг төгсгөнө. Бурхан бүгдийн энэрэлийн дүр бүгд Арьяабал болно. Дээд лам Цагаан Лянхуагаас: Ганга мөрний элсний тоотой амьтан бүгдийг энэрэн асрана гэсэн айлдвартай Арьяабал бурханы алдарыг ч гэсэн дуудвал энэ болон эцэс хойдын буянд тустай хэмээн айлджээ.

31. АРЪЯАБАЛ БУРХАНД ЕРӨӨЛ ӨРГӨХҮЙ

Энэрэлийн сан сүмбэр уулаас
Эгэлд туслах мөрөн далай гарч
Амьтан бүхэнд ялгал үгүй
Ариулан зохиогч их Аръяабал
Энэрэлийн шим энэхүү Зан үйлийг
Эгнэгт дамжуулан ёсчилон сахиад
Урьдын хураасан хилэнцийг арилгаж
Урагшлах газрын эрх олдтугай
Зовлонт хөвүүн тоолшгүй төрөлдөө
Зөвхөн туслах эх эцэг амьтны бүхэнд
Үргэлж Аръяабал өлзийг оршоож
Үтэр түргэн Диваажинд залартугай

ТАЙЛБАРСЭЛТ: *Дээрх гурван тасалгаат чогыг уншихдаа эхний чого дээр сожин нэмж сүүлийн чого дээр ерөөл, даши нэмж уншина уу.*

МААНИ ХӨГЖӨӨХ

Авралт гурван чухагтаа
Алгасал үгүй залбирал
Арга хуурмаг үгүйгээр
Амьтан бүхнээ өршөөмүй
УМ МАНИ БАД МЭ ХУМ
УМ МАНИ БАД МЭ ХУМ
УМ МАНИ БАД МЭ ХУМ
УМ МАНИ БАД МЭ ХУМ
Үзүүлэгч бурхан минь
Үнэн ёстой номууд минь
Эрдэмт олон хуврагууд минь
Үргэлж хамт яваарай.
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Өндөр ууланд шат бий
Өргөн далайд сал бий
Харанхуй мунхагт билэг бий
Хавцгай ганд газарч бий
УМ МАНИ БАД МЭ ХУМ/4/
Нисваанисын салбар бий
Нялхаст мунхаг явдал бий
Нэгтгэн бүгдээр залбирч
Нийтээр буянаа хичээлтэй
УМ МАНИ БАД МЭ ХУМ/4/
Орчлон мөнх биш юм
Олохуй чухал нь хүмүүн юм
Олсон бүгд нь хоосон шүү
Олзны дээд нь буян шүү
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Ертөнц мөнх биш юм
Ёрын учрал олон юм
Зориод очихын урьдах
Ерөөл буянаа хичээлтэй
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Сансар мөнх биш юм
Самуун явдал олон юм
Сайтар мааниа хөгжөөж
Шамдаж буянаа хичээлтэй
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Ачит зургаан үсгийг

Аялан шүлэглэн уншвал
Арван найман тамд нь
Хүртэл үгүй аварюу
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Маанийн зургаан үсгийг
Магтан шүлэглэн уншвал
Магад муу заяанд нь
Хүргэл үгүй аварюу
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Хүчит зургаан үсгийг
Хичээн шамдан уншвал
Хүйтэн халуун тамд нь
Хүртэл үгүй аварюу
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Харамлан зонхилон тачааж
Хайрласан бүгд хоосон
Харин ч хойноо тамтай шүү
Хайхарч буянаа хичээлтэй
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Зоорь зоорь гэхэд
Зөөж хураахын зовлонтой
Зөнд нь өсгөж баяжваас
Зүдрэн зовох чанартай
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Сонин сайхан боловчиг
Солонгын өнгө нь хоосон
Сонортонд баяр төрөвчиг
Сонссон баяр нь хоосон
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Цээжинд баяр төрөвчиг
Цэцгийн өнгө хоосон
Сэтгэлд баяр төрөвчиг
Чихэнд дуулдах нь хоосон
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Ханилж сууя гэхэд
Хагацаж салахын зовлонтой
Хайртай хайртай гэхэд
Халуун амь хоосон
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/
Энхрий хайртай биеийг чинь
Ижил үгүй орхисон шүү

Эрлэгийн газар очиход чинь
Эрдэмт лам газарчилна
Хутагт Арьяабалдаа
Хоромхон зуур залбирваас
Хилэнц нүгэл арилж
Бурханы хутгийг олно шүү
УМ МАНИ БАД МЭ ХУМ /4/

ЭЦЭГ ЭХИЙН АЧИЙГ ХАРИУЛАХ МААНИ

Нэг зуугийн бурхантай
Нэгэн ботийн номтой
Нэг мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Хоёр зуугийн бурхантай
Хоёр ботийн номтой
Хоёр мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Дөрвөн зуугийн бурхантай
Дөрвөн ботийн номтой
Дөрвөн мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Таван зуугийн бурхантай
Таван ботийн номтой
Таван мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар

УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Зургаан зуугийн бурхантай
Зургаан ботийн номтой
Зургаан мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Долоон зуугийн бурхантай
Долоон ботийн номтой
Долоон мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Найман зуугийн бурхантай
Найман ботийн номтой
Найман мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Есөн зуугийн бурхантай
Есөн ботийн номтой
Есөн мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/
Арван зуугийн бурхантай
Арван ботийн номтой
Арван мянган хуврагтай
Шагшаавадийн орондоо
Зулаа хүжээ өргөсөн
Эцэг эхийн ачийг ээ
Хариулж өгсөн номын чанар
УМ МАНИ БАД МЭ ХУМ /3/

Нүгнай буюу хатууд оршихуйн зан үйлийг ёсчлон дагаж бүтээл бясалгалын туйлд хүрсэн бясалгаач Ёгузер нарын намтраас дурьдвал

ДАВААШОНУГИЙН НАМТАР

Судлалыг туйлд нь хүргэж таван ухааныг болгоодог.

Хурдан хөл тэргүүтэн нийтийн шид бүтээлийг олсон

Дагинасаар эш үзүүлсэн Балму лугаа золгож

Дээдийн шид бүтээлийг олооч танд мөргөмүй.

Энэ бандид Энэтхэгийн баруун зүгийн Гүшийн цэцэрлэг хэмээх арал дээрх амгаланг тэтгэгч хот балгадад мэндэлжээ. Эцэг Дээд амгалант нь анагаах, урлах ухаан бүхнийг төгс мэддэг бөгөөд бярманы тарнид мэргэшсэн нэгэн, эх Панибадма нь хүж найруулахдаа мэргэн бөгөөд цэвэр цэмцгэр эмэгтэй юм. Эцэг эхээс гурвуул, отгон хүү нь билээ. Дөнгөж мэндлэхэд нь хэлэн дээр нь Дхи үсэг бичих тэргүүтэн бярманы үйлийг үйлдэж өсөж том болоод Балжи хэмээх багшийн дэргэд унших бичихэд хичээж төвөггүйгээр сураад Амгалан оюунт хэмээх бярманы алдрыг ч хүртэв. Дараа нь 13 масандаа хувраг болж сав гурван аймгийн номд хичээн таван ухаан тэргүүтэн бүхий л мэдлэгийг эзэмшив. Ялангуяа дууны, шалгадаг ухаанд мэргэшсэнээрээ хамаг зүгт алдар нь түгж, дотоодын бурханы шашныг наран ургасан мэт мандуулвай.

21 насандаа гэлэн сахил хүртэж, сонссон мэдсэн **бүхнээ** анхааран авч таримал цэцэрлэг, ой шугуй даяар хэсүүчлэн ахуй цагт ямар нэг шалтгаанаар дотоод хийнд нь зэтгэр гарсанд ямар ч арга тус болоогүй бөгөөд нэгэн шөнө зүүдэнд нь зүүн зүгээс нэгэн цагаан гэрэл зүрхэн тус газарт нь шингэлээ хэмээн зүүдлэв. Нойрноосоо сэрэх үед сэтгэлд нь их амгалан төрсөнд “Сайхан зүүд зүүдэллээ дээ» хэмээгээд дараа өдөр нь зах дээр явж байтал хүмүүс өгүүлрүүн:

-Зүүн зүгийн Лихарашимпэлд гэлэнмаа Балму хэмээх бүтээлийг олсон нэгэн байна хэмээхийг сонсов. Тийнхүү сонсоод гэлэнмаагийн дэргэд суин увдис айлтгасанд өнөөх дотоод хийн зэтгэр нь нэгхэн агшинд арилвай. Тэгээд гэлэнма бээр:

-Бандида чиний энэ өвчин нэгэн ламын тааллыг хямраасны урдын үйлийн тань тийн боловсрол мөн, тэгээд жич наминчилсан байсныг миний адистэдлэсэн төдийгөөр ариллаа хэмээжээ.

Арван нэгэн нигууртын авшгийг хүртээж, тантрыг номлож, үүсгэл

төгсгөлийн хөтөлбөрийг хайрлаж, бандида ч анхааран авснаар бие цогцос нь солонгон бие болон бүтэв. Рид хувилган хийгээд таван зөн билгийг олж нэгэн насандаа дээдийн шид бүтээлийг олвой. Гэлэнмаа Балмуу бээр: «Мянган мутар, мянган нигуурт Жанрайсигийн бүтээх арга нь гурван цагийн хамаг бурхадын мөн чанар, юмс бүгдийн эх булаг, хурц оюунтны ном, хүлээс бүтээл бүгдийн дээд нь мөн тул нандигнан бясалгаж олон амьтанд тусал хэмээн зарлиглаад авшиг хүртээв.

Энэ нь Даваашонугийн намтар бөгөөд түүний шавь Бал-Ишсамбуугийн намтрыг өгүүлье.

БАЛ-ИШСАМБУУГИЙН НАМТАР

Тэсэшгүй зовлонг өөрийн нөхөрт ургуулан,
Сүсгийн хүчээр ламыг хутагтад үзсэн
Хичээнгүйн хүчээр дээдийн шид хүчийг олсон
Ишсамбуугийн өлмий дор мөргөмүй.

Энэ бандидын мэндэлсэн нутаг нь Энэтхэгийн Ганга мөрний эрэгт орших Гишили ордон юм. Эцэг Паалшири хаан, эх Бүхнийг гэгээрүүлэх гэрэлт хоёрын таван хөвгүүний отгон болон хаан угсаанд мэндэлжээ. Занасиди хэмээн нэрлэж 7 нас хүрэхэд нь хувраг болгож ухаанд сургасанд таван ухаанд цагаарч, ялангуяа зохиол туурвилд мэргэшсэн бандида болсон боловч урдын үйлээрээ цээжин биен дээр нь яр гарч олон зүйл эм заслаар оролдоод засраагүй тул тэнгэр чөтгөрийн хорлол хэмээн санаад зүүн Энэтхэгээс хар Ямандагийн нэгэн бүтээлчийг залж авчрав.

Тэгээд увдис айлтган нямба бясалгалыг үйлдсэнд бие дэх өвчин эвэршээл нь урдахаасаа гурав дахин ихэсч, хамаг бие нь цэврүүгээр дүүрч, галд түлэгдэх мэт зовиурласанд унтлагынхаа өрөөнд жижиг усан цөөрөм авчруулан дотор нь суувал биеийнх нь халуун илч усыг буцалгах мэт байв. Дахин бүлээссэн усыг хүйтэн усаар солих шаардлагатай болдог энэ бэрх өвчнийг хар цагаа гэж нэрлэдэг. Энэ өвчнийг бас Гүвдрүүт хар цэцэг өвчин ч гэх бөгөөд өвчин зовиурыг нь тэсэхүйеэ бэрх юм. Тэрбээр: «Даваашону багшийг залан ирүүлж адислуулбал эдгэх болов уу» хэмээгээд хурдан хөлний эрдмийг бага зэрэг бүтээн эзэмшсэн өөрийн шавийг зарж явуулсанд тэр ч гэсэн Даваашону багшийг ой шугуйд самуд дияанд сууж байхад нь дэргэд нь хүрч ирээд болсон явдлыг айлтган сонсгоод заллага айлтгасанд, багш бээр:

-Маргааш бадар барьж гүйцээд хоёул хамтдаа одсугай гэж зарлиглав. Маргааш нь хот балгадад бинавад гуйн идээний үйлийг гүйцээгээд тэр элчтэй нөхөрлөн Энэтхэгийн зүүн зүгт орших Бишин аралд залрав. Шавийнхаа буй газрын ойролцоо буудаллан нойрссон шөнийн зүүдэнд нь торгон хувцастай навчин хээт өмсгөлтэй, гартаа удвал цэцэг барьсан хөх өнгөтэй эмэгтэй гарч ирээд:

-Бандида аа! чиний энэ шавь нэгэн багшдаа тангараг доройтуулсны урьдын тийн боловсролоор ийм болсон тул чи эдгээж үл чадна. Домбусадва сүмд гурван цагийн бурхан бүгдийн тааллын нэгэн мөн чанар болсон Их нигүүлсэгч бодитоор ирж авшиг хайрлан адис хүртээсэн гэлэнмаа Балму хэмээх чиний багш сууж буй тул түүнийг залж адис айлтга. Тэр түүнд туслах бөгөөд шид бүтээлийг хүртээх болно хэмээх бошгыг үзүүлжээ.

Маргааш нь Даваашону багш:

-Миний багш хутагт арван нэгэн нигуурт Жанрайсигийн бүтээлийг олсон, бурхан лугаа таалал сацуу нэгэн дагина буй. «Өдгөө Домбусадвын сүмд сууж байгаа тул залж авчран адис айлтгавал туслах болно» хэмээсэнд Домбусадвын сүм рүү элчээ зарж элч нь гэлэнмаа Балмуутай уулзан түүхийг нягт өчин залран ирэхийг айлтгав. Гэлэнмаа «Урьдын барилдлага буй тул одсугай» хэмээгээд залран ирж гэлэнмаагийн бясалгалын өргөөнд арван нэгэн нигууртын үүсгэлийн зэргийг нэгэнтээ бүтэн зохиосонд Ишсамбуу бээр гэлэнмаа өөрөө арван нэгэн нигуурт бодитой болж биеэс нь гэрэл сацран бандидын биед тусахыг илт Бодотоор үзэв. Тийнхүү адистэдлэсэн төдийхөнд бандидын өвчин хормын дотор илааршиж сүсэг болон адис жинлав бүрэлдэн бэлэг дэмбэрэл нь жигдрэв. Тэгээд Бал-Ишсамбуу арван нэгэн нигуурт гэлэнмааг ил бодитоор үзсэндээ хувиршгүй сүсэг бишрэлийг олж хутагт арван нэгэн нигууртын увдисны зарлиг ишлэлийг айлтган хүссэнд нэгэн товч хураангуйг хайрлав. Гэлэнмаа Балму тэр үед:

-Дэлгэрэнгүйг Даваашону багшдаа айлтган анхааран авлага болгогтун. Дээдийн шид бүтээлийг энэ яваа насандаа олох болмой хэмээн бошго буулгав.

Дараа нь Даваашону багшаас жанан, тантрын номлол, үүсгэл төгсгөлийн хөтөлбөр зэргийг айлтгаж Чилан ахуйг зохиохын сацуу бурханы егүзэр хийгээд хоосон чанарын егүзрийг гурван сарын турш бясалгаж оерийн биеэр Хутагт арван нэгэн нигууртын лагшинд илтэд хувилах тэргүүтэн үүсгэл төгсгөлийг бүтээгээд нэгэн яваа

насандаа цогцос нь солонгон биед хувилан их махамудрьш дээд шид бүтээлийг олж хутагтын тойрон хүрээлэгсдэд багтан оршвой хэмээн алдаршсан. Энэ нь Бал-Ишсамбуугийн түүх бөгөөд тэр бээр увдис үүнээ Балбын бандида Пеняпад хайрласан юм.

ПЕНЯПАГИЙН НАМТАР

Өгүүлээчийн арслан Зөөлөн эгшигтийн бошмиг сонсож,
Их нигүүлсэгчийг бүтээж шид бүтэлийг олоод
Таван ухаанд мэргэшсэн Балбын их бандида
Пеняпа багштан таны өлмий дор сөгдмүй.

Энэ бандидын мэндэлсэн орон нь Балбын Ямбу-Ягал хэмээх хот юм. Вивалоки хэмээх хааны ордны ойролцоо амьдрах Балбасамбуубал хэмээх чухаг дээдийн тахилыг эрхэмлэдэг нэгэн хийгээд Балмугүндүзэ хэмээх өнгө зүс сайтай, ааль авир дөлгөөн эмэгтэй нарт урт хугацааны туршид үр заяалгүй байж байгаад нэгэн цагт Жанрайсигийн адис жинлаштай хүү төрсөнд нутгийн заншил ёсоор шинэ хүний найр наадмыг зохиож тэр хүүдээ Үзэсгэлэнт охь хэмээх нэрийг хайрлажээ.

Тэр хүү бүхний сэтгэлт зохист, ая зөндөө өсч торних, бичих унших хийгээд урлахуй ухааныг ч төвөггүйгээр эзэмшсэн нэгэн тул эцэг эх нь түүнийг эрийн цээнд хүрэхэд нь язгуур нэгтнээсээ бэр буулгахыг завдсанд хөвгүүн өгүүллрүүн:

-Ингэх тань үхлийг ирүүлэхгүй, амьтанд тустай байх уу?

-Тийм бус ч гэсэн угсаа залгамжилна хэмээн эцэг эх нь хариулахад: -Тэгвэл амьтанд тусалсугай, хотол олонд туслагч нь хүмүүний дээд хүн мөн билээ! хэмээгээд амьтны тусыг зохиогч хүмүүн болов.

Тэр бээр өгүүлэгч арслан Манзушрийг бүтээж нигуур үзэх үедээ:

-Надад нэгэн насандаа бурхан болох шид бүтээлийг хайрла хэмээн айлтгасанд Зөөлөн эгшигт бээр:

-Чи Энэтхэгт одож арван нэгэн нигуурт Жанрайсигийн бүтээх аргыг хөтөлбөрийн хамтаар айлтгаж анхааран авахтун. Энэ яваа насандаа бурхан болох болно хэмээх эшийг үзүүлэв.

Тэгээд бандида Пеняпа өөрт байсан хэсэг алтан чимэг, зүүлт хийгээд багагүй хэрийн алтыг даавуунд боогоод модны навчинд ороож сугандаа хавчуулаад Энэтхэгт залран очиж хүмүүсээс:

-Энэтхэгт мэргэн нь хэн, ариун нь хэн, сайн нь хэн, амьтныг их

энэрэгч нь хэн, арван нэгэн нигууртын бүтээлийг олооч нь хэн бэ? хэмээсээр асуун явсанд зприм нь өгүүлрүүн:

-Чи хэт их хүсэлтэй байна. Тэр бүхнийг цогцлоосон багш машид ховор хэмээхэд зарим нь:

-Чи зөв сэтгэлтэй хүн байна. Тийм багш хэрэгтэй бол бандида лам Даваашону хийгээд Цогт Ишсамбуу нарт тэдгээр эрдэм бүрдсэн бөгөөд ялангуяа арван и.эгэн нигуурт Жанрайсигийн бүтээлийг ологчид мөн хэмээсэнд Пеняпа тэдгээр хоёр лам хаа суудгийг надад заавал хэлж өгөхтүн хэмээсэнд нэгэн хүмүүн өгүүлрүүн:

-Тэр хоёр лам рид хувилгааныг олсон учир заримдаа хутагт Жанрайсигаас ном сонсохоор Бодала уулын оройд одож, заримдаа Энэтхэгийн нутаг орон бүхэнд одож амьтны тусыг зохиодог тул орших тогтсон газар үгүй. Үйл болон ерөөл нь ариуссан зарим нэг хүмүүс л олж уулзана. Гэвч Домбусадвын сүмд хоёр бандида ихэнхдээ оршиж байдаг юм. Энэ сарын шинийн найманд Хасарваанийн цагийн тахил үйлдэх хурлын тэргүүнээр залрах тул чи тэнд уулзахаар одогтун.

Тийн хэлэхэд нь бандида машид их баясаад сага сарын шинийн найманд өргөлөө өргөөд болсон явдлыг өчсөнд баясангуйгаар ивээлдээ багтааж гэлэн сахил хүртээв. Арван нэгэн нигууртын бүтээх аргыг айлтгасанд «Маш их адистан, амьтанд туслах гүн ном хэмээгч энэ мөн» хэмээн зарлиппыад хутагт арван нэгэн нигуурт Жанрайсигийн авшгийг хүртээгээд тантрыг номлон үүсгэл, төгсгөлийн хөтөлбөрийг хайрласанд таван жилийн турш бадарчин амжиргааг шүтэж, бүтээлд нэгэн үзүүрт сэтгэлээр шамдаад хутагт арван нэт эн нигуурт мянган мэлмийт Жанрайсигийн эрх баялаг голлосон санаанд багташгүй олон бурхан бодисадвын нигуурыг үзэн их махамудрын дээд шид бүтээлийг олов. Тэгээд хоёр бандида лам нар:

-Язгууртны хөвгүүн ээ, чи их үйлийг бүтээсэн тул амьтны тусыг бодож гурван цагийн Түүнчлэн ажирсан бүгдийн үйлс бүхэн нэгдэн цогцолсон мөн чанар Арван нэгэн нигууртын бүтээх арга үүнийг зааж амьтны тусыг зохиогтун! хэмээн даган соёрхол хайрлав.

Тэгээд бандида Пеняпа Балба нутагтаа эргэн залрах замдаа нэгэн их голын захад залран онгоцоо хүлээх зуураа асралыг бясалган хэсэг зуур суух цагт тэр усанд байдаг Хүчний үндэс хэмээгч лус биеэ ил тодоор харуулан:

-Миний гүүрэн дээр залрагтун хэмээгээд лус өөрөө нэгэн их аварга могой болон голын дээгүүр гүүр болсны дээр залрав. Дараа нь тэр лус номыг айлтган зарлигийг сахихаар ам өгч, Балба

хүртэл барцад саад бүхнийг тань сахисугай хэмээв.

Тийнхүү Энэтхэг хийгээд Непалын нутаг орон даяар бүтээлийн тэмдэг, олон зүйлийн рид хувилгааныг үзүүлж амьтны тусыг зохиовой. Энэ нь Пеняпагийн намтар бөгөөд тэр бээр бодисадва Даваажанцанд увдисаа хайрласан юм.

ДАВААЖАНЦАНГИЙН НАМТАР

Хоёр чуулганы саран хот мандал машид дэлгэрсэн

Хоёр түйтгэрийн дайнд ялсан члалтын тэмдэгтэн

Их нигүүлсэгч гэлэнгийн ёсыг үзүүлсэн

Бодисадва түүний өлмий дор мөргөмүй

Хутагт Жанрайсиг өөрөө шавийн тусад хүмүүний дүрсэд хувилсан энэ их төрөлхтний лагшингийн эрдмийг згэл төрөлхтөн бид өгүүлж үл чадах боловч шавийн сүсэг бишрэлийг төрүүлэхийн тухайд хутагтын бодит хувилгааныг гэрчлэх нотолгоог өчүүхэн өгүүлье!

Энэ бодисадва цастын оронд мэндэлсэн бөгөөд өнө эртнээс гэм нь ариусч эрдэм нь төгссөн чанарт оршсон ч дагаар орогч олон шавь нарыг итгүүлэхийн тулд олон буяны садныг шүтэж, ялангуяа Балбын бандида Пеняпагаас арван нэгэн нигуурт Жанрайсигийн авшиг, тантрын номлол, хөтөлбөр тэргүүтнийг сонсох ёсыг үзүүлсэн билээ.

Балбын оронд суун ахуй нэгэн цагт арван гурван тэнгэрт Дэмчигийн хөөмөл лагшин тэргүүтэн нууц тарнийн олон бурхан шүтээнтэй Балбын Бехар хэмээх сүмд суудаг сүмийн эзэн Хату хэмээгч адис жинлаштай егүзэр ламыг шинийн аравны цогчид үйлдэж байхад нь олон хандмаа цугларсанд тэр егүзэрва:

-Дагинас та нар хаанаас залрав хэмээн асуувал:

-Бид Үржингийн орны дагинас байна, Энэтхэгийн зүүн зүг дэх Лихарашимпэл хэмээх газарт арван нэгэн нигуурт Жанрайсиг оршиж байна, түүний цаахнатай хулс тархсан цэцэрлэг хэмээхэд их нигүүлсэлт зургаан үсэгт оршино, түүний хувилгаан Даваажанцан хэмээх бодисадва байдаг тул саяхан түүний дэргэдээс бид ирлээ хэмээн хариулсанд егүзэр:

-Тэр бодисадва хэн бэ? Эдүгээ хаа байна? хэмээсэнд:

-Тэр Түвдэд мэндэлсэн нэгэн бөгөөд эдүгээ Бага тал хэмээгч газарт сууж буй гэцгээсэнд, маргааш нь нэгэн шадар хүмүүнийг үзүүлэхээр явуулсанд олоод тэр егүзэр машид бишрээд бодисадва

Даваажанцан багшийг шавь нарын хамт урьж залан ергөн дэлгэр хүндэтгэл үзүүлж Их нигүүлсэгчийн номын аймгуудыг айлтган сонсов. Бодисадва ч бас тэр егүзрээс Дэмчиг тэргүүтний олон номыг сонсов.

Бас Ам хэмээх гүүш лозава Жидон-манюл хэмээх газар өөрөө бүтсэн Жанрайсигийн шүтээнд эргэл үйлдэн нэгэн үзүүрт сэтгэлээр залбиран ядраад алжаал тайлахын тулд нойрсох зуур зүүдэнд нь Жанрайсиг хүрч ирээд:

-Хэрэв чи надад сүсэглэдэг бол Даваажанцан бодисадвад сүслэгтүн. Надтай ялгал үгүй хэмээн ойлдав.

Тэр бээр урд нь бодисадватай уулзахдаа нэгхэн ар үр өргөлд өргөөд:

-Та уг нь ариун, сайн хүн мөн л дөө. Гэхдээ энэхэн тодийгөөс илүү номын мэдлэггүй тань л гавихгүй юм хэмээн басамжилж байсан хэдий ч хойно машид бишрэл үүсгэж бодисадва түүний биеэ угаасан усыг ч хүртэл ууж байсан гэхчлэн хэмжээгүй ихээр өргөн хүндэлж сүсэглэх болсон байдаг.

Их нигүүлсэгчийн 108 лагшин бүхий нэгэн дэлгэмэл хөргийг бүтээж түүнийгээ аравнайлуулж, түүнээс хойш жаргавч, зововч зөвхөн Их нигүүлсэнгүйтэд залбирч, сүүлд Жанрайсиг бурхантай нүүр учран бүтээлийг олвой.

Бас Дэнрижаггон хэмээх нэгэн хүмүүн 25 жилмйн турш Жанрайсиг Донёдшагвын таван бурханы бүтээлийг үйлдсэнээр нэгэн шөнө «Маргааш Их нигүүлсэгчийн хувилгаан Даваажанцан бодисадва чиний су угаа газрын ойр нэгэн газарт залран ирэх тул тү/нд сүжиглэгтүн» хэмээхийг зүүдлээд маргааш нь шадарлагч хүндээ:

-Бидний байгаа газрын ойролцоо Даваажанцан хэмээх бодисадва залран ирлээ хэмээхийг сонслоо, асуугтун! хэмээгээд асуулгасанд «Цэда хэмээх газар Арижодон хэмээгч залж авчирсан байна» хэмээхийг сонслоо гэж дуулгасанд «Аа тийм бол, маш сайн байна» хэмээгээд нэгэн шадар хүнээрээ бодисадвад заллага айлтгав.

Шадар хүмүүн нь бодисадвын өмнө очоод:

-Бидний багш 25 жилийн турш бүтээлийг зохиогч нэгэн байдаг тул нүүр учран золгохыг хүсээд биднийг ийн явууллаа. Та заларч хайрла гэжээ. Бодисадва:

-Тийм бүтээлчийн лагшин харих (нас барах) аюул буй тул маргааш золгосугай хэмээн айлдав.

Дараа өдөр нь тэрбээр хөл хориогоо гэнэт тайлаад нэгэн хуй даавуу бариад бодисадвыг угтахыг хүмүүс үзээд нигуурыг нь үзэх гэсэн хүн олонтаа цугласныг бодисадва хараад «Эд нар юунд

цугласан улс вэ?» хэмээсэнд шадар хүмүүн нь «Энэ багш өнө удаан бүтээлийг үйлдсэн тул хүмүүс уулзаж чадаагүй юм.

Өнөөдөр хорио тайлж залрахад нь үзэх гэсэн хүмүүс цугларсан байна» гэжээ.

Бодисадва «Аяа, гайхамшиг» хэмээв. Тэгээд бодисадва дотогш морилон өргөн яриа дэлгэсний эцэст Дэврижагон:

-Би 25 жилийн турш Донёдшагвын бүтээл үйлдсэн ч нэгэн удаа зүүдэндээ Бодалын ордонд хүрч үүд нь хаалттай хот мандал байхыг үзсэнээс бус өөр ямар ч шинж тэмдэг гараагүйн учир юу вэ? хэмээн айлтгасанд:

-Хязгааргүй үүдэтийн тогтоолыг олонтаа унш! хэмээхэд нь:

-Тэр тогтоол энд бий юу хэмээн асуусанд:

-Дочэ хэмээх газар миний нэгэн шавь буй, түүнд бий гэв.

Түүний дараа Шанзун-содномбар хэмээхээс номыг зээлэн идам бурханд эшийг айлтган олонтаа уншсанд Бодалын ордонд хүрч очиход хот мандлын үүд нээгдсэн байхыг зүүдлэв. Тэгээд Доёдшагвын таван бурханаар хүрээлүүлсэн мянган мэлмийт Жанрайсигийн нигуурыг үзэж дээдийн шид бүтээлийг олов. Тийм учраас Их нигүүлсэгчийг бүтээгчдэд Хязгааргүй үүдэтийн гогтоолыг олох нь чухал гэж айлдав.

Бас яртсан Иши хэмээх Римади лхамыг бүтээсэн пэгэн байжээ. Тэр бээр Даваажанцан бодисадватай уулзахаар явахын алдад нэгэн балин хаяад бүтээсэн гэр лхамдаа хандан:

-Чи бүү атаархагтун” хэмээн зарлиг буулгасанд тэр шөнө нь Лхам:

-Чамайг Их нигүүлсэгчийн дэргэд очиход дургүйцэх зүйлгүй, түргэн одогтун! Ирэх замд аюул үл ирэхийг би хариуцна» хэмээн хэлэхэд нь:

-Би Их нигүүлсэгчийн дэргэд одож чадахгүй, Даваажанцангийн дэргэд очно» хэмээсэнд Лхам:

-Тэр чинь л Их нигүүлсэгч мөн шүү дээ. Тийм учраас Даваажанцан нь Их нигүүлсэгч бодитой мөн тул дамжлага бүтээл ойрхон байгааг мэдэгтүн!» гэж зүүдлэв.

Бас Даваажанцан бодисадва Жаргалант хотноо байх шүтээний дэргэд нэгэн үзүүрт сэтгэлээр залбиран суусанд шүтээн үг дугарч:

-Үйлдсэн ажилгүй байж бүү гоморх” хэмээсэнд:

-Тэгвэл хэрхэх нь зүйтэй вэ?” гэвэл:

-Зуун хараагүйд нүд оруулж, зуун гүм барьж босгон, зуун гэлэнгийн амьжиргааг бүтээж, зуун хавцгайт замыг зас» гэж зарлиглав.

-Тийм ихийг чадахгүй” хэмээсэнд:

-Мянган мутар, мянган мэлмийтийн ивээлд багтагтун, түүнээс

ч илүү хамаг бүхнийг болгоогч бурханы хутгийг олох болно гэв.

Тэгээд бодисадва түүнийг бүтээхийн тулд дөрвөн гэлэнгээс бүрдсэн нэг чуулганыг дагуулан бинавад идээнд оджээ. Өмнө зүгийн Омла хэмээх нэгэн балгадад очин бадар барьсанд нэгэн бүсгүй зэрвэс хараад:

-Гэлэнгүүд минь, түр хүлээгтүн!" хэмээгээд дотор одоод хэвтрийн өвчтэй эмэгтэйд хандан:

-Үүдэнд нэгэн сайн гэлэн байна. Гэртээ залаад хүндэтгэн нэгэн балин өргөхийг айлтгавал чиний энэ өвчинд тустай болох бус уу? хэмээн өгүүлсэнд өвчтэй эмэгтэй тус болно хэмээн горилон тэгэхийг зөвшөөрч бодисадваг шавь нарын хамт дотогш залж идээ бариад, балин өргөхийг хүссэн гуйлтыг нь ёсоор болгож балин зориулга үйлдэв. Дараа нь нэгэн адис жинлав айлтгасугай хэмээсний нь ёсоор болгож үс нь сэгсийсэн, нүдээ нээж чадахгүй эмэгтэй орон дээрээ хэвтэж байсанд адистэдлээд:

-Чиний энэ өвчин урдын нүгэлт үйлийн чинь тийн боловсрол мөн тул хүлцэл, асрал энэрэл, эрдэнэт бодийн сэтгэлийг бясалгагтун. Муу үйл чинь барагдах болно хэмээгээд ном айлдсанд тэр эм сүсэглээд нүүр нь нулимсаар дүүрч ийн хэмээв:

-Эрдэнэт багш минь, миний урдын муу үйл барагдаагүйгээр зогсохгүй энэ яваа насандаа ч хэмжээгүй их нүгэл үйлдсэн бөлгөө. Хилэнц наминчлах нэгэн аргыг бодолцож хайрлана уу гэхэд бодисадва:

- Аль үйлдсэн хил энц бүгдээ ил тодоор наминчлагтун, ариусна! хэмээхэд эмэгтэй өгүүлрүүн:

-Эрдэнэт багш минь, миний нутаг Жаргалант хот билээ. Маш их баян худалдаачны эхнэр болж долоон жил суугаад тэр худалдаачин найман дагалдагсдын хамтаар худалдаанд одож гурван жилийн турш эргэж ирээгүй тул тэр зуур миний зүс царай ч үзэсгэлэнтэй тул бусдын эрхээр өөр нэг хүнтэй нөхөрлөж хүү тогтсоноо эндүүлээд, эд таваарын ч хагас нь үгүй болж одсон тул худалдаачны хүү надад:

-Миний эцэг эргэж ирвэл эх танд юу болохыг үзтүгэй! хэмээн хэлсэнд:

-Би ямар гэм хийсэн юм гээд тангаран өшиглөтөл элгэнд нь тусаад амнаас нь цус гарч үхэв. Тэгэхэд нь "Хүүд минь гарагийн нүүр тулаад үхлээ" хэмээн зарлав. Тийн үйлдсэнийг минь нэгэн тахилч лам гадарлах тул хэлчих вий хэмээн сэжиглээд хор өгч алав. Дараа нь худалдаачин найман дагалдагсдын хамтаар эд таваарын олз ихтэй эргэн ирсэнд намайг ус авахаар одох зуур нэгэн зарц үйлдсэн бүх гэмийг минь худалдаачин нөхөрт

дуулгасанд худалдаачин:

-Өнөө оройдоо надад ингэж мэдэгдээгүй дүр үзүүл. Маргааш би хоёр үдийг нь ухаж орхиё! хэмээн өгүүлэхийг би хулгайгаар сонсоод тэр шөнө архинд хор найруулж дагалдагсдын хамт найман худалдаачин, хоёр хөрш, хоёр зарц нийлээд 12 хүнд өгсөнд гурав хоногийн дотор нэг нь ч үлдэлгүй үхэцгээв. Түүний гай эцгийн нэрэнд бууснаар гэр бүлээ гутаан дордуулав. Харин би өөрийн эрдэнэсээс аль сайныг нь шилэн авч шөнө дунд өмнөд Балба руу зугтан ирэв. Бас бус башир заль, луйвар, жингийн хулгай, лангийн хулгай тэргүүтнийг олонтаа үйлдсэн тул нигүүлсэн болгоо! Өдгөө энэ хилэнцийг ариутган засах аргыг бодолцож болгооно уу! хэмээгээд нүд нь нулимсаар мэлтэлзэн байхад бодисадва Даваажанцан «Эм хүний биеэр ийм их хилэнцийг хураажээ» хэмээн дотроо бодож мэлмийн шүүдрийг олонтаа дусаав. «Байз, би өдий номыг мэднэ. Яавал хилэнц нь арилах бол?» хэмээн бодоод Хутагт арван нэгэн нигуурт бээр толгойгоо өвтгөн байх цагтаа Чилан ахуйг нэгхэн удаа үйлдвэл муу заяанд төрөхгүйг амласан тул тэр эшийг буулгах хэрэгтэй юм байна» хэмээн болгоогоод:

-Эдүгээ чиний хилэнцийг арилгахад Арван нэгэн нигууртын энэ Чилан Ахуйгаас илүү арга үгүй тул чи энэ өвчнөөсөө салаад Чилан ахуйг 8 удаа үйлдэж чадах уу? хэмээсэнд тэр бээр ч «Чадна» хэмээх ам өчгийг өгсөнд зарлиг эшийг хайрлавай.

Тэгээд тэр эмэгтэй ч бодисадвын нигүүлслийн ачаар өвчнөөсөө салаад сага сард Чилан ахуйг үйлджээ. Чингэхдээ нэг Чилан ахуйн үеэр өдөр хэт их цангаснаас болж орой архи ууж сахил алдав. Бас тэрний хойд өдөр бэлтгэл увш сахилыг мөрдөөд Чилан ахуйг үйлдсэний орой хэт елссөн тул дөрвөн ширхэг тахилын гурилаас хоёрыг нь авч идсэн тул цаг бус идээний сахилыг алдаж Чилан ахуйгаа ариун үйлдэж чадсангүй. Хоёр тааруу Чилан ахуй хийгээд нэг суудал дээр суусан чанартай зургаан Чилан ахуй зэрэг нийт наймыг бүтээгээд нэгэн цагт тэр эмэгтэй нас барсан болой.

Тэгээд бодисадва Даваажанцангийн цог буян иь дэлгэрч амьтны тусыг хэмжээгүй ихээр үйлдэж, хуучныг нь сэргээж, шинээр сүм барьж босгосон нь зуу давжээ. Хүн алах, нүд сохлох нь эргэлзээгүй болсон 300 шахам хүнийг гэмт үйлээс сэргийлэв. 1200 шахам гэлэнгийн амьжиргааг бүрдүүлэв. Хавцгай бартаат 108 гаран замыг засаж, номын өглөгийг агуу ихээр зохиов.

Нэгэн цагт Зандод хэмээх газар тойн хувраг хийгээд эгэл хүмүүсийн ном сонсохоор цугласан их зээлийн газарт «Сэтгэл үүсгэгтүн» хэмээн номлох үед хүн бүхний нүднээ илхэн нэгэн газар их хуй салхи дэгдэн дотроос нь жадны хэрийн биетэй хар хүн гарч ирээд бодисадвад гурвантаа мөргөөд:

-Та Их нигүүлсэгчийн бүтээлийг олсон хүн гэсэн. Надад бүтээлийн шинж тэмдгээ үзүүлэгтүн. Би чиний сахиус босугай гэв. Бодисадва:

-Чи хэн бэ? хэмээхэд тэр өгүүлрүүн:

-Миний нэр Манва. Энэтхэгийн энэ оронд ягчисын хаан Ззвүмар хэмээгддэг Түвдийн төв нутагт Лянхуан хаан Ловон багш надад нууцын алдрыг зүүж бүхнээ гүгээмэл хатуу очрыг хайрлав. Бөө нар намайг нэрлэхдээ жанжны хаан Янлэбэр гэдэг. Эдгээр нь миний нэр болой. Орон нутаг минь хаданд оршино. Хамаг орчлонг хэсэн тэнэнэ. Жанрайсигийн сахиус бөгөөд дараа нь таны сахиус болно хэмээн Их нигүүлсэгчийн сахкус болохыг андгайлав.

Дараа нь бодисадва царайгаа мөшөөлгөн инээмсэглэн баруун мутрын алгыг үзүүлсэнд алган дээр **нь эрээн** нүд байхыг цугласан болгон үзэв. Заримд нь арван нэгэн нигуурт, заримд нь дөрвөн мутарт, заримд нь Хасарваань гэхчлэн элдэв янзаар үзэгдэв.

Тэгээд төрөлхтний чуулган бүгд сүсэглээд хилэнцээ наманчлах, буян үйлдэхийг амласан хүн олон гарав. Тэр хар хүн хуй салхи болон замхрав.

Тэр өдрийн орой бодисадвын дэргэд гэлэнгүүд хилэнцийг наминчлах тухай өргөн яриа дэлгэн цай уун суух цагт урдаас дагалдаж явсан гэлэн өгүүлрүүн:

-Багштан минь! урд багш шавь бид бадар барин явах цагт таарсан Омла балгадын 15 хүнийг алсан их хилэнцэт эмэгтэй өнгөрсөн жил өөд болсныг сонслоо. Өдгөө тэр юу болж төрсөн бол хэмээн айлтгасанд бодисадва инээмсэглэн мөшөлзөөд:

-Аа тийм. Чамд хэлье хэмээн бодсон боловч элдэвт алгасраад өдгөө хүртэл мартаж орхижээ. Одоо ярья, сонсогтун Хутагт арван нэгэн нигуурт Жанрайсигийн Чилан ахуй үнэхээрийн адис жинлаантай байна. Завсаргүй таван нүгэл үйлдсэн амьтан ч Арван нэгэн нигууртын Чилан ахуйг найман удаа үйлдэж Хутагтын нэрийг зуу давтан өгүүлэн мөргөвөөс муу заяанаас эргэлзээгүй гэтэлж өндөр язгуурт төрөөд бурханы хутгийг олж байх юм. Даанч Чилан ахуйг үйлдэж чадах хүн чухам ховор юм даа. Түүний учир нь гэвэл, их хилэнцэт тэр эмэгтэй ч тааруухан хоёр, нэгэн суудлын

зургаа, нийт найман Чилан ахуй үйлдсэн тул түүнийхээ буянаар өдгөө Энэтхэгийн зүүн зүгт энэтхэгээр Ратнакар, Түвдээр Ринченжунва /Эрдэнэ гаргагч/ хэмээх хот балгадын зүүн зүгт эд таваараар баялаг, эдлэл хэрэглэл төгс бярманы хүү болж төрөөд биеэ эрдэнийн чимгээр дүүрэн чимэглэсэн байх юм. Гэвч тэр бярманы хүү царай муутай, ухаан орон гаран, болж төржээ. Тэр хүүгийн царай муутай, саруул бус ухаантайн шалтгаан юун гэвэл, урд эмэгтэй төрөлд байхдаа хоёр Чилан ахуйг үйлдэхдээ эхний орой ам нь цанган архи уусны шалтгаанаар ухаан нь орон гаран, дараагийн Чилан ахуй үедээ ходоод нь өлсөж бурханд өөрийн ергөсөн аман идээнээс хоёрыг нь авч идээд цаг бус идээг хорих сахилаа алдсаны шалтгаанаар царай муутай болжээ. Тэр энэ төрөлдөө Жанрайсигийг ядам болгон шүтдэг байна. Дараа нь төрөл арилжаад Энхжингийн ертөнцөд Аюуш бурханы өлмийн өмнө эрдэнийн бадмаас хувилан төрөхөөр байна. Дараа нь хэзээ ч орчлонд эргэж уналгүйгээр эргэж үл няцах газарт хүрээд эцэстээ ханыдашгүй бурханы хутгийг олох болно. Тиймийн тул Чилан ахуйг найман удаа чанартай үйлдэх аваас үхэж егүүтсэн даруйдаа Энхжингийн оронд Авид бурханы өлмийн өмнө эргэлзээгүй төрөөд хэзээ ч орчлонд унахгүй эргэж үл няцагчийн газрыг олох болно. Мянган нигууртын энэ бүтээх арга нь бурхан бүгдийн бүтээх арга мөн тул хамаг бурханыг бүтээхийг хүсвэл үүнд суралцтугай хэмээн Даваажанцан айлдав. Энэ нь Даваажанцангийн түүх болой. Тэр бээр увдисаа бүтээлч Нипугвад хайрлажээ.

НИПУГВАГИЙН НАМТАР

Бишрэнгүй сэтгэлээр дээд багшийг шадарлан шүтэж
 Бүтээлд хичээснээр дээд шид бүтээлчийг олоод
 Амьтныг энэрч бусдын тусыг цохлон зохиосон
 Нипугва бүтээлчид бишрэн мөргөмүй

Энэ бүтээлчийн мэндэлсэн нутаг нь өмнөд Аригийн Чубав хэмээх хот юм. Эцэг Чимдаг-Одсэрсамбуу, эх Чимдагму-Жанму хоёрт нь таван үр заяасны ууган нь юм. Төрснөөсөө эхлэн сэтгэлд таатай, бусдыг хүндэлдэг, торниулахад хялбар, өсгөлүүн хүүхэд байсан тул алдрыг нь ч Сэтгэл булаагч хэмээв. Тэгээд 9 нас хүрэхдээ уншиж бичихэд суралцан мэргэшиж, тэр нутгийн эхээр орших Хадан гуу хэмээхэд хамба Чойжинсэнгэ хийгээд ловон

Шэйравжунай нараас сахил хүртэн тойн болжээ. Хамба, ловон хоёртоо:

-Би эш ухааныг сурч эзэмшээд мэргэн хүмүүн болсугай хэмээхэд нь:

-Сайн байна хэмээн урамшуулаад 20 насанд нь гэлэн сахил хүртээв.

Тэгээд эш ухаанд суралцсаар 21 насандаа мэргэн, ариун, сайн гурвыг туйлд нь хүргэв. Нэгэн шөнө бүрэн чимгээр чимэглэсэн хөх өнгөт эмэгтэй зүүдэнд нь үзэгдэн гараа толгой дээр нь тавиад:

-Аяа, язгууртны хөвгүүн минь ээ! Энд суулгүйгээр Ман нутгийн Чугбуганд залран буй хутагт Жанрайсигтай улзахаар одогтун! Хоёр тусыг түргэн бүтээгээд бурхан болох болно гэх эшийг үзүүлсэнд:

-Алс хол, аюул ихтэй тул хүрч очихгүй буй заа хэмээн өгүүлсэнд нүүрлэхгүй байхыг би даасугай, түргэн од хэмээв.

Маргааш нь хүнд зарлалгүй хэдэн цэн алт, гурван хуй даавуу авч гарсанд зам зуурт нь таарсан бүхий л эрэмчид өгүүлрүүн:

-Саяхан нэгэн хувраг ирж яваа сураг байсан юмсан хаашаа одчиюв оо? гээд үзээд үзээд олж харахгүй байсан тул зүүдэнд эш үзүүлсэн тэр эмэгтэй гэтэлгэгч Дарь эх байжээ хэмээн бодов. Тэгээд Ман нутгийн Чугбуганд хүрч ирээд Даваажанцан бодисадватай уулзсанаар бодисадва хэсэг зуур нүдээ анин сууснаа:

-Та амьтны их итгэл аврал болох юм байна. Липтгасан номууд тань амьтанд биелэхэд бэрх боловч муу цагийн эдгээр амьтад бурхан залрахад сүсэглэлгүй шуламд сүсэглэж, нирваанд дурлалгүй орчлонд дурлаж, бодийг бүтээхэд хичээлгүй зовлонг арвижуулахад кичээж, нирвааны хуурай газар үл одон орчлонгийн балчиг шаварт унаж, их амгалангийн тал газар одолгүй тамын галт нурам руу үсэрч, номыг ёсчлон үйлддэг багшаас холдон зайл баширт багшийг сонгож, номын туп бэрхшээл хатуужил туулж чадалгүйгээр хилэнцийг кичэээнгүйгээр үйлдэж, нэгэн номыг үйлдэгтүн хэмээвээс «Би завгүй» хэмээж “Үхэл ирнэ шүү дээ” хэмээвэл «Танд ч бас ирнэ» хэмээдэг. Ганц өдрийн ч турш бэрхшээлийн тэсвэрлэн үл чадах, бурантгаас нь барьсан ч чанагш буцаж оддог тийн боловсрол хийгээд хилэнцийн л үйлийг үйлдэж, зовлонгийн үрийг амсдаг эдгээр амьтад сонсох нь үгүй шүү дээ. Бурхан биеэрээ залравч «Цаадах чинь хэн бэ» хэмээгээд биеэ тоон хялайж ч үл харах, номыг огтоос үл үйлддэг хүмүүн олон буй

тул чи орчлонгоос ашид хагацан ариуссан оронд одохыг хүсвэл энэ номыг анхааран авагтун» хэмээн зарлиглаад Арван нэгэн нигууртын авшиг, бүтээх арга, хөтөлбөр зэргийг хайрлав.

-Чи арилаагүй газарт бүү суу. Ой шугуй, цаст уулын аль сайныг шилэн, ялангуяа хойд зүгийн Дарго нутгийн уулсын цасанд бүтээлээ зохиогтун. Тэнд нэгэн лүндэн буухаар байна хэмээн бошго үзүүлэв.

Тэгээд ус, чулуу зэрэг идэх юмсаа авч хойд зүг залрав. Тэнд Даргогийн цасанд таван жин замбаа гурилаар хийгээ дарахын хамт ус, чулуугаар амжиргаа залгуулж Чилан ахуйг уйлдээд хэнд ч мэдэгдэлгүй долоон жилийн турш бүтээлээ зохиох цагт Даргогийн онгод тэнгэр дээр доороос нь элдвээр элэг барин дээрэлхэхийг завдсан боловч барсангүй. Нэгэн өдөр гөрмөлийн үүдэнд морины янцгаах дуун хадсанд бүтээлч бээр «Цаст хаданд нэг ч хүнгүй атал морь янцгаах нь замбаа байхгүй тул хий хөдөлж элдэв юм үзэгдэж байгаа биш биз?» хэмээн бодоод үүсгэлийн зэргийг бясалгасанд бас нэг нь хүний хэлээр:

-Наашаа үүдэн дээрээ залрагтун! хэмээсэнд үзтэл үсээ торгоор тоорцоглон боосон, цагаан дарцагтай жад гартаа барьсан, цагаан нохой хойно.осоо дагуулсан, цагаан морьтой цагаан хүмүүс гарч ирээд өгүүллрүүн:

-Бүтээлдээ чин зүрхээ зориулсан тан шиг хүнийг элдвээр элэг барихыг оролдсоныг минь хүлцэн өршөөж „ах дүү, бид тавд нэгэн, ном айлдахыг гуйя. Сахиулах сахиус чинь, зарах зардас чнь бид болсугай хэмээсэнд бүгээгн:

-Хэн юм бол хэмээгээд нүд нь наранд гялбан х.фж чадахгүй байсан тул гараараа саравчлан хараад “Одоогоор бурхан болоогүй ч гэсэн харамсах зүйлгүй» гэж бодоод тэдэнд үйлийн уг үрийн тухай номыг “ионтаа айлдсан бөгөөд тэд ч сахиус нь болохоор ам өчиг өгч амин зүрхний тарниа нэг бүрчлэн өргөвэй. Тэгээд «Одоо бэрхшээл хатуужил хэт уртадвал хийн өчин мэтээр үхэж болзошгүй тул хөдөөний хүнээс багахан идээ, ундаа гуйхаар одъё» хэмээн бодох үед нь тэр онгод тэнгэрүүд ном сонсохоор ирээд:

-Багш танд хүнс бий юу? гэж асуухад нь:

-Үгүй хэмээн хариулсанд:

-Тэгвэл маргааш бид өргөсүгэй хэмээгээд одов. Маргааш үүр цайхад гөрмөлийн үүдэн дээр бугын бүхэл ие байсныг нь авч чанаад зооглосонд түүнээс хойш мах дуусах бүрт залгуулан нэг нэгээр нь авчирч өгөх болов. Тэд өгүүллрүүн:

-Та үүнд баясч байна уу? гэтэл бүтээлч “Ийн үйлдвэл пьмтны аминд хөнөөлтэй болно» хэмээн болгоогоод:

-Ийм юманд би дургүй, үүнээс хойш бүү авчир , хэмээв. Тэд өгүүлрүүн:

-Тэгвэл нэг арга байна, маргааш орой таныг залахаар нэгэн хүн ирэх тул заллаганд явагтун хэмээгээд одов.

Маргааш нь нар дөнгөж шарахын үед морь унасан нэгэн хар эр хүрч ирээд:

-Багш эрдэнэ минь, миний эхнэр өвдсөн тул здис жинлав хүртээхийн тулд та залран болгооно уу хэмээсэнд

-Би хүнтэй уулзалгүй долоон жил болсон тул явахгүй хэмээсэн ч үл сонсон ятгасаар залан авч явав.

Тэгээд нэгэн асар майхан дотор өвчтэй эмэгтэйн даланд өнөөх онгод тэнгэр хадаас шаасан байх бөгөөд тэр эмэгтэй нүдээ анивчин зовиурлан өвдөж байв. Бүтээлч нэгэн балинг өгөөд адисласанд тэр онгод тэнгэр төмрөө сугалан авч одсонд эмэгтэйн өвчин зовиур нь илааршсанд өглөгийн эзэн цөцгий, тосоор өргөл бариад буцаан хүргэж өгөөд үүнээс хойш үргэлжийн өглөг барьсугай хэмээв. Түүний дараа өдөр бас нөгөө онгод тэнгэрүүд ном сонсохоор ирсэнд:

-Та нар амьтныг ингэж хорлоод бэйвал би арвайтан газар руу одсугай хэмээсэнд тэд өгүүлрүүн-

-Арвайг бид үргэлж өгч бас болно хэмээгээд одсонд маргааш нь гөрмөлийн дотор арвайгаар дүүрсэн байв.

-Энэ юу вэ? хэмээн асуусанд:

-Дантав нутагт мөндөр буулгаад тэндээс авч ирлээ хэмээсэнд бүтээлч:

-Би энд суугаад байвал амьтанд маш их хорлолтой болох тул өөр газар одсугай гэхэд тэд:

-Багш та биднийг орхиод одож чадах юм уу хэмээсэнд:

-Чадахгүй л дээ, гэвч та нарын мөндөр буулгасам нутагт очиж амьтанд тус хүргэхээр одсугай хэмээв.

-Тэгвэл Нипуг хэмээх ардаа эрдэнэ овоолсон мэт хадат уултай, өмнөө цорго мэт хаднаас шид бүтээлийм усыг буулгадаг агуй байдаг. Тийшээ бид түрүүлж одъё. Та биднийг даган залар, миний шижилсэн тэр газрыг тп аглаг орноо болго хэмээгээд үзэгдэхгүй болов. Бүтээлч номын хувцсаа даль жигүүр хийж огторгуйд дүүлэн нисээд залран одож Тавлан-гарвууд нутагт хүрэлцэп ирж өнөөх онгод тэнгэрийн хэлсэн газрыг олон газар буугаад ажиглан харж байтал онгод тэнгэр гарч ирээд:

-Та энэ газрыг аглагаа болгогтун. Амьтны тус арвидах болно

хэмээгээд одов. Тэгээд бүтээлч тэр газрыг болгоогоод агуйд нь Чилан ахуйг зохион суусанд м иэн шөнө нэгэн цагаан хүн илт бодитоор гарч ирээд:

-Энэ газарт сүм, энд нь ордон, өргөөг нь энд байгуул хэмээсэнд Жанрайсигийн олон хувилгаан хүмүүс гарч ирээд зарим хувилгаан нь хана, зарим нь модоор эдлэл хнйж, зарим нь бурхан бүтээснээр сүм тэр дороо бүрэн босов. Аравнайг нь Хутагт Жанрайсиг өөрөө үйлдэв. Тэгээд хүмүүс бүтээлч гэдгийг нь мэдээд хувь төгс олон хүмүүс хурж цуглараад санаанд багташгүй буяны үилийг байгуулан оршвой. Нэгэн цагт шинийн найманд Чилан ахуйн гол өдрийн шөнө олон зүйл гэлэнгүүдтэй нөхөрлөн баруун зүг рүү нисээд өвөрмөц сайхан тогтоцтой, сэтгэл тэнүүн газартай хоосон сүмийн дотор нэгэн сэнтий ширээний дэргэд цагаан хүн байх ю. Түүнээс энэ юу гэдэг нутаг вэ? гэж асуухад тэр:

-Энэ баруун зүгийн Энхжингийн орон хэмээгч байна. Чи Нипугээс төрөл арилжин ирээд энэ ширээний эзэн болж олон нөхөддөө номыг заах юм байна хэмээн зарлиглахыг сонсов хэмээн зүүдлээд сэрсэнд «Яг одоо төрөл арилждаг ч болоосой» гэсэн бодол төрөв. Бас шинийн 15-ны Чилан ахуй шөнө нэгэн таатай сайхан сүмийг үзээд дээш өгссөн цагаан шат байсанд түүнийг өгсөөд цагаан цэцэг барьсан олон хүмүүс явж байхыг харав. Дотроос нь нэгэн цагаан хүн шатаар өгсөхийн соцуу

-Нааш ир хэмээн дуудсанд:

-Энэ юу вэ? хэмээн асуув. Тэр бээр:

-Мөнхөд уйлагч бодисадвын ясаар хийсэн шат байгаа юм хэмээн хариулав.

-Тэгвэл хөлөөр алхаж болохгүй юм байна хэмээгээд огторгуйд дүүлсэнд тэр хүн өгүүлрүүн:

-Чи билэг барамидад сүсэглэсэн тул өдгөө энэ биеэ орхилгүй Хүжит хотод бодисадва Чойпагын дэргэд очихоор байна хэмээсэнд тэрбээр:

-Би одоо үхэлгүй байж байгаад битүүний Чилан ахуйг бүтээвэл аштай юу хэмээн зүүдлэх зуур нойрноосоо сэрэв.

Бас нэгэн удаа Чилан ахуйн эхний өдрийн үд хэлбийх хавьцаа ямар ч шалтгаангүй гэнэт нүд бүлтрэн одох мэтийн зовиур бий болоход нэгэн цагаан хүн өгүүлрүүн:

-Чи таван зуун төрлийн урд Энэтхэгийн зүүн зүгт салчин байжээ. Онгоцоороо аварга загасны нүдийг сохолсон муу үйлийн тийн боловсрол мөн хэмээв. Үүрийн туяанаар тэр хүн гараараа зөөлөн арчсанд эдгэв гэнэ.

Бас Чилан ахуйгаа өндөрлөдөг өдөр нь шөнө дундын хэрд

ямар ч шалтгаангүйгээр гэнэт баруун шанаа нь маш ихээр өвдөн зовиурласанд нэгэн цагаан хүн өгүүлрүүн:

-Чи таван зуун төрлийн өмнө нэгэн махэ үхрийн эрүү хугалсан байна, түүний үйлийн тийн боловсролын үр энэ юм хэмээв. Түүнийг нь өглөөний гэгээ орж байх үед нэгэн хөх өнгөтэй эмэгтэй гарч ирэн хормойгоороо арчсанд эдгэсэн гэдэг.

Тийнхүү далан зургаан нас хүртлээ лагшин тунгалаг байхдаа Чилан ахуйг тасралтгүй залгуулан, лагшин тааруу байвал гурван сайн цагийг алгасал үгүйгээр үйлдсэн байна. Нэгэн удаа дэргэдийн шадар гэлэндээ:

-Би насан өтөлсөн тул маргааш явна. Энэ жил чи их бүтээлийг үйлдэж Чилан ахуйг хичээнгүйлэн гүйцээ хэмээв. Тэгэхэд нь тэр бээр хамаг шавь нарыг нь цуглуулаад бүтээлч таагүй үг дуулгасан тул шавь нар бид бишрэл сүсгийн сэтгэлээр шүтэж байх нэгэн шүтээнийг өөрөөс нь гуйвал зүйтэй бус уу хэмээсэнд "Тэр зүйтэй" хэмээгээд бүгд хамтдаа айлтгасанд:

-Муу цагийн шүтээнд залбирах хүн олдох уу? Зарим муу хүнд өр горын шалтгаан болох буй заа хэмээн айлдсанд дахин дахин ятгав.

-Тэгвэл хийдийн доод талд өчүүхэн хумхийг суулгаж тэргүүн оройн дотор гурван үзүүрт гурван төө хэрийн шарилын шүтээн босгоод гэрийн дотор нүүрний баг тавигтун. Би равнай үйлдсүгэй. Дотор нэгээс илүү хүн байхыг үл зөвшөөрнө хэмээжээ.

Тэгээд далан долоон нас хүрээд өөрийн шадар хүндээ:

-Өдгөө би өтөлсөн тул гурван өдрийн дотор одно. Ирэх шинийн наймны Чилан ахуй хийгээд Манал асрахаар байна хэмээн айлдав. Тэр шөнө таван улаан хандмаа ирээд:

-Чамайг баруун зүгт одоход замд тань бид байх тул заавал морилоорой гэжээ.

Учыг асуувал «Ариун оронд амьтны тус агуу их л дээ амьтны үхэх төрөхөд арай эртэдсэн тул хөөрхий дөө хэмээгээд солонго замхрах мэт одов.

Бас тэрний хойд шөнө нэгэн их нуурын захаас чинагш заларсанд нуурын ихэнх нь хөлдсөн байсан ч алхам хэрийн газарт хөлдөөгүй үлдсэн байсанд нэг хүнээс:

-Энд мөс тогтоогүй нь юунаас болов? хэмээн асуухад тэр хүн өгүүлрүүн:

-Чи энэ удаа сайн цагийг тасалснаас уршигтай. Хэрэв энэ удаа таслаагүй бол олон амьтныг орчлонгоос гэтэлгэх байсан юм хэмээн хэлэхийг зүүдлэн сэрээд нөгөө шадар хүндээ:

-Одоо би Чилан ахуй үйлдэх тул та нар намайг үхсэний

хойно зүрхийг минь бумбан дотор хийж хэлийг минь шарилын шүтээн дээр тавьж цогцсыг минь өндөр уулын оройд хүргэх юм уу, Маги голд урсгах юм уу эсвэл гурван уулзвар зам дээр суварган дотор хадгал Галд бүү шатаагтун. Ирээдүйн шавь нарыг баясгах их бэлэг дэмбэрэл байна хэмээн зарлиглаад дуугаа хураан суусанд үд хэлбийх хэрд солонгон гэр татаж огторгуйгаас цэцгийн хур бууж тэнгэрийн хөгжим, дагинасын дамрын дуутай хамт ариун ертөнц рүү заларвай.

Даргогийн тэр онгод тэнгэр энэ бүтээлчийн номыи сахиус мөн тул уг номыг анхааран авагсад үүнд балин өргөсүгэй. Тэр онгод тэнгэрийн гэнэн сахилын нэрийг Бумжэ хэмээдэг болой.

Энэ Нипугвагийн намтар бөгөөд өөрийн увдисаа Срува-Доржжалвуд уламжлуулжээ.

СРУВА – ДОРЖЖАЛВУГИЙН НАМТАР

Сүсэг, шагшаабад, сонсгол, өглөг хийгээд
Ичиж мэдэх бөгөөд сонжигууртай билэг оюунт
Хутагтын долоон эрдэм төгс хамаг амьтны итгэл
Доржжалвуу таны өлмийд мөргөмүй

Төрсөн нутаг нь Срүн-Юл хийд юм. Эцэг Гончиггомбо, эх Түнвагүнжид хоёрын цор ганц хөвгүүн бөгөөд төрөх цагаасаа авахуулаад зүс царай гуа, шагшаабадын анхилуун үнэртэй нэгэн байсан тул Цүлтэмгончиг хэмээх алдрыг хайрлажээ. Амар торних, өсгөлүүн, хамаг олны сэтгэлд зохистой, билэг оюуны ид хав их тул долоон нас сүүдэртэйдээ унших, бичихийг бүрэн сурч эзэмшив. Тэр цагт Срүн-Юл нутагт нэгэн сайн гэвш байсан бөгөөд тэр бээр Нипуг руу Чилан вхуй үйлдэхээр хүрлээ хэмээн бүтээлчид айлтгасанд идээ, угаалын ус, сахиус зангиа өгсөнд нялх хүүхэд түүнд баярлан:

-Би ч одсугай хэмээгээд хэнийг ч сонсолгүй хүрч очсонд:

-Энэ хүү бурханы хөвгүүдийн залгамж халаа болно хэмээгээд өвөр дээрээ авч магтвай.

Дараа нь гэнэн, гэцлийг тус тус хүртээгээд гурван хөлгөний номд сургаж, ялангуяа винайн үндсэн сударт мэргэшүүлсэн тул ариун хуврагийн дээд болов. Хорин насандаа гэлэн сахил хүртэн сав, аймаг бүхэнд мэргэшээд «Одоо нэгэн бүтээлийг анхааран авахыг минь болгооно уу» хэмээсэнд «Зүйтэй, чи ганц бие хүн тул чамд нэгхэн номоор болохуйц увдисыг

өгсүгэй” хэмээгээд Жанрайсигийн авшиг, Чилан авахуйн хөтөлбөр сэлтийг гарын авлагын хамтаар хайрласанд:

-Энэ Чилан Ахуйг үхэхээ хүртэл үйлдсүгэй хэмээх тангараг өргөсөнд бүтээлч машид баясаад Даваажанцай бодисадвын нандин шүтээн болох Жанрайсигийн болор шүтээнийг хайрлаж бүтээлийг олно хэмээн бошго үзүүлэв.

Чилан Ахуйг таван жилийн хугацаанд үл алгасан үйлдэж зургаа дахь жилийн гуравдугаар сарын шинийн найманд Мянган мутар, мянган мэлмийт Жанрайсигийн нигуурыг үзэн адислуулж бошго сонсоод рид хувилгаан, зөн билэг тэргүүтэн нь торж тээглэх зүйлгүй болсон тул шөнө бүр хэмжээлшгүй их бурханы ертөнцүүдийг хардаг болсон бөгөөд нэгэн шөнө Авид, Манал бурханыг олон бурхад бодисадвууд хүрээлэн оршиж, түүний өмнө өөрөө сууж байсанд тэд өгүүллрүүн:

-Бидний хэн нь сэтгэлд таатай нэгний хүү болох вэ? хэмээсэнд тэр нөхдийн дундаас цагаан өнгөтэй идэр залуу үзэсгэлэнт царайтай, таван өнгийн сэрэл сацруулсан, мутартаа цагаан лянхуа барьсан нэгэн бурхан өгүүллрүүн:

-Энэ надтай долоон наснаасаа авахуулаад үйлийн барилдлага тогтоосон тул миний хүү мөн хэмээгээд гэрлээ өөрт нь шингээлээ хэмээн зүүдлэн сэрэв.

Түүний маргааш номын цагаан дунг үлээж хувраг тойдыг цуглуулан сайтар хүндлэв. Шадар хүмүүн бурхан урлаачаа Түвдэд илгээж зүүдэндээ нигуур үзсэн бурхадүүдаа бүтээв. Энэ тэргүүтэн бүтээлийн тэмдэг, рид хувилгаан нь санаанд багташгүй.

Тэгээд:

-Өдгөө одох суухад өөрийн эрхтэй, бие өтлөн махбодь хямраагүй байхдаа бадар барьж амжиргаа залгуулъя. Гэнэн болсноосоо хойш өнөөдрийг хүртэл үмх төдий мах, дусал төдий архийг ч хэрэглэсэнгүй. Сар бүрийг алгасалгүй Чилан ахуй үйлдэж бие минь хөгширчээ, ном үгүй олон амьтад тамд одсонд сэтгэл минь уйсна хэмээв. Дараа нь өдгөө би явах боллоо. Энэ биеийг муу үйлт амьтны тусын тулд галд шатаан хийдийн талд Их бодийн суваргыг босгон чандрыг минь түүнээ талби. Энэ номын хүрээг Шандажиг эзэгнэж амьтанд нигүүлсэл бясалга. Нөхдүүддээ хандан:

Та нар ч бас номыг зохиох аваас зарим ертөнцөд багш, шавь учрах болно хэмээн зарлиглаад нэн гайхамшигт олон зүйлийн ёр тэмдэгтэйгээр залран одох ёсыг үзүүлэв. Баринтгийг нь тайлсанд их иш үүлслийн лагшин ил бодитоор гарч ирэв. Ясыг нь чандарлаад хумханд хийж тавьсан бөгөөд

өдгөө залбирахад сайн цагуудад шарилын савнаас нь пэлдэн жинлаантай шүтээн Срүн-Юл нутагт байдаг. Энэ нь Доржжанцангийн түүх болой. Тэрээр Шандандажигт увдисаа уламжлуулан үлдээжээ.

ШАНДАНДАЖИГИЙН НАМТАР

Өглөгөөр цуглуулж амьтанд зургаан барамидыг
Яруу өгүүлээд түүнийг бүтээлгээд
Өөрөө зургаан барамидад даган орсон
Шандандажигийн өлмийд мөргөмүй

Мэндэлсэн нутаг нь Топу хийд. Эцэг Шанданчойжидагва хэмээх нь мэргэн бичээч, эх Чугмогончигдан хэмээх Билиг билгүүний дагинын шинж тэмдэг бүрдсэн эмэгтэй нар юм. Төрсөн даруйд нь цахилгаан цахиж, аянга дуугарах тэргүүтэй үзэгдэл гарч хөрш нэгэн айлын дайсагнах хүмүүн нь «Ямар аймшигтай юм бэ» хэмээн дуу алдсан тул Дайсныг аюулгагч буюу Дажиг хэмээх нэрийг хайрлажээ. 5-7 насандаа унших бичихэд суралцаж түүнээ бүрэн эзэмшив. Бодисадвын хувилгаанаас сахил хүртэн тойн хувраг болж сахилаа машид ариунаар сахин Цайвар шороотод залран очиж чойрын ном, шалгадаг долоон аймаг тэргүүтнийг сонсож мэргэний туйлд хүрэв. 23 насандаа Үйзан номын хүрээнд шавилан мэргэний алдрыг олвой. Ахин Майдарын таван ном, таван аймаг газар, дээд доод Авидармад суралцаж мэргэшээд гэвш Шэнмогийн дэргэд заларч очсонд тэрбээр:

-Чи энэ орон хийдийн хамбын үүргийг гүйцэтгэгтүн хэмээв.

Тус болох болов уу даа хэмээсээр зөвшөөрч хамба болоод шашинд машид их тусыг хийв. Ялангуяа винайд мэргэн тул винайг эшийн дээрээс номлож 500 шахам ламыг ч цуглуулж чадав. Гаадамба ёсны авир байдлыг голчилж Манал хийгээд Дарь эх тэргүүтнийг өөрийн нандин шүтээн болгон бясалгасанд бодисадва Срува:

-Хүү минь, эдүгээгийн цөвүүн цагийн амьтанд тус адис машид ихтэй хутагт арван нэгэн нигуурт Жанрайсагийн номын аймаг үүнийг анхааран авагтун хэмээн зарлиглав.

Гэтэлгэгч Дарь эх ч мөн тийн эшийг үзүүлснээр хутагт арван нэгэн мутарт Жанрайсагийг бүтээж гурван жил дөрвөн сар болсны дараа шинийн арван тавны үдшийн бүрийгээр 21 Дарь эхийн нигуурыг үзэв. Шөнө дунд Маналын Түүнчлэн ажирсан найман бурханыг үзэв. Үүр цайхын эхэнд үйлийн, явдлын тантрын олон бурхадын чуулгадаар хүрээлүүлсэн арван нэгэн нигуурт, мянган

мудар, мянган мэлмийт Жанрайсагийн нигуурыг үзэн авшиг, адистэд хүртэв.

-Аяа, язгууртны хөвгүүн минь ээ! газрын мухар, аглаг уулыг шүтэж сүсгийн, үхээрийн идээг цээрлэж, хэрэв чадвал бэрхшээл хатуужил туулж шим аван өл залгаж, эс чадвал бадар барьж амьтны тусыг үйлдэгтүн хэмээн эш үзүүлээд гэрлийн цогц болон замхрав.

Тэрбээр бодисад Срувагийн өмнө морилон очоод “Намайг уулын аглагт явахыг минь зөвшөөрөөч” хэмээсэнд «Чи дахин гурван жилийн турш энэ хүрээ хийдийн олон хуврагуудыг тэтгэгтүн» хэмээгээд Жанрайсигийн болор шүтээнийг хайрлав. Гурван жилийн турш зөвхөн Чилан ахуйг нандигнан бясалгаж алив тааралдсан хүнийхээ санаа, ирээдүйн амьдралд нь тохиох аньсан чухал зүйлүүдийнх нь талаар сэтгэлээрээ болгоож мэддэг болов. Тэгээд баринтаг хувцас, олбог суудал тэргүүтнээ орхиод орон хийдээ Жанчүв-Ишийд даатгаад үүр гийх цагаар Эрдэнэ овоолсон хэмээх уулын шавартай хавцгайгаар хэнд ч үл үзэгдэн гурван сарын хугацаанд Чилан ахуйг зохиосноор урдын муу, үйл нь сэдрэн босч халуун өвчинд машид дайрагдан “Өдгөө миний үхэх болсон юм болов уу” хэмээн бодтол үүр цайх үеэр зүүрмэглэн байх зуур гэрлийн чанартай нэгэн цагаан хүн гэнэт гарч ирээд:

-Чиний энэ өвчин урдын үйлийн түйтгэр арилж буйн шинж тэмдэг мөн хэмээсэнд:

-Ямар үйлийн түйтгэр арилав?” хэмээн асуусанд:

-Олон төрлийнхөө урд Энэтхэгийн оронд загасчин болж төрөхдөө чи амьд загасыг халуун усанд чанаж идсэн тийн боловсролоороо зуун живаа жилийн турш тамын зовлонг эдлээд, тэр цагт миний гэрэл чамд туссанаар тамынхаа орноос гэтлээд хүний биеийг олж арван зургаан төрөл арилжих хугацаанд чинь би чамайг адистэдлэсэн юм. Өдгөө энэ өвчнөөр тэр үйлийн түйтгэрийн үлдэгдэл нь ариуслаа хэмээн зарлиглав.

-Та хэн бэ?” хэмээхэд “Би Жанрайсиг байна” хэмээн айлдахад нь

-Намайг нэг адистэдлэнэ үү гэж айлтгахад мутраараа адислахад бие, сэтгэл нь амар амгалангаар түгэн дүүрлээ гэж зүүдлээд нойрноосоо сэрэхэд өвчнөөсөө салсан байв.

Тэгээд хэдэн хоног болсны дараа ном судрыг нь хулганууд авч одсоныг хайхаар одов. Тэр үед нялх ногоо ургаагүй тул долоон өдрийн турш ухаангүй болсон бөгөөд нэг сэргэсэн боловч замбаа гурил байхгүй тул гал өрдөөд нохойн хошуу мод шатааж, үнсий

нь усанд хийж чанаад аяга дүүргэн уув. Бас нэгэн удаа нялх ногоо ургаагүй цагт хонины хатсан хорголоор зутан хийж зооглов. Тэгээд ахин амандаа нэг дусал ус ч хийлгүй долоон сарын турш үргэлжийн хөл хорио тогтоогоод самуд дияаны идээг зооглон оршвой. Дараа нь огторгуйн саран намар цагт хүрэхэд бие зүс доройтож туйлдаа хүрснээр халгай, зэрлэг төмс тэргүүтнийг зооглон орших үед дотор нь их амгалан хүчтэй төрөв. Таалал нь самуд дияаны агаарт байх агшинд чихэнд нь нэгэн чимээ сонсогдсонд үзтэл нэгэн хөдөөний хүн нэг сарлагт хоёр богц арвай ачаад өөрөө дээр нь суун явтал сарлаг түүнээс цочиход нь арагш шидэгдэж, түүндээ уурлаад:

-Энэ чинь юу вэ? Чөтгөр биш биз?" хэмээсэнд:

-Би хүн байна гэвэл:

-Чи өвчтөн үү? Эсвэл хатуужил хийж яваа даяанч уу? гэж асуухад нь:

-Би хатуужил үйлдэгч байна хэмээсэнд тэр сүсэглээд таван жин арвай өргөөд:

-Чи энд ингэж суувал бараг үхэхээр байна. Одоо Ампугт ургац хурааж байгаа тул тэнд заларвал дээр дээ хэмээв. «Тэр үнэн» хэмээн бодоод ургац хадаж буй газарт заларсанд нялхас хүүхдүүд хараад:

-Энэ чөтгөр үү? гэж өгүүлэлдэнэ. Ахмадууд нь:

-Чи өвчтөн үү гээд 12 боодол тариа өргөснийг цайруултал найман жин болсныг аваад түүний ачаар нэгэн бүтэн жил суусныг хэн ч мэдсэнгүй. Сүүлд нэгэн хоньчин түүнийг хараад заллага айлтгасан ч очсонгүй. Өдөр бүр үдээс хойш огторгуйд нисч, зүүн зүгийн Срү уулны шавартын завсарт нар гэрэлтэхэд уулнаас буух ус:ыг таягдсанд хагас өдрийн турш ус өөдөө урсч, "Ус чи доошоо буугтун хэмээхэд» тийн болсон тэргүүтэн санаанд багташгүй хосгүй рид хувилгааныг үзүүлж хэмжиж болшгүй амьтныг эргэж үл няцах газарт байгуулсан юм. Таалал төгсөхийн алдад:

-Миний зүрх шатахгүй тул сум хирийн хэмжээтэй шарилын шүтээнийг босгож түүндээ хийгээд Гааранд хүргэж тавь. Хэл үл шатах тул Донморид хүргэ хэмээгээд гайхамшигт ёр тэмдэгтэйгээр Энхжингийн оронд морилвой.

Шарилд нь сүсэглэхэд пэлдэн гарч ирдэг нь өмнө өгүүлсэн намтрын адил юм. Нэг жин хэртэй шарил гарсан нь Срүгийн суваргад байдаг. Энэ нь Шандажигийн намтар бөгөөд тэр Задвазидүлватүгжижанжүвт увдисаа хайрлажээ.

ЗАДВАЗИДҮЛВАТҮГЖИЖАНЖҮВИЙН НАМТАР

Цаглашгүй нигүүлслийн хүчинд аргагүй автаад
Бодь дээд сэтгэлийг бясалгах үедээ
Лам, Идамаа хоёр үгүйгээр болгоох болсон
Их Зидүлийн өлмий дор мөргөмүй

Энэ хүмүүн эд баялагтай, сүсэг ихтэй нэгэн язууртан айлд мэндэлсэн бөгөөд залуу цагтаа тойн хувраг болж уншлагын хүрдэн болох сонсох, санах үйлд хичээнгүйлснээр туйлд хүрсэн мэргэн болсон болой. Ялангуяа Майдарын ном хийгээд билэг барамидын мэдлэг нь итгэлт Майдарын тааллыг чанх зөвөөр оиосон, мэргэн ариун, сайн гурвын алдраар түгсэн, сүм орон хийд босгож хуврагийн аймгийг байгуулсан, дацан барьж, чойрын ном бий болгосноор мянга гаруй хувраг цуглуулсан зэргээр буян нь ихэд дэлгэрсэн бөгөөд хэдийгээр мэргэний туйлд хүрсэн боловч винайг голлон зохиодог тул шагшаабадын сайхан үнэр өртөө газраас үнэртдэг байсан гэдэг. Тийнхүү эрхэм нандин бясалгалаа өвөр бусдыг тэгш арилжихуй бодийн сэтгэл, Оточ манал, Дарь эхээр үйлддэг тул нэгэн шөнө гүн хөх арьстай эмэгтэй хүрч ирээд:

-Язгуурын хөвгүүн минь! гурван цагийн бурхан бүгдийн цогц мөн чанар нь хутагт Жанрайсиг мөн тул Догринченг нөхөр болгон дагуулаад Доглад хэмээх газар хувилгаан Шандандажиг хэмээх бодь сэтгэл айлдахаар залран буй тул түүнээс зарлиг сургаал, эш лүндин айлтгагтун. Амьтны тус арвижих болно хэмээгээд үзэгдэхгүй болов гэж зүүдлэв. Үүрээр нойрноос сэрж Догринченгээ дагуулан очоод бодьсэтгэлийн номлолыг ч сонсож Арван нэгэн нигууртын авшиг хөтөлбөр, бүтээх арга, нямбын хэмжээ тэргүүтнийг сонссон бөгөөд Шандан:

-Жад хэмээх нутаг сайхан нутаг боловч нэр нь муу юм. Нэг нутагт адилгүй таван үндэстэн тус тусын хэлээр ярилцана. Хортон лус орших тул хүн ард нь сүсэг багатай, хүйтэн хөндий. Нутгийн адагт Даман хэмээх лусын шуламс байдаг тул өвчин ихийн дээр шунал, уцаар ихтэй газар юм. Чи тэр орныг ивээлдээ багтаагтун. Ирээдүйд амьтанд агуу их тус болох болно хэмээгээд бүтээх арга, увдис, хөтөлбөр, гарын авлага зэргийг бүрэн гүйцэд хайрлав. Тэгээд буцаж залрахдаа Чилан ахуйг нэгэн мянга үйлдэхийг тангараглаад гурван зуу болох цагт сагад сарын арван тавны өдөр өмнийн огторгуйд гэрлийн хот мандал дунд орших хутагт 1 мянган мутар, мянган мэлмийт Жанрайсигтой

нүүр учран зарлиг бошгыг нь сонсов. Түүнээс эхлэн үргэлж Арван нэгэн нигуурттай нүүр учирч зарлигийг нь сонсож увдисыг сураад дээдийн шид бүтээлийг олов. Хэмжээлшгүй олон амьтныг боловсруулан гэтэлгэж Энхжингийн орноо залрав. Энэ Задвазидүлватүгжижанжүвийн намтар бөгөөд Чойжилдоглходвашагжажанчүвт увдисаа хайрлажээ.

ЧОЖИЛ ДОГЛХОДВА ШАГЖА ЖАНЧҮВИЙН НАМТАР

Зохилдох оронд оршиж дээд төрөлхтнийг шүтэн
Өвөр ямагт сайныг ерөөж урд хураасан буянтан
Дөрвөн хүрд лугаа төгс номын дээд богд
Диваажимбын өлмий дор сөгдөн мөргөмүй

Энэ хүмүүний мэндэлсэн нутаг нь Догмадва бөгөөд чинээлэг, өр зөөлөн сэтгэлтэй, гэрийн эзний хоёр хүүгийн ахмад нь юм. Долоон насандаа тойн хувраг болж сонсол саналыг үйлдсэнээр 15 насандаа билэг барамид хийгээд винайг болгоон мэдээд цээжээрээ номлож, ялангуяа винайд мэргэн хэмээх алдрыг олов. Дараа нь Оточ Манал хийгээд Гэтэлгэгч Дарь эхийг нандигнан бясалгаж нэгэн агуйд суусанд зуны дунд сарын шинийн 28-нд Сэндэннагжийндулма Дарь эх Зохор сүмийн нигуурыг үзсэнд шид бүтээл хайрлан:

-Аяа, язгууртны хөвгүүн ээ! Доглходад аглаг газар олж суугтун. Би нөхөр болсугай. Доглхаднагву хэмээх газар нь уулын хавцгай, бартаа ихтэй, хүмүүс иь хатуу сэтгэлтэй, үйлийн үрийг үл хянамгайлдаг тэр оронд амьтны тусыг үйлдэх хэрэгтэй тул Жадвад суух Зидүлвагийн дэргэд очин цаст Түвд орны хувь зохиолын бурхан хамаг амьтныг аврагч Хутагт арван нэгэн нигуурт, мянган мутар, мянган мэлмийт Жанрайсигийн авшиг хөтөлбөр, бүтээх аргыг айлтгагтун хэмээн эшийг үзүүлжээ.]

Тэгээд маргааш нь үүр цаймагц залран Зидүлватай уулзан увдисыг айлтгасанд Их нигүүлсэгчийн авшиг хөтөлбөрүүдийг сайтар хайрлаад өөд залрахыг завдтал Зидүлва:

-Хорин нэгэн удаагийн нямбыг миний дэргэд сууж гүйцээгтүн гэв. Түүнийг ёсоор болгон зохиов. Тэгээд өөд залраад Доглход хийдийг байгуулж буян заяаны цог дорвилго нь дэлгэрэн жил бүр билэг барамид хийгээд винайн номлол үйлддэг хорь шахам хүн гарах болов. Тэгээд Чилан ахуйг нэгэн мянга үйлдэхээр

тангараглаад суух цагт гурван зуу хүрсний шинийн наймны эхний шөнийн зүүдэнд цагаан гэрэл өмнө нь сүлбэн ирснийг гараараа барьсанд тэр гэрэл өөрийг нь өөд авч одон Бодалын оронд хүргэсэнд газар дэлхий бүгд нь тунгалаг, цав цагаан цэцэг цайран халиурсаи, эрдэнээр бүтсэн бөгөөд дэлгэрсэн цэцгийн дээр олон хувилгаан шувууд суугаад их хөлгөний номыи дууг дуурсгана. Алгуур зөөлөн салхи үлшгүй харшид үлээхэд алтан хонх, жингэнүүр чимэгнээс цаглашгүй дөрвийн дуун дуурссанаар чихний эрхтэнг цэнгүүлэн үйлднэ. Үзэхүйеэ гоо үсний сайхан сортой хувилгаан гөрөөснүүд баясан наадаж зугаацаж нүдний эрхтэнг баясгана. Завсрын үзэгдэл огторгуйгаас рашааны урсгал бууснаар өлсөх цангахыг арилгаж цаг цагтаа галбар модноос тэнгэрийн торгон хувцас гарч ирж биеийн энэллийг арилган олон зүйл эрдэнийн чимгээр сэтгэлийг баясгаж гурван талын үүдэн нээсэн таван эрдэнээр бүтсэн үлшгүй орд харш дотор хутагт Жанрайсиг тоолж баршгүй олон бодисадваар хүрээлүүлэн оршихыг үзээд олонтаа мөргөж эргэлийг ч үйлдэн залбирсанд Хутагтан:

-Язгууртны хөвгүүн ээ, чиний ирсэн сайн болжээ хэмээгээд цагаан өнгийн гэрлийг зүрхэн тус газар нь шингээснээр бие сэтгэл нь амар амгалангаар дүүрэв.

-Үхэхээ хүртэл амьтны тусыг үйлдэгтүн. Төрөл арилжих цагт чинь би дуудуулъя хэмээн зарлигламагц нойрноос сэрэв.

Түүний дараа өдөр амьтанд өөр өөрийнх нь номхруулах таарсан номыг зааж тусыг нь үйлдээд шөнө нь нойрсоод Хутагтын өмнө ном сонсохоор залрав. Түүний хүчээр юмс бүгдийн тэгш чанарыг сайтар үзэхүй хэмээх тоолшгүй олон самуд дияаныг илтэд болгов. Нэгэн цагт «Би өдгөө явах болсон тул та нарт асуух зүйл байваас одоо ирэгтүн» хэмээгээд суудал засан зөвөлгөө байгуулан зохиогоод зүлэгт аглаг Диваажинд аглагийн байшинг байгуулан өнө удаан бясалгалд суувай. Тэгээд нэн гайхамшигт олон зүйлийн ёр тэмдэгтэйгээр Бодалын ордонд залрав. Ясыг хуулсанд олон зүйл шарил хийгээд олон тооны шүтээн, Шалдашимбалаас залж авчирсан Дарь эх хоолой дотор нь оршиж байв. Энэ Диваажимбын намтар бөгөөд өөрийн увдисаа хамба Чүсамбажанчүвбарт хайрлажээ.

ЧҮЛСАМБА ЖАНЧҮВ БАРЫН НАМТАР

Гэм уналын цөвт хирээр халдалгүй
Алгасал үгүй буяны үйлд хичээгч
Үргэлж тасралтгүй амьтны тусыг зохиогч Бодисэтгэлт
Чүсамба дор мөргөмүй.

Энэ хүмүүний мэндэлсэн орон нь Мүй нутгийн Дэнгарва хэмээх газар юм. Эцэг Жосрайбар, эх Жидбор хэмээхийн хоёр хөвгүүний их хөвүүнд ийнхүү Жосрайбалбар хэмээх алдрыг өгчээ.

11 насандаа Доглходвын дэргэд гэнэн, равжунгийн санваарыг хүртэн сонсол саналын үйлдлийг зохиосноор явдалд орохуй, төв үзэл тэргүүтэн ба ялангуяа винайд мэргэшсэн бөгөөд 20 насандаа гэлэн сахил хүртэж аглаг уулын орныг шүтэн гүн бүтээлээр цагийг элээн орших нэгэн шөнө нэгэн цагаан хүн гарч ирээд:

-Чи надтай барилдлага буй бөгөөд Доглходва бид хоёрт ялгаа үгүй тул түүнээс Жанрайсигийн авшиг, лүн, бүтээх арга зэргийг айлтган анхааран ав хэмээн зарлиглаад үзэгдэхгүй болж одлоо хэмээн зүүдэлжээ.

Тэгээд маргааш нь Чойжилдоглходвын дэргэд очоод түүхээ өгүүлсэнд тэр бээр:

-Итгэмүй, итгэмүй, Хутагтан мөн байна! Надад ч сайхан зүүд зүүдлэгдсэн хэмээгээд хутагт Жанрайсигийн бүтээх арга, хөтөлбөр, гарын авлага зэргийг хайрлав. Тэгээд Диваажинд Чилан ахуйг 101 удаа үйлдэн:

-Эдүгээ одохыг минь зөвшөөрнө үү хэмээн айлтгасанд:

-Хутагтын нигуурыг үзтэлээ ахин хэсэг суугтун хэмээн айлдаад:

-Чи бусадтай адилгүй тул бүтээлийг хичээнгүйлэн үйлдэх хэрэгтэй гэж захижээ. Айлдсан тэр ёсоор нь Чилан ахуйг таслалгүйгээр 300 дахин үйлдсэний дараа шинийн 15-ны Чилан ахуйн гол өдрийн шөнө дундын хэрд дотор бүгд нь гэрлээр цайран дүүрсэн байсанд “Энэ юу вэ? Зулын гэрэл юм уу, эсвэл миний нүдэнд эндүүрэл үзэгдэв үү» гээд сайтар хичээнгүйлэн хартал өмнийн огторгуйд үүлний завсарт олон тэнгэрүү дээр тахиулан оршиж буй, гаадамба ёсны дамжлагын багш нараар хүрээлүүлсэн мянган мутар, мянган мэлмийт хутагт Жанрайсигийн нигуурыг үзээд «Хэт баярлавал уйлдас хүрнэ» хэмээхийн жишгээр:

-Хутагтан таны хувилгаан надад бүтээ хэмээсэн зарлиг буулгасан ёсоор бүтээсэн боловч өдгөө хүртэл нигүүлсэн болгоогогүй тань муу үйлт миний юунаас уршигдав хэмээн айлтгасанд Хутагтын нигуураас:

-Би чамаас хором нэгээхэн ч хагацаагүй, би чамд бошгыг үзүүлэх цагт чиний атгаг бодолд «Энэ шуламсын хувилгаан биш биз» хэмээс бодол ургасанаас уршигдвай. Өдгөө чи бид хоёрт нийлж, салах нь үгүй. Гурван цагийн бурхан бүгдийн таалал надад хурсан тул чи амьтны тусад ном номлож гурван үүдээ утга учиртай болгогтун хэмээн зарлиглаад тэр цагаан гэрэл Мүйгийн хамаг нутгийг гэгээрүүлэн цайлгав гэдэг.

Маргааш нь баясан баяссаар Их номын хааны дэргэд бараалхан мөргөсөнд тэр бээр:

-Хүү минь, сэтгэл чинь сая л нэг тэнийв үү? хэмээн асуухад:

-Би сэтгэлийн цацралаас тнийн гэтлэв гэж хариулсанд:

-За тэгвэл эдүгээ дуртай газраа оршиж амьтнь тусыг үйлдэгтүн хэмээсэнд Мүй нутагтаа заларч буяан заяа нь дэлгэрэв. Сар тутамд Чилан ахуйн бүтээлийн тахилыг нижгээд үйлдэж, дөрвөн зүгтээ дэлгэр, дунд, хураангуй гурван Юм судрын зарлигийн дууг нэжгээд дуурсгаж бадар идээнд түшиглэдэг гурван зуу шахам хуврагийг байгуулж гаадамбын түүх цадигийг ариунаар залгамжлан хутагт Их нигүүлсэгчээс биеийн сүүдэр мэт үл хагацан оршив. Гурван цагийг болгоодог зөн билгийг эрхшээсэн тул нэгэн өдөр ном номлон ахуйдаа нүдээ анисхийн «Өдгөөгөөс гурван зуун жилийн хойно Лэлүнцалын ойролцоо нэгэн хөл муутай хүн явах, энэ мүй нутгаар хуй салхи дэгдэх, миний энэ хийд хүрээнд эм хүний хэл ам гарахаар байна. Тэр үед миний энэ ном бүтэхэд хялбар тул бүтээлд хичээгтүн» хэмээн зарлиглав. Тэгээд 88 нас сүүдэр зооглох жилийн зуны сард нэгэн хэргийг бүтээн зохиосонд хот мандалд цэцгэн хур ил бодитойгоор орж, дуу гарах, гэрэл цацрах тэргүүтэн гайхамшигт олон ёр тэмдэг үзэгдэв. 16 батагчийн мөргөл тахилыг зохиох цагт шөнө дунд 25 наст олон бадарчин гэлэнгүүд залрав. Бэрээ сарын шинийн 8-нд Оточ Манал бурханы нигуурыг үзэж ягчисын аймгийн ноёдууд тэнгэрийн рашааныг барив. 29-ний өдөр язгуурын гурван бурханы нигуур үзэв. Түүний нигуураас:

-Өдгөө миний явах цаг болсон тул шавь нар та нугууд ч номыг арвижуулан жаргагтун. Тачаал, уурт гэвш нар хэрэв надтай дүйх бол амьтны тусыг үйлдэгтүн. Миний цогцсыг долоон өдөр байлгаад, надад үлдсэн буй бүх хүнсээр минь хойтын буяан үйлдэж түүнээс өөр элдэв зүйлийн олон буяныг бүү зориулсугай. Чилан Ахуйд цуглаж ирсэн хүмүүст чадал хүрвэл нижгээд олбог барь, эс чадвал нижгээд зутан барь, бүр эс чадвал ус хийгээд хормой дүүрэн түлээгээр хүндлэл үзүүл. Үүнийг асар их буянтай гэж хутагтан өөрөө надад бодитоор бошго буулгасан юм. Энэ

цуу худал үг бус, тэр худал үл айлдана. Надад хойтын өөр буян хэрэггүй. Мажойчойжид бээр Чилан ахуйн олбог даран суухад үхээрийн газраас нэгэн хэрээ түүний ясыг авчрахад шарил болон одож байсныг үзээгүй гэж үү? Би хилэнц буяны үйлийг мэдэж, Адиша богдын намтрыг өнөөдрийг хүртэл суралцаж даган тэтгэсэн. Та нар ч тэрчлэн үйлдэгтүн хэмээгээд бярман сарын шинийн 2-нд олон гайхамшигт ёр тэмдэгтэйгээр Бодалын оронд заларвай. Үүнээс гурав хоногийн дараа үзтэл бие лагшингийн жавхаа, өнгө зүс нь арилж замхралгүй 7 настай нялх хүүхдийн хиртэй болоод түүнээс хойш 7 хоног болсны дараа бунхлан залсанд сүр жавхаа нь бадарсан олон зүйлийн шарил хийгээд бурханы шүтээн, үсэг тэргүүтэн гарч ирэх болов. Энэ нь Чүсэм хамбын намтар болой. Тэр бээр өөрийн увдисаа Шэйрэвбумд хайрласан юм.

ШЭЙРЭВ БУМЫН НАМТАР

Хоцроолгүй хамаг хүссэн хэргийг үүтгэгч эрдэнэ

Ахуй ёсыг ямарчлан онох билэг оюунтан

Хэмжээлшгүй буман тоот эрдмийн их уурхай

Цорж эрдэнэд сөгдөн мөргөмүй

Энэ хүмүүний мэндэлсэн нутаг нь Зан бөгөөд сүсэг ихт эцэг эхийн хөвгүүн болон мэндлэх цагт солонго татах, цэцгэн хур буух тэргүүтэн олон зүйлийн сайны ёр гарч байв. 16 насандаа тойн хувраг болж, эрдэмд суралцсанд дөрвөн бэрхийг мэдэж, эргэл мөргөлийг ч үйлдэв. Төв үзэл, ухааны зургаан чуулган номд мэргэн хэмээн алдаршсан бөгөөд өөр бус олон шастирыг ухаандаа багтаан зохиов. Хоёр шинжлэл, нууцын хураангуй, цагийн хүрдэн тэргүүтэн нууц тарнийг ч ихэд болгоон мэдэв. Бүтээлч эрдэнээс зургаан найрлага сонссонд найман тэмдэг хийгээд найман эрдэм ургасан тэргүүтэй олон эрдэм хийгээд таван зөн билгийг эрхшээсэн хэмээн алдаршвай.

Улаан Манзушрийг бүтээж нигуурыг нь илтэд үзэн агуу их сэтгэл үүсгэвэй. Нэгэн шөнө зүүдэнд нь хөх патрари торгон өмсгөлтэй ногоон өнгөт эмэгтэй гартаа удвал цэцэг барин гарч ирээд:

-Чи энд бүү суу. Хамба Чүсэмбийн дэргэд одогтун. Гурван цагийн бурхан бүгдийн мөн чанар арван нэгэн мутарт Жанрайсигийн бүтээх аргыг анхааран авагтун, дээдийн шид бүтээлийг олох болно! хэмээн эш үзүүлэв. Тэр ёсоор хамба

Чүсэмбийн дэргэд залран долоон цэн алтыг өргөөд Арван нэгэн нигууртын авшиг, үүсгэл төгсгөлийн хөтөлбөр, бүтээх аргыг айлтган гурван сарын хугацаанд бүтээл зохиосонд найман аюулаас аврагч бурхадаар хүрээлүүлсэн арван нэгэн нигуурт Жанрайсигийн нигуурыг үзэв.

Тэгээд тэр цагаас хойш Арван нэгэн нигуурт, Гэтэлгэгч Дарь эхийн нигуурыг үргэлжид үзэх болов. Номлол бүтээлийн үүднээс хэмжээлшгүй их амьтны тус хийгээд шашныг дэлгэрүүлэх их үйлсийг зохиосны эцэст лагшин морилох үед нь ч газар хөдлөх, цэцгэн хур буух тэргүүтэн санаанд багташгүй сайн ёр тэмдгүүд гарч байв. Ясыг хуулсанд элдэв шарил шүтээн хийгээд Жанрайсигийн олон нандин шүтээн гарав. Энэ нь Шэйрэвбумын түүх бөгөөд увдис үүнээ ялгуусны хөвгүүн Тогмидсамбуубалд хайрлажээ.

ТОГМИД САМБУУ БАЛЫН НАМТАР

Хөвгүүд сэлт бурханы айлдал энэрэл нэгдэн хурсам
Торолт үгүйгээр мэдэгдэхүүний оронд машид орогч
Агуу сайн даяар их үйлсийн цогт охь шим болгосон
Түүн дор мөргөмүй

Энэ дээд төрөлхтний намтрыг бага зэрэг дэлгэр өгүүлвээс мэндэлсэн нутаг нь Цогт сажаан хийдээс баруун урагш 2.5 багцадад зорчиход байх Цайвар хад хэмээх газар юм. Яс угсаа нь Додын гаралтай Эцэг Гончигбал, эх Бумдон нарын хүү болж, элдэв гайхамшигт сайн ёр тэмдэгтэйгээр мэндэлжээ. Хэлд орох цагаасаа ном номлож буй, бясалгал үйлдэж буй тэргүүтэн хэмээн тоглож, буяны үйлээр цагийг өнгөрөөж, урьдын авъяас нь сэрсний шинж төрхийг үзүүлж, их нигүүлсэнгүй бодь сэтгэлтэй тул модны навч салхинд хийсэхийг хараад амьтан салхинд хийсэв хэмээн гуниглаж, хяруунд дарагдаж өтөнд идэгдэн зовж буй согоог хувцсаараа бүтээгээд сууж байсан тэргүүтэн зөвхөн бодисадвын явдлаар явдаг байв.

Есөн нас хүрэхдээ номд сэтгэл нь булаагдаж, хонь малаас зугтан Самлин хийдэд залрав. Домбадашринчен хэмээх багшаар унших бичихийг заалгасанд томъёо төдий мэдэх болов. 11 насандаа Балбар ламаар ловон болгож тойн болсонд тэнгэр огторгуйгаас тэнгэрийн дуу дуугарсан бөгөөд Самбуубал хэмээх алдрыг хүртэв. 15 насандаа Бодон-Эйгийн хүрээнд залрав.

Гүнжалва ламын дэргэд Онбогүндүй, Майдарын таван ном, таван аймаг газар, хоёр зүйл боомтлол, пракарнийн найман аймаг, төв үзэл ухааны зургаан чуулган, явдалд орохуй, суртгаалын хураангуй зэрэгт цагааран нэвтэрхий суралцаад ухаандаа ёсоор нь багтаав. Нэгэн удаа цайны суудал дээр Жамъяннмажанцан бээр:

-Самбуубал тэргүүтэн шинэхэн суралцагч хуврагуудаас асуух асуулт байна. Авидармад «Эд идээ үгүй мэдрэхүй зовлон» хэмээн номлосон нь эд идээ үгүй мэдрэмж нь зовлон байдаг гэдгийг учир шалтгаанаар үгүйсгэж байна. Үүнд хариулна уу гэв. Бусад нь хариулсангүйд тэрбээр үүнд хариулахдаа:

-Эх бичигт зарим нэг дайснаа дарсан ширвагууд “Эд идээ байхгүй ч үйлийн чадал гарна» хэмээн зовлонгийн уг шалтгааныг номлосон байна хэмээн болгоогоод тэр талын нотолгоо, няцаалтыг айлдсанд мэргэдүүд гайхширсан бөгөөд Даш лам өгүүлрүүн:

-Асанга богд өөрөө биеэрээ чи мөн байна. “Би хоёрдугаар Асанга байна» хэмээгээд тахилыг дээш үйлдэгтүн гэсэн нь яг тэр үед тахилыг дээш үйлдэх лүгээ нь тийн таарч хэлсэн тул түүнээс хойш ялгуусны хөвгүүн Тогмид /Асанга/ хэмээн алдаршвай.

Сажад залран билэг барамид, шалгадаг ухаанд мэргэжин 23 насандаа Зангийн зүгийн хүрээ хийдүүдээр эргэл мөргөл зохиосонд Ухаан сайт хэмээн ихэд алдаршив. 30 насандаа Эйгийн номын хүрээнд хамба Жансэмринченгомбо хийгээд Ловон Намхайсанжэй нарын өмнө гэлэн сахил хүртэн эл шарыг баригчдын оройн чимэг болов. Бодон-Эйгийн ширээтийг өргөсөнд тэнд мориллов.

Майдарын таван ном тэргүүтэн номын рашаанаар шавь нараа цэнгүүлээд 38 насандаа «Явдалд орохуйн тайлбар» тэргүүтнийг зохиож, 115 номыг үсгэнд буулгав. Бас бус нууц тарнийн номын хувьд ч, таван насандаа Санжай-Уонгоос дэлвү ёсны Дэмчигийн номыг айлтган дөрвөн авшгийг таньж мэдэв. Улмаар түүнээс хойш дараалан Чойжанцан лам, их хамбя Чойжилбалсан, Бүхнийг мэдэгч Бүдон эрдэнэ, цорж Дамба лам, Жансэмринченгомбо, Райринченлам, Жамъянхондон, Гүнжалва лам, Нямжанцан, Дашгомбо, Шагжаажанчүв, Сономгомбо, лозава Лодойдамба, гүүш Ринченсэнгээ тэргүүтэн дөчин мэргэн, бүтээлч ламыг шүтэн сажийн уламжлалт номын аймаг, Жовуу богдоос дамжсан, Дагву гаржүдээс дамжсан, Паадамбагаас дамжсан, Жононбагаас дамжсан, Топугаас дамжсан судар, тантра, шастир, увдисын Түвдэд орчуулсан бүхий л зэргэмжийн

зонхилоход нь мэргэшсэн бөгөөд анхааран бас авчээ. Түүнд тэнслэх хүнгүй хоёр их багш бий. Ханчин Содномдагваас судар, тантра бүгдийн охь шим болсон их хөлгөний оюун судалбарыг айлтган бясалгаснаар өөрөөсөө бусдыг энхрийлэх бодийн сэтгэлийг усны урсгал мэт бат болгов. Тэрхүү багшаа хэмжиж баршгүй олон төрлийн өмнөөс өөртэйгээ барилдлагатай байсныг мэдээд алдрыг нь өгүүлэхдээ ч шар ус нь хөдөлж нулимс нь асгардаг байв. Золгох цагтаа ч 16 батагчийн нэгэнтэй уулзаж буй мэтийн үзэгдэл үргэлж гардаг байв хэмээнэ. Жовуу багшаас уламжилсан Жанрайсиг тэргүүтний судар, тарнийн номыг олонтаа сонсож «Миний бодийн сэтгэл үүний ачаар төрөв» хэмээгээд эрхэмлэн дээдэлдэг байв. Эх Очирдарын мөн чанартайгаар оршигч Шэйравбум эрдэнээс найруулгын зургаан номын хөтөлбөрийг айлтган бясалгаснаар арван тэмдэг, найман эрдэм ил болов. Очрын биеийн ахуй ёс, бурханы ертөнцийг үзэх ёс тэргүүтэн нь хязгааргүй бөгөөд их махамудрын онол чанх буруу бусаар сэтгэлд нь төрсөнд Шэйравбум эрдэнэ:

-Хутагт Арьяабал арван нэгэн нигуурт, мянганмутар, мянган мэлмийт Жанрайсиг нь чиний хэмжээлшгүй олон төрлийн идам бурхан мөн хэмээн зарлиглаад Нагаржунайгаас уламжилсан, Чандрагомигоос уламжилсан, гэлэнмаа Балмугаас уламжилсан Арван нэгэн мутартын даган соёрхол, бүтээх арга, Энэтхэг голуудыг бүрэн гүйцэдээр, Чилан ахуйн багш Даваажанцангаас уламжилсан улаан хөтөлбөрийн, зэрэг, дээд тааллын шүтээн, судар тэргүүтнийг хайрлан өөрийн болоод өрөөлийн тусыг агуу ихээр үйлдэх болно хэмээн бошго үзүүлэв.

Номлол сонслын үед зарим нэг багш, номын ахан дүүс нөхдүүдээс лам хувраг тэтгэхэд гарын эд нимгэн байгаа тул гарын авлагын аймгуудыг тэтгэхийг дахин дахин айлтгасанд «Ялгуусны хөвгүүдийн гарын авлагыг айлдсугай» хэмээгээд «Ялгуусны хөвгүүдийн гарын авлага» номоо зохиов. Тэгээд Бодонгийн хүрээ хийдийг өөрийн их хөвгүүн Жанцан сэнгээд даатган байх цагт Жамъян донёд Жанцан номын ах дүүгийн хамтаар ирж Э-гийн номын тэргүүн болохыг бас айлтгасанд Ялгуусны хөвгүүн:

-Би тэгсүгэй хэмээгээд Сажад морилон очиж лозава Лодойдамбад айлтгасанд:

-Төрвөлгүй /Тогмэд/ энэ үг яруу сайхан байна. Миний лам багш Дагом Сэнгээ жанцны олоогүй орон хийд тул би одсугай хэмээгээд маш ихээр баясав. Тэгэхэд нь Лозаваг залан суулгаад ном судруудаа өргөөд өөрөө ч аглаг оронд дуртай тул дөчин гурван насандаа Үлчүгийн номын хоргонд залран хорин жилийн

турш хөл хорин бясалгахдаа нандин бясалгалынхаа голыг хутагт арван нэгэн нигуурт Жанрайсигийн үүсгэл, төгсгөлийн зэрэг хийгээд их хөлгөний оюун судалбарыг анхааран авснаар зургаан сарын дараа мянган мутар мянган мэлмийт хутагт Жанрайсигийн нигуурыг үзэн самуд дияаны олон үүд сэтгэл үндсэнд нь төрөөд Их нигүүлсэгчийн таалалтай ялгалгүй нэг болсон тэргүүтэн хэмжээгүй их намтартай болой.

Бас бус номын ахан дүүс нь бараалхал цаг айлтгасан боловч зовшоөрөлгүй, гаднаас өргөсөн сүсэгтний идээг ч авалгүй, бясалгалын хорион дотор зөвхөн мөнх бусыг бясалган сэтгэл үндсээ шавдуулна. Айлдахдаа ч бас:

-Мөнх бусыг сэтгэлдээ төрүүлэх хэрэгтэй, эхэнд номын аймагт орох үндэс, дунд нь анхааран авах ташуур, эцэс сүүлд номын лагшинг олохын нөхцөл болохын тул чухал гэдэг бөгөөд үймцээн, алагасралын эрхэнд огт орж байгаагүй билээ. Дараа нь хөл хориогоо тайлан Зан нутгийн багш нартай уузан шавь нартаа агуу их тусыг хүргэв.

Бас нэгэн удаа Бодонд сууж байх цагт хур бороо огт орохгүй байгааг Жалсрайбад айлтгасанд Жалсрайба бээр Жангод шогийн Зуу бурханд угаал соёрхож, магтаж, залбирсанд долоон өдрийн турш тасралтгүй их бороо оров. Зуу бурханаас «Чи амьтны тусыг уйсаж, алжаалгүй үйлдэхтүн» хэмээн зарлиг болохыг сонсов. Бус бас Жиддонгийн Зуу хийгээд Эл шар Дарь эх ч бас Жалсрайбад зарлиг буулгасан хэмээн алдаршсан юм. Энэ их төрөлхтөн үйл, уг, үрийн хуурмаггүй утгыг үзсэнээр гэмийг өчүүхэн нарийнаас нь өгсүүлэн хянамгайлан зуны навчит ногоон мод үл түлэн, хоргогүйгээр зул үл өргөн, цутангийн хийцийг буцлахаас нь өмнө хийж дотроо асрал энэрэл ихтэйн хүчээр ойр орчимд нь байдаг хорт араатан амьтад нь ч бусдад хор хүргэлгүй харин ч гөрөөстэйгээ эв найртай байдаг байв.

Нэгэн хун галуу Жалсрайбагийн явдал мөрийг адил үйлддэг байсанд таалал ихэд баясан төвийн цэрэг ирэх цагт өөр ямар ч эд зүйлс авч чадаагүй хэрнээ зөвхөн хун галуугаа нэгийг нь ч орхилгүй авч одсон гэдэг. Үлчүгийн хүмүүсээс зугтаад зайлж чадаагүй зарим нь багшийн дэргэд суусанд төвийн цэргүүд хилэгнэн уурсан хүрч ирээд нүүр тулсан даруйдаа уур хилэн нь намдаж тэнд суух хүмүүст хор хүргэлгүй багшаас адис хүртээд тэдний дундаас хилэнц нүглээ наминчилсан хүмүүс ч олон гарав гэдэг. Жалсрай эрдэнийн дэргэд суудаг хувраг шавь нар нь ч нэг нэгийгээ хүндлэн, хэрүүл маргаан гаргалгүй эрвийх дэрвийхээрээ суудалдаа хичээнгүйлэн суудаг байв.

Жалсрай эрдэнийг арван зургаан нас сүүдэртэй байхад нь тус болж байсан нэгэн гэвш лам Бодонгоос Сажаа руу илгээсэнд замдаа явж байгаад хэн нэгний ачаа сэлгэхдээ хаяад явсан таван гөлөг байхыг үзээд их нигүүлсэн энэрч гуниглаад үүнийг орхиод одвол үхэх нь гарцаагүй ул тухайлан шөнө одсугай хэмээгээд тэдгээрийг аваад эргэж явах зуур нэгэн гудамжинд тэр гэвштэй тааралдтал «Чи миний хэргийг цалгардуулсан байна» хэмээн загнаснаа сүүлд ихэд ичсэн гэдэг. Тэгээд тэр даруйдаа залран үүр цайхад Сажад ирж үйлсээ бүтээгээд дахин буцаж Бодонд орой ирэв. Тэр гэвш ч гэсэн сүсэг төрж хүлцэл өчсөн гэдэг. Тийнхүү бага балчир цагаасаа л бодийн сэтгэлээс хагацаагүй юм.

Бас хатуу хөл хорио тогтоон бясалгал үйлдэж байх нэгэн цагтаа Ханчэн эрдэнэ бие барсныг зөн билгээрээ мэдээд хөл хорионоосоо гэнэт гарч залран очих замд нэгэн ямааг алба гувчуурт өгөх гэж байгаа хоёр хүнтэй тааралдан ямааг ихээр нигүүлсэн ихээр гуниглаж хагас цэн алт өгч ямааны амийг хэлтрүүлэв. Дараа нь Шандад хүрч ирээд:

-Цай чана гэтэл:

-Ус байхгүй байна хэмээсэнд гараа элсэнд зоотол сэрүүн, тунгалаг ус гарав. Шадар хүн нь өөрийн нүдийг илбийн юм харав уу гэтэл цайгаа уугаад дууссан хойно ч бас л ус гарсаар байв. Дахин нэг хартал усны мөр ч байсангүй. Тэгээд цааш залран багштайгаа уулзан золгож ихэд баясаад Жалсрайба:

-Орохуйн бодийн сэтгэлийг урд нь төрүүлсэн боловч таны лагшин чилэхгүй бол дахин нэг айлтгасугай хэмээсэнд багш:

-Түүнд маш их дуртай байна. Яг одоо тахил бэлтгэхтүн хэмээн зарлиглаад бодь сэтгэл хүртэх бодит суурийн /ойши/ үед газар хөдлөх тэргүүтэн олон сайны ёр тэмдэг үзэгдэв. Зан үйлээ өндөрлөсний дараа багш лам:

-Ном маань эзнээ олсон бол өвгөн лам би үхсэн ч сэтгэл амар боллоо хэмээгээд орлоочоор өргөмжилсөн билээ.

Тэгээд Үй, Зан, Хам гурван газарт гэвш нар болон, түмэн олонд бодисадвын санваар хүртээж бодисадва болгон:

-Жовуу эцэг хөвгүүний үед бол энэ номын зарлиг түгээмэл бус хориотой байлаа. Хойд үед ихэд цөөрсөн бололтой. Энэ номыг хүртээгч биднээс өөр олон хүнгүй. Бодь сэтгэлийг төрүүлэгчид ч олон гарлаа. Өдгөө би зарлигийг чөлөөлсөн тул гэвш та нараас хүртээж чадах бүхэн нь хүртээгтүн хэмээн зарлиг болов.

Тийнхүү бодийн сэтгэлийг голчлон анхаарч үргэлж өөрийн амар амгаланг бусдад өгч бусдын зовлонг өөрөө авах явдалд орсон юм. Ловон Балиший оюун судалбарыг бясалгаж байхдаа хачиг өвчин

тусаад Жалсрайбад айлтгаснаар:

-Тэсвэрлэж байгаад эдгээ. Эс эдгэвэл над дээр хүрээд ирэгтүн хэмээжээ. Тэр бээр урт удаан хугацаанд эдгээхийг оролдсон боловч багасаагүй тул түүний ойролцоо Чойзонд хүрэлцэн ирээд Лаеэ-д хэдэн хоног суутал багассан боловч буцаад гарах вий хэмээн эргэлзээд уулзахаар дэргэд нь хүрч очтол бие дүүрэн хачигтсан байхыг үзэв.

-Саяхан би өөрөө тэвчээр гаргаж эдгээлээ хэмээсэнд «Чиний хачиг бус надад угаасаа байгаа юм хэмээв. Хэдэн хоногийн дараанаас бүгд замхран алга болсон гэдэг.

Бас Даяан аглаг хийдийн хамба нэг удаа толгой, зүрхээр тэсэхийн аргагүй ихээр хатгах эвэршээлт өвчин тусаад Жалсрайбад түүнийгээ айлтгасанд:

-Өвчнийг тань би авсугай гэж хэлэхэд өвчин эвэршээл бүгд хаашаа одов гэлтэй гэнэт алга болов. Лам ер бусаар сүсэглэн итгэх болов.

Бас Монголын улаач бээр урагацын талбай дээр нэгэн хөгшин нохой хүрч ирсэнд хавирган дундуур нь чулуудсанд муухай гаслах дуу гарахыг Жалсрайба үзээд:

-Ео ёо гээд нулимс унагав.

-Юу тань өвдөв гэж асуутал:

-Чулуунд өртсөн нохойн өвдөлтийг өөртөө авлаа хэмээн айлдав.

-Хаана тань өвдөв гэж асуутал

-Энд өвдлөө гээд хавирган дээрээ гарсан товгор хавдрыг үзүүлэв. Тэгсэн нь Монголчуудын сүсгийг төрүүлж сургаал хэлж өгөөд л цаазаар авахуулах олон хүнийг өршөөлгөв.

Бас нэг удаа хачиг өвчтэй гуйлгачин хүний хувцсыг өмсч олбогийг нь дэвсээд ихээхэн хувцас хоол өгч явуулав. Хэдэн хоногийн дараа нэгэн хувраг мэдээд үзэхээр иртэл хамаг бие нь гөвдрүүтсэн мэт болсныг хараад гайхан

-Та бүү ингэх түн гэж айлтгасанд:

-Би бээр амьтан бүхэнд

Энэ биеэ чөлөөлөн өгч гүйцсэн

Үргэлж алах хийгээд гутаах юмуу

Зодох тэргүүтэн аль дуртайгаа үйлдэгтүн хэмээн айлдаад сонссонгүй тул тэр бээр Ловон Жамъяантай хамтраад ятгасан боловч дахин:

Бусдад тусгүй сансрыг барсан амгаланг ч

Тамын гал мэт үзээд сайтар тэвчээд

Бусдад тустай бол нэрвэлтгүй тамд ч

Үргэлж орогчдыг дуурайн суралцалтай хэмээн айлдаад эмчилсэнд өнө удалгүй эдгэрч одов.

Бас бус олон хачиг өвчтөнийг эмчилсэнд тэд нар нэг хоногийн дотор үхэв, замхарч алга болов гэцгээж байснаас нь харвал бодисадвын лагшинтай барилдлага тогтоосон тул муу үйл нь барагдан сайн заяанд төрсөн нь илт буйзаа. Жалсрай эрдэнэ нь бусдын эрдмийг л өгүүлж байснаас бус гэмийг өгүүлж байх нь огт үзэгдээгүй. Тэр бээр Наро багш Дэло багшийгаа загас авлаж байхыг харсан, Санжай иший Жамбал шэнинг гэргийтэй, загас худалдаж байгаа мэтээр харсан тухай намтрыг айлдан «Бусдын гэмийг харах нь өөрийн тань үзэл ариусаагүйн уршиг мөн бөгөөд хүнийг нь мэдэхгүй хэрнээ гэмийг нь хэлвэл өөр лүү тань тэрслэх бөгөөд бусдын эрдмийг өгүүлбэл өөрийн тань эрдмийг өгүүлдэг нь номын чанар юм» хэмээн зарлигладаг байв.

Бас төв газрын цэрэг Үлчүгийн талд ирэхэд Жалсрай эрдэнэ:

-Миний эцэг, эх нар андуурч эндүүрээд зовлонгийн шалтгаанаа өөрсдөө тавьж байгаа нь хөөрхийлөлттэй хэмээн зарлиглаад суудал дээрээ тогтож чадахгүй байгаа мэт ухаан алдан гуниглаж ийнхүү айлдав:

-Сайтар бодоод үзэгтүн! хүний дотор зовлонгийн үндсийг үйлдээчид өдгөө энэ ертөнцөд их хүмүүнд тооцогдон, хүрээлэгчид олон, эрх мэдэлтэй, эд баялагтай, зөвхөн хилэнцийг л үйлдэж буйг харахаар нулимс өөрийн эрхгүй алдах юм. Тамын амьтнаас ч өрөвдөлтэй бус уу хэмээн айлдав.

Бас олонд ном айлдаж байхдаа «Төрвөлтгүй /Тогмэд/ миний ачит эцэг, эхүүд хөөрхий» хэмээгээд нулимс унагасанд чуулсан бүх хүмүүс нэг бүрчлэн нулимс унагаж байхыг нэгэн чойрын номтон үзээд:

-Өөр бусад лам багш нар ном айлдахад нижгэнэтэл инээлдэх атал Жалсрайбаг ном айлдахад энхрий хүнээ алдсан аятай хангинатал уйлалдаж байх юм хэмээсэн гэдэг. Түүний хэлсэнчлэн Жалсрай эрдэнийн нигүүлслийн хүч шавийн сэтгэлд нөлөөлж мөнх бусыг төрүүлсэн юм.

Бас бус Жалсрай эрдэнэ үнэмлэхүй бодийн сэтгэлийг илт болгосон тул тэгш ахуй огторгуй мэт агаарт хөдлөхгүй, даган олох нь ч бас янагуух юмс бүхнийг илбэ мэт ухаарсан тул найман номын тачаал, уураас хагацсан бөгөөд зургаан барамидын үүднээс амьтны тусыг зохиохдоо шүлэгч, дууч, эргэлчин тэргүүтэн ямарваа гуйлгачин хүнд ирвэл «Аль дуртай зүйлээ аваад яв» гэхээс бус нэг агшин ч харам үүсгэж үзээгүй юм. Бусдаараа байхгүй цагтаа хөшиг, лавир тэргүүтнээ тайраад өгчихнө. Шадар

хүн нь байхгүй хооронд тэнэмэл гуйлгачин олноороо ирсэнд хувцас, хүрэм, цээживч, арвайн гурил, малгай тэргүүтэн юу байгаагаа хайрлаж дууссаны сүүлд гал өрддөг ганц хөөргө байснаа ч өгсөн нь нүүрийг нь улайлгав гэдэг. Бусдад тус болж байвал тэргүүнээ ч өгч чадах болой.

Бас Үлчүд хуврагууд хийгээд олон ардад оюун судалбар, бодь сэтгэл үүсгэл, Явдалд орохуй айлдах цагт цэцгэн хур цас орох мэт буусанд:

-Бидэнд ийм эрдэм байхгүй, энэ номын л эрдэм мөн байна хэмээсэнд:

-Хамба Чойлой мөргөөд

-Ингэж бүү айлд, хэрэв зөвхөн номын хүч бол “Явдалд орохуйг” би ч гэсэн нилээн хэдэн удаа номлосон боловч нэг ч цэцэг унаж байсангүй гэсэнд

-Тэр ч бас үнэн хэмээн айлдсан гэдэг.

Дараа нь Дээд Цорж багшийн зарлигаар Сажад хар, шар олон түмэнд ном айлдан амьтны тусыг хэмжиж баршгүй ихээр үйлдэв. Бал, Дин, Чүмиг, Шаалү зэрэг газарт номын өглөгийг агуу ихээр түгээв. Жаран долоон нас сүүдэр зооглож байхдаа Дааей Сидү Жанчүвжанцан бээр айлтгал өчин Ринбрүнгээс эхлээд олон хоргуудаар дараалан залрав.

-Тэр үүлний харалдаа байгаа юу вэ? гэж асуусанд:

-Самяай хийд байна хэмээн өчсөнд:

-Үүнийг үзсэн маань гайхамшиг хэмээн айлдав

Тэгээд Нэүдон хэмээх их орд харшид залж ирүүлэн элбэг дэлбэг их хүндлэлийг үзүүлэн зочлов. Гурван сарын турш хавийн ноход хүртэл гадны хүн уралгүй асрангуй сэтгэлтэй байв. Дараа нь Табрүг, Зэдтэн хэмээх газруудад ном айлдаж Дансатэл, Самяай, Гүнтан, Сампү, Сүлпү, Лхас тэргүүтэнд лам шар, энгийн олонд хүссэнээр нь номын хүрдийг эргүүлэн айлдав. Ном айлдсан газар болгонд нь цэцгийн хур бууж олон зүйлийн сайхан ёр тэмдэг илэрч шавь нарыг боловсруулан гэтэлгэх болов. Цаазын ялтай олон гэмт хэрэгтнийг аюулаас аврав. Цалд залраад ерөөл тавьснаар хижиг өвчний тархалтыг таслан зогсоов. Гүнтэнд өнө удаан оршин хөтөлбөр айлдсны дараа Лхасад залран усны эрэг дээр морилоход найман морьтой хүн усанд автсан байхыг хараад алга хавсран:

-Гэтэлгэгч Дарь эх минь гэтэлгэгтүн гээд Мэлмийгээ аньсанд нэгээс бусад нь мориноосоо салалгүй усны захад эсэн мэнд гарав. Усанд автсан нэгийг нь Жасрайбагийн хойноос өндөр чацархаг биетэй цагаан хувцастай жамаа /туухай боодог эрээн

оосор/ бүс бүсэлсэн нэгэн цагаан хүн гэнэт гарч ирээд:

-Би очье хэмээгээд эргэлзээ тээнэгэлзээгүйгээр ус руу орж хүн, морийг хуурай газарт гаргаад солонго шиг замхран одов. Тэгэхэд нь өмнө нь байсан хүмүүс учрыг шалгаан асуутал:

-Жанрайсигийн нэгэн хувилгаан бололтой. Сэтгэл оюунаа даатгаж чадвал чухаг дээд хуурмаггүй гэдэг энэ дээ хэмээн айлдсан гэдэг.

Тэгээд Лхаст заларч алтан ус тэргүүтэн тахилыг өргөж шавь нараа ном болон эд өглөгөөр цэнгүүлэв. Тэгээд Төв газар оршин суухыг айлтгасанд үл сонсон Зангийн зүг залраад хуврагийн аймгуудад номын хүрдийг эргүүлж дөрвөн зүйлийн өглөгөөр хэрэгцээнд нь тааруулан лам шар, эгэл олны сэтгэлийг баясгав. Гурван санваартаа хир үл суулган шагшаабадад үргэлж оршин ангид тонилгохуй санваарын үүдэнд оршоод 253 зүйл цаазыг гэм цөвөөр халдуулалгүй ерөөх, орохуйн бодийн сэтгэлийг үүсгэж, аминчлан жаргахуйн хүслийг цээрлээд, зөвхөн бусдын тусыг л бүтээж, нууц тарнийп үүдэнд оршиж, арилаагүй атгаг бодлыг цээрлэн сав шимийн ертөнцийг арилсан хүрдэнд болгов. Биеэс нь ханхлах шагшаабадын анхилуун үнэр хувцас, нойрсох өргөөг нь дүүрэн байдаг байв. 57 нас хүртлээ мах зооглоогүй бөгөөд түүнээс хойш амьтанд тустай гэж болгоогоод бага зэрэг зооглодог боллоо гэлцэнэ.

Жалсрай эрдэнэ нь их, бага ямар ч хохирол гарз учирсан таалал сэтгэлээ хямрааж байсан удаагүй. Нэгэн даяанч хоригийн лацыг эвдэж, шадар хүмүүнд нь хутга тулгаж, Улаачын дундуур хутгууш хийж их гэм хийсэн ч таалал нь хямарсангүй.

Сүүлд өнөөх даяанч Үлчүд таарсанд «Эхлээд иймэрхүү догшин хэрцгий энэ хүмүүн таарахгүй бол сайнсан хэмээн санадаг байсан. Дараа нь амьтанд оюун минь огтоот одох цагт хорлол үйлдсэн хүн үүнээс өөр гарсангүй, хариуд нь тус хүргэх хэрэгтэй» хэмээн бодоод ном хийгээд эд өглөгөөр баясгав. Жалсрай ринбүүчи хором ч үл сулрах хичээнгүй сэтгэлийг эрхшээсэн нэгэн юм. Хөө хуягийн хичээнгүйгээр хамаг амьтныг орчлонгийн далайгаас гэтэлгэнэ хэмээн тангараглаад найруулгын хичээнгүйгээр шөнө тэргүүнээ дэрэн дээр тавилгүй Бяруузана бурханы долоон номыг биеэсээ огт салгалгүй зохиосон юм. Таалал нь тэгш агуулахуй хийгээд санамсар мэдэмсэр төгс болой. Хөл хорин бясалгах цагтаа эдгээр номын явдлыг таслаагүй билээ. Өглөө босмогцоо угаал үйлдээд 100 мөргөл өргөж, долоон гишүүнтийг дэлгэрэнгүй үйлдээд орох, ерөөхуйн бодийн сэтгэлийг товч нэжгээд авч, Цагунд дөрвөн хувь цагаан балинг өргөж,

цав зооглоод 100 удаа өргөж, Миёва, Югү, Хорин нэгэн Дарь эх, Брүлдор, зуурдын балинг хураан зохионо.

Бас ерөөх, орохуйн сэтгэлийг хураангуйгаар авч, 100 удаа эргэл хийнэ. Нэгээс хоёр түмэн маани, юмдүгдулмааг бүтэн гучин удаа, бишазийг 21, бизъяагийн сүнг 21, орой Дэмчигийн «Илт онохуй»-г голд номлосон ёсоор бясалган зүрхэн тарнийг мянгантаа уриад нойрсохын өмнө долоон гишүүнтийг өргөж, ерөөх, орохуйн сэтгэл үүсгэлийг огт таслалгүй авдаг байв. Эдгээрээс бусад нь тодорхойгүй байлаа.

Тийнхүү тэгш ахуйгаас үл хөдлөхийн сацуу номын явдлын эдгээр горимыг зохиох нь ханьцашгүй их хичээнгүйтэн мөний баталгаа гэж хэлж болно. Жалсрай эрдэнэ самуд дияаны чанадад хүрсэн тул торолтгүй зөн билгийг эрхшээжээ. Амьтан бүхнийг асран энэрч, самуд дияанаар өвөр бусдыг арилжиж чадах, амирлан ахуй болон үлэмж үзэхүй хослон барилдсан самуд дияанаар орчлон болон орчлонгоос хэтийдсэн бүхнийг зүүд, илбэ мэт мөн чанаргүйгээр ухаарсан тул хязгаараас ангид хослон орсон самуд дияан дунд алгасралыг үл эрхшээсэн билээ. Хамгийг айлдагч Бүдон хийгээд Жалсрай ринбүүчий хоёр уулзан золгох үеэр Бүдои багш:

-Та зүүдэнд хэр зэрэг мэргэшив хэмээхэд Жалсрайба:

-Би Гандангийн оронд Майдараас өөрөөс нь Майдарын таван номыг сонсч чаддаг болсон. Харин та хэдий хэр онов хэмээн асуусанд Бүдон:

-Би өдрийн цагаар номлол сонсолд алгасраад үзэх, бодох чөлөө олдоогүй үедээ зүүдэндээ ганжуур, данжуурын аль дуртайгаа үзэж болохоор болсон. Тэр ботийн оосрыг тайлахад хялбар байдаг хэмээн зарлигласан гэдэг.

Бас нэгэн удаа Ханчинжанчувзэнмугийн лагшин тавгүйтэхэд Жалсрайба з үүдийг нь барьж адистэдл эс энд тэр шөнөдөө тусыг үзүүлэв гэдэг. Бусдын сэтгэлийг мэдсэн тухайд ч хязгааргүй. Жалсрайбад өргөсөн жимсийг лозава Намсан хараад «Сайхан өнгөтэй юм, амт нь ямар байдаг бол» хэмээн санамагц:

-Амтыг нь үз хэмээгээд дэргэд нь шидэхэд тэр бээр ихэд ичсэн гэдэг. Бас нойрсох өргөөнд нь байдаг цагаан ирвэсийн арьсан дэвсгэр байсныг нь Сампугва хамба үзээд «Надад байсан бол лавир хийчихмээр эд байна» гэж бодсон даруйд нь

-Та үүгээр лавир хий “ гээд хайрласан гэдэг. Энэ тэргүүтэн өнгөрсөн, ирээдүйг болгоох, бурханы ертөнцийг харах тэргүүтэн нь хязгаар үгүй ч жишээ төдийг энд өгүүлсэн болой. Жалсрай эрдэнэ билэг барамидыг бүрэн гүйцээсэн тул үнэмлэхүй үнэн,

төрөх үгүй ахуй ёс, номын чанарыг ямарчлан онохын агаараас номын чанарыг агуулагч, янагуухан үнэний мэдэгдэхүүн бүхэнд торолтгүй оюуныг эрхшээсэн бөгөөд ном номлох цагтаа бүхий л шавь нартаа ойлгуулж, жич бас оюуны сэжүүрийг эргүүлэхгүй байх гэж үгүй. Туурвисан шастируудаас нь ч Энэтхэг, Түвд, Монгол гуравт түгээгүй шастир гэж үгүйн шалтгаан нь уужим их тааллынх нь хүч юм. Энэрэнгүй, яруугаар өгүүлэх хийгээд бат ямагт хийгээд гар сунгадаг, омоггүй, гүн, магад, номхорсон эдгээр нь оюунтан хүний шинж юм.

Эдгээрээр тэргүүлсэн өөр олон эрдмийг эрхшээсэн болой. Үүсгэл, төгсгөлийг хязгаарт нь хүргэснээр арилсан үйлстэй шавь нар Их нигүүлсэгчид бодитой үздэг бөгөөд, гүүш Содномлодой хүзүүнээс дээш нь арван нэгэн нигууртад үзсэн байна. Даяанч Намхайбазар оройн цоморлигтой Хасарваань мөн гэж харсан. Их Балжалва насны авшиг айлтгах цагтаа Аюуш бурханд бодитойгоор үзсэн. Ранжүндоржийн их хөвүүн Дрэводогдан «Би зүүд бариад түүний хажууд нэг бус удаа хүрсэн ч арван нэгэн нигуурт л гэж харсан. Энэ Жалсрайтогмид Их нигүүлсэгчийн бодит хувилгаан мөн байна. Ер нь Жанрайсиг гэдэг чинь ханан дээр зурсан тэр цагааныг л зөвхөн хэлдэг бус, амьтан бүхнийг ганц хүү мэтээр харах хуран мэдэхүйг эрхшээж, хоосон чанар хийгээд нигүүлсэн сэтгэлийн гуу сан болсон ийм багшийг л хэлнэ» гэжээ.

Жалсрай эрдэнэ төгстөлийн зэргийн огторгуйн егүзрийг эрхшээсэн тул хилэнцтэн, буруу тангарагтан, хулгана яртан тэргүүтэн хэнээс ч болов болгоомжлох үй мөртлөө дэв бузар тусахгүйгээр зогсохгүйгээр үл барам харин ч тэдэнд асар их тус болдог байсан болой. Ярны хувцас гэдэг тусгай хувцсыг өмсгөөд бусдын хулгана ярыг ч олонтаа арилгаж байсан удаатай. Энэ их дээд төрөлхтний бие лагшинг харахад л оюуны сэжүүр ном руу урваж, хөтөлбөр тавих цагт нь бэлтгэлийн үеэс өгсүүлээд бясалгалд өөрийн эрхгүй автан орсон удаа ч олонтаа гарав. Ном номлох цагт нь амийг нь хэлтрүүлсэн цэтэртэй хонь, анч нохой хийгээд янгир гэх мэт буй бүхэнийг суулган ном сонсгосонд нэгэн удаа Нартангийн тойн хийгээ барих ёсыг мэдэхгүйн улмаас солиорч нүцгэлэн гүйсэнд бусад хүмүүс барихыг оролдсон боловч чулуу мэсээр харваж хэнд ч үл баригдах үед тэр янгир давхиж очоод илдэн хөөж мөргөх гэтэл чнхдэн барьсаар ном өндөрлөх хүртэл хөдөлгөөнгүй суув. Ном өндөрлөсний дараа санамсар оржээ.

Жалсрайба хувцас өмсгөөд дагуулаад ир хэмээсэн ёсоор

дэргэд нь авч ирсэнд хорин нэгэн Дарь эхнийг бүтэн нэгэнтээ айлдаад адистэдлэн:

-Чиний зэтгэрийг энэ янгир арилгалаа. Энэ янгир Дарь эхийн үйлстэн байна гэсэн гэдэг. Бас Чумба ламын гурван шавь дэм увдис айлтгасанд:

-Энэ насыгоюунаараа орхи, амьтанд асрал энэрлийг бясалга, багшид энэлэн энэлэн залбир, сэтгэлийг цацрал лугаа хагацуулахын сацуу алгасрал үгүй байлга гэсэн увдисыг л айлдсанд тэд сайтар танин мэдээд онолын эрдэм сэтгэлд нь ургасан гэдэг. Товчилвоос, шавь нар нь Энэтхэг, Хятад, Балба, Уйгар, Монгол, Додмад Амдо нутаг, Үйзан, Аарий тэргүүтэн нутгийн олон үндэстэнгүүд ба адилгүй олон хэлтэй хэмжээгүй олон шавийг боловсруулан гэтэлгэсэн бөгөөд энэ их бодисэтгэлтний үйлс намтар санаанд багтахгүй, өгүүлж дуусашгүй юм. Асрахуй, энэрэхүй, бодь сэтгэлийг нь үзэхэд хэмжээгүй олон төрлийн урдаас зөвхөн бодь сэтгэлд л суралцсан мэт, самуд дияаныг эрхшээснийг нь үзвэл тэргүүлшгүй олон төрлийн өмнөөс зөвхөн самуд дияанд суралцсан мэт, зүүд хийгээд илбийн биеийг эрхшээснийг нь үзвэл хэмжиж баршгүй олон төрлийн өмнөөс зөвхөн илбийн бие хийгээд зүүдэнд дадсан мэт, ядам бурханы нигуур үзсэнийг нь харвал хэмжиж баршгүй олон төрлийн урдаас зөвхөн үүсгэлийн зэрэгт суралцсан мэт, зөвхөн энэ яваа насандаа ч анхлан буяны садан болж олныг хуруулсан нь насад номлол сонслыг зохиосон мэт, хөл хорин бясалгасан жилийн тоог нь харвал олон төрөлдөө аглагийг шүтсэн мэт, мөргөл эргэл зохиосон тоог нь үзвэл өнө эрт төрлөөсөө зөвхөн мөргөл эргэлийг зохиосон мэт, маани хийгээд Гэтэлгэгч Дарь эхийн нямбыг нь үзвэл бүхий л насаараа зөвхөн урьж өгүүлсэн мэт, ангид тонилгохуйн санваар хүртээсэн гэлэн гэцэл шавь нарыг нь үзвэл насаараа хамба л байсан мэт, дээд бодид сэтгэл үүсгэсэн шавь нарыг нь үзвэл насаараа зөвхөн бодисадвын санваар хүртээсэн мэт, өөрөөсөө бусдыг эрхэмлэх, бодь сэтгэл мэйдлүүлээд хорлосны хариуг тусаар хүргэх тангараг авсан шавь нарыг нь үзвэл бүхий л насаараа зөвхөн янагуухан боди сэтгэлийн хөтөлбөрийг бясалгасан мэт, амирлан ахуй, үлэмж үзэхүйн онол төгссөн шавь нарыг нь үзвэл бүхий л насаараа үнэмлэхүй бодь сэтгэлийн хөтөлбөрийг л тэтгэсэн мэт байдаг. Тийм учраас энэ их бодьсэтгэлтэн айлдал энэрэл хотол чуулсан их бүтээлч байжээ.

Хоёр чуулганы их далай дотроос хоёр тусыг зөнд нь бүтээх зэндмэнэ эрдэнийг гаргаж аваад тоолж баршгүй олон амьтны оюуны үгүйрэл хоосролыг арилган зохиосныг нь хэлбэл илүүц

болох буйзаа.

Эдгээр нь товч хураангуй намтар бөгөөд мөнхөд барих үзэлт шавь нарыг номхотгох хийгээд санаанд багташгүй үйлийн ёсыг үзүүлэхийн тулд өөр ертөнцөд залран одсон тухай өгүүлье. Ловондад:

-Энэ жил улаач заллагаа айлтгахаар айсуу хэмээсэнд:

-Улаачийг ирэхээс өмнө өөр нэг заллага ирж байна даа хэмээжээ.

Тэр жил бясалгалын хорионд орохын алдад алин байгаа эд бүгдээ бурсан хуврагууд хийгээд олон түмэнд тараав. Дараа нь өнө удалгүй лагшин нь үл ялиг чилээрхэх болов. Хуврагууд цуглан хураад ном уншлага, Манал, олон зүйлт заслыг үйлдэж, ялангуяа өөрийнх нь тааллын хөвгүүн Ханчинжанчүвзэнму хийгээд цорж Нимашону хоёр бат оршил өргөж цэцэг цацаад шашин хийгээд амьтны тусад оршин суухыг хүсэн залбирсан их хүчээр дөрвөн сарын туршид лагшин тунгалаг болов. Дараа нь долдугаар сард өвчин нь буцаж лагшин чилээрхэх ёсыг үзүүлэхэд:

-Ахин эм засал үйлдвэл ямар вэ? хэмээн асуувал:

-Бидний хүсэж байгаа нас ч өдгөө эцэстээ хүрчээ. Өвчинд хориглох, бүтээх зүйл ихээр үгүй. Хоосон чанар, нигүүлсэхүйн увдисыг анхааран авлаа. Угтаа өвчин хэмээхэд бүтсэн зүйл үгүй боловч андуурлын оюунд үзэгдэж байна. Үйл, уг үр хуурмаг үгүйг заагч юмуу номт хүний ташуур дэм юмуу аль эсвэл хоёр түйтгэрийг арилгах дээд арга ч юмуу, буяны үйлд шавдуулах ятгалга ч мэт ч зүйл мөн байгаа тул үүнээс цээрлэх арга үл хайсугай. Та бүхний эдгээр засал хүндлэлээр өдгөө хүртэл миний нас уртассан хэмээн зарлиглажээ. Өөрийнх нь нигуурыг үзэх, зарлигийг сонсохыг хүссэн олон шавь байдаг тул бас л насаа уртасган адистэдлэж хайрла хэмээсэнд:

-Тарианы шуудуунд байхгүй бол тааранд хаанаас байх вэ. Тос нь барагдсан зул лугаа адил шүү дээ. Бусдын тусад ихээхэн үйлдсэн юмгүй боловч өөрийн хэр чадлаар тооцвол тус болохын дээдээр тус болжээ. Үхсэн ч бусдын тус багасахгүй. Үхье хэмээв.

-Таны хувьд бусдын тус асар их боловч над тэргүүтэн итгэл, авралгүй болсон амьтдын тусад оршин хайрла хэмээн айлтгасанд:

-Хэрэв эрдэм чадал үгүйсэн бол хамтдаа нөхөрлөөд хэрэг үгүй биз. Чадал байсан сан бол сэтгэл оюунаа даатгасан барилдлага бүхий та нөхдийгөө хаанаас би чинь хөсөр орхих билээ. Надаас хагацаж буйдаа харамсаж гаслах хэрэггүй. Үргэлж залбирагтун. Би байснаас ялгаагүйгээр адис жинлаантай. Би билгийн мэлмийгээр цаг үргэлж та нарыгаа харж байх болно хэмээн зарлиглажээ.

-Ариун оронд заларсны тань хойно яах ёстойг бодолцон сургаалаа хайрлана уу хэмээсэнд:

-Бид бие махбодийн сайн цагт номын болон ертөнцийн үйлд тууштай бус, хааш яаш байдаг боловч өдгөө үхвэл сүүлд нь тийнхүү тууштай байх эрх хаанаас байх вэ. Хэрэв сурах хүн байдаг бол гэрээсээ биеийн сайн дээр өөрийн мэдэхийн хирээр харамгүйгээр заасан билээ. Их бага олон зүйл бүтээл туурвил ч бий. Ялангуяа олон олон их, бага шүлгүүдийг үсгэнд буулгасан маань гэрээс мөн боловч тэдгээрийн утгыг эс шинжилвээс өдгөө холбоо уялдаагүй үг өгүүлэх нь хэрэггүй буй заа. Түүнийгээ л сайтар бодвол уулзавч үүнээс илүү хэлэх зүйл үгүй. Үхсэн ч өөр гэрээс байхгүй. Үйлэнд ч түүнээс бус нь үгүй. Та бүхэн чухаг дээдэд сэтгэл оюунаа даатгаж, энэ нас лугаа холилдоогүй нэгэн номыг үйлдээд амьтны тусад номын ёсоор заасан бүхэн тань бурхан болон түүний хөвгүүдийн залгамж халаа хүний үйл хэрэг мөн тул номыг ёсчлон үйлдсэн бидний дамжлага халааг сайтар баригтун. Эдлэл хэрэглэл үгүй бол сайн тул ганц жин зүйл зориулах чадалгүй боловч хамаг тэвчээрээ зориулж дорой буурай амьтдыг асрах ёсоор намайг дуурайн суралцаж, ялангуяа өдгөө бясалгах хэрэгтэй атлаа чадахгүй байгаагаа сайтар бясалган дадуул. Хэлэх гэсэн зүйлүүд минь энэ хэмээн зарлиглаад тэр шөнөдөө шадар хүмүүндээ сайн тахилыг бэлтгэгтүн хэмээн зарлигласан юм.

Тахилыг бэлдмэгц олон ерөөл талбин суухын учрыг шадар хүн нь асуусанд долоовор хуруугаа огторгуй руу заагаад:

-Чи үзээгүй гэж үү? Өмнийн огторгуйд Түшитийн орны олон тэнгэрээр хүрээлүүлсэн Ялж төгс нөгчсөн итгэлт Майдар оршиж байхын дэргэд Хачбандида Шагжашри ч сууж байх юм. Чи ч гэсэн ерөөлийг олонтаа талбигтун. Би амьтанд тустай бол нэрвэлтгүй тамын оронд ч одож чадах бөгөөд ном дэлгэрээгүй алс бөглүү газарт төрөөд амьтанд тус болох ерөөлийг ч олонтаа талбисан бөгөөд Гандангийн оронд одох ёр тэмдэг мөн шиг байна хэмээн зарлигласан.

Маргааш нь лам нар цуглах цагт:

-Өчигдөр Хачбандида шагжашри болон түүний дагалдагсдад өргөл хүндлэл сайтар үзүүлэв хэмээн зарлигласанд:

-Таныг өргөл өгөх цагт Хачбандида хаана сууж байв гэж асуусанд

-Итгэл Майдарын дэргэд сууж байлаа гэж зарлиглав. Тэрбээр бас зарлиглахдаа зүүд барих энэ эрдэмд урд нь ихэд мэргэшсэн байсан тул тоолшгүй олон орон ертөнцийг харах хийгээд тоолшгүй

олон бурхадаас номыг сонсох тэргүүтэн хичээлтгүйгээр болдог байлаа. Дунд үед энэ зүүдний эрдэм бага зэрэг бүдгэрсэн нь саяхнаас энэ өвчнөөс шалтгаалан сэргэлээ. Төрвөлтгүй энэ үзэгдэл их гайхамшигтай. Дунд үед бүдгэрсэн нь буян заяа ихээр дэлгэрснээс уршигдсан байна. Ер нь номд оюун одох аваас тэр үед их буян заяа дэлгэрэхгүй бол сайн байна даа. Махран үл зүтгэсэн ч өөрийн эрхгүй дэлгэрээд байвал эдлэж болно хэмээн зөвшөөрсөн ч баяжих, гутах хоёрын аль алиныг гэгээрлийн замд авч бүтээл үйлдэх нь чухал байна хэмээн зарлигласан юм.

Шинийн наймны үүрээр ловон Бале-д хандан:

-Намайг босгоод нуруу түшигтүн” хэмээн зарлигласны ёсоор гүйцэтгэхэд алгаа хавсраад удаан хугацаанд гуниглан сууж хэсэг ерөөл талбив. Маргааш түүний шалтгааныг асуутал мэлмийгээрээ огторгуй өөд том хараад намайг өвчлөн хэвтэж байхад өмнө минь Тэргүүлэгч тойн Дарь эх заларч ирсэн тул түүний өмнө налайгаад хэвтэж байх минь зохисгүй хэмээн санаад “Намайг босгож түш” гэсэн юм гэж зарлиглав.

-Тэргүүлэгч Дарь эх ямар нэг юм зарлиглаж байна уу хэмээн асуухад нь:

-Зовж буй амьтан бидний зовлонд тэсэлгүй хэдийгээр Гэтэлгэгч Дарь эхэд үйлдэх зүйл байхгүй ч тунирхлаа л өчлөө дөө. Тэр цагт нэгэн асрагч нь:

-Тоогүй юм болж гэнэт таалал барих болуузай. Хэрэв тэгвэл егүүтгэл тэргүүтэн нандин бясалгалын ургуулах ёсыг ийнхүү үйлдэнэ хэмээх сургаалаа айлдагтун хэмээн өчсөнд өгүүлрүүн:

-Та нар хүсээгүй зүйл толгой дээр бууж үхнэ хэмээн бодож сууна, үхэвч хүсээгүй зүйл толгой дээр бууж байгаа минь бус. Үхэл ирэх вий гэж сэжиглээд аль эрт нэгэн бэлтгэлийг урд гүйцээчихсэн. Хөгшин би үйлээ гүйцээгээд 77 нас хүрлээ. Өнөө цагтаа л богино нас бус. Хөл хориог цуцлаад олон хүн цуглуулах, номын хуримыг цацруулх нь ч үлдээгүй тул өвдөх цагт маань ч болж. Ийм нэг юм бүтээсэнгүй гэх зүйл оюун ухаанд минь огт үлдсэнгүй. Энд амьтны тус нэжгээдээр гарсан байна. Амьтны тус ч багадсан үгүй. Эндээс тэнд одно гэсэн баталгаа надад байна. Хоёр зүйлийн бодийн сэтгэлээс хагацаж хэзээ ч үзсэнгүй. Өвчний шалтгаанаар зүүд сэргэсэн лүгээ адил тул хавар өвдсөнөөс эхлээд биеийн тэнхээгүй болсон ч бодийн сэтгэл улам бүр арвижих болов. Хичээл шамдалгүйгээр буяны ажлыг олсон чухаг дээдийн ач мөн. Энэ мэтийн агаараас үхэхийг өгүүтгэл гэдэг. Өөр ургуулан бясалгах зүйл юу ч үг Бодисадвын явдалд орохуйд «Түүгээр бурханыг да санах тэргүүтэн юугаар ч алгасрах зүйл

үгүй» хэмээн зарлигласантай та нар ч харшлал үгүй байгтун гэв.

-Та хойд төрөлдөө хаана төрөх вэ?» хэмээн асуусанд:

-Амьтанд тус болж байвал там ч байсан тэнд төрөх тун дуртай байна. Тус болохгүй бол арилсан орон байлаа ч үл дурлана» хэмээн айлдав. Тэр шөнө ч бас “Тахил бэлтгэ” хэмээв. Тахил бэлдмэгц маданагийн нэг тахил авчруулаад дээж тахилыг өргөн дэлгэрээр ергөөд алгаа хавсран тэргүүнээ бөхийлгөн таван зүйл тахилаа мутарлагтайгаар тав таван удаа давтан өргөж дэргэдээ байгаа хүмүүсдээ ч бас тахил өргөхийг айлдаад мэлмийнээсээ шүүдэр унагсаар ерөөл олонтаа тавив. Түүнийгээ өндөрлөсний дараа учирыг нь болохыг асуусанд:

-Ханьцашгүй дээд нууц тарнийн олон бурхан залран ирсэн тул та нарыг тахил ергө гэсэн юм, өөр хэлэх зүйлгүй хэмээн айлдав. Тэгээд Ловон Ёндон, одыг өвчнөө сувилуулахаар дуудсан үедээ нэгэн орой үдшийн бүрий хавьд мутраа огторгуй өөд тохиод:

-Арилаагүй үйлүүд минь үлдэлгүй арилан ариусаад үзэсгэлэнтэй, сэтгэлд таатай, огторгуйн хаяа мэт, хэмжиж баршгүй саруул уужим, дарахад налчийж, авахад өөд хөвсийх, хүрэхэд таатай мэдрэмж төрүүлж тэргүүтэн элдэв олон сайхан шинж чанартай тийм нэг гайхамшиг төрүүлсэн арилсан газарын дунд би байх юм. Эргэн тойронд чуулсан олон нөхөд тоолшгүй олноороо байна. Өдгөө өдөр маань дэргэд ирсний учир энэ буй заа хэмээн айлдав. Тийнхүү энэ их лам багш маань анх мэндэлсэн цагаасаа эхлээд эцэстээ бурхан болох хүртлээ Бирузана бурханы долоон номноос огт хагацаагүй юм. Бурхан болохынхоо дөнгөж өмнөхөн хүртэл:

Угаасаа хэвтэх, суухад дасаагүй учрааё явган суух минь л амар байна гээд явган суув. Арван есний шөнө дуу хураан огторгуй өөд хараад тааллаа тод гэрлээс үл хөдөлгөн суувай. Дараа нь мөнх үзэлт шавь нарыг номхруулах, санаанд багташгүй үйлийн ёсыг үзүүлэх, бусад ертөнцөд ч тус болохыг бодолцон болгоогоод далан долоон нас сүүдэр зооглодог эм шороон тахиа жилийн тагар сарын шинийн хорины өдөр нар шингэхийн алдад номын лагшины их амирлангуйн төв рүү гаслангаас хэтийдэхийн ёсыг үзүүлэв. Тэр шөнө газар алтан бурханыг сэнтий ширээн дээрээс нь унагах хэртэй хөдөлж опторгуйн орон зай солонго, таван өнгийн гэрлээр түгэн дүүрч, уянгат сайхан хөгжм дуу дуурсаж, тэнгэрийн цэцэг цас будрах мэт бууж, хүн ард ч гашуудан их дуугаар уйлж, адаглаад янгир анч нохой тэргүүтэн адгуус амьтад хүртэл маш их гашуудаж байв. Бие лагшин нь муудаад ирэх үедэс эхлээд янгир, анч нохой хоёр нь уул руу бүгэн одож, өргөөний

нь дэргэдүүр эргэлдэхээ байсан бөгөөл бурхан болсон өдөр нь гарч ирээд өргөөг нь тойрон эргэл хийж шарилд залбирал үйлдэх үеэр янгир нь өргөөний доохон талд По түлхэн егүүтгэл үйлдсэн мэт үхсэн байв. Жалсрай эрдэнийг бурхан болсны тав дахь хоногийн шөнө хатуу хөл хориг тогтоон бясалгал үйлдэж байгаа ариун үзэгдэлт зарим нэгэн Хасарваань Жанрайсиг урин залж Энхжингийн оронд залран одох зарим нь гэтэлгэгч Дарь эхээр угтуулан Юүло годвийн оронд ажрахыг үзэж, хэсэг нь хач бандида Шагжаа шири Дүшдийн орон луу залан одох, зарим нь хэмжиж тоолж баршгүй тэнгэр, дагина нарт угтуулан одох, огторгуйг халхалсан их цагаан суварга өөд шат тагтаар авиран очир хонхны дууг жингэнүүлсээр бид Агнистын оронд одсугай хэмээгээд суварга юутайгаа хамт огторгуйн гүн рүү залран одох тэргүүтэн адилгүй олон зүйл үзэгдлүүд гарав. Жононгийн ёсны нэгэн бүтээлч эмэгтэй Цүлсан хэмээгчийн үзэгдэлд Жанрайсигийн шүтэгч, шүтээний хот мандал эвдрээд зүүн зүгт одох үзэгдэл гарав гэдэг. Бурхан болоод долоо хоносны дараа ясыг нь уудлан үзсэнд дахин газар хөдлөх, огторгуйн орон зай солонгоор завсар зайгүй болтлоо дүүрэв. Шарилыг өөр нутаг руу залан авч явахад солонго хөтлөн одож, болор тунгалаг өнгөтэй шарил олноороо гарч, цахиур шүднээс нь нар саран чимэгтэй зөв эргэсэн номын дун олноороо гарч мөн сүүлд нь Жанрайсигийн бие шүтээн тэргүүтэн ч гарав. Эдгээр нь Жалсрай эрдэнийн намтар бөгөөд үүнээс хойшх лам нарын дэлгэрэнгүй намтрыг олоогүй боловч бодитоор дамжсан уламлал баш нарыг дурьдяа.

Хутагт Жанрайсигийн хувилгаан Жалсрай Тогмэд бээр увьдсаа Цорж Нягчэн Соднам вамбууд хайрлав. Тэр бээр бат агч Бакулагийн хувилгаан Нягбон Содном самбууд, тэр бээр Пагчэн тогдүмбаа Содном даржайд, тэр бээр Пагва содном жамцад, тэр бээр Мааньч Дагва содномд, тэр бээр Ловоба Жансэм Гунгаа чогдүвт, тэр бээр ловон багш Жодвий доржийн хувилгаан Жэвзун гунгаа долчогт, тэр бээр хөшөө чулааны даяанч Уомбо Гунгаа жанцанд, тэр бээр Жодвий доржийн хувилгаан Жонон лозаваа Гунгаа нямууд тус тус дамжуулан хайрлав. Бас өөр нэг дамжлага нь Жалсрай эрдэнээс Гүнбан эрдэнэд, Жансэм Содномринчэнд, түүнээс Браггар Сэмбааринчэнд, түүнээс **Дооринбаа** Гунгаажанцанд, түүнээс Жонон Лозаваад, **түүнээс** Жалцав-онгаа Ринчэн жамцад, түүнээс Жээдүн **эрдэнэ** Ишжамцад, түүнээс Дагданба Жэ-лодойнамжалд, **тэр** бээр Уомбоо Чалүнбаа Агваандэрэнлэйд, **түүнээс** бүтээлч Гүнсанвамбууд, тэр бээр Гатогригзин Цэвээнноровд, тэр бээр

Бүрүгваа эрдэнэ Гаржүд пэрэнлэй шиндаад, тэр бээр бүхнийг болгоогч Сидүү эрдэнэ Гармаава шашны наран Зүглаг чойжий нанваад, тэр бээр Сүрманбаа Хайдүв гармаа цэвээн гүнчавт, тэр бээр Цүрпүжалцавын хувилгаан Гарма Ээндонравжай Чой-балсамбууд, тэр бээр Бригүнба Жалваанчагнаабадмо Данзан Бадмай-жанцанд, тэр бээр Бригүнба Чогбрүл Жамьян Чойжийжанцанд, тэр бээр Нинзонтичэн Ринчэн лодойжанцанд, тэр бээр Бригүнба Тамжадчинсиг Ранжүнчойниднорвууд, тэр бээр Бригүгёнзон эрдэнэ Пэрэнлэйгүнчав хийгээд Ханчэндунгар хувилгаан Дожзинваан дамчой жүрмэдэд хоёрт тус тус хайрлав. Тэр хоёрын аль алинаас нь Цог тогт язгуурын лам, хүрдний итгэл, Гончогчойжов багш маань сонсож, дээдэс тэр бээр Аваадүдийба Ээндон-жамц би тэргүүтэн олон шавь нартаа баясангуйгаар хайрлав. Ум Сувасти.

Маш олон хоёр чуулган хурсан их далайгаас
 Машид мэндэлсэн дамжлага ламын алдруудыг
 Машид цагаан үсийн утсанд хэлхснийг
 Маш үзэмжит намтрын үнэт эрхи хэмээдэг
 Энэ номонд сүсэгтэй, үзэмжит үснир хадгаласан
 Хувь сайтай залуу тогосуудын сонор чихэнд
 Тус эрдэмт цадигийн зуны хэнгэрийн их дууг
 Өнөөдөр дуурсгасугай, баясан бүжиглэтүгэй аяа!
 Өтөл эх болсон огторгуй чацуу
 амьтны сэтгэлийн толинд
 Гурван түйтгэрийн халтар бултар бохирлон
 халдсаныг
 Гүн гүнзгийн мөрийн рашааны
 сайн урсгал үүгээр угааж
 Хоёр айлдлын дүр зургийг
 үтэр түргэн ургаалах болтугай

**Нэрт эрдэмтэн Заваадамдин гавжийн энэрэнгүй сэтгэлийн
тухай түвд хэл дээр магтаж бичсэн яруу найраг**

**ИХ НИГҮҮЛСЭНГҮЙ СЭТГЭЛ ДОР МАГТМУ ХЭМЭЭХ 108
БАДАГТ БОЛОР ЭРДЭНИЙН ЭРХ СУДАР ОРШИВОЙ**

1. Их төрөлхтөний замын үүд
Их хөлөгний мутрын тамга
Их бодийн хөрөнгө онгоц
Их нигүүлсэх сэтгэлд мөргөө
2. Бурхан бүгдийн игүүсгэгч эх
Бодьсодва бүгдийн зүрхний эд
Бүхийл амьтны тэгш багш
Бат нинжин сэтгэл та намайг авар
3. Аль бээр гагцаар мөргөхөд
Авралт бодьсадва бүхэнд
Алга хавсран тахихийн түлхүүр
Ашдын нинж таныг магтая
4. Эрмэг бодьсадбаа архад бээр
Ээжээс төрөх уг шалтгаан
Эцсийн ханьцашгүй язгуур
Энэрэнгүй сэтгэлийг магтая
5. Бурханы цэцгийн чугуулган
Бусад хөрөнгө ч услаж боловсрох шиг
Эх адаг дунд хаа ч чухал
Энэрэнгүй сэтгэлийг магтая
6. Эх болсон амьтан бүгдийг
Эвдрэх орчлонгийн нарийн бүдүүн үйлээс
Энэрэн таалах мөн чанарт
Энэрэнгүй сэтгэл таныг магтая
7. Олон амьтан мунхрахын эрхэнд
Орчлонгийн худагт унасан бүгдийг
Огоот зовлонгоос гаргагч
Олон амьтны төлөөх нинжийг магтая
8. Эргээ халих усны давалгаа шиг амьтад
Эгшин зуур төдий ч амгалангүй
Эвдрэх мөнх бусыг тийн болгоогч
Эрхэм номын төлөөх нинжийг магтая

9. Сарны дүр усанд буух шиг амьтан бүгдийг
Сайтар болгох мөн чанарт
Аль мэт хоосон шинж төрхтэй
Албадлаггүй төрөх нинжийг магтая
10. Их нинжийг бясалгаснаар
Ирмэг хүч төгсхийн цагт
Илт туулсан бурхан болохын
Илбэ шид нь та билээ
11. Ховор нинжийг дэлгэвээс
Хорлох хэзээч оршихгүй
Хотол дээдийн номондоо
Харин ч эрхэм эрдэнэ нь та
12. Үзүүлэгч бурханы шавь нь
Үнэхээр нинжийг хамгаалагч
Үнэн буяны номыг бүтээхийг
Үүргэлэн авсан хуврагийн хань та
13. Бурхан багш шаарийбуу
Булт олон дээдэс бүгд
Таныг дамжуулж авалгүй
Тааваараа дээшлэх замгүй
14. Аюул бүгдээс гэтэлгэгч
Асрангуй сэтгэл та бээр
Асар тэнгэр ертөнцийн
Авралын орон та билээ
15. Ялж төгссөн Бурхан бээр
Ялгамжтай төрөлхтөн болсон нь
Энэрэнгүй таныг бүтээж
Эцсийн замдаа тулсан
16. Иймийн тулд Бурхан бээр
Эцэс нярваан бол шашин
Ирэх үүдийн дээдийг магад олох нь
Энэрэнгүй сэтгэл гэж сайшав
17. Чухаг дээд гурав бурхан
Чухам авралын учир ч
Зарим нь аврал одуулахгүй ч
Зөвхөн та тэдэнд эрхэм
18. Уг үүгээр ном хуврага ч
Аврал зохистой бүтээхийн тухайд
Ураглах захлахын эрх ялгамжтай ч

- Аврах аврахгүй гэх ялгаа танд үгүй
19. Архад шарбагаан бясалгалын хүчээр
Арван их галавт сууж чаддаг ч
Аяа таныг эрхэмлэн залахгүйгээр
Ахиж дэвшиж үл чадна
 20. Туулсан бурхад бодьсадба нар
Тун их эрх мэдэлтэй ч
Таньдаа мөргөн тахихгүйгээр
Төгсөх орчлонгийн тусыг бусдад үйлдэж чадахгүй
 21. Мулгуу над адил нь санаагаараа тахиж
Мэргэн танд толгойгоо даатгая
Цаагуур одон өнгөрөх зовлонг
Цохлон өөртөө даллан авч
 22. Бусдад амгалан нэгийг ч гэсэн өгөөд
Буцлам зовлонгоос нь өөртөө ирүүлж
Хойшид гарах зовлон бүгдийг хөөгч
Хаашил таниас өөр хэн байх вэ
 23. Аль нь нэгнийг хүлээн авснаар
Алимад зовлон барагдахын шалтгаан
Хувирах зовлон алийг барьсан ч
Хааж чадахгүйч гайхамшиг нь та
 24. Аньс тодорхой итгэлт та бээр
Аль өөрийн зовлон үүсгэх нь
Саранд дэлгэх цэцэг бодьсадваа шиг
Сааталгүй төрөлхтөнг амьчилан сахиж
 25. Там хилэнцэд унгалгүй
Төрөлхтөн бүгдийг сахиж
Бусад аньсны суурь болох
Бурхан нинж та болой
 26. Бусдын төлөө зовж чадах
Бадма цэцэг шиг уснаас төрөгч
Бие сэтгэлийн баясал амгалант
Бахтай нинж та мэргэн
 27. Та амьтан бүгдийг гэтэлгэж
Тагаалал нь баясалийн далайг булааж
Өөрийгөө чухалчилах зүйл үгүй
Өрөвдөхийн нулимс нь мөрөн гол шиг та
 28. Асрал энэрэл баясгалан
Ашдийн нөхөр баатар

- Алив үйл ерөөлийн хүч
Амьтан зургаан язгуурт төрсөн ч
29. Буяны хүчээр бие амгалан
Бас мэргэн ухаанаар сэтгэл амгалан
Бусдын тусд орчлонгийн эцэс хүртэл
Буцахгүй оршиж уйсалгүй төрөхгүй
30. Бүх энэрэлийг төвлөрүүлэгч
Бусдад туслах нь гайхам шиг
Хариу үр дүн горлохгүй
Харин ч чөлөөгүй зүтгэгч та
31. Амьтан бүгдийг зовлонгоос
Аврах хүсэл авир ёст
Зовсон хөвгүүнд ухаант ээж шиг
Зүтгэх үлгэр харуулагч та
32. Хүү олонтой ч өвдсөн хүүдээ
Хайрлан зовох эх шиг
Хамаг амьтан олон ч
Харин та бүгдийг энэрэнэ
33. Өчүүхэн төрөлхтөн над мэтэд
Өөрөөсөө илүү энэрэл өгч
Магад та амьтан бүгдэд
Маш их энэрэх тушаалтан
34. Зовлон үүлээс айдаг ч
Хилинц нүглээс айдаггүй бид
Зовиурт нүгэлийн үйлийн үр
Хязгааргүй ихдэхээс айдаг та
35. Нисва нисаар бугуйлдуулсан
Нилэнхүй орчлонгоор хүлэгдсэнийг
Нээрэн таныг дээдэлсэн бурхад
Нинжид мөргөн ертөнцөд залардаг
36. Тэр юуны тул бурхад бээр
Тэргүүлэшгүйгээс эхлэн энэ орчлонд
Тэтим болгон танд мөргөдөг нь
Тэртээх энэтхэг мэргэдийн журам
37. Энх амгалангийн далайгаас
Эргэлдэн гарах булаг шиг
Эх бурхад лусын хаад ч
Энэлэх шавь нараа гаргаж үл чадна
38. Эрхэм таньтай адил боловч

- Эд шидтэй тарнийн хүч алин бээрч
Эзлэн амирлуулж үл чадна
Эгнэгт таны сүрэнд дарагдана
39. Бурханы хүч мөнхөд төгөлдөр
Бүхий мэдэгдэхүүнийг мэддэгч
Үрээд барахгүй хашын чулуу шиг
Үлгэрлэж таныг жишиж мэддэг
40. Зовлонгийн их үхлийг зайлуулж
Зайлуулсны сүүлээр тусах заримд
Заавал өөртөө авах таалалтай
Зоригтон таниас өөр хэн ч үгүй
41. Бусдын бүх зовлонг өрөвдөн
Өөрийнхөө амиар солих
Бурхан мэт таалал тань
Өглөгийн баян далай мэт
42. Бусад бээр өөртөө тустайг л хийдэгч
Буцаад хорлол болох нь олон байдаг
Хор хүргэж үйлдсэн нэгнийг
Хосгүй тус бүтээснээр тооцдог та
43. Амьтан бүгд бээр тань доор
Атаархах дайсагнах урагнах бүгдийг
Өөлөх нэгэн зүйл өчүүхэн ч үгүй
Өгөөмөр ээжийн сэтгэлийг харуулдаг
44. Хөгшин ээжийгээ адаар галзуурхад
Хүндлэл байвч болгоомжтой ханддаг нь
Хамаг амьтаныг ачит эх хэмээн бодож
Хэнд ч өчүүхэн болгоомжгүй энэрэнэ
45. Бурхан бүгд энэхүү ертөнцийг
Бүхэл өдөр шөнө амралгүй тольдсоор
Нярвааний замыг заан өгч орших нь
Нигүүлсэнгүй таны их ач
46. Алин бээр би итгэл үгүй ч
Амьтан бүхнийг аврах нь зөв хэмээн
Арслангийн хүрхэлтийг дуурсагдаг
Агуу нинж таны ач гавьяа билээ
47. Хүмүүн бус нугууд бээр амьтаныг
Хомроглон устгах шидийн тарнийг
Хувирган эрдэм болгосон ач
Хувьтай таны адистэд мөн

48. Алимад шулмасын цэрэг
Аймшигт нисэн хорыг буулгавч
Алаг цэцэг дэлбээлэн ургах нь
Агуу нинж таны хуяг
49. Алин бээр амьтан бүгдийг
Амь алдахын жам ёс таархад
Атган тэврэх хүчит мутраар
Авран нигүүлсэх нь ямагт та
50. Дээд удирдагч хамаг амьтаныг
Дэлхийн аймшигт хүлээс аюулаас
Дээш нь татан гаргах мутарлагаар
Дэгээдэн татах нь таны таалал
51. Тиймийн тулд та бээр амьтан бүгдийг
Татах буурах алинд нь ч тааруулалгүй
Орчилонгийн хотол чуулганыг
Онцгой тэгш мэдээ чинь та билээ
52. Өчүүхэн дотортой бид бүгд
Өөрийн гарзыг бусдад нилзааж
Хотол чуулган сайн бүгдийг
Хувийнхаа төлөө залбиран хүсдэг бол
53. Бурхан нинж та бээр
Буян сайхныг бусдад нилзааж
Бусдийн зовлонг өөртөө татаж
Бүгдийг бурхан болгохыг хүсдэг
54. Ертөнцийн жаргал зовлон бүгдийг
Ер өөр бусдыг энхрийлэн барьдаг
Гэм буруу эрдэм тусыг
Гэтэлгэн ялгаж танд итгэмжилдэг
55. Бусад бүгд ихээр бишрэвч
Буруугаар зарим нь уригнан үйлддэгч
Тэрхүү гэрцгий ард олныг ч
Тэгш сэтгэлээр тахиж үйлддэг
56. Ялгуусан хутгыг бүтээхүй доор
Ямагт бурхан амьтан хоёр
Ачын их багыг адилтгах ёсыг
Арга ухаанаар онислон болгоогч
57. Хамгийг болгоогч амьтан нугуудын
Хилинцийг усаар үл угаамой
Зовлонг мутраар үл арилагмой хэмээн

- Зарлиг шаштирт айлдсан байдаг
58. Нигүүлсэнгүй бясалгагч бясалгасан бээр
Нохойн биеээс хавдар өвчин
Хүний биеээс бөөсний өвчин
Халдааж авсан энэ юу нэгэн буй
59. Гэвч өөр бусдын жаргал зовлонг
Гээх авахыг бясалгасан еүгзэрийн
Оюуны чадал сэтгэшгүй бөгөөд
Олныг тольдогч ямагт бээр болгоосон
60. Тэгш багш лугаа нэгэн үндэст
Тамын тэргийг татагч хийгээд
Таарсан хувь зохиолоор
Тэнд ёроолд нь оршидог
61. Өдгөө тэр бүх бурхан болсон боловч
Өвөр бидний авир ёсыг
Санах цагт их нигүүлсэнгүй сэтгэл
Саадгүй төрж ялган тодолмой
62. Огоот нигүүлсэхүй тань дор
Ойр холын ялгаа юу байх вэ
Өөр болон бусдын тус ямагтыг
Өчүүхэн ч үл мартаж эрдэм амуй
63. Тамад олон галваа суух үйлтэй
Тэд ч мөнхүү таныг олоод
Тэрхүү агшинд үйл нь барагдаад
Тэнгэрийн оронд төрснийг номолдог
64. Зовлонгын галын өмгийг сөнөөх үед
Зуны хур адил даган орох бөгөөд
Хилинцийн цогцосыг шатахуй дор
Хэнээс ч асуулгүй тэмцэлд одмуй
65. Амьтан заримын толгойны өвчин төдийг
Арилгахыг хүсэгч нигүүлсэхүй төрмөгц
Янагхан шувуухай тэр тамын
Янагш хүрднээс гэтэлсэн бөгөөс
66. Огторгуйн сац хамаг амьтаны
Олон арван зүлийн зовлон арилгахыг
Бясалгал нигүүлсэхүйн дээдийг хүсэгч
Буяны цогцосыг юугаар хэмжих вэ
67. Таван цэвүүн дэлгэрсэн муу цагийн
Та мэт зуу наст амьтан нугууд

- Сайн цагийн бусад бодьсадваа нугууд бээр
Саадыг номхотгон болгоон орхидог
68. Тэр цагт бярман далайн тоос хэмээх нь
Тэнцэшгүй баатар нигүүлсэхүйн залиар
Таван зуун ерөөлийг сайтар талбиж
Тэгш хувьт дээд шавь нарт мутраар адисласан
69. Сайваар одогсон эрдэнийн зүрхэн тэргүүтэн
Сайх арван зүгийн бурхан шавь нар сэлт
Сайтар эрдэнийн цагаан лянхай цэцэг шиг
Сайшаалаар дэлбээгээ нээн дэлгэсэн мэт
70. Тэр бүгд их нинжин сэтгэлийн ачаар
Тэнгэрлэг эрдэмийн цадиг ёсоор
Та ану гурван цагийн бурханы
Тэргүүн их багш хэмээн магтагдмой
71. Алинтүгэй итгэлт майдраас
Ахин дөчинхоёр их галавын сүүлд
Агуу бодьсадын сэтгэлийг үүсгэвч
Аяаа их урд бурхан болой хэмээн номолсон
72. Тэр мэт нинжин сэтгэлт та бээр
Тэнгэрлэг багшийн үйлсийг үүрээд
Төгсгөх боловсруулах арилгах гуравт
Түвшин хичээл шамдалын ач амуй
73. Бусдын тусыг үүрэглэн авч
Бүхийл сэтгэлээ нинжээр ариулсан
Энгүй шавь нарын их адал явдал нь
Эглийн оюунд багтахуй бэрх бөлгөө
74. Төглийн ганц найлзуур модны тэргэд
Тэргүүнээ мянга дахин өгөх ёсыг
Үзэх байтугай сонсон ч зүйл үгүй
Үлгэрлэн бодвоос зүрхэнд шимшрэл төрнө
75. Сайваар одогсон номын хааны
Сайн язгуурт төрсөн дээд шавь нь
Нинжийн цэцэг мэт дэлбээлэн ургасны
Нижгээд боожуулсан эх нь нинж та
76. Магад гархын тийн ариун санаач
Машид нигүүлсэхүйгээр бүтхүй
Нүүр нь нааш цааш харсан байв ч
Нийлбэр ялгавар адилыг номолсон
77. Бодь сэтгэлийн галбарваас мод

- Буй хийгээд төрөх арвидах бүхэн
Хос долоон шалтгаан үр барилдсан
Ховор нинжийн язгуурт дулдуйдмой
78. Удам хоосон чанарын их далайд
Уран аргат ухаан сүмбэр уулаар
Дахин давтан найруулсаны охь
Дамай нинжийн рашаан та ямагт гарсан
79. Таван зөн мэдэл ба дөрвөн үрийг
Та олвой хэмээн өгүүлэгч олон
Их нинжийн сэтгэлийг олвой хэмээж
Илэрхий өгүүлэгч гарах нь бэрх
80. Бусад эрдэмүүд бүтсэний шинжийг
Бултыг үзүүлэгч шөнийн одчилон
Их нинжин сэтгэл бүтсэний шинжийг
Ингэж үзүүлэгч нь өдрийн одноос ховор
81. Тиймийн тулд гурван мянган ертөнцөд
Дээд нинжин сэтгэл эрдэнийг
Төрлөхтөн буй нь олсон төдий мөний
Дээд ёсыг барамидийн сударт номлов
82. Өөрийн махыг таслаад өгөхдөөч
Өлөгчин бард тусалсан гэж баярлаж
Мэдэрхүйеэ бэрх энэхүү нинжин сэтгэлийг
Мэргэн мунхаг хэн бээрч жишиж чадмуй
83. Алин бээрээс ч гуйхын дуу сонордвоос
Амгалант шарваан барадагуудын
Амгалан нирваанд ч үл тэнцэх тул
Ашдын нинж таны цог заль гайхамшиг
84. Бодьсадваа баатар тогосын их чуулган
Бодол эрдэмийн хурыг хэдий чинээ идсэн
Төдий чинээ эрдэмийн өдөнд уригнах
Төгөлдөр сүр жавхлан таных амуй
85. Ховор нандин зэндмэн эрдэнүүд
Хэрэг тус төдийг нижгээд бүтээдэг
Эрдэнийн хаан оргил нинжийн зэндмэн
Эрсэн хүссэн бүгдийг шамдалгүй бүтээдэг
86. Өглөг тэргүүтэн зургаан барамид нь
Өгөх авхын нэгэн талыг бүтээдэг
Өгөөмөр их нинжин сэтгэл та бээр
Өөр бусдын тус бүгдийг бүтээдэг

87. Гайхамшигт нинжин сэтгэл эрдэнэ
Гарын алганд буй болвоос
Бурхан ном бүгдийн үйл нь
Буцалтгүй бээр гарт нь хурдаг
88. Туулсан их бурхан хэмээгч нь
Тунгалаг солонго эргэлдэх гэрлэн хүрээнээс
Найман зүйлийн рид хувилгааныг үзүүлэгч
Нэгийг бодох нь хаанаас байхав.
89. Тэнгэрлэг нинжин сэтгэл таны
Таалсан хэрэг нь амьтан ертөнц
Үргэлжид болгоох их зовлонгоос
Үнэхээр аврагч таныг тавьмуй
90. Туулсан их бурхан бээр
Таван мянган жил шашинаа оршоохын угт
Тэнгэрлэг нинжин сэтгэл таныг
Тавьж орлуулан нирваанд заларсан
91. Бид мэт молхи нугуудад нэн ихээр
Болгоолт энэрэл хэтэрсний тул
Агуу нинжин сэтгэл таны
Ачыг нь бид яаж хариулахав
92. Өвөг итгэлт хоншин бодьсад бээр
Өөрийн алдарыг адистэдлэж
Алив сонсон аюулыг гэтэлгэдэгч
Аяа нинжин сэтгэлийн оньс мөн
93. Асангийн зөөлөн итгэлт
Аглагт арван хоёр жил бясалгаад
Авьяас билэг тодорсонгүй ч
Адгын гөлгөнд туслаж
94. Агуу хүчит нинжийг
Агшин дор бүтээсэн буй
Олон зуун бурханыг бүтээснээс
Онцлон нинжин сэтгэлийг бүтээ
95. Ханьцашгүй богд адиша бээр
Хэмжээт нас арван ёс үлдсэн ч
Цаст түвдийн оронд заларч
Цаглашгүй нинжийг номлож
96. Шашин амьтаны журмыг сэргээж
Сайжран дэвжихын үйлийг таалж
Шинэ цаг ирэхгүй болсонч

- Сайтар нинжийг шүтэхийг захив.
97. Хаан хөвүүн самбууцог бээр
Хамгаас нинжийг онцолсоны хүчээр
Хажууд нь байх хулгана чоно ч
Хавьталгүй тэвчив улаан идээ махыг
 98. Төгөлдөр итгэлт бодь лам зонхооба бээр
Таван зуун жилийн эцэс нэн цэвүүн цагт
Тунгалаг шагшаабадын хэргүй номлолоор
Төгс үзэсгэлэнт замбуу тивийг болгоосон ч
 99. Урдын баатар эрхэтийн өмнө
Увидаст төгөлдөр нинжийн хүч
Дээдийн номыг барихын ерөөл
Дэлгэрэх сайн цагтаа боловсрохыг мэдвэй
 100. Товчилвоос орчлонгийн их далай доор
Том бага их мөрөн сайн чуулган бүгд
Торохгүй урсах нь эхэнд байх цаснаас болдог шиг
Төв сэтгэл болох нинжээс хамаарна
 101. Энэрэнгүй сэтгэл нь огторгуйгаар дүүрч
Эрдэм мэдлэг нь уудам хязгааргүй
Бүхнийг болгоох мэлмий төгөлдөр учир
Бяцхан батгана мань мэт яаж хэмжих вэ
 102. Хурын үүлний тусал зарим өчүүхнээр
Хараацай шувууг амаржуулдагчилан
Энэрэнгүй сэтгэлийн зарим эрдэмийг
Энд өгүүлсэндээ сэтгэл минь баясмуй
 103. Нялах балчир цагаасаа эхлэн
Нүгэл хэлний уналыг үйлдсэн ч
Миний хэлээр хэлсний дээд үг
Магтах нинжин сэтгэлийн өдөр болой
 104. Алин бээр нэгэн үндсэнд төрсөн буй
Адуу мал лугаа харших бодол үгүй мэт
Эр хүний нэр цог залиг мандаагч
Энэрэнгүй сэтгэл танд аврал одуулмой
 105. Зүрхнээс бурханыг олохыг хүсвээс
Нинжин сэтгэлт ламын өмнө оч
Зүрхнээс ажил үйлсээ бүтээж үйлдэхийн тухайд
Нинжин сэтгэлийг бясалгаж үйлд
 106. Тэгүүнчилэн хэлсэн магтаал буян үүгээр
Миний сэтгэлд нинжин их сэтгэл

- Түргэн төрөх тэр цагт дор
Төрөлхтөн бүгд дэвжих болтугай
107. Огторгуйн энтэй их болсон тус цохилдох чуулганыг
Онц энэрэнгүй сэтгэлийн их онгоц бээр
Бодын их далайд залахуй их мэргэн
Богд их сартваах нь би болох болтугай
108. Цөвүүн цагийг аврахын орон болсон их нинжээр
Цанган энэлсэн амьтан бүгдийг
Цаглашгүй нинжийн рашаанаар чигтүүлж
Цогт бурхан тэнгэрийн адистэд орших болтугай

99 | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | 32 | 33 | 34 | 35 | 36 | 37 | 38 | 39 | 40 | 41 | 42 | 43 | 44 | 45 | 46 | 47 | 48 | 49 | 50 | 51 | 52 | 53 | 54 | 55 | 56 | 57 | 58 | 59 | 60 | 61 | 62 | 63 | 64 | 65 | 66 | 67 | 68 | 69 | 70 | 71 | 72 | 73 | 74 | 75 | 76 | 77 | 78 | 79 | 80 | 81 | 82 | 83 | 84 | 85 | 86 | 87 | 88 | 89 | 90 | 91 | 92 | 93 | 94 | 95 | 96 | 97 | 98 | 99 | 100 |



100 | 101 | 102 | 103 | 104 | 105 | 106 | 107 | 108 | 109 | 110 | 111 | 112 | 113 | 114 | 115 | 116 | 117 | 118 | 119 | 120 | 121 | 122 | 123 | 124 | 125 | 126 | 127 | 128 | 129 | 130 | 131 | 132 | 133 | 134 | 135 | 136 | 137 | 138 | 139 | 140 | 141 | 142 | 143 | 144 | 145 | 146 | 147 | 148 | 149 | 150 | 151 | 152 | 153 | 154 | 155 | 156 | 157 | 158 | 159 | 160 | 161 | 162 | 163 | 164 | 165 | 166 | 167 | 168 | 169 | 170 | 171 | 172 | 173 | 174 | 175 | 176 | 177 | 178 | 179 | 180 | 181 | 182 | 183 | 184 | 185 | 186 | 187 | 188 | 189 | 190 | 191 | 192 | 193 | 194 | 195 | 196 | 197 | 198 | 199 | 200 |

ॐ । मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग
 रसुविसपरिक्रमपठकदुमपिदपमलुसमसपसपदिमोपरेकुदो । देअदसा
 कुनपयस । मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग
 उअतेपडेहुलेसापसअककपमलुन । मपपहुगुगसपदमठसपयस
 रेदनेनहुकेगसरेअसापरेकेअयस । रथगसपरेसुदमगकुअदपसुसा
 कअमपरेपअसप्रअसठदलुमपमसुस । कुअपसुसपठसप्रअसठद

ॐ मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग

मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग
 कुनपयस । मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग
 उअतेपडेहुलेसापसअककपमलुन । मपपहुगुगसपदमठसपयस
 रेदनेनहुकेगसरेअसापरेकेअयस । रथगसपरेसुदमगकुअदपसुसा
 कअमपरेपअसप्रअसठदलुमपमसुस । कुअपसुसपठसप्रअसठद

ॐ मनेरुदनेकठुदसापरेदुवाकुगशेनउत्रेअवालेकपहुनयिग

ॐ । | पठुच्छयतिशयद्विरेरममम एतदत्रमत्रिदमकं गृह्यते
 यः । एसाप्रमसठयतिमप्रियकसुवनेनेयदय । सुसाकमसयदसु
 यस्तुयानेददमदसुसमिहिसुसमिरेददय । निसुसातिपयसायस
 कुमसायकमपगपठेदसपवेदयेरेममप्रमसुठक । निसुसासुसपरि
 मसिपतिशयसादपृकपदमपदमदसोपतिप्रदपसमदिसप । निसो
 केरेदसुठक । सुवकुव । मसुवकुव । एसागसु । विमसगसु ।

२७

ठवः । निसुच्छयतिशयद्विरेरममम एतदत्रमत्रिदमकं गृह्यते
 यः । एसाप्रमसठयतिमप्रियकसुवनेनेयदय । सुसाकमसयदसु
 यस्तुयानेददमदसुसमिहिसुसमिरेददय । निसुसातिपयसायस
 कुमसायकमपगपठेदसपवेदयेरेममप्रमसुठक । निसुसासुसपरि
 मसिपतिशयसादपृकपदमपदमदसोपतिप्रदपसमदिसप । निसो
 केरेदसुठक । सुवकुव । मसुवकुव । एसागसु । विमसगसु ।

२८

100
 101
 102
 103
 104
 105
 106
 107
 108
 109
 110
 111
 112
 113
 114
 115
 116
 117
 118
 119
 120
 121
 122
 123
 124
 125
 126
 127
 128
 129
 130
 131
 132
 133
 134
 135
 136
 137
 138
 139
 140
 141
 142
 143
 144
 145
 146
 147
 148
 149
 150
 151
 152
 153
 154
 155
 156
 157
 158
 159
 160
 161
 162
 163
 164
 165
 166
 167
 168
 169
 170
 171
 172
 173
 174
 175
 176
 177
 178
 179
 180
 181
 182
 183
 184
 185
 186
 187
 188
 189
 190
 191
 192
 193
 194
 195
 196
 197
 198
 199
 200

201
 202
 203
 204
 205
 206
 207
 208
 209
 210
 211
 212
 213
 214
 215
 216
 217
 218
 219
 220
 221
 222
 223
 224
 225
 226
 227
 228
 229
 230
 231
 232
 233
 234
 235
 236
 237
 238
 239
 240
 241
 242
 243
 244
 245
 246
 247
 248
 249
 250
 251
 252
 253
 254
 255
 256
 257
 258
 259
 260
 261
 262
 263
 264
 265
 266
 267
 268
 269
 270
 271
 272
 273
 274
 275
 276
 277
 278
 279
 280
 281
 282
 283
 284
 285
 286
 287
 288
 289
 290
 291
 292
 293
 294
 295
 296
 297
 298
 299
 300

ॐ । मीसावर्द्धद्विषापकुप्रपममु ॥ ॥ देहदुःखुआवणश्रिकेणपरपुण्यम
 क्वससुखवपदिह्रिमपदिहेव । अकन्य श्रेणार्द्धेन । अकन्य श्रेणसपामसी
 पावर्द्धिरेणस श्रेणसपे । दगनयासुखायमहेवपरिचसयादक्यादिमिमा । पत्रसयवेस्यदुपपरिसि
 यत्रपयुनयदुकिनकेनका । नदसुखसहेकेवयेनयासयापयककेनयहेकुपय । श्रेणारिमुणसहे
 केवयेदुप्रथमसज्जदसुपयेदमेसकेसकसादेवककेनयपरिमसकापसापयस्यदु । कुदयामपमद ।
 यथा । यथाश्रीवदकससुखेन । उदेददुस्य । गपदुदश्रेणसावेस्यदुपयवसा । वेदेहापिदश्रेण

५३

मी मीसावर्द्धद्विषापकुप्रपममु ॥ ॥ देहदुःखुआवणश्रिकेणपरपुण्यम
 क्वससुखवपदिह्रिमपदिहेव । अकन्य श्रेणार्द्धेन । अकन्य श्रेणसपामसी
 पावर्द्धिरेणस श्रेणसपे । दगनयासुखायमहेवपरिचसयादक्यादिमिमा । पत्रसयवेस्यदुपपरिसि
 यत्रपयुनयदुकिनकेनका । नदसुखसहेकेवयेनयासयापयककेनयहेकुपय । श्रेणारिमुणसहे
 केवयेदुप्रथमसज्जदसुपयेदमेसकेसकसादेवककेनयपरिमसकापसापयस्यदु । कुदयामपमद ।
 यथा । यथाश्रीवदकससुखेन । उदेददुस्य । गपदुदश्रेणसावेस्यदुपयवसा । वेदेहापिदश्रेण

५२

*“Wherever the Buddha’s teachings have flourished,
either in cities or countrysides,
people would gain inconceivable benefits.
The land and people would be enveloped in peace.
The sun and moon will shine clear and bright.
Wind and rain would appear accordingly,
and there will be no disasters.
Nations would be prosperous
and there would be no use for soldiers or weapons.
People would abide by morality and accord with laws.
They would be courteous and humble,
and everyone would be content without injustices.
There would be no thefts or violence.
The strong would not dominate the weak
and everyone would get their fair share.”*

*** THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL ***

Taking Refuge with a mind of Bodhichitta

**In the Buddha, the Dharma and the Sangha,
I shall always take refuge
Until the attainment of full awakening.**

**Through the merit of practicing generosity
and other perfections,
May I swiftly accomplish Buddhahood,
And benefit of all sentient beings.**

The Prayers of the Bodhisattvas

**With a wish to awaken all beings,
I shall always go for refuge
To the Buddha, Dharma, and Sangha,
Until I attain full enlightenment.**

**Possessing compassion and wisdom,
Today, in the Buddha's presence,
I sincerely generate
the supreme mind of Bodhichitta
For the benefit of all sentient beings.**

**"As long as space endures,
As long as sentient beings dwell,
Until then, may I too remain
To dispel the miseries of all sentient beings."**

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

*** The Vows of Samantabhadra ***

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

*** The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ***

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：紐涅八關齋戒修法》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO032 - 16010